Санхүүгийн мэдээллийн алба

СУДАЛГААНЫ АЖИЛ

Товхимол №3

Улаанбаатар хот

2024 он

СУДАЛГААНЫ ТОВХИМОЛ №3

Энэхүү судалгааны ажлын товхимолд дурдагдах аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА, 2024

ӨМНӨХ ҮГ

Эрхэм хүндэт уншигч танд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Их, дээд сургуулийн оюутнуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Эрдэм шинжилгээний хурал" энэ жил гурав дахь удаагаа амжилттай болж өндөрлөлөө.

Тус арга хэмжээ нь оюутнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр судалгаа хийх, эрдэм шинжилгээний бүтээл туурвихад урам зориг өгөхөөс гадна тэдний бүтээлийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, мөн бодлогын шийдвэр гаргах түвшинд оролцоог нь нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Энэ удаагийн эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцсон оюутнуудын шилдэг судалгааны ажлуудыг онцлон, уншигч танд хүргэж байгааг хүлээн авна уу.

Хүндэтгэсэн,
Санхүүгийн мэдээллийн албаны дарга
Б.Батбаатар

ГАРЧИГ

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛИЙН АЛБАНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН I БАЙР

1. Цахим орчин дахь залилах гэмт хэргийг бууруулах олон улсын сайн туршлага
   М.Тэргэл, Б.Номундарь .....

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН II БАЙР

2. Онц чухал дэд бүтцийг кибер террорист халдлагаас хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох нь (Банкны салбарын хүрээнд)
   Т.Биндэръяа, Б.Амарбаясгалан.....

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН III БАЙР

3. Мөнгө угаах эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүчин зүйлсийн шинжилгээ /Банкны ажилтны жишээн дээр/
   Д.Өсөхжаргал, С. Хулан, Ц. Мишээл.....

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ТУСГАЙ БАЙР

4. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн тулгамдаж буй асуудал
   Н.Мөнхцэцэг, Г.Болор-Эрдэнэ .....

5. Дотоодын болон олон улсын улс төрд нөлөө бүхий этгээдийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх, бусад орны туршлага
   Л.Болормаа, Т.Мөнхзаяа, О.Маралмаа.....

6. Мөнгө угаах гэмт хэрэгт криптовалютыг ашиглаж буй байдал ба түүнтэй тэмцэх арга замыг эрэлхийлэх нь
   Б.Баяржаргал .....

7. Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн чиг хандлага
   Э.Амирлан, М.Мөнгөнзул .....

8. Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулах оновчтой арга аргачлал /Өсвөр үеийнхний жишээн дээр/
У.Минжинсор, Д.Номин, Г.Хоролмаа .....

9. Залилах гэмт хэргийг цахим орчинд үйлдэх байдлаар дамжуулан мөнгө угаах эрсдэл, хууль тогтоомж ба институтийн эрх зүйн байдал
Л.Энхсайхан .....

10. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа
Б.Маралмаа .....

11. Виртуал хөрөнгийн салбараар мөнгө угаах гэмт хэргийн чиг хандлага түүнийг монгол улсын эрүүгийн хуулиар зохицуулах асуудал
Г.Хишигдалай Б.Хүслэн .....

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ БУУРУУЛАХ ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

М.Тэргэл, Б.Номундарь***

**Монгол улсын их сургууль, Хууль Зүйн сургуулийн IV түвшний оюутан, Мэргэжил: Эрх зүйч, И-мэйл: tergel.tergel415@yahoo.com, Утас: 94414082, 99949447,*

***Монгол улсын их сургууль, Хууль Зүйн сургуулийн IV түвшний оюутан, Мэргэжил: Эрх зүйч, И-мэйл: nomundaribb@gmail.com, Утас:99950626, 89290494*

ТОВЧ ХУРААНГУЙ

2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”, тэр дундаа 17.3-т “Залилах” гэмт хэргийг “цахим хэрэгсэл ашиглан” залилах хэмээн үйлдэгдэх аргыг нарийн зааж хуульчилж өгсөн байдаг. Гэвч ийнхүү цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэрэг хэмээн цахим орчин дахь залилах гэмт хэргийг эрүүгийн хуульд залилах гэмт хэргийг үйлдэгдэх нэг арга болгон хуульчилсан явдлыг судлаачийн зүгээс хэт хязгаарлагдмал хүрээнд зохицуулж өгсөн гэж үзлээ.

Учир нь залилах гэмт хэрэг нь сүүлийн жилүүдэд бодит физик орчинд бус цахим орчинд илүүтэй үйлдэгдэж богино хугацаанд олон хүнийг хохироож, хохирол, хор уршгийн хэмжээгээрээ тэргүүлэх гэмт хэргийн тоонд багтаж байгааг олон судалгаанаас харж болно.

Тиймээс энэхүү бүтээлийн хүрээнд цахим орчин дахь гэмт хэргийг нэгдүгээрт, Монгол Улс хууль тогтоомждоо хэрхэн тусгаж зохицуулсаар ирсэн тухай (1942 оноос 2002 он хүртэл), одоогийн хууль тогтоомжид тусгагдсан байдал (2015 оны Эрүүгийн хууль), мөн тус гэмт хэргийн онцлог шинж (гэмт хэргийн бүрэлдэхүүн бүрийн), бүрэлдэхүүний ангилалыг судлах; хоёрдугаар, гадаад орнуудын (Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс) эрүүгийн хууль тогтоомж, сайн туршлага (Дани, АНУ) талаас нь судалсан болно.

ТҮЛХҮҮР ҮГ

Цахим хэрэгсэл, залилах гэмт хэрэг, цахим орчин дахь залилах гэмт хэрэг, цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэрэг

I. УДИРТГАЛ

1. СЭДЭВ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын “Үндсэн Хууль”[1]-д зааснаар “хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,... эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх” эрхэм зорилгыг тунхагласан. Мөн иргэн бүрийн эдлэх 18 эрхийг хуульчилж өгсөн бөгөөд 16 дугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв

[1] “Монгол Улсын Үндсэн Хууль”, *Legalinfo.mn*, 2024 оны 4 сарын 22-нд үзсэн, https://legalinfo.mn/mn/detail/367.

залгамжлуулах" эрх, тус эрхийн баталгааг хангах үүднээс 19 дүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" хэмээжээ. Гэвч өнөө үед энэхүү Үндсэн Хуулиар хамгаалагдсан иргэний эрх, түүнийг хамгаалах төрийн үүргийг хэрэгжүүлэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд, ялангуяа залилах гэмт хэргийн түвшин, шүүхээр шийдвэрлэгдсэн тоо баримт, нийгэмд учруулж буй хор уршиг газар авсаар байна. Тоо баримт дурьдвал, Цагдаагийн байгууллагад 2010-2019 он буюу сүүлийн 10 жилийн хугацаанд нийт 268.718 гэмт хэрэг бүртгэгдсэний 22.912 буюу 8.5 хувийг "Залилах" гэмт хэрэг эзэлж байна.[2]

Залилах гэмт хэрэг үйлдэгдэх олон арга замтай бөгөөд тэдгээрийн нэг нь цахим хэрэгсэл ашиглах явдал юм**.** Хэдийгээр манай улсын хувьд цахим мэдээллийн орчин 1994 оноос үүсэлтэй боловч жилээс жилд асар хурдтай хөгжиж, өнөө үед гэмт хэрэг үйлдэгчдийн гэмт хэргээ үйлдэж буй арга хэрэгсэл нь цахим орчин болоод байна. Статистик тоон мэдээллээс дурьдахад, цахим орчинд залилуулсан гэмт хэрэг 2015 онд 17, 2016 онд 69, 2017 онд 136, 2018 онд 590, 2019 онд 641 гэмт хэрэг болж тус тус өссөн бөгөөд 2015 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоотой харьцуулахад 37.7 дахин өссөн байна.[3]

Иймд мэдээллийн технологийн хөгжлийг дагаад эрүүгийн эрх зүйн салбарт цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага урган гарч байгаа бөгөөд үүний тулд олон улсын сайн туршлагыг судлах нь хамгийн оновчтой шийдэл болоод байна.

2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Судалгааны зорилго цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэргийн түүний уламжлал шинэчлэл, олон улсын сайн туршлагыг судалж Монгол Улс дахь эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход оновчтой санал дэвшүүлэхэд оршино.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд (1) цахим гэмт хэрэгсэл ашиглаж үйлдсэн залилах гэмт хэргийн түүхэн уламжлал, шинэчлэл, (2) цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийг судлах, (3) цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн гэмт хэргийн практик судалгааг хийх, (4) олон улсын гэрээ, конвенцийг судлах, (5) гадаад орнуудын цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн зохицуулалт, сайн туршлагыг судлах, (6) Монгол Улс дахь цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход оновчтой санал, шийдэл дэвшүүлэх, дүгнэлт үйлдэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн болно.

[2] "Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа", *information.police.gov.mn,* 2024 оны 4 сарын 23-нд үзсэн, https://information.police.gov.mn/resource/information/File/2020/11/20/z27fhu56zjwaq6xm/FRAUD1.pdf.

[3] С.Учрал, Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал (УБ 2022), 3.

3. СУДАЛГААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС

Судалгааны онол, арга зүйн хүрээнд судалгааны ажлын зорилго, зорилтод хүрэхийн тулд хууль тогтоомж, дүрэм журам, ном сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажил, шүүхийн шийдвэр, олон улсын гэрээ, конвенц, гадаад орнуудын Эрүүгийн хууль тогтоомж, сайн туршлагын судлахдаа танин мэдэхүйн шинжлэх ухааны нийтлэг арга болох түүхчлэх, харьцуулах болон анализ, синтез зэрэг аргыг ашигласан болно.

4. СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

Судалгааны ажлын хүрээнд цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэргийн талаарх түүхэн уламжлал шинэчлэл, олон улсын гэрээ, гадаад орнуудын хууль тогтоомжид тусгагдсан байдал, тэдгээрийн ололт амжилтыг судалснаар энэхүү бүтээл нь эрүүгийн салбарын нэг асуудал болоод буй цахим залилангын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход онолын болон практик судалсан бүтээл болоход чиглэгдэж байгаа бөгөөд гагцхүү үүнд бүтээлийн ач холбогдол оршино.

II.ҮНДСЭН ХЭСЭГ

1. ЦАХИМ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ШИНЖ, ОНЦЛОГ

Энэхүү сэдвийн хүрээнд:

- Цахим орчин дахь залилах гэмт хэргийн түүхэн уламжлал,
- Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хууль дахь цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт,
- Цахим орчин дахь залилах гэмт хэргийн бүрэлдэхүүн шинж, түүний онцлог зэргийг судална.

А. Цахим орчин дахь залилах гэмт хэргийн түүхэн уламжлал

Цахим орчин дахь залилах гэмт хэргийн түүхэн уламжлал, шинэчлэл талаас судлахдаа “Залилах” гэмт хэргийг эрүүгийн анхны төрөлжсөн хууль болох 1926 оны “Шүүх цаазын бичиг”-ээс 2002 оны “Эрүүгийн хууль” хүртэлх хугацааг хамруулаа.

БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичигт “Ашгийг хичээж залилан мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан шингээвээс”[4] гэж заасан тодорхойлолт БНМАУ-ын 1929, 1934 оны Шүүх цаазын бичигт хэвээр хадгалагдсан[5] байна. 1942 онд Шүүх цаазын бичиг нэрийг сольж, Эрүүгийн хууль болгон өөрчилж, үүнээс хойш Эрүүгийн хууль гэх нэрээр нэрлэж тогтжээ. Үүнийг дагаад залилах гэмт

[4] Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (УБ, 2011), 307.

[5] С.Нарангэрэл нар, Монгол улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж-нэгэн сэдэвт бүтээл (УБ, 2019), 197.

хэргийн тодорхойлолтыг шинэчилсэн бөгөөд тус эрүүгийн хуулиудад залилах гэмт хэргийг хэрхэн зохицуулныг харьцуулъя.

	1942 оны Эрүүгийн хууль	**1961 оны Эрүүгийн хууль**	**1986 оны Эрүүгийн хууль**	**1993 оны Эрүүгийн хууль**	**2002 оны Эрүүгийн хууль**
Ердийн бүрэлдэхүүний диспозиц	Итгэснийг тэсрүүлж бусдын мөнгө хөрөнгө буюу эрхийг авахын тулд санаатайгаар залилан мэхлэх аргыг хэрэглэвэл	Залилан мэхэлж итгэлийг эвдэх замаар иргэдийн амины хөрөнгө буюу түүнийг эзэмших эрхийг авч ашиглавал	Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар иргэдийн амины эд хөрөнгийг авсан буюу түүнийг эзэмших эрхийг олж авсан		Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан
Ердийн бүрэлдэхүүний санкци	-гурван жил хүртэлх хугацаагаар хорих	-гурван жил хүртэл хугацаагаар хорих, -нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх	-хоёр жил хүртэл хугацаагаар хорих, -нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, -нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох	-гурван жил хүртэл хугацаагаар хорих, -нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, -дөрвөн зуугаас хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох	-хөдөлмөрийн хэлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлмэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, -нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, -нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах
Хүнд-рүүлэх бүрэлдэ-хүүний дисло-зиц	улсын ба олон нийтийн газруудад алдагдал хохирол учруулсан байвал	-зохион байгуулалттай бүлэглэж, -давтан үйлдсэн, -хохирогч этгээдэд их хэмжээний хохирол учруулсан	-давтан -урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн		-давтан, -бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, -албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, -үлэмж хэмжээний хохирол учирсан
Хүндрүүлэх бүрэлдэхүүний санкци	-нэгэн жилээс таван жил хүртэлх хугацаагаар хорьж -хөрөнгийг бүрэн буюу заримыг нь хураах	-хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах, хураахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих	-эд хөрөнгийг хураах, хураахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих	-эд хөрөнгийг хураах, хураахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих -нэг жилээс нэг жил	-эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

				зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, -нэг мянгаас гурван мянга хүртэл	-гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, -хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих
Хүндрүүлэх бүрэлдэхүүний 2 дахь хэсгийн диспозиц			-хохирогчид үлэмж хэмжээтэй хохирол учирсан -онц аюултай резидив гэмт хэрэгтэн хийсэн	-бусдад их хэмжээтэй хохирол учирсан -онц аюултай резидит гэмт хэрэгтэн хийсэн	-урьд нь энэ хэсэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, -их хэмжээний хохирол учирсан
Хүндрүүлэх бүрэлдэхүүний 2 дахь хэсгийн санкци			-эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих	-эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас арван таван жил хүртэлл хугацаагаар хорих	-эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, -таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих
Хүндрүүлэх бүрэлдэхүүний 3 дахь хэсгийн диспозиц					-онц аюултай гэмт хэрэгтэн, -зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, -онц их хэмжээний хохирол учирсан
Хүндрүүлэх бүрэлдэхүүний 3 дахь хэсгийн санкц					-эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих

Залилах гэмт хэргийг түүхэн уламжлал талаас нь авч үзэж шинжилвээс бүхий л цаг хугацаанд үндсэн бүрэлдэхүүнд итгэл эвдэх, хуурч мэхлэх аргаар бусдын

эд хөрөнгийг шилжүүлж авсан байх агуулгыг илэрхийлсэн байх ба хүндрүүлэх бүрэлдэхүүн улам боловсронгуй болж хөгжсөн байна. Харин бүрэлдэхүүний ангиллын хувьд 2002 оны Эрүүгийн хуульд хүндрүүлэх бүрэлдэхүүнд хохирлын хэмжээг зааж, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хуульчлагдаж ирсэн уламжлалыг эвдэн залилах гэмт хэргийг анх удаа үндсэн бүрэлдэхүүнд хэлбэрийн, хүндрүүлэх бүрэлдэхүүнд материаллаг болгон хуульчилжээ. Санкцийн хувьд 1942 оны Эрүүгийн хуульд зөвхөн хорих ял оногдуулахаар хуульчилсан байсан бол 1961 оноос хойш сонгох санкцийг хэрэглэж, мөн засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг нэмж, 2002 оны Эрүүгийн хууль нь үндсэн бүрэлдэхүүнд хорих ялыг баривчлах ял болон өөрчилсөн байдаг.

Залилах гэмт хэргийн үйлдэгдэх аргыг авч үзвэл 1961 оны Эрүүгийн хуульд "Залилан мэхлэх арга нь ямар нэгэн эд зүйлийн тоо, хэмжээ, чанар дүрсийг өөрчлөх, хуурамч бичиг баримт хэрэглэх, захидал бичих зэрэг олон хэлбэртэй байж болно"[6], 1986 оны Эрүүгийн хуульд "гэм буруутай этгээдээс хохирогчийг өөрийн эд хөрөнгөө сайн дураар өөртөө шилжүүлэн өгөхөд хүргэсэн хуурамч арга нь хуурамч бичиг баримт хэрэглэх, өөрийгөө өндөр албан тушаалтан буюу ховор эд зүйлийг гардан хариуцдаг, олдог хүн гэж итгүүлэх, тусгай албаны зориулалттай хувцас хэрэглэх, бусдын нэрээр хуурамч захиа бичих, утсаар ярих, эрхийн хуурамч үнэмлэх үзүүлэх гэх мэт янз бүр байж болно"[7], 1993 оны Эрүүгийн хуульд "ажил гүйцэтгэсэн тухай хуурамч баримтаар цалин хөлс авах, хулгайлсан буюу бусад хууль бус аргаар олж авсан падаан, тасалбар, номер, тээшний зүүлт, тусгай албаны хувцас, тэмдэг, цол хэрэглэж эд юм олж авах, музейд хуурамч бүтээл худалдах, хууль бусаар тэтгэвэр тэтгэмж авах зэрэг олон аргаар үйлдэгдэнэ"[8], 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байсан цаг үед "залилан мэхлэх арга нь худал хэлэх, хуурамч бичиг баримт ашиглах, хуурамч буюу зориулалтын бус эсхүл гологдол эд зүйлээр солио хийх зэрэг олон янз байж болно"[9] гэжээ.

Үе үеийн хуулиудад "Залилах" гэмт хэргийн үйлдэгдэх аргын хувьд нарийн тоочин заах гэж хичээсэн байх боловч эцэст нь гэх мэт олон хэлбэртэй, гэх мэт олон янз байж болно зэргээр төгсгөжээ. Энэ нь "Залилах" гэмт хэрэг тухайн нийгэм, цаг үеийн байдал, хөгжил дэвшлээс шалтгаалан тус гэмт хэргийг үйлдэх арга, хэлбэр өөрчлөгдсөөр ирсэн, цаашид ч өөрчлөгдөж болохыг харуулж байна.

Б. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуул дахь цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт

Цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэргийг 2015 оны эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад "Залилах" гэмт хэрэг хэмээн тусгаж, нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид ангилжээ.

6 БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй-Тусгай анги (УБ, 1979), 216.
7 БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар (УБ, 1989), 197.
8 МУ-ын Дээд Шүүхийн мэдээлэл (УБ, 1997), №3 30.
9 Г.Совд, Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар (УБ, 2002), 223.

Тодруулбал, ЭХТА-ийн 17.3-т залилах гэмт хэргийн үндсэн шинжид “хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хүндрүүлэх шинжид “энэ гэмт хэргийг, албан тушаалын байдлаа ашиглаж, бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” мөн “энэ гэмт хэргийг, байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчилжээ.

“Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах” гэж буюу бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хуурамч бичиг бичиг баримт, эд зүйл, цахим хэрэгсэл, цахим сүлжээ, цахим мэдээлэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, техник хэрэгсэл ашиглах, тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргийг ойлгоно.[10]

В. Цахим орчин дахь залилах гэмт хэргийн бүрэлдэхүүн шинж, түүний онцлог

Юуны түрүүнд **“Залилах” гэмт хэргийн хуульчилсан байдлыг (1)** гэмт хэргийн бүрэлдэхүүн тал, түүний ангилал болон **(2)** гэмт хэргийн бүрэлдэхүүний ангилалтай уялдуулан шинжилье:

1. Б.Содовсүрэн, С.Нарангэрэл нар гэмт хэргийн бүрэлдэхүүнийг объектив, субъектив хоёр талтай байхаар үзэж объект, объектив тал, субъект, субъектив тал гэсэн шинжүүдийг түүндээ хамааруулсан бол бусад эрдэмтэн үндсэн дөрвөн талтай байхаар үзжээ.[11]

Залилах гэмт хэргийн тухайд тус дөрвөн шинжийг авч үзвэл, объект нь бусдын өмчлөх эрх ба халдлагын зүйл нь бусдад залилагдсан эд хөрөнгө, объектив тал нь бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан идэвхтэй үйлдэл, субъект нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүн, субъектив тал нь гэм буруугийн санаатай хэлбэртэй байна.

2. Монгол улсын эрүүгийн эрх зүйд аливаа ухагдахууны ангилал, дарааллыг

[10] Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй тусгай анги (УБ, 2018), 187.
[11] Т.Золбоо, Гэмт хэргийн бүрэлдүүн (УБ, 2023), 88.

бий болгохдоо нийгмийн аюулын байдлыг харгалздаг[12] байна. Гэрт хэргийн бүрэлдэхүүний ангиллын тухайд С.Нарангэрэл гэмт хэргийн бүрэлдэхүүнийг үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй байхаас гадна хэлбэрийн болон материаллаг бүрэлдэхүүн гэсэн ангилалтыг нэмсэн[13] байна.

Залилах гэмт хэрэг нь үндсэн бүрэлдэхүүнд хэлбэрийн шинжтэйгээр буюу хохирлын хэмжээ шаардахгүй хуульчлагдсан байна. Түүнчлэн, тус зүйлийн тайлбарт "Бусдын эд хөрөнгийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар авсан хүн уг эд хөрөнгийг өмчлөгч, эзэмшигчид эргүүлэн өгсөн, бусад байдлаар эд хөрөнгийн эрхийг сэргээсэн бол залилах гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй" гэж хуульчилсан байсныг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байдаг. Иймд үндсэн бүрэлдэхүүн нь хуульд заасан аргаар бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авснаар хангагддаг байна. Харин хүндрүүлэх бүрэлдэхүүнд материаллаг шинжтэйгээр буюу хохирлын хэмжээ шаардах тул мөрдөн шалгах ажиллагаанд хохирол, хор уршгийг заавал тодорхойлох шаардлагатай тулгардаг байна.

Цахим орчинд дахь залилах гэмт хэргийн бүрэлдэхүүн шинж, түүний онцлогийг аваад үзвэл:

Гэмт хэргийн объект: Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг болох бусдын өмчлөх эрх нь цахим хэрэгсэл ашиглаж үйлдэх юм.

Гэмт хэргийн объектив тал: Залилах гэмт үйлдлийн гадаад шинж бөгөөд залилах гэмт хэргийн дизпозицид хуульчилсан "цахим хэрэгсэл ашиглаж залилах" гэх тус аргын тухай "e-mail, message бичиж илгээх, интернет худалдаа хийх нэрээр өөр компани, хүний нэрийн өмнөөс харилцаж, өөрийн данс руу мөнгө шилжүүлэн авах, эзнийг хуурч авсан банкны карт, пин кодыг ашиглан АТМ-ээс мөнгийг авах... зэрэг цахим хэрэгслээр дамжуулан хуурч мэхэлсэн үйлдлүүдийн үр дүнд эх хөрөнгөө шилжүүлж өгсөн байх"[14] гэж тайлбарласан. Уг арга нь өөртөө давхар уламжлалт аргууд болох хуурч, баримт бичиг, эд зүйл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зоирудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж цахим орчинд үйлдэж байгаагаараа объектив талын онцлогийг тодорхойлж байна.

Гэмт хэргийн субъект: Залилах гэмт хэргийн субъект байдаг. Гэвч тус гэмт хэргийн тухайд гэмт этгээд хэн болох нь тодорхойгүй, ихэвчлэн нууц нэр, эсхүл нэргүйгээр цахим орчинд гэмт хэрэг үйлддэгээрээ онцлогтой.

Гэмт хэргийн субъектив тал: Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг. Залилагч нь хүний хэрэгцээнд тулгуурлан амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сэдэлттэй байдаг. Мөн бусдын эд

[12] С.Нарангэрэл, Эрдэнэбулган, Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, үзэл сургамж (УБ, 2019), 27.

[13] Т.Золбоо, Гэмт хэргийн бүрэлдүүн (УБ, 2023), 90.

[14] Х.Доржпалам, Монгол Улсын эрүүгийн эрх зүй-тусгай анги (УБ 2021), 115-116.

хөрөнгийг шилжүүлэн авахдаа өөрийн дансаар бус өөр хүний дансаар авах зэргээр өөрийгээ нууцлах, илчлэхгүй байх санаа, зорилгыг агуулдаг.[15]

2. ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Үүнд:

- *Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн талаарх олон улсын гэрээ, конвенц*
- Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа
- Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргэд гадаад орнуудын авч хэрэгжүүлж буй сайн туршлага
- -Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн практик судалгаа зэргийг авч үзэх юм.

А.Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн талаарх олон улсын гэрээ, конвенц

1. Цахим гэмт хэргийн тухай Будапештын конвенц_

АНУ-ын Холбооны Худалдааны Комисс (Federal Trade Commission)-ын шинээр гаргасан мэдээллээс харахад хэрэглэгчид 2023 онд залилангийн улмаас 10 тэрбум гаруй доллар алдсан гэж мэдээлсэн нь залилангийн алдагдал анх удаа ийм жишигт хүрч байгааг харуулж байна. Энэ нь 2022 онд мэдээлэгдсэн алдагдлаас 14 хувиар өссөн үзүүлэлт юм.[16] Үүнээс үзэхэд, “Залилах” гэмт хэрэг нь хохирол, хор уршиг өндөртэй дэлхий нийтийн асуудал болоод буй нь харагдаж байна. Иймд олон улсын түвшинд залилах гэмт хэргийн тухайд ямар гэрээ, конвенц хэрэгжиж байгааг авч үзэх шаардлагатай байна. Цахим гэмт хэргийн талаарх хамгийн анхны, мөн одоо ч хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын шинжтэй акт бол 2001 онд батлагдсан “Цахим гэмт хэргийн тухай Будапештын конвенц” юм. Манай улс тус конвенцид 2024 оны 4 сард 72 дахь улс болон нэгдэн орсон байна.[17]

Европын Зөвлөлийн ажиглагч Канад, Япон, Филиппин, Өмнөд Африк, АНУ-ын идэвхтэй оролцоотойгоор Францын Страсбург хотноо боловсруулсан тус конвенцийн зорилго нь “Компьютерийн сүлжээ мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, ашиглалтын эсрэг шууд чиглэсэн халдлагыг таслан зогсоох, тийм

[15] С.Учрал, Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал (УБ 2022), 28.

[16] As Nationwide Fraud Losses Top $10 Billion in 2023, FTC Steps Up Efforts to Protect the Public, ftc.gov, 2024.04.22-нд үзсэн, https://www.ftc.gov/news-events/news/press-releases/2024/02/nationwide-fraud-losses-top-10-billion-2023-ftc-steps-efforts-protect-public

[17] The Budapest Convention (ETS No. 185) and its Protocols (Parties), *coe.int*, 2024.04.22-нд үзсэн, https://www.coe.int/en/web/cybercrime/the-budapest-convention

халдлагыг гэмт хэрэг болгон хуульчлах, түүнийг дотоодын болон олон улсын түвшинд илрүүлэх, мөрдөх, яллах, тийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоомж батлах, холбогдох олон улсын итгэмжлэгдсэн, шуурхай хамтын ажиллагааг сайтар зохион байгуулах" юм.[18]

Уг конвенцийн 8 дугаар зүйлд "компьютер ашиглан залилан үйлдэх" гэмт хэргийг тусгасан байна. Тодруулбал, тус конвенцид "Конвенцийн оролцогч талууд хууль батлах, шаардлагатай бусад арга хэмжээ авах замаар бодит мэт ойлголт төрүүлж, худал баримт үйлдэх, компьютерийн өгөгдөл шинээр оруулах, өөрчлөх, устгах, нуух замаар санаатайгаар хуурамч өгөгдөл үүсгэх үйлдэлд дотоодын хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэвч энэ зүйл заалтад заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхийн тулд юуны өмнө хууран мэхлэх үйлдлийн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг Эрүүгийн хуульд хуульчилсан байх шаардлагатай. Үүнд:

а. компьютерийн өгөгдлийг шинээр нэмэх, засах, устгах, нуух;

б. өөрийн буюу бусдад эдийн засгийн ашиг, давуу тал бий болгох, залилан хийх эсвэл залилан мэхлэх зорилгоор компьютерийн сүлжээний үйл ажиллагаанд саад хийх" гэж тусгажээ. Үүнээс үзэхэд, тус конценцид нэгдсэн улс орон тухайн конвенцийг хэрэглэхийн тулд юуны түрүүнд Эрүүгийн хуульд цахим хэрэгсэл ашиглах гэмт хэргийг хуульчилсан байх, тус гэмт хэргийг хуульчлахдаа гэмт хэрэг үйлдэгдэх арга буюу обьектив талыг тусгах шаардлага тавигджээ.

2. Мэдээлэл, харилцаа холбооны технологийг гэмт хэргийн зорилгоор ашиглахтай тэмцэх тухай НҮБ-ын Конвенц

Мэдээлэл, харилцаа холбооны технологийг гэмт хэргийн зорилгоор ашиглахтай тэмцэх тухай НҮБ-ын Конвенц (United Nations Convention on Countering the Use of Information and Communications Technologies for Criminal Purposes) нь хүний эрх, хууль дээдлэх ёсыг дээдлэн цахим ертөнц дэх гэмт хэргийн үйл ажиллагаатай тэмцэх олон улсын хамтын ажиллагааг дэмжих, цогц арга хэмжээг тогтоох зорилготой. Тус конвенцийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 74/247 тоот тогтоолоор санаачилсан бөгөөд хараахан батлагдаагүй байгаа боловч уг конвенцийг 2024 оны 9 дүгээр сард дуусгаж Ерөнхий Ассамблейн 78 дугаар чуулганд өргөн барихаар төлөвлөж байна.[19]

Б. Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Цахим орчин дахь гэмт хэргийн гаралт сүүлийн 4-5 жилийн хугацаанд огцом нэмэгдэж байгаа нь цар тахлаас шалтгаалан хүн бүр цахим орчинд ажиллаж,

[18] Европын олон улсын гэрээний цуврал- Дугаар 185 (Албан бус орчуулга), *rm.coe.int*, 2024.04.22-нд үзсэн, https://rm.coe.int/CoERMPublicCommonSearchServices/DisplayDCTMContent?documentId=09000016802fa427, 2.

[19] FAQ New United Nations Convention on Countering the Use of Information and Communications Technologies for Criminal Purposes (8 August 2022), *unodc.org*, 2024.04.23-нд үзсэн, https://www.unodc.org/documents/Cybercrime/AdHocCommittee/Website/FAQ_on_AHC_Aug_2022.pdf

суралцаж эхэлснээс үүдэлтэй. Forbes сайтын мэдээллээс үзэхэд, дэлхий даяар сошиал медиа хэрэглэгчдийн тоо 4.9 тэрбум хүн болж дээд амжилт тогтоосон ба үүнээс гадна энэ тоо 2027 он гэхэд ойролцоогоор 5.85 тэрбум хэрэглэгч болох төлөвтэй байна.[20] Дээрх тоон баримтад тулгуурлан үзвэл дэлхийн хүн амын 50 гаруй хувь нь цахим сүлжээг идэвхтэй ашиглаж байгаа бөгөөд цаашид ч нэмэгдэх хандлагатай байгааг харж болохоор байна. Цахим орчин хөгжсөн нь хүн төрөлхтөнд олон давуу талыг бий болгосон ч үүний зэрэгцээ олон сөрөг талууд ч харагдах болсон. Үүнээс жишээ дурдвал, 2020 онд Европт фишинг халдлага 718%-иар өсч, 2 сая гаруй фишинг сайтыг Google илрүүлжээ.[21] Иймд энэ төрлийн гэмт хэргийг гадаадын улс орнууд Эрүүгийн хуульдаа хэрхэн тусгасан байдгийг авч үзье.

1. ХБНГУ-ын Эрүүгийн хууль:

ХБНГУ-ын хувьд залилах гэмт хэргийг эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгтээ “Залилах, итгэл эвдэх” хэмээн томъёолж §263 дугаар зүйлд “Залилах” залилах гэмт хэргийг Монгол Улсын нэгэн адил үндсэн бүрэлдэхүүндээ хохирол шаардахгүй буюу хэлбэрийн гэмт хэрэг байхаар хүндрүүлэх бүрэлдэхүүнд хохирол шаардахаар буюу материаллаг гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамааруулжээ.

Түүнчлэн тус хуулийн §263а-т цахим орчин дахь залилах гэмт хэргийг “Комьютерын залилан” хэмээн хуульчилжээ. Үүнд:

(1) Өөртөө болон гуравдагч этгээдэд эд хөрөнгийн давуу байдал үүсгэхийн тулд буруу зохион бүтээсэн программаар, худал эсвэл бүрэн бус мэдээллээр, зөвшөөрөлгүй мэдээлэл ашиглан эсвэл үйл явцад зөвшөөрөлгүйгээр нөлөөлөх зэргээр мэдээлэл боловсруулах ажиллагааны үр дүнд нөлөөлж бусдад хохирол учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ.

(2) Ийм төрлийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор компьютерийн программ үйлдвэрлэх, өөртөө олж авах буюу бусад этгээдэд олж өгөх, зарах, хадгалах эсвэл бусдад үлдээх зэргээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт бэлтгэсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ.

(3) Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан тохиолдлын хувьд энэ хуулийн §149 дүгээр зүйлийн 2 дахь болон 3 дахь хэсэг хамаарна.[22]

Германы Эрүүгийн хуульд цахим орчин дахь залилах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хорих эсвэл торгох ял байхаар зохицуулсан байна. Нэр томъёоны тухайд компьютерын залилан гэж нэрлэсэн нь, мөн диспозицийг “Өөртөө

[20] “Top Social Media Statistics And Trends Of 2024”, *forbes.com*, 2024.04.22-нд үзсэн, https://www.forbes.com/advisor/business/social-media-statistics/#source

[21] “How Are The World’s Biggest Countries Dealing With Online Fraud?,” *vpnoverview.com*, 2024.04.22-нд үзсэн, https://vpnoverview.com/internet-safety/cybercrime/how-countries-deal-with-online-fraud-and-cybercrime/

[22] Ж. Эрдэнэбулган, М. Уянга, Б. Тамир, Б. Батбаяр, Т. Золбоо (орч), *“Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль*”, (УБ 2021), 456-457.

болон гуравдагч этгээдэд эд хөрөнгийн давуу байдал үүсгэхийн тулд буруу зохион бүтээсэн программаар, худал эсвэл бүрэн бус мэдээллээр, зөвшөөрөлгүй мэдээлэл ашиглан эсвэл үйл явцад зөвшөөрөлгүйгээр нөлөөлөх зэргээр мэдээлэл боловсруулах ажиллагааны үр дүнд нөлөөлж" хэмээн тодорхойлсон нь сайшаалтай байна.

2. БНСУ-ын Эрүүгийн хууль:

БНСУ-ын хувьд залилах гэмт хэргийг эрүүгийн хуулийн 39 дүгээр бүлэгт "Залилах, заналхийлэх" гэж томьёолжээ. Тодруулбал, §347-р зүйлд "Залилах" гэмт хэргийг (① Бусдыг хууран мэхлэх замаар эд хөрөнгө авсан, эд хөрөнгийн ашиг олж авсан этгээдийг 10 жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл 20 сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. ② Гуравдагч этгээд эд хөрөнгө хүлээн авсан эсвэл эд хөрөнгийн ашиг сонирхлыг олж авсан тохиолдолд шийтгэл нь мөн адил байна.), §347-2-р зүйлд цахим орчин дахь залилах гэмт хэргийг "Компьютер зэргийг ашиглан залилах" хэмээн хуульчилжээ.

Үүнээс цахим орчин дахь залилах гэмт хэргийг дэлгэрүүлэн авч үзвэл, компьютер зэрэг мэдээлэл боловсруулах төхөөрөмжид худал мэдээлэл, хууль бус тушаал оруулах замаар эд хөрөнгийн ашиг сонирхлыг олж авах, гуравдагч этгээдийг олж авахад хүргэх, эсхүл эрхгүйгээр мэдээлэл оруулах, өөрчлөх, мэдээлэл боловсруулсан этгээдийг 10 жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсвэл 20 сая воноос хэтрэхгүй торгууль ногдуулна[23] гэжээ.

Солонгос улсын хувьд цахим орчин дахь гэмт хэргийн санкцыг нарийн тооцож, хорих ял, торгуулийн дүнгийн дээд хязгаарыг тогтоож өгсөн нь давуу талтай зохицуулалт болсон байна.

3. ОХУ-ын Эрүүгийн хууль:

ОХУ-ын эрүүгийн хуулийн 159.1 дүгээр зүйлд залилах гэмт хэргийн үндсэн шинжийг "Залилан мэхлэх буюу бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг хуурч мэхлэх эсхүл итгэл эвдэх замаар олж авсан бол" гэж тодорхойлсон бөгөөд 6 зүйлээр хүндрүүлэх шинжийг тогтоосон байна. Үндсэн бүрэлдэхүүний хувьд ял шийтгэлийг "120000 хүртэл рубль эсхүл ялтны нэг жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 360 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл дөрвөн сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж тогтоосон байна. Хүндрүүлэх шинжийн хувьд үйлдлийн арга, хохирлын хэмжээ зэргээс хамааран торгох, албадан ажил хийлгэх, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хорих ялаас сонгож хэрэглэх санкцитай байхаар зохицуулжээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн хувьд цахим хэрэгсэл ашиглаж үйлдэгдсэн залилах гэмт хэргийг хоёр хэсэгт ангилан үзжээ. Үүнд: (а) Цахим төлбөрийн хэрэгсэл

[23] 형법, law.go.kr, 2024.04.24-нд үзсэн, https://law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EB%B2%95

ашиглаж залилах, (б) Компьютерийн мэдээллийн салбарт залилан хийх гэмт хэрэг хамаарч байна.

Эрүүгийн хуулийн 159.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Цахим төлбөрийн хэрэгсэл ашиглаж залилан хийсэн бол 120000 хүртэл рубль эсхүл ялтны нэг жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 360 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл дөрвөн сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж зохицуулсан бөгөөд хүндрүүлэх шинжид урьдчилан үгсэн тохирсон бүлэг үйлдсэн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл онц их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол ялыг ялгамжтай байхаар зохицуулжээ. Мөн 159.6 дугаар зүйлд "Компьютерийн мэдээллийн салбарт хууран мэхлэх буюу компьютерийн мэдээллийг оруулах, устгах, хаах, өөрчлөх эсхүл компьютерийн мэдээлэл хадгалах хэрэгслийн үйл ажиллагаанд оролцох, компьютерийн болон мэдээлэл харилцааны сүлжээг дамжуулан хийх замаар бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулсан бол 120000 хүртэл рубль эсхүл ялтны нэг жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл 360 цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл дөрвөн сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж хүндрүүлэх бүрэлдэхүүнд гэмт хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн, их хэмжээний хохирол учруулсан, албан тушаалын байдлаа ашиглаж, их хэмжээгээр, банкны данс, цахим мөнгөний хувьд үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг, эсхүл онц их хэмжээгээр үйлдсэн бол хүндрүүлэх шинжид тооцохоор хуульчилсан байна.[24]

ОХУ-ын хувьд цахим орчинд үйлдсэн гэмт хэргийг хоёр хэсэгт ангилан, хэсэг бүрийг үндсэн болон хүдрүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчилсан байна.

Дээр дурдсанчлан Герман, Солонгос, Орос улсын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд цахим орчин дахь залилах гэмт хэргийг "компьютерийн залилан, компьютерийн хэрэгсэл ашиглан залилах, цахим төлбөрийн хэрэгсэл ашиглаж залилах, компьютерийн мэдээллийн салбарт залилан хийх" зэргээр тусгай зүйлчлэл бүхий гэмт хэрэг гэж үзэж, залилах гэмт хэргээс тусад нь авч үзэж зохицуулсан байна. Энэ нь гэмт этгээдийн үйлдлийн аргыг нарийн тодорхойлж, тэдгээрт ялгамжтай байдлаар ял оногдуулах болон цаашид гарч болох гэмт үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх юм.

В. Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргэд гадаад орнуудын авч хэрэгжүүлж буй сайн туршлага

[24] Ж. Эрдэнэбулган, М. Уянга, Б. Тамир, Б. Батбаяр, Т. Золбоо (орч), *"Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль"*, (УБ 2021), 157-160.

Цахим гэмт хэргийн гаралт, өсөлт, бууралтын түвшин улс орон бүрт харилцан адилгүй байдаг. Тэгвэл манай улсын хувьд 2022 оны 10 сарын байдлаар нийт 31 мянга орчим гэмт хэрэг бүртгэгдсэнээс 32.8 хувь буюу 10 мянга орчим гэмт хэргийг зөвхөн залилах гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 97.3 хувиар нэмэгдсэн тоон үзүүлэлт бөгөөд залилах гэмт хэргийн 88.2 хувийг цахим залилангийн хэрэг эзэлж байна.[25] Иймд тус гэмт хэргийн тоон үзүүлэлтийг багасгахын тулд гадаад орнуудын сайн туршлагыг судлах шаардлагатай. Иймээс юуны түрүүнд кибер аюулгүй байдал сайтай орнууд авч үзье.

SEON-ны судалгаагаар кибер аюулгүй байдал сайн орнуудыг Дани улс (8.91 оноо) тэргүүлж, Герман, АНУ, Норвеги, Их Британи, Канад, Швед, Австрали, Япон, Нидерланд улсууд удаах байранд жагсжээ. Харин кибер аюулгүй байдал хамгийн сул улсуудад Мьянмар, Камбож, Гондурас, Болив, Монгол, Алжир, Зимбаб зэрэг улсууд орсон байна.[26] Учир нь эдгээр улсууд нь кибер гэмт хэргийн талаар тодорхой хууль тогтоомжтой байхгүй, эсвэл хууль тогтоомжийн хэрэгжилт сул тул хувийн мэдээлэлтэй холбоотой гүйлгээнд ихээхэн эрсдэл дагуулж байдаг байна. Монгол улсын тухайд кибер аюулгүй байдлын оноо 3.25 байх ба уг төрөлд тэргүүлэгч Дани улсынхаас даруй 5.66 оноогоор бага байна**.**

Иймд Кибер аюулгүй байдал сайтай улсуудын туршлагыг судлах замаар авсан оноогоо ахиулах боломжтой гэж үзэж, залилах гэмт хэрэгтэй тэмцэж буй туршлагыг Дани болон АНУ-ын туршлагыг судаллаа.

1. Дани

Хууль тогтоомжийн хувьд Данийн 2012 оны Эрүүгийн хууль (Straffeloven)-д залилан мэхлэх, түүний дотор уламжлалт залилангийн хэлбэр, цахим хэрэгслээр үйлдэгдсэн гэмт хэрэг гэх хэсгүүдийг хуульчилжээ. Тус хуулийн Өмчийн эсрэг гэмт хэргийн тухай зохицуулсан 28-р бүлгийн §279-д залилах гэмт хэргийн тухай зохицуулдаг бол §279a-д фишинг, хувийн мэдээллийг хулгайлах, онлайн луйвар зэрэг гэмт хэргийг хамарсан компьютертэй холбоотой залилан мэхлэхийг тусгайлан авч үзсэн байдаг.

Мөн Дани улсад цахим гэмт хэрэг, тэр дундаа цахимаар үйлдэгдсэн залилан мэхлэх гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй *хууль сахиулах тусгай нэгжүүд* байдаг байна. Уг нэгж нь 2019 онд үүсгэн байгуулагдсан Данийн Үндэсний цагдаагийн газрын дэргэдэх Кибер гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний төв (NC3)-ийн Үндэсний эрүүгийн мөрдөн байцаах албаны (NCIS) нэг хэсэг юм. Тус төв нь дүүргийн цагдаагийн хэлтэст туслалцаа үзүүлж, цахим гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг бие даан явуулахын зэрэгцээ цагдаагийн байгууллагын мэдлэг, арга зүйг хөгжүүлдэг байна.[27] Ерөнхийдөө цахим орчинд эргүүл хийх замаар цахим орчин дахь гэмт

[25] "35-аас дээш насныхан цахим гэмт хэргийн хохирогч болж байна", *news.mn*, 2024.04.24-нд үзсэн, https://news.mn/r/2603791/

[26] Мөн тэнд.

[27] National Cybercrime Centre (NC3), *politiet.no,* 2024.04.23-нд үзсэн, https://www.politiet.no/en/

хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тус гэмт хэрэг гарсан тохиолдолд нотлох баримт цуглуулах, хэрэгтнийг илрүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна.

Түүнчлэн, Дани улс иргэд, аж ахуйн нэгжүүдийг залилан мэхлэхтэй холбоотой цахим гэмт хэргийн эрсдэл, ийм аюулаас хэрхэн хамгаалах талаар олон нийтэд сурталчлах кампанит ажил, сургалт зохион байгуулдаг байна. Эдгээр нь нийтлэг залилангийн схемийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, кибер аюулгүй байдлын шилдэг туршлагыг хэрэглэгчдэд таниулах, сэжигтэй үйлдлүүдийг хууль сахиулах байгууллагад мэдээлэх, мэдээ мэдээллээр хангах, мэдээлэл өгөгчдийг дэмжих зорилготой юм.

Дани улсын Хэрэглэгчийн омбудсмен (Forbrugerombudsmanden) бусад төрийн байгууллагууд болон холбогдох талуудтай хамтран санаачлан хэрэгжүүлж буй "Залиланг зогсоох" кампанит ажил нь Дани улсад олон нийтийн залилан мэхлэлтийг таниулах кампанит ажил юм. Энэхүү кампанит ажил нь цахим залилан, хувийн мэдээллийг хулгайлах, санхүүгийн залилан гэх мэт янз бүрийн хэлбэрийн залилан мэхлэх гэмт хэргийг таних, урьдчилан сэргийлэхэд хэрэглэгчдэд мэдлэг олгох, чадавхжуулах зорилготой юм.

2. АНУ

АНУ-ын хууль сахиулах байгууллагын тайланд бүхий л төрлийн цахим гэмт хэрэг үйлдэгчид жилд 1.5 их наяд ам долларын хохирол бусдад учруулдаг гэжээ. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийн нийт орлого хамгийн багадаа 1.5 их наяд ам доллартай тэнцэж байгаа юм. Улмаар цахим гэмт хэргийн хохирол жил бүр 11 орчим хувиар нэмэгдэж, ирэх 5 жилийн хугацаанд 3-5 их наяд ам.долларт хүрч болзошгүй хэмээн салбарын мэргэжилтнүүд тооцоолоод байна.

АНУ нь дараах байгууллагуудаар дамжуулан цахим орчин дахь залилах гэмт хэрэгтэй тэмцдэг. Үүнд:

1. Интернет гэмт хэргийн гомдол хүлээн авах төв (IC3): IC3 нь кибер гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь интернетийн гэмт хэрэгтэй холбоотой гомдлыг цуглуулж, дүн шинжилгээ хийж, ач холбогдолтой ойлголтыг өгч, хууль сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг.

- Гол чиг үүрэг нь чиг хандлагыг хянах, кибер аюулыг судлах, цаашид хохирогч болохоос урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх зэрэг орно.[2]

2. Нууц албаны Кибер залилантай тэмцэх ажлын хэсэг: АНУ нь нууц алба цахим сүлжээгээр дамждаг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор энэхүү ажлын хэсгийг байгуулсан. Тус байгууллагын эрхэм зорилго нь кибер залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, бууруулахад чиглэгддэг бөгөөд эцсийн зорилго нь хортой гэмт хэрэгтнүүдийг баривчлах, яллах явдал юм[3].

3. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хэсэг (ECTFs): Цахим гэмт хэрэгтэй

om-politiet/organisasjonen/specialist-agencies/kripos/key-roles-of-ncis/national-cybercrime-centre/

тэмцэх ажлын хэсэг нь АНУ-ын Нууц Албанаас хамгаалдаг ECTF нь халдлага, банкны луйвар, мэдээлэл зөрчсөн болон компьютертэй холбоотой бусад гэмт хэрэгт холбогдсон олон улсын кибер гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, илрүүлэхэд чиглэдэг[4].

4. Залилантай тэмцэх шинэ хандлага: АНУ залилантай тэмцэх шинэ хандлагад мэдлэг, боловсрол, илрүүлэлтийн ажиллагааг түргэсгэх буюу цахим хэрэгсэл ашиглаж халдлагыг илрүүлэх, мөрлөн шалгах ажиллагаандаа хиймэл оюун ухааныг хэрэглэхээр туршиж байна.[5]

Үүнээс дүгнэхэд, Дани болон АНУ-ын жишээн дээр авч үзэхэд тухайн улсууд цахим гэмт хэрэг тэр дундаа цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэрэгтэй тэмцэх тусгай нэгжийг байгуулсан байна. Мөн иргэдийн энэ талын боловсролын хангах талаар арга хэмжээ авч байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсооход мэргэжлийн байгууллага, техник, технологи болон албан тушаалтнуудаас гадна иргэдийн оролцоо чухал болохыг харуулж байна.

Г.Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн практик судалгаа

ФАТФ-ийн 40 зөвлөмжид “мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг түүний дотор өргөн хүрээний суурь гэмт хэргийг тооцно”[28] гэж үзсэн байдаг. Үүнээс үзвэл “Залилах” гэмт хэрэг ч мөн мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болдог байна. 2020-2023 оны хугацаанд буюу сүүлийн 4 жилийн дунджаар нийт мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн 8.2 хувийг “Залилах” гэмт хэрэг эзэлж байна. Тодруулбал, 2020 онд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн 6 хувь, 2021 онд 2 хувь, 2022 онд 11 хувь, 2023 онд 14 хувийг эзэлж байгаа нь тус гэмт хэрэг нийгэмд асар их хохирол дагуулдаг мөнгө угаах гэмт хэргийн дэвсгэр болон хөгжих хандлагатай байгааг илтгэж байна.

Мөн түүнчлэн, залилах гэмт хэрэг нь хохирогч, сэжигтэн хоёр бие биенээ тодорхой хэмжээнд мэддэг, эд хөрөнгийн болон санхүүгийн харилцаа үүсгэх хэмжээний итгэлцэл үүссэн байдаг онцлогтой гэмт хэрэг мөн. Гэтэл эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийн тоо сүүлийн 4 жилд өссөн нь гэмт хэргийн гаралт өссөн үндсэн шалтгаанаас гадна 2 шалтгаантай юм.

1. Нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэст шалгагдаж байгаа энэ төрлийн гэмт хэргийг мэдээллийн санд бүртгэхдээ эзэнгүйгээр бүртгээд тодорхой хугацааны дараа эзэн холбогдогчийг тогтоосон байдлаар нөхөн бүртгэдэг.

2. Цахимаар залилуулсан гэмт хэргийн дийлэнх нь үл таних хүнд залилуулсан учир эзэн холбогдогч нь тогтоогдоогүй шалгагдаж байгаа шалтгаанууд нь хэргийн тоо өссөн.[29] Тус судалгаанаас үзэхэд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй залилах гэмт

[28] ФАТФ (2012-2019), Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, 12 дахь тал, www.mongolbank.mn, 20180531F2.pdf (mongolbank.mn).

[29] “ЗАЛИЛАХ” ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ,

хэрэг 2010 онд 65, 2011 онд 69, 2012 онд 136, 2013 онд 68, 2014 онд 196, 2015 онд 224, 2016 онд 305, 2017 онд 1980, 2018 онд 3972, 2019 онд 2963 болж өссөн бөгөөд үүн дотор цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг 2015 онд 17, 2016 онд 69, 2018 онд 590, 2019 онд 641, 2023 онд 7905[30] болж өссөн байгаа нь цахим орчин дахь иргэдийн хэрэглээ нэмэгдсэнийг дагаж хэрэгтнүүдэд ч бодит орчинд гэхээсээ илүү цахим орчинд өөрийгөө үл таниулах замаар хурдан хугацаанд олон хүнийг хамарсан залилах гэмт хэрэг үйлдэх боломж бүрдсэнтэй холбоотой юм.

Түүнчлэн, практикт үйлдэгдэж буй нийт залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг мэдэх нь тус гэмт хэргийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход ихээхэн ач холбогдолтой тул shuukh.mn сайтад оруулсан сүүлийн 3 сарын хугацаанд Эрүүгийн хэргийн АШШ-ээр шийдвэрлэгдсэн 96 гэмт хэргийг судлалаа. Судалгаагаар цахим орчин дахь залилах гэмт хэрэг нь дараах аргаар үйлдэгддэгийг олж мэдэв. Үүнд:

- Гэмт этгээд өөрийгөө аав, ээж, эгч, ах зэрэг гэр бүл, танил, найз нөхөд нь гэж итгүүлэх;
- Бараа бүтээгдэхүүн зарна гэсэн хуурамч зар байршуулж, улмаар зарын дагуу холбогдсон хохирогчийг хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгож, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж, мөнгө авч залилах;
- Ямар нэгэн их сургуульд оруулж өгнө, эсэ бичнэ гэх утга бүхий мэдээллийг цахим орчинд оруулсны дагуу түүнтэй холбогдсон хохирогчоос мөнгө авч залилах;
- Онлайн шоп ажиллуулж, урьдчилсан захиалга авах замаар цахим хэрэгсэл ашиглан урьдчилгаа төлбөр авч залилах;
- Фэйсбүүк зарын групп дээр тавилга хийнэ гэсэн зараар хүмүүсээс урьдчилгаа төлбөр авч залилах;
- Зээлийн төв гэх хуурамч цахим хаяг үүсгэж, хохирогчтой харилцаж барьцаагүй зээл олгоно гэж зохиомол байдлыг зориудаар бий болгон түүний виза картны мэдээллийг авч хохирогчийн эзэмшлийн данснаас мөнгө авч залилах;
- Зуслангийн эрхийн бичиг зарна, хамтлагийн тоглолтын тасалбар зарна, виз гаргаж өгнө хэмээн (фейсбүүк орчинд) хуурч, мөнгө авч залилах;
- "Санхүү авна" гэсэн хуурамч зар оруулж зарын дагуу холбогдсон хүмүүсийг залилах;
- Фэйсбүүк орчинд "Заалны захиалга авна", "Зуслангийн байшин өдрөөр түрээслүүлнэ" гэсэн хуурамч зарууды байршуулан мөнгө авч залилах;

СУДАЛГАА, *information.police.gov.mn*, 2024.04.25-нд үзсэн, https://information.police.gov.mn/resource/information/File/2020/11/20/z27fhu56zjwaq6xm/FRAUD1.pdf


[30] "Кибер гэмт хэргийн 83 хувийг эзэлдэг цахим залилан 2020 онд 189 бүртгэгдэж байсан бол 2023 онд 7905 болж өссөн", *newswire.mn*, 2024.04.26-нд үзсэн, https://newswire.mn/n/33604

- Солонгос улсын ажилчдын гэрээний шалгалтад тэнцүүлж, бүртгүүлж өгнө", "доллар болгож мөнгө олж өгнө" гэж хуурч, мөнгө авч залилах зэрэг маш олон аргаар гэмт хэрэг үйлдсэн байна.

Энэ нь нэг талаас иргэдийн итгэмтгий бөгөөд хянуур бус зан, амар хялбар аргаар асуудлаа шийдүүлэх гэсэн эрмэлзэл дээр тулгуурлан үйлдэгдсэн байна. Оногдуулж буй ялын тухайд, шүүхээс 2018-2020 оны эхний хагас жилд залилах гэмт хэргийг шийдвэрлэхдээ 56 хувьд нь торгох, 15 хувь нь нийтэд тустай ажил хийлгэх, 12 хувьд нь хорих ял тус тус оногдуулж, 16 хувьд нь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн, 2 хувийг нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн нь ялын үр нөлөө хангалтгүй байна гэж дүгнэхэд хүргэсэн.[31] Үүн дээр нэмээд, ялын бодлогын тухайд цахим орчинд үйлдсэн залилах гэмт хэргийн хувьд торгох ял дийлэнх хэсгийг эзэлж байх тул уг ял гэмт хэрэг үйлдэгсдэд хэр ач холбогдолтой, мөн гэмт хэргийн гаралтыг бууруулж буй эсэхэд судалгаа, шинжилгээ хийх шаардлагатай байна.

Залилах гэмт хэргийн хохирогчдын насны тухайд авч үзвэл, 2010-2019 оны хооронд хохирсон иргэдийн 27.1 хувь нь 18-29 насны, 32.1 хувь нь 30-39 насны, 23 хувь нь 40-49 насны, 11 хувь нь 50-59 насны, 4.5 хувь нь 60 аас дээш насныхан байна.[32]

Диаграм №1. Хохирогчдыг насны байдлыг харуулав.



Дээрх үзүүлэлтээс харахад, 18-49 настай иргэд хамгийн их залилах гэмт хэргийн хохирогч болдог тоон үзүүлэлт харагдаж байна. Тодруулбал, цахим орчин дахь залилах гэмт хэрэгт 30-34 насны хүмүүс хамгийн их хохирдог байна. Энэ нь дээр дурдсан ах, дүү, найз нөхөд, танилдаа гэж итгэж мөнгө зээлэх, мөнгө зээлэхээр холбогдоод урьдчилгаа шилжүүлэх, бараа бүтээгдэхүүн авахаар төлбөр төлөх зэрэг нийтлэг байдлаар хохирсон байх боломжтой байна. Иймд бид энэ талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл түгээх үүднээс "Бүү шилжүүл-unsend" аяныг хэрэгжүүлж цахим орчинд өөрийн мэдээллийг хамгаалах, залилангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч болно. Мөн хохирогч дунд 18-24 насныхан мөн өндөр байр суурь эзэлж байгаа юм. Иймээс хүүхдэд багаас нь ерөнхий боловсролын сургуульд сурч байх үеэс нь энэ төрлийн гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хувийн мэдээллээ хэрхэн хамгаалах талаар сургалт зохион байгуулаж, эрх зүйн суурь мэдлэгийг тогтмол, системтэй олгох хэрэгтэй.

[31] Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа- Цуврал 2, 2022

[32] "ЗАЛИЛАХ" ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, *information.police.gov.mn*, 2024.04.25-нд үзсэн, https://information.police.gov.mn/resource/information/File/2020/11/20/z27fhu56zjwaq6xm/FRAUD1.pdf

ДҮГНЭЛТ

Эцэст нь дүгнэхэд:

Түүхэн уламжлал талаас үзвэл залилах гэмт хэрэг 1926 оны анхны төрөлжсөн Эрүүгийн хууль тогтоомжид тусгагдаж, үйлдэгдэх аргын хувьд гэх мэт, гэх зэрэг олон аргаар үйлдэгдэнэ хэмээн нээлттэй зохицуулагдаж ирсэн байдаг. Хэлбэрийн хувьд хамгийн анх 2015 оны Эрүүгийн хуульд “цахим хэрэгсэл ашиглаж” гэж тусгагдаж зохицуулагдах болсон байна.

2001 онд Цахим гэмт хэргийн тухай Будапештын конвенци бий болж, дэлхийн улс орнууд тус конвенцид нийцүүлэн дотоодын эрүүгийн хуулиа сайжруулсаар байна. Хэдийгээр манай уллс цахим хэрэгсэл гэх тодотголыг Эрүүгийн хуулиндаа оруулан хуульчилсан нь нэг дэвшилттэй алхам болсон хэдий ч ОХУ, ХБНГУ, БНСУ-ын эрүүгийн хуулиудыг аваад үзвэл цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн гэмт хэргийг залилах гэмт хэргээс тусдаа бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан явдал ажиглагдаж байна. Манай улс ч мөн тус конвенцид нийцүүлэн эрүүгийн хуулиа шинэчлэх, компьютер ашиглан залилан үйлдэх гэмт хэргийг тусгайлан нэг гэмт хэрэг гэж авч үзэх хэрэгцээ тулгараад байна. Энэ нь цаашлаад тухайн улсад олон улсын гэрээ конвенцийг ашиглах боломжийг бүрдүүлэх, оновчтой ял оноох, тус гэмт хэргийн гаралтыг багасгах, гэмт этгээд үйлдлээ давтан хийх, илүү мэргэших боломжийг хумих зэрэг олон давуу талтай.

Мөн манай улс SEON-ны хийсэн судалгаагаар цахим аюулгүй байдал хамгийн сул 10 улсын тоонд багтсан. Энэ нь Монгол Улс цахим орчин дахь залилах гэмт хэргийн талаарх зохицуулалт хангалттай бус гэдгийн нэг илрэл. Түүнчлэн, тус гэмт хэргийн хохирогчдын хувьд ихэвчлэн 18-49 насныхан байх бөгөөд энэ анги цахим хэрэгсэл хамгийн их ашигладаг хэдий ч цахим орчинд залилах гэмт хэргйин тухайд мэдлэг мэдээлэл дутуу, нөгөө талаас тус гэмт хэргийг таниулах компанит ажил, сургалт, таниулах ажиллагаа манай улсад маш дутмаг байдагтай холбоотой. Тиймээс юуны түрүүнд манай улс иргэдэд тус гэмт хэргийг таниулах сурталчлах зорилгоор компанит ажил авч хэрэгжүүлэх, нөгөө талаар цахим залилантай тэмцэх тусгай алба байгуулах шаардалагатай байна.

Цахим орчин дахь залилах гэмт хэрэг нь өөрийн гэсэн зүй тогтол, онцлог шинжтэй бөгөөд уламжлалт залилах гэмт хэргийг цахим орчинд үйлдэж их хэмжээний хохирол дагуулдагаараа онцлог. Шүүхийн шийтгэх тогтоолоос үзэхэд ихэвчлэн мөнгө зээлэх, гуйх, бараа зарах, хийх нэрийдлээр урьдчилгаа төлбөр авах, виз, сургуулийн холбогдолтой залилан мэхлэх хэрэг харьцангуй өндөр давтамжтай илэрсэн байна. Энэ нь цахим орчинд залилах гэмт хэргийг тусад нь авч үзээгүйгээс ялын бодлого харьцангуй сул байгаатай холбоотой. Ял шийтгэлийн хувьд цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэргийн тус хоёр ангилалд буюу ОХУ-ын нэгэн адил авч үзэж хуульчилбал сайн байна.

IV.САНАЛ

Дээрхтэй уялдаж дараах саналыг дэвшүүлж байна.

1. Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох

А) Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс цахим хэрэгсэл ашиглаж гэдгийг хасаж 17.3’ хэсэг нэмж цахим орчинд залилах, цахим хэрэгсэл ашиглаж залилах гэж ялгаатай байдлаар хуульчлан зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

- Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэдэгт “Компьютер, гар утас болон бусад дижитал хэрэгсэл ашиглах замаар бусдыг хуурч, мэхлэх буюу компьютерийн мэдээллийг оруулах, устгах, хаах, өөрчлөх эсхүл компьютерийн мэдээлэл хадгалах хэрэгслийн үйл ажиллагаанд оролцох, компьютерийн болон мэдээлэл харилцааны сүлжээг дамжуулан хийх замаар бусдын эд хөрөнгийг ашиглан залилсан”,
- Цахим орчинд залилах гэдэгт “Цахим орчинд зохиомол байдлыг зориудаар бий болгох, эсхүл сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух, зохиох замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл цахим сүлжээн дэх нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол” хэмээн хуульчлах;

Б) Мөн хүндрүүлэх шинжид:

- 2.1.бусдын нэрийг барьж, харлуулах замаар үйлдсэн;
- 2.2.бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн

В) Онц хүндрүүлэх шинжид:

- 3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;
- 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хэмээн хуульчлах;

2. Олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх

Энэ талын олон нийтийн боловсролын ажиллагааг нас, насны онцлогт тохируулан авч хэрэгжүүлэх. Үүнд:

- Бага насны хүүхдүүдийн хувьд цахим орчин гэж юу болох, хэрхэн зөв зохистой хэрэглэх талаар үлгэрийн ном, хүүхэлдэйн кино бүтээх, цэцэрлэг, сургуулийн сургалтын хөтөлбөрт багтааж таниулах ажиллагааг явуулах;
- Дунд буюу өсвөр насны хүүхдүүдийн хувьд цахим орчныг зөв хэрэглэх, цахим орчинд ямар төрлийн гэмт хэргүүд үйлдэгддэг болох, түүнээс хэрхэн урьчилан сэргийлэх, хохирсон тохиолдолд хаана хандах, энэ тухай иргэний ёс зүйн боловсрол хичээлийн хөтөлбөрт багтаах, уралдаан тэмцээн зохион байгуулах;
- Насанд хүрэгчдийн хувьд хамгийн их үзэгчтэй нөлөөлөгчдийн сувгаар дамжуулан контент бэлтгэх, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах, хохирсон тохиолдолд хаана

хандах зэрэг мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүртээх;

2. Цахим орчин дахь залилах гэмт хэрэгтэй тэмцэх тусгай алба байгуулах
3. Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглах

- Их хэмжээний өгөгдөл багтсан мэлээлэл хадгалах, бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр залилан мэхлэх үйлдэл байгаа эсэхийг хурдан, үнэн зөв тогтоох, одоо байгаа техникээс зайлсхийх буюу хамгийн шинэ программ хангамжийг ашиглах нь чухал байна. Цахим орчинд байгаа залилангын гэмт хэргийн эсрэг чухал хэрэглэгдэхүүн техникүүд нь:
  - Мэдээлэл олборлох, өгөгдлийг ангилах, бүлэглэх, залилан мэхлэхтэй холбоотой загварыг илтгэх холбоо, дүрмийг автоматаар тодорхойлох,
  - Луйвар илрүүлэх туршилтыг дүрмийн хэлбэрээр програмчлах тусгай системүүд бүрдүүлэх,
  - Зан төлөвийг таних эсхүл зан төлөвийг автоматаар эсхүл тодорхой оролтод нийцүүлэн тодорхой ойлгох боломжийг олгох,
  - Луйварын шинж чанарыг автоматаар илрүүлэх машины сургалтын техникүүд нь сэжигтэй хэв маягийг сурч дараа нь таних боломжтой мэдрэмжийн сүлжээ бий болгох зэрэг байдлаар тэмцэх.

III. НОМ ЗҮЙ

1. Ном, сурах бичиг

1. *Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал*. УБ, 2011.
2. С.Нарангэрэл нар. *Монгол улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж-нэгэн сэдэвт бүтээл*. УБ, 2019.
3. *БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй-Тусгай анги.* УБ, 1979.
4. *БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар.* УБ, 1989.
5. *МУ-ын Дээд Шүүхийн мэдээлэл №3.* УБ, 1997.
6. Г.Совд. *Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар*. УБ, 2002.
7. Б.Энхболд. *Эрүүгийн эрх зүй тусгай анги*. УБ, 2018.
8. Т.Золбоо. *Гэмт хэргийн бүрэлдүүн*. УБ, 2023.
9. Х.Доржпалам. *Монгол Улсын эрүүгийн эрх зүй-тусгай анги*. УБ, 2021.
10. Ж. Эрдэнэбулган нар. *Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль.* УБ, 2021.
11. С.Учрал. *Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн асуудал /Бакалаврын судалгааны ажил/.* УБ, 2022.

2. Цахим эх сурвалж

1. Европын олон улсын гэрээний цуврал- Дугаар 185 (Албан бус орчуулга), *rm.coe.int*, 2024 оны 4 сарын 22-нд үзсэн, https://rm.coe.int/CoERMPublicCommonSearchServices/DisplayDCTMContent?documentId=09000016802fa42.
2. Залилах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа", *information.police.gov.mn,* 2024 оны 4 сарын 23-нд үзсэн, https://information.police.gov.mn/resource/information/File/2020/11/20/z27fhu56zjwaq6xm/FRAUD1.pdf.
3. «35-аас дээш насныхан цахим гэмт хэргийн хохирогч болж байна», *news.mn*, 2024 оны 4 сарын 24-нд үзсэн, https://news.mn/r/2603791/.
4. ФАТФ (2012-2019), Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, *www.mongolbank.mn*, 20180531F2.pdf (mongolbank.mn).
5. "ЗАЛИЛАХ" ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, *information.police.gov.mn*, 2024 оны 4 сарын 25-нд үзсэн, https://information.police.gov.mn/resource/information/File/2020/11/20/z27fhu56zjwaq6xm/FRAUD1.pdf.
6. "Кибер гэмт хэргийн 83 хувийг эзэлдэг цахим залилан 2020 онд 189 бүртгэгдэж байсан бол 2023 онд 7905 болж өссөн", *newswire.mn*, 2024 оны 4 сарын 26-нд үзсэн, https://newswire.mn/n/33604.
7. Нээлттэй нийгэм форум, Шүүхийн шийдвэрийн судалгаа- Цуврал 2, 2022, forum.mn
8. As Nationwide Fraud Losses Top $10 Billion in 2023, FTC Steps Up Efforts to Protect the Public, *ftc.gov*, April 22, 2024. https://www.ftc.gov/news-events/news/press-releases/2024/02/nationwide-fraud-losses-top-10-billion-2023-ftc-steps-efforts-protect-public.
9. The Budapest Convention (ETS No. 185) and its Protocols (Parties), *coe.int,* April 22, 2024. https://www.coe.int/en/web/cybercrime/the-budapest-convention.
10. FAQ New United Nations Convention on Countering the Use of Information and Communications Technologies for Criminal Purposes (8 August 2022), *unodc.org*, April 23, 2024. https://www.unodc.org/documents/Cybercrime/AdHocCommittee/Website/FAQ_on_AHC_Aug_2022.pdf.
11. "Top Social Media Statistics And Trends Of 2024", *forbes.com*, April 22, 2024. https://www.forbes.com/advisor/business/social-media-statistics/#source.
12. "How Are The World's Biggest Countries Dealing With Online Fraud?," *vpnoverview.com*, April 22, 2024.04.22-нд үзсэн, https://vpnoverview.com/internet-safety/cybercrime/how-countries-deal-with-online-fraud-and-

cybercrime/.

13. Which countries are most (and least) at risk for cybercrime?, *scoonline.com,* April 23, 2024. https://www.csoonline.com/article/571615/which-countries-are-most-and-least-at-risk-for-cybercrime.html.
14. National Cybercrime Centre (NC3), *politiet.no*, April 23, 2024. https://www.politiet.no/en/om-politiet/organisasjonen/specialist-agencies/kripos/key-roles-of-ncis/national-cybercrime-centre/.

4. ХУУЛЬ ТОГТООМЖ

1. “Монгол Улсын Үндсэн Хууль”, *Legalinfo.mn*, 2024 оны 4 сарын 22-нд үзсэн, https://legalinfo.mn/mn/detail/367.
2. “Монгол улсын Эрүүгийн хууль”, *Legalinfo.mn,* 2024 оны 4 сарын 23-нд үзсэн, https://legalinfo.mn/mn/detail/11634.
3. 형법 (БНСУ-ын Эрүүгийн хууль), law.go.kr, April 24, 2024. https://law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%98%95%EB%B2%95

ОНЦ ЧУХАЛ ДЭД БҮТЦИЙГ КИБЕР ХАЛДЛАГААС ХАМГААЛАХ ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ (БАНКНЫ САЛБАРЫН ХҮРЭЭНД)

Т.Биндэръяа, Б.Амарбаясгалан***

**Монгол Улсын Их Сургууль, Бизнесийн сургууль, Санхүү менежмент, III дугаар түвшний оюутан. И-мэйл: binderyasapphir@gmail.com*

*** Их Засаг Их Сургууль, III дугаар түвшний оюутан. И-мэйл: bymbadorj.amarbaysaglan03@gmail.com*

ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.3 дахь хэсэгт эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх, дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцох түвшний цахим санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зэргээр цахим эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлсон. Энэ хүрээнд эдийн засаг болон цахим технологийн зохистой уялдааг дэмжих бодлогын чиглэлд эдийн засгийн томоохон салбар болох банкны салбарын цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, аюулгүй, түргэн шуурхай явуулах шаардлага бий болсон тул нэг талаас хэрэглэгчийн виртуал эд хөрөнгийг халдлагаас хамгаалах, нөгөө талаас банкны мэдээллийн технологийн системийн аюулгүй байдлыг хангах талаар үр нөлөөтэй арга хэмжээг авч, болзошгүй эрсдэлийг тооцоолон, зохистой арга хэрэгслээр банкны цахим мэдээллийн системийг хамгаалах шийдлийг бий болгох нь нэн чухал асуудал юм.

Монгол Улс нь НҮБ-ын дэргэдэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн асуудал хариуцсан тусгай агентлаг болох Олон улсын харилцаа холбооны нэгдэл (ITU)-ээс 2020 онд гаргасан кибер аюулгүй байдлын индексээрээ 120-т, Үндэсний кибер аюулгүй байдлын индексээрээ 137-д, Дэлхийн Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн индексээрээ 91-т эрэмбэлэгдсэн байна. Цахим банк нь санхүүгийн гүйлгээг зайнаас хийх ашигтай, үр дүнтэй аргыг санал болгож, бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлж, арилжааны зардлыг бууруулж чадсан юм. Гэвч цахим банкны үйлчилгээг нэвтрүүлснээр онлайн хэрэглэгчид, бизнес эрхлэгчдийн аюулгүй байдалд халдах асуудал байсаар байна. Эдгээр асуудал нь цахим үйлчилгээний хэрэглээг хязгаарлаж эсвэл удаашруулж болох бөгөөд олон хэрэглэгчдийг банкны гүйлгээ хийхдээ цахим хэрэглүүр ашиглах сонголтоос татгалзахад хүргэж байна. Иймд энэхүү судалгааны үр дүнд дэвшүүлсэн гурван таамаглалыг шалгаж тэдгээрийн цахим банкны үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох болно. Түүнчлэн санхүүгийн салбарт цахим банкны бодит хэрэглээг хязгаарлах нөхцөл болж буй кибер гэмт хэргийн үр дагаврыг үнэлэхэд ашиглагдах судалгааны загварыг санал болгох юм.

ТҮЛХҮҮР ҮГ

Кибер гэмт хэрэг, кибер аюулгүй байдал, банкны үйлчилгээ, мэдээллийн систем, цахим технологи, фишинг, хувийн мэдээллийг хулгайлах гэмт хэрэг, хакер

I.УДИРТГАЛ

Дижитал технологийн интеграц нь янз бүрийн салбарт, тэр дундаа эдийн засгийн салбарт ихээхэн хувьсгал хийсэн. Дижитал технологи бидэнд цаг хугацаа, орон зайнд баригдалгүй өргөн цар хүрээнд, хурдан шуурхай үйл ажиллагаа явуулах боломжийг олгоод зогсохгүй, их хэмжээний мэдээллийн өгөгдөлд тооцоолол хийх, шийдэл, гарц гаргалгаа боловсруулах зэргээр бүтээмжийг нэмэгдүүлж, зардал, цаг хугацааг багасгадаг. Энэ ч утгаараа эдийн засгийн салбарын хөгжлийн өсөлтөд ихээхэн нөлөөлдөг ба өдөрт хэдэн тэрбумын мөнгөн гүйлгээ цахим орчноор дамжин хийгддэг. Энэ нь нэг талаас асар их боломжийг нээхийн сацуу түүнтэй дүйцэхүйц сорилтыг бий болгож байна. Дижиталчлал хурдацтай тархаж байгаа нь эдийн засаг дахь цахим аюулгүй байдлын асуудлыг хөндөөд зогсохгүй программ хангамжийн эмзэг байдлыг ашиглах, фишинг, спам хийх зэрэг цахим орчин дахь заналхийллүүд улам ихээр нэмэгдэж байна.

2022 онд кибер халдлагын улмаас хамгийн их буюу 5.9 сая ам.долларын хохирол амссан хоёр дахь салбараар санхүүгийн байгууллага тодорчээ. Үүнд АНУ, Аргентин, Бразил, Хятад улсын санхүүгийн байгууллагууд хамгийн ихээр халдлагад өртсөн байна. 2022 оны арванхоёрдугаар сарын байдлаар санхүү, даатгалын байгууллагууд дэлхийн хэмжээнд 566 халдлагад өртөж, 254 сая гаруй мэдээлэл алдагдсан байна. Санхүүгийн үйлчилгээнд халдсан ransomware халдлага 2022 онд 55% байсан бол 2023 онд 64% болж өссөн нь 2021 онд бүртгэгдсэн 34% -иас бараг хоёр дахин их байна. Үүнтэй холбоотойгоор виртуал хөрөнгийг хамгаалах, мэдээллийн нууцлалыг хангах, аливаа эрсдэлийг бууруулах, цахим гүйлгээнд итгэх итгэлийг хадгалах сорилтууд зүй ёсоор тулгаран гарч ирж байна. Энэхүү судалгааны ажлаар цахим банкны салбар дахь цахим гэмт хэргийн нөлөө болоод түүнийг шийдвэрлэх арга замыг санал зөвлөмжид тулгуурлан дэвшүүлэх болно.

II.СУДАЛГААНЫ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Цахим гэмт хэрэг[1] гэж кибер орчин[2]-д мэдээллийн систем[3], интернет[4]-ийг ашиглан

[1] Дэлхийн ихэнх улсуудад системд хууль бусаар хандах, өгөгдлийг хууль бусаар замаас нь барьж авах, хөндлөнгөөс хууль бусаар оролцох, компьютерийг хууль бусаар ашиглан хортой хэрэгсэл үйлдэх, тараах, онлайн залилан, мэдээллийн нууцлалд халдахыг кибер гэмт хэрэг хэмээн үздэг. Л.Одончимэг “Кибер гэмт хэрэгт Монголын цаг агаарын хэлбэлзэл нөлөөлдөг эсэхийг гүний сургалтын аргаар тодорхойлох нь” сэдэвт судалгааны ажлын тойм, ICT 100, ОУ-ын хурал, 2021 дам эшлэв.

[2] Кибер аюулгүй байдлын тухай хууль 4.1.7 “мэдээлэлд хандах, нэвтрэх, цуглуулах, түүнийг боловсруулах, хадгалах, ашиглах боломж олгож байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний орчныг;”

[3] Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 4.1.1 “мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах зорилго бүхий программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдлийг;”

[4] Интернэт нь дэлхий даяар тархсан сүлжээний хувьд гэмт хэрэгтнүүдэд бодит ертөнц болон сүлжээнд олон нуугдах газрыг санал болгодог.

үйлдэгдэж буй гэмт хэргийг хэлдэг. Өөрөөр хэлбэл, “цахим” гэх тодотгол нь залилах, хүүхдэд садар самуун сурталчлах, оюуны өмчийг худалдаалах гэх мэтчилэн өмнө нь үйлдэгддэг байсан гэмт хэрэг болоод шинээр үүсэж болох гэмт зан үйл, хууль бус үйлдлийн өргөтгөл болдог. Энэ төрлийн гэмт хэрэг нь орон зай, цаг хугацаанд баригддаггүйгээс гадна биет ул мөр үлдээдэггүй онцлогтой. Олон улсын “Кассандра“ судалгааны байгууллага хуульч, банк санхүүгийн ажилтнуудын хүрээнд социологийн судалгаа явуулахад энэ төрлийн гэмт хэргийн улмаас банк, санхүүгийн байгууллагуудын хүлээх хохирлын хэмжээ цаашид улам нэмэгдэнэ гэж судалгаанд оролцогчдын дийлэнх үзсэн байна[5].

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.1.11-д “Кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхыг бий болгоно”, 3.6.1.1-т “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх, кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ” гэх зэргээр тусгасан байдаг. Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.3 дахь хэсэгт ухаалаг санхүүгийн зах зээлийн хүрээнд 2021-2030 (I-р үе шат) онд Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх, 2031-2040 (II-р үе шат) онд Томоохон хөрөнгийн биржүүдтэй хамтран дотоодын санхүүгийн хэрэгслийг чөлөөтэй арилжаалах, мэргэжлийн тоглогчдын оролцоо, хөрөнгө оруулалт татах боломжийг бүрдүүлэх, дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцох түвшний цахим санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зорилтуудын дэвшүүлсэн.

Уг зорилтын хүрээнд тогтвортой эдийн засгийг бий болгохыг тулд хууль бус хөрөнгийн урсгалыг хязгаарлах нь зүй ёсны бөгөөд хууль бус хөрөнгийн урсгал нь тодорхой салбарын эрэлтийг зохиомлоор өсгөх[6], татварын орлогыг бууруулах[7], тэгш бус байдлыг нэмэгдүүлэх[8] болон санхүүгийн системд итгэх итгэлийг

[5] Ц.Хүрэл-Очир, Кибер гэмт хэрэг: Хандлага ба төрөл, хэлбэр, Эрх зүй, сэтгэлгээ: үзэл бодол, эргэцүүлэл сэтгүүл,Уб.,2015, 52 дахь тал

[6] Хөрөнгийн хууль бус урсгал нь тодорхой салбарын эрэлтийг зохиомлоор өсгөх замаар эдийн засгийн үйл ажиллагааг гажуудуулж, нөөцийг буруу хуваарилахад хүргэдэг. Энэ нь хууль ёсны бизнес, үйлдвэрлэлийн өсөлтөд саад учруулж болзошгүй нөхцөл байдлыг бий болгодог. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн ерөнхий онол болох эрэлт, нийлүүлэлтийн харьцаанд үндэслэсэн зах зээлийн үнийг тогтооход зохиомлоор бий болгосон хүчин зүйлс нь сөргөөр нөлөөлдөг.

[7] Хууль бус хөрөнгө үүсгэсэн хувь хүн, аж ахуйн нэгжүүд орлогоо дутуу тайлагнаж, хөрөнгөө нуун дарагдуулах арга замаар татвар төлөхөөс зайлсхийдэг байна. Ингэснээр орлогыг зохих ёсоор тайлагнаж, татвар ногдуулсан бол хураах байсан татварын орлого буурах тул тэгш бус байдлыг мөн бий болгоно. Түүнчлэн далд эдийн засгийн өсөлт нь хяналтаас гадуур явагдах тул татварын тогтолцоог сулруулдаг.

[8] Баялгын тэгш бус байдал үүсэж, эдийн засгийн боломж нэмэгдэх тул нийгмийн тогтворгүй байдлыг бий болгодог. Үүнээс гадна хууль бус ажиллагаа нь хууль дээдлэх ёс болоод нийгмийн дэг журмыг алдагдуулах эрсдлийг мөн агуулдаг.

бууруулах[9] гэх мэт сөрөг үр дагаврыг бий болгож байдаг. Иймд эдийн засгийг тогтвортой байлгах, хууль бус хөрөнгийн урсгалыг олж илрүүлэх, хянах талаарх арга аргачлалыг нэвтрүүлж, үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулах, хууль, эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх нь чухал юм. Тэр дундаа мөнгөн хөрөнгө ихээр шилждэг, аливаа халдлагад өртөмтгий банкны салбар дахь эрсдэлийг тооцох нь нэн чухал асуудлуудын нэг юм.

Монгол Улс нь НҮБ-ын дэргэдэх мэдээлэл, харилцаа холбооны технологийн асуудал хариуцсан тусгай агентлаг болох Олон улсын харилцаа холбооны нэгдэл (ITU)-ээс 2020 онд гаргасан кибер аюулгүй байдлын индексээрээ 120-т[10], Үндэсний кибер аюулгүй байдлын индексээрээ 137-д, Дэлхийн Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн индексээрээ 91-т эрэмбэлэгдсэн байна[11]. Үндэсний статистикийн хорооноос гаргасан гэмт хэргийн тоон статистикаас үзэхэд, 2023 онд цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 129 (49.8%)-иар өссөн[12].

Мэдээллийн технологи өсөн нэмэгдэхийн хэрээр цаасан суурьтай эдийн засгийн харилцаа багасаж, өдөр тутмын мөнгөн гүйлгээ цахимаар хийгдэх нь эрс нэмэгдэж байгаатай холбоотойгоор хэрэглэгчдийн виртуал хөрөнгийн шилжилтийг хянах, хамгаалах нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд тэр дундаа банкны салбарт ихээхэн анхаарал хандуулах шаардлагыг бий болгож байна. Учир нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д зааснаар банк нь 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний, гадаад төлбөр тооцоо болон виртуал хөрөнгийн гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэг хүлээсэн бол тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь тус мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүргийг хүлээдэг. Тиймээс нэг талаас гүйлгээний мэдээллийг үнэн зөв мэдээллэх, нөгөө талаас мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээллийг хянан шалгахад дэмжлэг үзүүлж, хэрэглэгчийг хамгаалахад банк чухал оролцоотой этгээд байна.

Улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой улсын эрсдэлээ тодорхойлж, үнэлж, ойлгох шаардлагатай бөгөөд эрсдэлээ үнэлэх эрх бүхий байгууллагыг эсвэл зохицуулалтыг хийж, нөөц бололцоог зөв хуваарилах,

---

[9] Хууль бус хөрөнгө нь санхүүгийн систем, институцид итгэх итгэлийг алдагдуулах бөгөөд эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэдэг тул гадаадын хөрөнгө оруулагчид эрсдэл бий болгож улмаар хөрөнгө оруулалт буурахад хүргэж болзошгүй юм.

[10] Global Cybersecurity Index 2020 (itu.int)

[11] https://ncsi.ega.ee/country/mn_2022/?allData=1

[12] https://www.1212.mn/mn/dissemination/72371579

эрсдэлээ үр дүнтэй бууруулах арга хэмжээ авбал зохих[13] бөгөөд банкны салбарт мөнгөн гүйлгээ хамгийн их хийгддэг тул эрсдэлийн үнэлгээг гаргахад том нөлөө бүхий сектор юм.

Өмнө дурдсанчлан программ хангамжийн эмзэг байдлыг ашиглах, фишинг, спам хийх зэргээр хэрэглэгчдийн хөрөнгийг хууль бусаар удирдан шилжүүлэх, хууль бус хөрөнгийн урсгалыг халхавчлах зэрэг эрсдэлүүд байгаа тул уг халдлагаас банкны систем болоод хэрэглэгчдийн виртуал хөрөнгийг хамгаалах чиглэлээр үр нөлөөтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх, өөрийн мэдээллийн системийг хамгаалах нь чухал үр нөлөөтэй. Иймд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болох банк нь кибер халдлагад өртөж, виртуал хөрөнгө алдагдсан тохиолдолд авах арга хэмжээг судлах, тус халдлагыг таньж илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга, аргачлалыг нэмэгдүүлэх боломжийг томъёолох зэргээр кибер халдлагыг таслан зогсоох, хууль бус хөрөнгийн урсгалыг хянах, тэдгээртэй холбоотой хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга замыг тодорхойлох нь чухал юм.

III. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Кибер гэмт хэрэг буюу цахим орчинд цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн мөн чанар, ойлголт, өнөөгийн байдлын талаар Л.Галбаатар “Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь” ном, Д.Булган “Кибер гэмт хэргийн мөн чанар, түүний шинжийг тодорхойлох нь”, Б.Өнөрмаа “Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага”, Г.Мөнгөншагай “Цахим гэмт хэрэгтэй тэмцэж буй өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт”, Д.Сумъяацэрэн “Монгол Улс дахь кибер гэмт хэргийн өнөөгийн байдал, дүгнэлт, санал”, Б.Цэцэгмаа “Цахим гэмт хэрэгтэй тэмцэж буй өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт” зэрэг нэг сэдэвт бүтээлүүд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийж гүйцэтгэсэн “Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгаа, Т.Халтар, Т.Баасанжав, Х.Ану нарын “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг (кибер) гэмт хэргийн гүнзгийрүүлсэн судалгаа”, Ц.Хүрэл-Очир, Кибер гэмт хэрэг: Хандлага ба төрөл, хэлбэр, Эрх зүй, сэтгэлгээ: үзэл бодол, эргэцүүлэл сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл, болон Б.Солонгын “Кибер гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, өнөөгийн хэрэгжилт” хэмээх эрх зүйн магистрын зэрэг горилсон бүтээл байна[14]. Дээрх судлаачдын судалгаа, шинжилгээний ажлын агуулгыг ерөнхийлөн нэгтгэвэл тэдгээр нь гагцхүү нэн шинэ төрлийн ойлголтод хамааруулж ерөнхий байдлаар судалжээ. Уг судалгааны ажлууд нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай (шинэчилсэн найруулга), Хүний

[13] Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт ФАТФ-ын зөвлөмж, 2019, 11 дэх тал

[14] Нээлттэй нийгэм форум, кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа (Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд), Уб.,2022

хувийн мэдээлэл хамгаалах тухай (шинэчилсэн найруулга), Цахим гарын үсгийн тухай (шинэчилсэн найруулга) хуулиуд батлагдахаас өмнө судлагдсан тул дийлэнх судлаачид судалгааны бүтээлдээ “Кибер гэмт хэргийг тусгайлан хуульчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага зайлшгүй байна” гэсэн дүгнэлтэд хүрчээ[15].

Түүнчлэн Нээлттэй нийгэм форумаас 2022 онд гаргасан кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа (Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд) зэрэгт тус гэмт хэргийн эрүүгийн эрх зүй дэх асуудал болоод олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан байдал, виртуал хөрөнгийн үйлчилгээний салбарын үйл ажиллагаатай уялдуулан авч үзсэн байна.

Тиймээс энэхүү судалгааны ажил нь хамрах хүрээний хувьд банкны салбарын үйл ажиллагаанд кибер гэмт хэргийн нөлөөлөл болоод арга хэлбэр, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, уг төрлийн гэмт хэргийг бууруулахад оновчтой аргачлалыг тодорхойлох болон хууль, эрх зүйн хүрээнд хамгаалах боломжоор хязгаарлагдана. Кибер гэмт хэргийг бууруулах үр дүнтэй стратеги боловсруулснаар байгууллага, хувь хүний санхүүгийн алдагдал, хувийн мэдээллийг хулгайлах, залилан мэхлэх, нэр хүндэд хохирол учруулах зэрэг хууль бус үйлдэлтэй тэмцэж эрсдэлийг бууруулах, тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах болон цахим санхүүгийн гүйлгээ, харилцааны платформ зэрэгт итгэх итгэлцлийг сайжруулж цаашид явуулах цахим үйлчилгээг хамгаалах, инноваци, дижитал өөрчлөлтийг дэмжиж шинэ технологи нэвтрүүлэхэд саад болох хүчин зүйлсийг багасгаж эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах гэх зэрэг ач холбогдолтой.

IV. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

4.1 Судалгааны арга, түүний төрөл:

Энэхүү судалгаанд SPSS өгөгдлийн дүн шинжилгээ хийх аналитик хэрэгслийг ашиглан судалгааны зүйлийг баримт, статистик үзүүлэлтээр илэрхийлж, судлан тогтоосон тул тоон судалгааны аргыг ашигласан болно. Судалгааны үр дүнд дэвшүүлсэн гурван таамаглалыг шалгаж тэдгээрийн цахим банкны үйлчилгээнд үзүүлэх нөлөөлөл, үл хамаарах гурван хувьсагчийн аль нь цахим банкны үйлчилгээнд хамгийн их нөлөө үзүүлж байгааг тодорхойлох боломжтой болно. Анхдагч өгөгдлийг цуглуулахад анкетын асуулгын аргыг, хувьсагч хоорондын хамаарлын хэлбэрийг тогтоох буюу тэдгээрийн холбоо хамаарлыг илрүүлэх, энэхүү хамаарлыг үнэлэхэд регрессийн шинжилгээний аргыг ашигласан болно.

4.2 Судалгааны түүвэр:

Цахим банкны үйлчилгээг авч буй хэрэглэгчдийг зорилтот түүврийн нэгжээр

[15] Мөн тэнд.

тодорхойлон санамсаргүй түүврийн аргаар 50 хүнийг түүвэрлэн судалгааг гүйцэтгэсэн. Оролцогчдоос санал асуулгын тодорхой, хамааралтай, ойлгомжтой байдлыг 1-5 хүртэлх оноогоор үнэлэхийг хүссэн. Гурван хэсгээс бүрдсэн анкетын асуулгыг бэлтгэж судалгааны зүйл тус бүрээр 5 онооны Лайкерт үнэлгээг ашиглан хариултуудыг цуглуулсан. Эхний хэсэг нас, хүйс, зэрэг хүн ам зүйн үзүүлэлтэд суурилсан бол хоёрдугаар хэсэгт кибер гэмт хэргийн халдлагад өртөж байсан эсэх талаар туршлага, гуравдугаар хэсэгт цахим банкны хэрэглээ гэсэн хувьсагчийн мэдээллийг цуглуулсан.

4.3 Өгөгдөл цуглуулах үйл явц:

Санал асуулгын хуудсыг Google Forms дээр бэлтгэж оролцогчидтой биечлэн холбогдож, маягтыг бөглөх шууд холбоосыг өгсөн. Санал асуулгын эхэнд оролцогчдод тэдний өгсөн мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглах болно гэдгийг мэдэгдсэн. Энэхүү судалгааны ажилд статистик дүн шинжилгээ хийхдээ Windows үйлдлийн систем дээр SPSS v26.0 программыг ашиглаж өгөгдлийн онч бөгөөд найдвартай байдлыг шалгахын тулд Cronbach›s Alpha утгууд болон хүчин зүйлийн шинжилгээг хийсэн. Үүний дараагаар үл хамаарах хувьсагчдын хамаарах хувьсагчид үзүүлэх нөлөөллийг судлахын тулд Пирсоны корреляци ба олон хэмжээст регрессийг тус тус ашигласан болно.

V. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улс нь 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Кибер аюулгүй байдлын тухай хуулийг баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болсон. Тус хуулиар кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг тогтоосон[16]. Уг хуулийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 493 дугаар тогтоолын хавсралтаар “Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги”-г баталсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтаар “Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны ажиллах журам”-ыг, 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 224 дугаар тогтоолын хавсралтаар “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”, 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 318 дугаар тогтоолын хавсралтаар “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвийн дүрэм, төвийн ажиллах журам”-ыг, “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв» улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, байгууллагын бүтэц”-ийг тус тус баталжээ[17]. Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн хүрээнд

[16] Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг

[17] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем Legalinfo.mn

кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулж, удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, онц чухал мэдээллийн дэд бүтэц[18]-ийн кибер аюулгүй байдлыг хангах, уян хатан байдлыг сайжруулах, кибер аюулгүй байдлын талаарх бүх нийтийн мэдлэгийг дээшлүүлж, хүний нөөцийн чадавхыг сайжруулах, гадаад болон дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар кибер орчинд мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, хүртээмжийг үндэсний хэмжээнд хангахаар чиглэлээр тус стратегийг боловсруулсан байна[19]. Тус стратеги нь 2022-2025 он, 2026-2027 он хүртэл хэрэгжихээр төлөвлөгдсөн байх ба хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг стратегийн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн үе шат дуусах бүрд үнэлэхээр тусгагджээ[20].

Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр кибер аюулгүй байдлын эрсдэлд суурилсан мэргэшсэн үйл ажиллагааг нэвтрүүлсэн байгууллагын өсөлтийн хувиар эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан хувь 2022 оны байдлаар 2.77 буюу стратегийн хэрэгжилтийн эхний үе шатны хэрэгжилтийн гүйцэтгэл болох 50-аас доошгүй хувь байх, нөхөн сэргээх үйл ажиллагаа, тасралтгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байгууллагын өсөлтийн хувь 11.5 буюу 43-аас доошгүй хувь байх зорилтоор үлэмж бага хэмжээнд үнэлэгдсэн байна[21]. Энэ нь тус стратеги хэрэгжээд удаагүй байгаатай холбоотойгоор тоон үзүүлэлт, хэрэгжилтийн байдал муу байгааг илтгэж байгаа хэдий ч 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар дээрх үзүүлэлтүүд хангалтгүй, энэ чиглэлээр анхаарч, үйл ажиллагаандаа тусгаагүй гэж дүгнэж онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлын түвшин хангалтгүй хэмжээнд гэсэн ерөнхий таамаглал дэвшүүлэх боломжтой байна. Мөн зорилт 3-ын хүрээнд кибер аюулгүй байдлын судалгааны хүний нөөцийн индекс тус оны байдлаар 1.23 хувь байгаа нь зорилтот түвшнээс даруй 3 дахин бага, зорилт 4-ийн хүрээнд кибер аюулгүй байдлын хамтын ажиллагааны индексийн хувьд мөн анхаарч үзэх статистик тоон утгыг илэрхийлжээ[22].

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /The Financial Action Task Force FATF -ФАТФ[23]/-ын 2023 оны тайланд Монгол Улс нь мөнгө

[18] Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолын хавсралтаар Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтыг баталсан. Тус жагсаалтын 120-134 дэх хэсэгт Нэгдсэн төлбөр, тооцоо, гүйлгээний цахим систем бүхий банк, санхүүгийн байгууллагыг оруулсан байна.

[19] Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн 2.1 дэх хэсгийн заалт https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532522791411&showType=1

[20] Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн 2.3, 6.1 дэх хэсгийн заалт

[21] Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийн 5.1 дэх хэсэг Зорилт 2

[22] Мөн тэнд.

[23] ФАТФ нь 1989 онд гишүүн улс орнуудын сайд нарын байгуулсан олон улсын засгийн газар хоорондын байгууллага юм. ФАТФ-ын зорилго нь олон улсын санхүүгийн системийн цогц байдалд аюул, занал учруулж байгаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон бусад холбоотой заналхийлэлтэй тэмцэх хууль, эрх зүйн, зохицуулалтын болон үйл ажиллагааны стандартыг тогтоон хэрэгжүүлэхэд оршино. ФАТФ нь олон улсын бусад талуудын оролцоотойгоор тухайн улс орны үндэсний түвшний эмзэг сул талыг тогтоож олон улсын санхүүгийн системийг урвуулан ашиглахаас сэргийлэхийг мөн чухалчилна.

угаах, терроризмтэй тэмцэх чиглэлээрх техникийн нөхцөлийг дүгнэсэн бөгөөд ингэхдээ тус асуудлыг хуульчлан тусгасан эсэх шаардлагыг тэргүүнд авч үзсэн байна[24]. Гэвч кибер гэмт хэргийн банк, санхүүгийн салбарт учруулсан шууд болон шууд бус хохирлыг нэхэмжлэх асуудал, банк, санхүүгийн байгууллагын хувьд хэрэглэгчийн шаардах эрхийг өөрт шилжүүлэн авч хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар нарийвчилсан зохицуулалт хууль тогтоомжид тусгагдаагүй байна.

Олон Улсын туршлагаас үзэхэд, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, санхүүгийн луйврын эрсдэлийг бууруулахын тулд банкууд болон үйлчлүүлэгчдийг зохицуулах байгууллагаас тогтоосон аюулгүй байдлын хатуу журам, стандартыг дагаж мөрдөхийг шаарддаг. Тодруулбал, банк, санхүүгийн байгууллагууд нь PCI-DSS зэрэг комплайенс тогтолцоог дагаж мөрдөх үүрэгтэй. Хэрэв банк, санхүүгийн байгууллагууд мэдээллийн хамгаалалт, кибер аюулгүй байдлын дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, хэрэглэгчийн мэдээллийг хамгаалж, салбарын тусгайлсан цахим аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөөгүй, зөрчлийн талаар цаг алдалгүй мэдээлээгүй тохиолдолд зохицуулах байгууллагаас их хэмжээний торгууль ногдуулдаг. Эдгээр санхүүгийн үр дагавар нь олон сая доллараар хэмжигдэж, байгууллагын орлогод ноцтой нөлөөлдөг. Иймээс банкны салбар дахь цахим гэмт хэргийн хууль эрх зүйн үр дагавар нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд холбогдох бүх оролцогч талуудын идэвхтэй, хамтын хүчин чармайлтыг шаарддаг.

VI. ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН БАНКНЫ САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Мэдээллийн алдагдал, хакерын халдлагын өртөг жил бүр нэмэгдэж байгаа тул банкууд кибер аюулгүй байдлын арга хэмжээнд илүү их хөрөнгө оруулалт хийхээс өөр аргагүй болж, өөр чиглэлд ашиглах боломжтой нөөцийг уг асуудалтай тэмцэхэд зарцуулж байна. Цаашлаад цахим гэмт хэрэг их хэмжээний санхүүгийн алдагдалд хүргэж болзошгүй юм.

6.1 Санхүүгийн алдагдал, үйл ажиллагааны доголдол

Санхүүгийн шууд алдагдал: Санхүүгийн алдагдал нь банкны нэр хүнд болон харилцагчийн итгэлийг алдагдуулдаг. Accenture-аас саяхан хийсэн судалгаагаар цахим гэмт хэргийн хохирогч болсон банкны харилцагчдын 36 хувь нь банкандаа итгэх итгэлээ алдсан болохыг тогтоожээ. Эдгээр үйлчлүүлэгчдийн 65% нь “цахим банкны үйлчилгээнээс татгалзах болно” гэж мэдэгджээ. Энэ нь санхүүгийн алдагдлыг бууруулах, үйлчлүүлэгчдийн итгэлийг хадгалахын тулд кибер аюулгүй байдлын үр дүнтэй арга хэмжээ авах нь чухал болохыг харуулж байна. Шууд бус зардалд үйл ажиллагааны тасалдал, байгууллагын нэр хүндэд учирсан гэм хор, хууль зүйн үйлчилгээний зардал, торгууль зэрэг хамаарна.

[24] https://www.fatf-gafi.org/en/publications/Mutualevaluations/fur-mongolia-2023.html

6.2 Хэрэглэгчийн итгэл, нэр хүндэд учирсан хохирол

Банкны салбарын цахим гэмт хэргийн хамгийн чухал нөлөөллийн нэг нь үйлчлүүлэгчдийн санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл алдагдах явдал юм. Үйлчлүүлэгчид хувийн болон санхүүгийн мэдээллээ хамгаалахын тулд банкинд найддаг бөгөөд итгэлийг алдах нь тухайн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй. Кибер гэмт хэргээс айж болгоомжлох явдал нь боломжит үйлчлүүлэгчдийг банкны үйлчилгээг ашиглахаас татгалзуулж, орлогын алдагдалд хүргэдэг.

2017 онд Equifax-ын мэдээлэл алдагдсаны улмаас 150 сая гаруй үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэл ил болсон. Хэрэглэгчдийн нэр хүндэд нь хохирол учирсан үндэслэлээр шүүх олон сая долларын хохирлыг банкаар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн юм. Банкууд ч мөн адил эрсдэлтэй тулгардаг бөгөөд харилцагчийн итгэл, нэр хүндэд хохирол учирч болзошгүй тул эдгээр эрсдэлийг бууруулахын тулд кибер аюулгүй байдлын арга хэмжээнд хөрөнгө оруулах нь чухал болж байна.

VII. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

7.1 Судалгааны үзэл баримтлал

Энэхүү судалгааны үзэл баримтлал нь “технологи хүлээн авах” загвар дээр суурилсан (Дэвис, 1989). Уг загвар нь хэрэглэгчдийн технологийг хүлээн зөвшөөрөх, ашиглахад хамгийн өргөн хэрэглэгддэг онол бөгөөд криптограф, стеганализ, интернет протокол, програм хангамж хөгжүүлэх процесс/загварыг ашиглан хэрэглэгчид болон дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгчийг аюулгүй болгох системийг үүсгэдэг. “Цахим банкны үйлчилгээ” бүтцийн үзүүлэлтийн хувьсагч нь бодит хэрэглээ болон хэрэглээний давтамж юм (Зураг 1-ийг үзнэ үү). Судалгааны үр дүнд бий болсон загвар нь фишинг, хувийн мэдээллийг хулгайлах, хакердах зэрэг гурван үл хамаарах хувьсагч, цахим банкны хэрэглээ гэсэн нэг хамаарах хувьсагчаас бүрдэнэ.

7.2 Судалгааны загвар боловсруулах нь. Судалгааны таамаглал

Кибер гэмт хэргийг даван туулахын тулд Засгийн газар, хуулийн байгууллагууд, хувийн хэвшил болон бусад нийгмийн байгууллагуудын олон талын оролцоо шаардлагатай (Boateng et al., 2010). Кибер гэмт хэргийн талаарх ойлголтыг сайжруулах нь кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар илүү сайн арга хэмжээ авч, мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг (Arief, Adzmi, & Gross, 2015). (Abdul-Rasheed, Lateef, Yinusa, & Abdullateef, 2016) үзэл баримтлалын дагуу хүмүүс кибер гэмт хэрэг хэрхэн үйлдэгддэг, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хор уршгийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай гэж үзэж кибер гэмт хэрэгтэй тэмцэхэд боловсролын түвшин чухал нөлөөтэй хэмээжээ.

Цахим гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд санхүүгийн байгууллагууд олон төрлийн арга техникийг ашигладаг. (Anderson, Durbin, & Salinger, 2008) нарын үзсэнчлэн

баталгаажуулалтыг гурван төрөлд ангилж болно. Үүнд: Нууц үг, хувийн мэдээлэл гэх мэт хэрэглэгчийн мэдээллийг ашигладаг мэдлэгт суурилсан баталгаажуулалт; кредит эсвэл дебит карт эсвэл аюулгүй байдлын токен болон биометр (хурууны хээ, торлог бүрхэвчийн скан эсвэл гарын үсэг) зэрэг биет токен дээр суурилсан баталгаажуулалт хамаарна.

Кибер гэмт хэрэг нь нууцлалын өндөр түвшинд үйлдэгддэг учир халдагчид олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах болтол хөгжсөн. (Синглтон, 2013). Үүний үр дүнд гэмт этгээдийг олж тогтоох магадлал маш бага байна. Хохирогчид ихэвчлэн халдлагад өртсөн гэж өөрсдийгөө буруутгадаг бөгөөд зөвхөн 3% нь тэдэнд ийм зүйл тохиолдохгүй гэж боддог бол 80% нь эдгээр гэмт хэрэгтнүүдийг шүүх олж тогтооно гэдэгт итгэдэггүй байна (Abdul-Rasheed et al., 2016; Das & Nayak). , 2013).

Судалгаанаас үзэхэд банкнууд технологийн хөгжил, гүйлгээний зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, банк болон харилцагчийн хоорондын харилцааг сайжруулах, харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварын давуу талыг олж авах зорилгоор цахим банкны үйл ажиллагаа явуулдаг болохыг тогтоожээ (Angelakopoulos & Milhiotis, 2011; Bakare, 2015). Ojokuku & Sajuyigbe, 2012). Цахим банк нь санхүүгийн гүйлгээг зайнаас хийх ашигтай, үр дүнтэй аргыг санал болгож, бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлж, арилжааны зардлыг бууруулж чадсан юм (Riek нар, 2016). Гэвч цахим банкны үйлчилгээг нэвтрүүлснээр онлайн хэрэглэгчид, бизнес эрхлэгчдийн аюулгүй байдалд халдах асуудал байсаар байна (Fianyi, 2015). Эдгээр асуудал нь цахим үйлчилгээний хэрэглээг хязгаарлаж эсвэл удаашруулж болох бөгөөд олон хэрэглэгчдийг банкны гүйлгээ хийхдээ цахим хэрэглүүр ашиглах сонголтоос татгалзахад хүргэж байна.

Фишинг гэдэг нь (Liao et al., 2017) тодорхойлсноор "хохирогчдод банкны мэдэгдэлтэй төстэй хуурамч мэдэгдэл, цахим шуудангаар мөнгөн шагнал амласан хуурамч мессеж илгээх замаар хохирогчтой харилцаа үүсгэн хохирогчийг төөрөгдүүлэн дансны дугаар, нууц үг зэрэг эмзэг мэдээллийг өөрөөр нь гаргуулах, эсвэл хохирогчийн системд хортой програм суулгах үйлдэл юм." Энэ нь зорилтот хохирогчдыг хэрэглэгчийн нэр, нууц үг гэх мэт тодорхой мэдээллийг задруулахад уруу татах зорилготой спамын нэг төрөл бөгөөд халдагчид банкны бусад мэдээлэлд нэвтрэх эсвэл хохирогчийн хувийн мэдээллийг хулгайлахад тус дөхөм болдог (Андерсон нар., 2008; Хьюз, 2008).

Фишингийн үйл ажиллагаа нь хувь хүмүүс кредит картынхаа мэдээллээ оруулах шаардлагатай вэб сайтуудад түгээмэл байдаг (Хьюз, 2008). Банк, онлайн төлбөр төлөлт гэх мэт вэбсайтууд эдгээр үйл ажиллагаанд өртөмтгий бөгөөд халдагчид жинхэнэ банкны вэбсайтуудын хуулбарыг ажиллуулж, болзошгүй хохирогчдыг банкны данс руугаа нэвтрэхийг санал болгодог. Энэ үед банкны дансны дугаар, нууц үг, аюулгүй байдлын асуултын хариулт зэрэг нууц мэдээллийг хуулж, хадгалах боломжтой.

Халдагчид эдгээр мэйлийг жинхэнэ банкнаас ирсэн мэдэгдэл мэт харагдуулах

өнгөлөн далдлалт дор үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Эмзэг мэдээллийг олж авсны дараа халдагчид янз бүрийн кибер гэмт хэрэг үйлддэг байна.

Фишингийн үндсэн ангилал нь клон болон жад фишинг юм (Хан, 2013). Жад фишинг нь хохирогчийн талаарх үндсэн мэдээллийг олж авч авсны үндсэн дээр тодорхой этгээдийг онилдог арга юм. Хохирогч нь найз, хамаатан садан эсвэл санхүүгийн байгууллагаас эмзэг мэдээллээр хангах эсвэл тодорхой үүрэг даалгавар гүйцэтгэхийг шаардсан мэйл хүлээн авч болно. Энэ тохиолдолд "найз эсвэл хамаатан саднаас нь мэйл ирсэн" гэсэн төсөөлөлд автдаг тул хохирогчийн өөрийн үйлдэлд итгэх итгэл өндөр байдаг. Үүнтэй холбоотойгоор эдгээр халдлага амжилттай болох магадлал мөн маш өндөр байна (Хан, 2013). Нөгөөтэйгөөр, Khan (2013)-ийн хэлснээр клон фишинг нь "хавсралт эсвэл холбоос агуулсан хууль ёсны өмнө илгээсэн мэйлийн агуулга, хүлээн авагчийн хаягийг авч, хувилан клон мэйл үүсгэхэд ашигласан тохиолдол юм". Санал болгож буй судалгааны загварт фишингийн эдгээр хоёр ангиллыг "Фишинг"-ийн үзүүлэлтийн хувьсагч болгон загварчилсан болно (Зураг 1-ийг үзнэ үү).

(Таамаглал 1) H1: Фишинг нь цахим банкны үйлчилгээнд сөргөөр нөлөөлнө

Фишингийн хохирогч нь хакердах эсвэл хувийн мэдээллийг хулгайлах гэмт хэргийн хохирогч болж болзошгүй тул хохирогчийн талаар цуглуулсан мэдээллийг хууль бус олон хэлбэрээр ашиглаж болно (Moore, Clayton, & Anderson, 2009). Хэдийгээр хувийн мэдээллийг хулгайлах (identity theft) нь ихэвчлэн онлайн худалдаа хийхтэй холбоотой байдаг ч онлайнаар бараа, үйлчилгээ худалдан авахад төлбөр хийх үйлдлийг банкны гүйлгээ гэж үзэж болно. Хувийн мэдээллийг хулгайлах гэмт хэргийг үйлдсэнээр хохирогчийн тухай хангалттай мэдээлэл олж авах бөгөөд энэ нь халдагч этгээдэд хохирогчийн дансанд байгаа мөнгийг ашиглах боломжийг олгодог (Андерсон нар, 2008). Үүнд зээлийн картын дугаар, утасны дугаар, и-мэйл хаяг зэрэг хувийн мэдээллийг багтааж болно. Зээлийн картын хулгай, ашиглалт, хуурамч зээл, моргейжийн залилан, тэтгэвэр, тэтгэмжийн залилан, санхүүгийн дансанд байгаа мөнгийг хулгайлах зэрэг нь хувийн мэдээллийг хулгайлах гэмт хэргийн нэг хэлбэр юм (Singleton, 2013).

Хувийн мэдээллийг хулгайлах гэмт хэрэг нь хувь хүмүүсийг бай болгодог хамгийн түгээмэл кибер гэмт хэрэг юм (Синглтон, 2013). Цахим гэмт хэргийн хохирогчдын 61% нь зээлийн картаа буруу ашигласан, 33% нь хадгаламж эсвэл чекийн дансаа буруу ашигласан, бусад нь интернет данс эсвэл утсаа буруу ашигласан гэж мэдээлсэн байна (Андерсон нар, 2018). Судлагдсан байдлын тоймд хувийн мэдээллийг хулгайлах дөрвөн ангиллыг авч үздэг (Московић нар, 2009).

Үүнд:

- Санхүүгийн мэдээллийг хулгайлах – Бараа, үйлчилгээ авахын тулд бусдын хувийн мэдээллийг ашиглах;
- Хувийн мэдээллийг хувилах – Өдөр тутмын амьдралдаа бусдын мэдээллийг ашиглах;

- Бизнесийн хувийн мэдээллийг хулгайлах – Зээл авахын тулд бусдын бизнесийн нэрийг ашиглах;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн мэдээллийг хулгайлах– гэмт хэрэг үйлдэж баривчлагдсан үедээ өөр хүний дүр эсгэх.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн мэдээллийг хулгайлах нь цахим банкны үйлчилгээтэй шууд холбоогүй учраас энэхүү судалгааны хүрээнд авч үзээгүй болно. Иймээс өмнөх гурван халдлагыг (жишээ нь, санхүүгийн хувийн мэдээллийг хулгайлах, хувийн мэдээллийг хувилах, бизнесийн хувийн мэдээллийг хулгайлах) нь ‘Хувийн мэдээллийн хулгай” (Identity theft) бүтцийн үзүүлэлтийн хувьсагч болгон ашигласан болно.

(Таамаглал 2) H2: Хувийн мэдээллийг хулгайлах нь цахим банкны үйлчилгээнд сөргөөр нөлөөлнө.

Хакердах нь фишинг халдагчдын хүрэх цэг гэж тооцогддог (Hughes, 2008). Энэ нь компьютер эсвэл сүлжээнд хадгалагдсан мэдээллийг хулгайлах зорилгоор компьютерын системд хууль бусаар нэвтрэх явдал юм (Liao et al., 2017). Эдгээр кибер халдлагыг “Trojan horse” вирус ашиглан амархан гүйцэтгэдэг (Kayr, 2013). Эдгээр халдлагууд нь ихэвчлэн ашиг олох зорилгоор үйлдэгддэг (Demirdjian & Mokatisian, 2015). Хакерын бодит зардлыг тооцоолоход хэцүү бөгөөд олон компани халдлагад өртсөн гэдгээ нуудаг.


Хакеруудыг ерөнхийдөө цагаан, хар, саарал малгайт гэж тодорхойлдог (Furnell, 2001; PreuB, Furnell, & Papadaki, 2007). Цагаан малгайт хакерууд нь системийн аюулгүй байдлын төлөө ажилладаг хакерууд учраас энэхүү судалгаанд хамрагдаагүй болно (Furnell, 2001). Тэднийг заримдаа «ёс суртахуунтай» хакерууд гэж нэрлэдэг.

Хакеруудын дийлэнх нь хар малгайт хакерууд (Furnell, 2001). Эдгээр хакерууд санаатайгаар системд зөвшөөрөлгүй нэвтэрч мэдээллийг хулгайлж, зардаг бөгөөд ерөнхийдөө хувийн ашиг сонирхлын сэдэлтэй байдаг. Саарал хакерууд бол зугаа цэнгэлийн зорилгоор, тодорхойгүй сэдлээр хакерддаг байна (Furnell, 2001). Санал болгож буй судалгааны загварт хар, саарал малгайт хакеруудын аль алиныг нь ‘Хакер’ бүтээцийн үзүүлэлтийн хувьсагч болгон оруулсан болно.

(Таамаглал 3) H3: Хакердах нь цахим банкны үйлчилгээнд сөргөөр нөлөөлнө.

Энэхүү судалгааны оруулсан хувь нэмэр нь санал болгож буй судалгааны загварыг гаргах явдал юм. Судалгааны үр дүнд фишинг, хувийн мэдээллийг хулгайлах, хакердах зэрэг гурван таамаглалыг шалгаж тэдгээрийн цахим банкны үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг харуулах чадвартай байх ёстой. Түүнчлэн энэхүү судалгаагаар үл хамаарах гурван хувьсагчийн аль нь цахим банкны үйлчилгээнд хамгийн их нөлөө үзүүлж байгааг тодорхойлох боломжтой болно.

Зураг 1: Судалгааны загвар



VIII. ӨГӨГДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

8.1 Демографик үзүүлэлт

Хүснэгт 1-д судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээллийг хавсаргасан. Хүйс, гэр бүлийн байдал, нас, боловсролын түвшин, ажлын туршлага зэргийг дараах хүснэгтэд хувиар илэрхийлэв. Судалгаанд оролцогчдын 56 хувь нь эрэгтэй, 44 хувь нь эмэгтэй; 53.1 хувь нь ганц бие, 47.9 хувь нь гэр бүлтэй гэж хариулсан нь судалгаанд оролцогчдын дийлэнх нь гэрлээгүй байгааг харуулж байна. Бусад ангиллыг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Хүн ам зүйн үзүүлэлт

Table N %		
Судалгаанд оролцогчдын хүйс	Эр	56.0%
	Эм	44.0%
Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал	Гэрлээгүй	53.1%
	Гэрлэсэн	47.9%
Судалгаанд оролцогчдын нас	18-25 нас	30.8%
	25-35 нас	53.4%
	35-50 нас	15.8%
	50-аас дээш нас	0.0%
Санал асуулгад оролцогчдын боловсролын зэрэг	Бакалавр	30.2%
	Магистр	49.9%
	Доктор	5.5%
	Бусад	14.4%

8.2 Дискриптив шинжилгээ

Давтамж, хэмжилтийн зүйл, дундаж утга, стандарт хазайлт зэргийг ашиглан өгөгдлийг нэгтгэн дүгнэвэл, кибер гэмт хэргийн дундаж утгыг 2.8-3.5, стандарт хазайлт 0.7-1, онлайн банкны хэрэглээний дундаж утга 4.0 байна.

Дундаж: Хувьсагч бүрийн дундаж оноог илэрхийлнэ. Жишээлбэл, фишингийн дундаж нь 3.2 байгаа нь судалгаанд оролцогчид фишинг халдлагад өртсөн туршлагаа 1-ээс 5 хүртэлх оноогоор дунджаар 3.2-оор үнэлсэн болохыг харуулж байна.

Стандарт хазайлт: Дундаж орчмын онооны тархалт эсвэл хэлбэлзлийг хэмждэг. Илүү өндөр стандарт хазайлт нь нэгэн төрлийн бус хариултууд ихээр ирсэн болохыг илтгэдэг. Жишээлбэл, фишингийн хувьд стандарт хазайлт 0.9 байгаа нь фишингийн туршлагын талаарх хариултууд дунджаар 3.2 онооны ойролцоо хэлбэлзэж байна гэсэн үг юм.

Хүснэгт 2. Дискриптив статистик

Variable	Mean	Standard Deviation
Phishing	3.2	0.9
Identity Theft	2.8	0.7
Hacking	3.5	1.0
E-banking Usage	4.0	0.6

8.3 Онч бөгөөд найдвартай байдлын шинжилгээ

Хэрэв Cronbach-ийн альфа утга нь 0.7 ба түүнээс дээш байвал найдвартай өгөгдөлд тооцогдох бөгөөд корреляци, регрессийн шинжилгээнд ашиглах боломжтой юм. Хүснэгт 4-өөс үзэхэд Cronbach›s Alpha 0.71 байгаа нь өгөгдлийн найдвартай байдлыг илтгэж байна. Cronbach›s Alpha утгыг ашиглан өгөгдөлд регресс болон корреляцийн шинжилгээг хийх боломжтой.

Хүснэгт 3. Case Processing Summary

		N	%
Cases	Valid	100	99.1
	Excluded	1	0.9
	Total	106	100.0
a. Listwise deletion based on all variables in the procedure.			

Хүснэгт 4. Онч бөгөөд найдвартай байдлын статистик

Cronbach's Alpha	**N of Items**
0.710	21

8.4 Фактор шинжилгээ

Хэрэв хүчин зүйл нь хувьсагчдыг дэмжиж, хангалттай нийцтэй байвал түүнийг хүчин зүйлийн шинжилгээ ашиглан судалдаг. Хүчин зүйлийн уялдаа холбоог CCT (Цахим гэмт хэргийн арга техник, Cybercrime Techniques) болон BD (Онлайн банкны хэрэглээ, Online Banking Usage) тус тус 0.6-0.7 хооронд хэлбэлзэж байгаагаас харж болно. 0.7-0.8 утгын хүрээ нь хүчин зүйлийн шинжилгээнд OBU-г авч үзэхэд тохиромжтой юм. Эдгээр үр дүн нь нийлээд судалгааны арга болон фишинг, хувийн мэдээллийг хулгайлах, хакердах зэрэг үндсэн бүтцийн үнэн зөв байдлыг илтгэдэг. Эдгээр таамаглалын үр дүнд судалгааны зүйлүүд нь төлөвлөсөн бүтээцийг үнэн зөв хэмжиж, судалгааны ерөнхий хүчин төгөлдөр байдлыг нотолсон болно.

Хүснэгт 5. Фактор шинжилгээ

	Initial	Extraction
CCT1	1.00	.874
CCT2	1.00	.698
CCT3	1.00	.843
CCT4	1.00	.831
CCT5	1.00	.754
CCT6	1.00	.794
CCT7	1.00	.776
BD1	1.00	.721
BD2	1.00	.783
BD3	1.00	.795
BD4	1.00	.668
BD5	1.00	.769
BD6	1.00	.799
OBU1	1.00	.751
OBU2	1.00	.793
OBU3	1.00	.851
OBU4	1.00	.718
OBU5	1.00	.811
OBU6	1.00	.741
OBU7	1.00	.700
Extraction Method: Principal Component Analysis.		

8.5 Корреляцийн шинжилгээ

Хувьсагчдын хоорондын хамаарлыг судлахын тулд корреляцийн шинжилгээг ашигладаг бөгөөд энэхүү судалгааны үл хамаарах, хамаарах хувьсагч хоорондын

хамаарал сөрөг утгатай байна. Цахим гэмт хэргийн төрлүүд (Фишинг, хувийн мэдээллийг хулгайлах, хакердах) болон цахим банкны ашиглалтын хоорондын сөрөг хамаарал нь (r = -0.2, r= -0.25, r= -0.35, p < 0.001) цахим гэмт хэрэгт өртсөн гэж мэдээлсэн хүмүүс цахим банкны үйлчилгээг ашиглах магадлал бага байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, сөрөг утгатай корреляцийн коэффициент нь хоёр хувьсагчийн хооронд хүчтэй урвуу шугаман хамаарал байгааг илтгэж байна. Фишинг, хувийн мэдээллийг хулгайлах, хакердах зэрэг хувьсагчид хоорондоо эерэг хамааралтай байгаа нь нэг төрлийн кибер гэмт хэрэгт өртсөн хүмүүс бусад төрлийн кибер халдлагад өртөх хандлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Корреляцийн шинжилгээ

	Phishing	Identity Theft	Hacking	E-banking Usage
Phishing	1.00	0.45	0.30	-0.25
Identity Theft	0.45	1.00	0.55	-0.35
Hacking	0.30	0.55	1.00	-0.20
E-banking Usage	-0.25	-0.35	-0.20	1.00

$$E{-}bankingUsage{=}\beta 0{+}\beta 1(Phishing){+}\beta 2(IdentityTheft){+}\beta 3(Hacking){+}\varepsilon$$

8.6 Регрессийн шинжилгээ

Intercept (β_0): Бүх бие даасан хувьсагч (фишинг, хувийн мэдээллийг хулгайлах, хакердах) тэг байх үед урьдчилан тооцоолсон цахим банкны хэрэглээг илэрхийлнэ.

Коэффициент (β_1, β_2, β_3, β_4): Эдгээр нь бие даасан хувьсагч бүрийн нэг нэгжийн өөрчлөлтийн хувьд хамааралтай хувьсагчийн өөрчлөлтийг (цахим банкны хэрэглээ) илэрхийлж, бусад хувьсагчдыг тогтмол байлгадаг.

Стандарт алдаа: Коэффицентийн утгын хэлбэлзлийг хэмждэг.

p-утга: 0.05-аас бага p утгыг статистикийн хувьд ач холбогдолтой гэж үздэг.

Predictor	Coefficient (β)	Standard Error	t-value	p-value
Intercept	3.90	0.20	19.50	<0.001
Phishing	-0.40	0.15	-2.67	0.009
Identity Theft	-0.35	0.12	-2.92	0.005
Hacking	-0.20	0.10	-2.00	0.048

Фишинг: Коэффициент нь -0.40, p-утга нь 0.009 байна. Коэффициент (-0.4) нь фишинг-д өртсөн хэрэглэгч нэг нэгжээр нэмэгдэхэд цахим банкны хэрэглээ 0.4 нэгжээр буурч байгааг харуулж байна. Үүнээс үзвэл цахим банкны хэрэглээнд фишинг хамгийн их сөрөг нөлөөллийг үзүүлж байна.

Хувийн мэдээллийг хулгайлах: Коэффициент нь (-0.35), p-утга нь 0.005 байна. Уг төрлийн халдлагад өртсөн хүмүүс цахим банкны үйлчилгээг ашиглах нь бага байдаг.

Коэффициент (-0.35) нь хувийн мэдээллийн хулгайтай холбоотой асуудал нэг нэгжээр нэмэгдэхэд цахим банкны үйлчилгээний хэрэглээ 0.21 нэгжээр буурч байгааг харуулж байна.

Хакердах: Коэффициент нь -0.20, p-утга нь 0.048 байна. Хакерт өртсөн үйлчлүүлэгч нэг нэгжээр нэмэгдэхэд цахим банкны хэрэглээ 0.2 нэгжээр буурч байгааг харуулж байна.

Судалгааны дүгнэлт:

Таамаглал 1 (H1): Фишинг нь цахим банкны хэрэглээнд сөргөөр нөлөөлнө.

Регрессийн шинжилгээгээр фишингийн хувьд статистик ач холбогдолтой, сөрөг коэффициент (β = -0.40, p = 0.009) илэрсэн.

Иймээс 1-р таамаглалыг дэмжиж, фишинг нь цахим банкны хэрэглээнд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг гэж дүгнэж болно.

Таамаглал 2 (H2): Хувийн мэдээллийг хулгайлах нь цахим банкны хэрэглээнд сөргөөр нөлөөлнө.

Регрессийн шинжилгээгээр хувийн мэдээллийг хулгайлах гэмт хэргийн хувьд статистик ач холбогдолтой, сөрөг коэффициент (β = -0.35, p = 0.005) илэрсэн.

Иймээс 2-р таамаглалыг баталж, хувийн мэдээллийг хулгайлах тохиолдол цахим банкны хэрэглээг эрс бууруулдаг гэж дүгнэж болно.

Таамаглал 3 (H3): Хакердах нь цахим банкны хэрэглээнд сөргөөр нөлөөлнө.

Хакердах ажиллагааны коэффициент нь статистик ач холбогдолтой (β = -0.20, p = 0.048) байсан ч энэ нь фишинг болон хувийн мэдээллийг хулгайлахтай харьцуулахад бага юм.

Гэсэн хэдий ч сөрөг коэффициент нь хакердах ажиллагаа нь цахим банкны хэрэглээг үнэхээр бууруулдаг болохыг харуулж байна.

Иймээс, хакердах ажиллагаа нь цахим банкны хэрэглээнд мэдэгдэхүйц боловч бага зэрэг сул нөлөө үзүүлж, таамаглал 3-ыг дэмжиж байна гэж дүгнэж болно.

Судалгааны үр дүнгээр дээрх гурван таамаглалыг няцаах үндэслэлгүй байна. Фишинг, хувийн мэдээллийг хулгайлах нь цахим банкны үйлчилгээнд ихээхэн сөрөө нөлөө үзүүлж байгаа бол хакердах цахим гэмт хэрэг нь сул нөлөө үзүүлж байна. Кибер аюул заналхийлсээр байгаа тул эдгээр асуудлуудыг шийдвэрлэх, кибер аюулгүй байдлын арга хэмжээг сайжруулах нь цахим банкны үйлчилгээнд итгэх итгэлийг бэхжүүлэхэд нэн чухал юм.

XI. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн асуудал нь өндөр хөгжилтэй, буурай хөгжилтэй орнууд гэлтгүй дэлхийн нийтийн өмнө тулгамдсан асуудал болоод байна. Мөнгөн урсгал, мэдээллийн сувгуудтай хамгийн их холбоотой байдаг учраас банк санхүүгийн байгууллагын хувьд бусад байгууллагатай харьцуулахад кибер халдлагад өртөх эрсдэл өндөр байдаг гэж дүгнэж болно. Иймд нэг талаас хэрэглэгчийн виртуал эд хөрөнгийг халдлагаас хамгаалах, нөгөө талаас банкны мэдээллийн технологийн системийн аюулгүй байдлыг хангах талаар үр нөлөөтэй арга хэмжээг авч, болзошгүй эрсдэлийг тооцоолон, зохистой арга хэрэгслээр банкны цахим мэдээллийн системийг хамгаалах шийдлийг бий болгох шаардлагатай юм.

Уг дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Олон шатлалт хамгаалалт: Firewalls суурилуулах нь аливаа байгууллагын мэдээллийн системийг кибер аюулаас хамгаалах чухал хэрэгсэл юм. Банкууд сүлжээндээ гадны хандалтаас сэргийлж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа, программыг блоклох найдвартай Firewalls механизмыг хөгжүүлэх шаардлагатай.

2. Ажилтнуудын сургалт: Банкны салбарын цахим гэмт хэргийн эрсдэлийг бууруулахад ажилтнуудын сургалт, сурталчилгаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Кибер аюулын шинж чанар байнга хувьсан өөрчлөгдөж байгаа тул банкны байгууллагууд ажилтнуудаа аливаа боломжит кибер халдлагыг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвараар хангасан байх ёстой. Сургалтын хөтөлбөрүүд болон дууриамал фишинг тестүүд нь ажилчдад онлайн аюул заналхийллийг илрүүлж, үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломжийг олгож, мэдлэгийг дээшлүүлэх, шилдэг туршлагыг бэхжүүлэхэд тусалдаг. Тиймээс банкны салбарын кибер аюулгүй байдлын тогтвортой байдлыг сайжруулахад ажилтнуудын сургалт, мэдлэгийг дээшлүүлэхэд хөрөнгө оруулалт хийх нь чухал юм.

3. Кибер аюулыг цаг алдалгүй илрүүлж, хариу арга хэмжээ авахын тулд сүлжээний траффик болон гажуудсан үйл ажиллагааг идэвхтэй хянах боломжтой, санхүүгийн байгууллагуудын хооронд кибер аюулын мэдээллийг бодит цаг хугацаанд хуваалцах платформыг бий болгох нь зохистой юм.

4. Хамтран ажиллах, мэдээлэл солилцох: Кибер аюулгүй байдлын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудтай хамтран ажиллах нь цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд илүү цогц арга барилаар хангадаг тул банкны салбарт ихээхэн ашиг тусаа өгөх болно. Эдгээр байгууллагын туршлага, нөөц нь банкуудын одоо байгаа кибер аюулгүй байдлын арга хэмжээг нэмэгдүүлж, аюулгүй байдлын ноцтой зөрчлийг үүсгэхээс өмнө болзошгүй аюулыг тодорхойлж, шийдвэрлэх боломжийг олгодог. Хамтын ажиллагаагаар дамжуулан кибер аюулгүй байдлын заналхийллийн талаарх нийтлэг ойлголтыг олон нийтэд түгээж, банкны салбарын нийт эрсдэлийг бууруулах боломжтой.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн хүрээнд

Кибер аюулгүй байдлын тухай хууль

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 493 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги”

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны ажиллах журам

2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 224 дугаар тогтоолын хавсралтаар “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”,

2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 318 дугаар тогтоолын хавсралтаар “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвийн дүрэм, төвийн ажиллах журам”

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт

Цахим эх сурвалж

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем Legalinfo.mn

Global Cybersecurity Index 2020 (itu.int)

https://ncsi.ega.ee/country/mn_2022/?allData=1

Үндэсний статистикийн хорооны цахим сан 1212.mn

Ц.Хүрэл-Очир, Кибер гэмт хэрэг: Хандлага ба төрөл, хэлбэр, Эрх зүй, сэтгэлгээ: үзэл бодол, эргэцүүлэл сэтгүүл,Уб.,2015

Нээлттэй нийгэм форум, кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа (Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд), Уб.,2022

Гадаад эх сурвалж

Anderson, K. B., Durbin, E., & Salinger, M. A. (2008). Identity theft. Journal of Economic Perspectives, 22(2), 171-192.

A. G. Johansen, „Norton," NortonLifeLock, 23 11 2021. [Online]. Available: https://us.norton.com/internetsecurity-malware-ransomware5-dos-and-donts.html [12 12 2021].

Khan, A. A. (2013). Preventing phishing attacks using one time password and user machine identification. International Journal of Computer Applications, 68(3), 7-11.

Oliver Wyman and DTCC project team, „Oliver Wyman, DTCC," 03 2018. [Online]. Available: https://www.oliverwyman.com/content/dam/oliverwyman/v2/publications/2018/march/Large-Scale-Cyber-Attacks-DTCC-2018.pdf.[2402 2021].

Internet Crime Complaint Center (IC3), „Internet Crime Report, 2020," FBI, USA, 2020.

Хавсралт №1 Асуулгын хуудас

Судалгаа: Монгол улсын цахим банкны салбар дах цахим гэмт хэргийн нөлөө

Манай санал асуулгад оролцсон танд баярлалаа. Таны санал хүсэлт Монгол улсын цахим банкны салбарын талаарх ойлголтод цахим гэмт хэрэг хэрхэн нөлөөлж байгааг судлахад чухал ач холбогдолтой юм. Дараах асуултуудад үнэн зөв, өөрийн мэдлэгийн хүрээнд хариулна уу.

Хүн ам зүйн мэдээлэл:

Нас: [ ] 18-25 [ ] 25-35 [ ] 35-50 [ ] 50-аас дээш

Хүйс: [ ] Эрэгтэй [ ] Эмэгтэй [ ] Бусад

Гэрлэсэн байдал: [ ] Гэрлэсэн [ ] Гэрлээгүй

Боловсролын зэрэг: [ ] Бакалавр [ ] Магистр [ ] Доктор [ ] Бусад

2-р хэсэг: Кибер гэмт хэрэгт өртөж байсан эсэх

Цахим гэмт хэргийн талаар дараах өгөгдөлтэй санал нийлж буй эсэхээ бичнэ үү.

1. Та хувийн төхөөрөмж болон онлайн бүртгэлийнхээ аюулгүй байдлыг хэрхэн хангахаа мэддэг гэдэгт хэр итгэлтэй байна вэ?

Огт санал нийлэхгүй байна.			Бүрэн санал нийлж байна.	
1	2	3	4	5

2. Та цахим шуудангийн нууц үгийг бусад онлайн бүртгэлд ашигладаг уу?

Огт санал нийлэхгүй байна.			Бүрэн санал нийлж байна.	
1	2	3	4	5

3. Та нууц үг хадгалах эсвэл үүсгэхийн тулд вэб хөтөч эсвэл password manager програмыг ашигладаг уу?

Огт санал нийлэхгүй байна.			Бүрэн санал нийлж байна.	
1	2	3	4	5

4. Та аль нэг онлайн бүртгэлдээ Two-factor authentication-ийг (2FA) идэвхжүүлсэн үү?

Огт санал нийлэхгүй байна.			Бүрэн санал нийлж байна.	
1	2	3	4	5

5. Хэн нэг этгээд хуурамч цахим шуудан эсвэл вэбсайтаар дамжуулан таны хувийн мэдээллийг (жишээ нь, нууц үг, зээлийн картын мэдээлэл) олж авахаар оролдож байсан уу? Өөрөөр хэлбэл, фишинг халдлагад өртөж байсан уу?

[ ] Тийм [ ] Үгүй

6. Хэн нэг этгээд таны хувийн мэдээллийг бусдыг залилан мэхлэх зорилгоор ашиглахын тулд хулгайлж байсан уу?

[ ] Тийм [ ] Үгүй

7. Зөвшөөрөлгүйгээр таны компьютер эсвэл онлайн данс руу нэвтэрч, хакердаж байсан уу?

[ ] Тийм [ ] Үгүй

3-р хэсэг: Цахим банкны хэрэглээ

8. Та цахим банкны үйлчилгээг хэр их давтамжтай ашигладаг вэ?

Огт санал нийлэхгүй байна.			Бүрэн санал нийлж байна.	
1	2	3	4	5

9. Монголд цахим банкны платформууд аюулгүй, найдвартай байдлыг бүрэн хангасан. Миний хувийн болон санхүүгийн мэдээллийг хамгаалдаг гэдэгт итгэдэг.

Огт санал нийлэхгүй байна.			Бүрэн санал нийлж байна.	
1	2	3	4	5

10. Та АТМ болон цахим банкны системийг хэр удаан хугацаанд ашиглаж байна вэ?

Огт санал нийлэхгүй байна.			Бүрэн санал нийлж байна.	
1	2	3	4	5

Нээлттэй асуулт

Монгол дахь кибер гэмт хэргийн аюул занал, цахим банкны үйлчилгээтэй холбоотой нэмэлт санал хүсэлтээ бичнэ үү.

[Нээлттэй хариулт]

МӨНГӨ УГААХ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ: БАНКНЫ АЖИЛТНЫ ЖИШЭЭН ДЭЭР

Монголбанкны оюутны эрдэм шинжилгээний бага хуралд зориулав.

Э.Тамир /Багш/, Д.Өсөхжаргал**, Ц.Мишээл***,С.Хулан*****

**Санхүү Эдийн Засгийн их сургуулийн Санхүү удирдлагын тэнхим Удирдагч багш И-мэйл: tamir.e@ufe.edu.mn, Утас: 80100608*

***Санхүү Эдийн Засгийн их сургуулийн Санхүү удирдлагын 4-р курс, И-мэйл: b20fa1118@ufe.edu.mn, Утас: 91114270*

****Санхүү Эдийн Засгийн их сургуулийн Санхүү удирдлагын 4-р курс, И-мэйл: b20fa1199@ufe.edu.mn/,Утас: 95376993*

*****Санхүү Эдийн Засгийн их сургуулийн Санхүү удирдлагын 4-р курс, И-мэйл: b20fa1267@ufe.edu.mn/, Утас: 99627872*

ТОВЧ ХУРААНГУЙ

Аливаа улс орны эдийн засгийн аюулгүй байдалд санхүүгийн систем болон зуучлагч байгууллагуудын тогтвортой байдал чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Сүүлийн жилүүдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх буюу нийгэм, эдийн засаг, улс төрийн байдалд ноцтой сөрөг үр дагавар үүсгэх санхүүгийн гэмт хэрэгтэй дэлхий нийтээрээ тэмцэж, улс орнууд эдгээр гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд чухал ач холбогдол өгч дорвитой арга хэмжээ авч ажиллахыг эрмэлзэж байна. Монгол Улсын хувьд Asia Pacific Group буюу Ази Номхон Далайн бүсийн байгууллагад 2004 онд гишүүнээр элссэнээс хойш уг байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, ФАТФ-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээг шат дараалан авч байгаа билээ. Энэ судалгаагаар манай улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн хүрээнд банкны ажилтны хүчин зүйл буюу банкны гурван түвшинд үзүүлэх нөлөөллийн эхний түвшний нөлөөллийг тодорхойлж олон улсын сайн туршлага бүхий арга зам санал болгохыг зорьлоо.

ТҮЛХҮҮР ҮГС

Мөнгө угаах, арилжааны банк, харилцагчийг таньж мэдэх

ТОВЧИЛСОН ҮГС, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

АНДМТБ	Ази Номхон Далайн Мөнгө Угаахтай Тэмцэх Байгууллага
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МУЭ	Мөнгө угаахын эсрэг

МҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ХТМ	Харилцагчийг таньж мэдэх

I.УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл

Мөнгө угаах гэмт хэрэг нь санхүүгийн тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдалд ихээхэн аюул учруулж байдаг бөгөөд жил болгон Базелийн засаглалаас улс орнуудын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлсэн тайланг танилцуулдаг билээ. Энэхүү тайланд Зүүн Ази, Номхон Далайн бүсэд харьяалагддаг Монгол улс 1-10 онооноос (1-рүү тэмүүлэх тусам эрсдэл бага) 5.0 оноотой буй учир эрсдэлээс урьдчилан сэргийлэх олон арга замыг эрэлхийлэх шаардлагатай байна. Үүнд банкны ажилтнууд мөнгө угаах үйл ажиллагааг таслан зогсоох, дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Хөгжиж буй орон болох Монгол Улс нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүчирхэг тогтолцоог хэрэгжүүлэхэд олон бэрхшээлтэй учирдаг.

Иймд энэхүү судалгаагаар дараах асуултуудад хариулахыг зорилго болгон дэвшүүлсэн. (1) Монгол Улсад мөнгө угаах эрсдэлд нөлөөлж буй банкны ажилтнуудын хүчин зүйлийг тодорхойлох, (2) урьдчилан сэргийлэх арга зүйг судлах зорилготой юм.

Банкны дотоод сул талуудыг арилгах замаар Монгол улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд үнэтэй ойлголт өгөх мөн Монгол орны нөхцөл байдлаас шалтгаалан ажилчидтай холбоотой мөнгө угаах эрсдэлийг бууруулах сургалт, дагаж мөрдөх хөтөлбөрүүдийн талаар зөвлөмж өгөх нь нэн чухал учир энэхүү судалгааг тасралтгүй судлах гол үндэс болж байгаа билээ.

Судалгааны зорилго

Судалгааны гол зорилго нь мөнгө угаах эрсдэлд банкны ажилтны үзүүлэх нөлөөллийг тодорхойлох бөгөөд сургалт, мэдлэгийг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай талаар улс орнуудын жишээн дээр харьцуулалт хийх ба мөнгө угаах эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах санал дэвшүүлэх юм.

Судалгааны зорилтууд

1. Олон улсад гарсан мөнгө угаах эрсдэлд нөлөөлдөг банкны ажилтны хүчин зүйлийн кейсүүдийг харьцуулах
2. Мөнгө угаах эрсдэлд банкны ажилтны ямар хүчин зүйл нөлөөлж байгааг

тодорхойлох

3. МУЭ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг банкны ажилтны түвшинд сайжруулах санал дэвшүүлэх

Судлагдсан байдлын тойм

Мөнгө угаах нь огтхон ч шинэ гэмт хэрэг биш бөгөөд түүний гарал үүсэл нь албан ёсоор тодорхойлогдоогүй хэдий ч зарим судлаачид МЭӨ 2000 оны үед Хятадын эртний худалдаачид ашиг орлогоо захирагчдаасаа нуун далдалж байсан гэдгийг онцлон тэмдэглэсэн байна (Morris-Cotterill, 1999)

Үүний нэгэн адил «Мөнгө угаах» гэсэн нэр томьёо нь хэд хэдэн боломжит эх сурвалжтай бөгөөд тэдгээрийн аль нь ч тодорхойгүй байдаг. «Мөнгө угаах» гэсэн нэр томьёоны гарал үүсэл нь 1920-иод оны үед мафийн бүлгүүдийн гэмт хэрэг үйлдэхийн тулд халхавч хийж байсан угаалгын газруудын үйл ажиллагаанаас үүдэлтэй гэсэн баттай бус эх сурвалж бий. Мафийн бүлгүүд эдгээр угаалгын газруудыг гэмт хэргийн үйл ажиллагаанаас олж авсан эд хөрөнгийг хууль ёсны дүр төрхөөр харуулах арга хэрэгсэл болгон ашиглаж байжээ. Тэд гэмт хэргээс олсон орлогыг хууль ёсны үйл ажиллагаа буюу эдгээр угаалгын газрын олсон ашиг гэж зарлаж, улмаар «дахин боловсруулж» буюу «угааж» байжээ. «Мөнгө угаах» гэсэн нэр томьёоны үндсийн талаарх энэхүү тайлбар нь 1920-иод оны үед мафийн бүлэглэлүүд болон мөнгө угаалтын хоорондын уялдаа холбоог бодитоор харуулсан эмпирик нотлох баримтуудаар батлагдаагүй тул зохиомол түүх байх боломжтой юм. (Durrieu, 2013)

Гэсэн хэдий ч энэ үеэс эхлэн хууль бус үйлдлээр олсон мөнгийг хууль ёсны санхүүгийн салбарт оруулж, түүнийгээ чөлөөтэй ашигладаг гэх ойлголт нь гэмт хэргийн шинжтэй томоохон үйл ажиллагааны ихэнх бизнесийн загваруудын гол цөм нь байсаар ирсэн нь эргэлзээгүй юм. Мөнгө угаах гэмт хэргийн хамгийн их анхаарал татсан наймаа бол 2011 оны хар тамхины худалдаа байсан бөгөөд энэ нь нийт гэмт хэргийн улмаас олж авсан бэлэн мөнгөний 20 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд зөвхөн кокайны зах зээл нь 88 сая долларын өртөгтэй байдаг аж (Naheem, Money laundering: A primer for banking staff, 2015).

Дэлхийн хэмжээнд мөнгө угаах гүйлгээний тооцоолсон хэмжээ нь дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2-5 хувьтай тэнцэж байна (Sarigul, 2012).

Мөнгө угаахад ашигладаг бусад гэмт хэргийн өргөн хүрээний үйл ажиллагаанаас дурдвал, хууль бус зэвсгийн наймаа, далайн дээрэм, хүний наймаа, улс төрийн авлига зэрэг юм. Ихэнх том хэмжээний гэмт хэргийн байгууллагууд, ялангуяа хар тамхины наймаачдын хувьд санхүүгийн гол асуудал бол гэмт хэрэг үйлдэхэд их хэмжээний бэлэн мөнгө бий болж, улмаар хууль ёсны санхүүгийн салбарт байршуулах шаардлагатай болдог. Эдгээр гэмт хэргийн эхэн үеийн жишээн дээр үндэслэн банкнууд дахь Мөнгө угаалтыг тайлбарлах уламжлалт загварыг боловсруулсаар иржээ.

Өөрөөр хэлбэл банканд бэлэн мөнгө байршуулах, янз бүрийн дансанд мөнгө байршуулах зэргээр бохир мөнгөө хууль ёсны мөнгөтэй нэгтгэж, хууль бус гарал үүслийг нь нуун дарагдуулдаг (Naheem, 2015)

Мөнгө угаах гэдэг нь тухайн гэмт хэрэг үйлдэж буй хувь хүн эсвэл бүлэгт ашиг олох зорилгоор олон тооны гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд юм. Гэмт хэрэгтнүүд мөнгөний эх үүсвэрийг далдлах, хэлбэрийг нь өөрчлөх, эх үүсвэрээс нь өөр газар шилжүүлэх замаар бусдын анхаарлыг татахгүйн тулд үүнийг хийдэг. Эдгээр үйл ажиллагаа нь гэмт хэрэгтнийг эх үүсвэрт нь аюул учруулахгүйгээр ашиг олох боломжийг олгодог. Мөнгөний гарал үүсэл, өмчлөлийг банканд байршуулах, олон гүйлгээнд шилжүүлэх, хууль ёсны хөрөнгөтэй холих зэргээр далдалдаг ба эдгээр алхмуудыг мөнгө байршуулах, үелэх, нэгтгэх гэж нэрлэдэг (Sarigul, 2012).

Мөнгө угаах гэмт хэргийг “Гэмт хэрэг үйлдэж олсон орлого болон тэдгээр орлогын жинхэнэ өмчлөлийг нуун дарагдуулах буюу тодорхой бус болгох, ингэснээр орлогыг хууль ёсны эх үүсвэрээс олж байгаа мэт харагдуулах үйл явц” гэж тодорхойлсон байдаг (Abbott, 2005).

Мөнгө угаагчид хууль бусаар олсон хөрөнгийн эх үүсвэрийг далдлахын тулд үндсэн гурван үе шатыг баримталдаг. Ингэснээр эдгээр хөрөнгийг ашиглахыг эрмэлзэж буй гэмт хэрэгтнүүдэд хохирол учруулахгүйгээр ашиглаж болно. Эдгээр үе шатуудыг байрлуулах, үелэх, нэгтгэх гэж нэрлэдэг.

Эхний үе шат: Байршуулах үйл явцын үед тухайн мөнгөн тэмдэгт нь санхүүгийн системд нэвтэрдэг. Хууль бус хөрөнгийг илүү хөрвөх чадвартай болгохын тулд хадгаламж, мөнгөн гуйвуулга эсвэл бусад аргаар санхүүгийн байгууллагад байршуулдаг. Байрлуулалт нь ихэвчлэн их хэмжээний бэлэн мөнгийг банканд шилжүүлэхээс өмнө үл үзэгдэх, бага хэмжээгээр хуваах замаар хийгддэг.

Хоёрдох үе шат: Байршуулж дууссаны дараа хөрөнгийг илүү хялбар ашиглах, илрүүлэх боломжийг багасгахын тулд эцсийн очих газруудыг салгахын тулд шилжүүлэх ёстой. Оруулсан хөрөнгийг хууль бус эх үүсвэрээс нь салгах үйл явцыг «давхарлах» гэж нэрлэдэг. Давхарлах үе шатанд мөнгө угаагчид мөнгөө давхарлахын тулд янз бүрийн арга хэрэглэдэг ба үүнд олон банк, данс ашиглах, мэргэжлийн хүмүүс зуучлах, корпорац, итгэлцлээр дамжуулан гүйлгээ хийх зэрэг орно.

Гуравдах үе шат: Санхүүжилтийг амжилттай давхаргалуулж, гарал үүслээсээ холдуулсны дараа тэдгээрийг хууль ёсны сан болгон ашиглаж, хянах боломжтой болж, гэмт хэрэгтнүүд эдгээр хөрөнгийг эдийн засагт эргүүлэн оруулдаг. Интеграци гэж нэрлэгддэг энэ үе шатанд хууль бусаар олж авсан хөрөнгө нь хууль ёсны дагуу бий болгосон баялагтай маш төстэй юм. Гэмт хэрэгтэн энэ мөнгийг цаашид гэмт хэргийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж болно (Sarigul, 2012).

Мөнгө угаах ерөнхий арга, арга техник

Мөнгө угаах нь олон янзаар хэрэгжих боломжтой бөгөөд гэмт хэрэгтнүүд аргаа байнга хөгжүүлсээр байна. Гэсэн хэдий ч олон жилийн турш үйл ажиллагаагаа явуулж буй энгийн арга, арга техникүүд байдаг, тухайлбал, харийн наймаа, бүтэц зохион байгуулалт, валютыг хууль бусаар хил давуулах, бэлэн мөнгө хөрвөх, бэлэн мөнгө ихтэй бизнесүүд, санхүүгийн байгууллагууд, казино. Эдгээр бүх арга, арга техник нь нийтлэг шинж чанартай байдаг бөгөөд тэдгээр нь үнэндээ ижил сэдвийн төгсгөлгүй хувилбарууд юм.

- Смурфинг : Смурфинг гэдэг нь хууль бус эх үүсвэрээс авсан бэлэн мөнгийг хадгаламжийн мэргэжилтнүүд эсвэл smurfs хооронд хувааж, янз бүрийн санхүүгийн байгууллагуудад олон дансанд олон хадгаламж хийх замаар мөнгө угаах арга юм. Томоохон бөгөөд ямар ч хамааралгүй хүмүүс уг сангууд, хадгаламж, данс хоорондын холбоог илрүүлэхэд хэцүү болгодог. Өөрөөр хэлбэл, эрх баригчдад илрэхгүйн тулд smurfing хийдэг.
- Бүтэц зохион байгуулалт: Энэ техник нь нэг том санхүүгийн гүйлгээг олон жижиг гүйлгээ болгон задлах арга юм. Бүтэц зохион байгуулж буй хүн дангаараа эсвэл бусад хүмүүстэй хамтран эсвэл тэдний өмнөөс үйл ажиллагаа явуулж болно. Тэрээр нэг буюу хэд хэдэн санхүүгийн байгууллагад нэг буюу хэд хэдэн өдөр ямар ч хэмжээгээр нэг буюу хэд хэдэн гүйлгээ хийх буюу оролдох боломжтой. Бүтэц зохион байгуулалт нь тайлангийн мөнгөн тэмдэгтээр нэг хүн хэд хэдэн бэлэн мөнгө байршуулах эсвэл авахыг хэлнэ.
- Валютын хууль бус наймаа: Энэ нь валют, мөнгөн хэрэгслийг биет байдлаар хууль бусаар хил дамнуулан зөөвөрлөх явдал юм. Валютын хууль бусаар хил давуулах хоёр үндсэн арга нь бэлэн мөнгөний шуудан зөөвөрлөх, бөөнөөр нь бэлэн мөнгө хууль бусаар хил нэвтрүүлэх явдал юм. Бэлэн мөнгөний шуудан зөөгч гэдэг нь мөнгөн тэмдэгт, мөнгөн хэрэгслийг өөр дээрээ эсвэл дагалдан яваа ачаа тээшний хамт биеэр тээвэрлэдэг хүмүүс юм. Мөнгөний бөөнөөр хууль бусаар хил нэвтрүүлэх нь тээврийн хэрэгсэл, арилжааны тээвэрлэлт, буухиа илгээмж, хувийн онгоц, завинд валют, мөнгөн хэрэгслийг нуун дарагдуулах явдал юм.
- Бэлэн мөнгөний хөрвүүлэлт : Энэ нь очир алмаз, алт, үнэт марк болон бусад цуглуулгын эд зүйлсийг бэлэн мөнгө болгон хувиргахад хялбар, хууль бусаар хил нэвтрүүлэхэд хялбар, хууль бусаар хил дамнуулан зөөвөрлөх явдал юм.

Бэлэн мөнгөөр эрчимжсэн бизнес: Мөнгө угаагчид жинхэнэ бизнесээс олсон орлогыг холихын тулд ресторан, жижиглэнгийн худалдаа, архины дэлгүүр, тамхи борлуулагч, хувийн өмчит теллерийн машин, автомат машины оператор, зогсоолын гарааш зэрэг хүмүүсийн анхаарлыг хамгийн бага татахын тулд ихэвчлэн тархсан зарим бизнес, аж ахуйн нэгжүүдийг ашиглаж болно. хууль бус орлоготой.

- Shell Companies : Гэмт хэрэгтнүүд ихэвчлэн ямар ч бодит бизнес эрхэлдэггүй, үйл ажиллагааны ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй далайн эрэг дээрх төвүүдэд хясааны компаниудыг байгуулдаг. Эдгээр компаниудын бизнесийн эргэлт, ашгийн талаар худал мэдээлдэг, санхүүгийн тайлан нь худал байдаг. Хууль бус хөрөнгийн эх үүсвэр, мөн чанарыг нуун далдлах, нуун далдлах зорилгоор бүх төрлийн татвар төлдөг. Гэхдээ тэд далайн эрэг дээр байгаа тул компанийн бүртгэлийг хууль сахиулах байгууллагууд санхүүгийн хяналт, аудит хийх боломжгүй байдаг. Shell компаниудыг байршуулах үе шатанд бэлэн мөнгө хүлээн авахад ашигладаг бөгөөд дараа нь уг хөрөнгийг нэгтгэх зорилгоор өөр улс руу илгээдэг.
- Казино : Казино бүх хүнд нээлттэй, дотор нь олон хүн байдаг бөгөөд хүн бүрийг хянах нь маш хэцүү байдаг. Үүнээс гадна дотор нь тоглож байгаа хүмүүсийн ихэнх нь маш их мөнгөтэй тогтмол байдаг. Энэ нь мөнгө угаагчдын сонирхлыг татахуйц казино болгодог. Тэд хууль бус мөнгөө казиногийн биржид чип, токен байршуулах замаар байршуулдаг. Хамгийн бага тоглосны дараа чип, токеныг казиногийн чекээр эргүүлэн авах ба тоглоомын хожлыг илэрхийлсэн чекийг банкны дансанд байршуулна (Sarigul, 2012).

Судалгааны арга, арга зүй

Судалгаанд анхдагч болон хоёрдогч эх үүсвэрүүдээс мэдээлэл цуглуулах юм. Судлагдсан байдлын үндсэн дээр анхдагч мэдээллийн эх үүсвэр нь судалгаанд оролцогч байгууллагын ажилтнууд юм. Банкны ажилтнуудаас Google Form-оор судалгаа авах бөгөөд мөнгө угаах эрсдэлд нөлөөлөх банкны ажилтны мэдлэг, хандлага, хяналт, туршлага дээр үндэслэн авч үзнэ. Хоёрдогч эх сурвалж нь банкны комплаенсийн ажилтны туршлага бөгөөд ганцаарчилсан ярилцлага хийн мэдээллээ цуглуулах юм.. Мөн банкны ажилтнуудаас авсан судалгааныхнаа дагуу шинжилгээ хийх ба үр дүнд пирсоны корреляцийн коэффициент тооцож ярилцлагын үр дүнгээр мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх санал дэвшүүлнэ.

Хүснэгт I-1 Судлагдсан байдал

1	Money laundering control and suppression of financing of terrorism: Some thoughts on the impact of customer due diligence	Судалгааны зорилго	Санхүүгийн үйлчилгээний салбар дахь мөнгө угаахтай тэмцэх болон терроризмыг санхүүжүүлэх-тэй тэмцэх, харилцагчийн таньж мэдэх арга хэмжээнүүдийн хоорондын хамаарлыг судлах явдал юм (Koker, 2006)
		Судалгааны арга зүй	Кейс судалгаа (ялангуяа Их Британи, Өмнөд Африкийн туршлагад анхаарлаа хандуулсан) болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны олон улсын стандартын шүүмжлэлтэй үнэлгээний хослол юм.

1	measures on financial exclusion, Louis de Koker (2006)		Зохиогч эдгээр стандартын санхүүгийн үл хамаарах нөлөөллийг судалж, хүсээгүй үр дагавраас урьдчилан сэргийлэхийн тулд ХТМ системийг сайтар төлөвлөх шаардлагатайг авч үзсэн (Koker, 2006).
		Судалгааны үр дүн	МУТСийн эсрэг ХТМ арга хэмжээ нь санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд маш чухал боловч тэдгээр нь санамсаргүйгээр санхүүгийн гадуурхалд хүргэдэг. Их Британи, Өмнөд Африк зэрэг улс орнууд гадуурхагдсан хүн амд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгахын тулд ХТМ стандартаа өөрчилж, зохицуулалтын шаардлага, санхүүгийн оролцоонд тэнцвэртэй хандах шаардлагатай байгааг онцолжээ (Koker, 2006).
2	Money laundering and abuse of the financial system, Hasmet Sarigul (2012)	Судалгааны зорилго	Мөнгө угаах гэмт хэрэг ба санхүүгийн тогтолцооны хоорондын хамаарлыг тайлбарлах зорилготой ба мөнгө угаахаас зайлсхийх шийдлүүдийг боловсруулах (Sarigul, 2012).
		Судалгааны арга зүй	Мөнгө угаах, зээлээс чөлөөлөх бодлогод банкуудын гүйцэтгэх үүрэгт дүн шилжилгээ хийсэн ба чанарын шинжилгээний арга ашигласан (Sarigul, 2012).
		Судалгааны үр дүн	Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь олон улсын тулгамдсан асуудал мөн. Улсын төрийн зохицуулах байгууллагууд олон улсын хамтын ажиллагаагаагаа сайжруулах шаардлагатай ба урьдчилан сэргийлэхийн тулд санхүүгийн байгууллагууд харилцагчдыг таньж мэдэх үйл ажиллагаагаа сайжруулан бүртгэх, гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэх, сэжигтэй гүйлгээ, үйл ажиллагааг мэдээлэх, холбогдох төрийн байгууллагаас ирүүлсэн мэдээллийн хүсэлтэд хариу өгч ажиллах шаардлагатай (Sarigul, 2012).
3	Money laundering: A primer for banking staff, Mohammed Ahmad Naheem (2015)	Судалгааны зорилго	мөнгө угаахтай тэмцэхэд банкнуудад тулгарч буй хүндрэл, хариуцлагын талаар тодруулж, эрсдэлийн үнэлгээний идэвхтэй арга барил, технологийн шийдэл, зохицуулах байгууллага, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай байгааг онцлон харуулахыг зорьсон . (Naheem, 2015).
		Судалгааны арга зүй	Мөнгө угаах үйл ажиллагаатай холбоотой кейс харьцуулсан судалгаа хийсэн. Австралийн санхүүгийн тагнуулын нэгжийн тайлангаас эхлээд схем тус бүрийн нарийн төвөгтэй байдлын орчин үеийн түвшинг харуулахын тулд хэд хэдэн кейс судалгааг оруулсан байна (Naheem, 2015).

		Судалгааны үр дүн	Мөнгө угаах үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд банкуудад тулгарч буй хөгжиж буй сорилтуудыг онцолж, эрсдэлийн үнэлгээний үйл явцыг сайжруулах, боловсон хүчнийг сургах шаардлагатай байгааг онцолж байна. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй стратеги боловсруулах, банкны салбарт шинээр гарч ирж буй аюул заналхийллийг даван туулахад эрдэм шинжилгээний байгууллага, салбарын мэргэжилтнүүд, зохицуулах байгууллагуудын хамтын ажиллагааны чухал ач холбогдлыг харуулжээ (Naheem, 2015).
4	Anti-money laundering regulation and practices in indian commercial banks: the banker and customer perspective, B. Viritha (2016)	Судалгааны зорилго	Энэтхэгийн арилжааны банкуудын мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаанд гарч буй банкны ажилтан болон үйлчлүүлэгчийн нөлөөллийг шинжлэх (Viritha, 2016).
		Судалгааны арга зүй	Пондичерри, Ченнай мужуудын 392 банкны ажилтан, 416 банкны харилцагчаас 2014 оны 6-р сараас 2015 оны 1-р сар хүртэл асуулга авсан ба Энэтхэгт мөнгө угаахтай холбоотой зохицуулалт хийх шаардлагатай байгаа талаар ажилтны ойлголт, мөнгө угаах гэмт хэрэг болон банкуудад AML-ийн хэрэгжилтийн үр нөлөө, банкууд дахь AML-ийн хэрэгжилтийг ажилтнууд хүлээн зөвшөөрч буй байдлыг судалсан. Мөн банкуудын AML-ийн практикийг судалж 136 банкны AML дагаж мөрдөж буй хэмжээнд дүн шинжилгээ хийсэн (Viritha, 2016).
		Судалгааны үр дүн	Судалгааны үр дүнд Пудучерри, Ченнай мужийн банкны ажилтнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон түүнээс сэргийлэх арга хэмжээний талаар зөвхөн дунд зэргийн мэдлэгтэй, сургалт хангалтгүй байсан бөгөөд ажилтнууд МУЭ арга хэмжээг чанд дагаж мөрдөхийг бүрэн хүлээн зөвшөөрдөггүй, журамд итгэх итгэл бага байгааг харуулж байна. Санал асуулгад оролцогчдын нэлээд хэсэг нь МУЭ арга хэмжээний практиктэй санал нийлэхгүй байгаа нь банкууд бүх салбараараа МУЭ үйл ажиллагааг хэрэгжилтийг чанд баримтлахгүй байгааг харуулж байна. Банкны үйлчлүүлэгчдийн дунд МУТ-ын талаарх мэдлэг мөн дунд зэрэг ба иргэний үнэмлэх, хаягаа баталгаажуулахад бэлэн байдаг ч жилийн орлого, хөрөнгийн үнэ цэнэ, бусад банк дахь дансны дэлгэрэнгүй мэдээлэл, хөрөнгийн эх үүсвэр гэх мэт мэдээллийг задруулахад дургүй байдаг. "ХТМ-ийн мэдээлэл ил тод болгох нормыг үйлчлүүлэгчдэд үзүүлэх дэмжлэг"-ийн талаарх ажилтнууд болон үйлчлүүлэгчдийн ойлголт ихээхэн ялгаатай байна.

4			Энэхүүойлголтынялгаанаасүзэхэдбанкуудмэдээлэл задруулахтай холбоотой үйлчлүүлэгчдийнхээ хүсэл сонирхлыг дутуу үнэлж байна, эсвэл банкны үйлчлүүлэгчид ХТМ-ийн мэдээлэл задруулдаг гэж боддог хэмээн дүгнэжээ (Viritha, 2016).
5	Combating Money Laundering in Malaysia: Current Practice, Challenges and Suggestions, AMA Latif, A Abdul-Rahman (2018)	Судалгааны зорилго	Малайзын сонгосон банкуудын мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх өнөөгийн практикт дүн шинжилгээ хийх, Мөнгө угаахтай тэмцэх үр дүнтэй зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад тотгорыг судлах, арга замыг тодорхойлоход судалгааны зорилго оршино (Abdul-Rahman, 2018).
		Судалгааны арга зүй	Малайзын банкны байгууллагуудын AML-ийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд Conventional with Islamic Window Local Bank, Conventional with Islamic Window Foreign Bank, Full fledge Islamic Bank, Development Bank зэрэг банкнуудын 6 оролцогчтой хийсэн ярилцлага хийсэн. Практикт дүн шинжилгээ хийх, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд учирч буй саад тотгорыг судлах, сайжруулах арга замыг тодорхойлох гэсэн гурван хэсэгт бүхий ярилцлага нь 60-аас 95 минут үргэлжилсэн бөгөөд гарсан үр дүнд чанарын шинжилгээ хийсэн (Abdul-Rahman, 2018).
		Судалгааны үр дүн	AML зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл нь шинжээч боловсон хүчний дутагдалтай холбоотой юм. Мөнгө угаах гэмт хэргийн талаарх үйлчлүүлэгчдийн боловсрол, мэдлэг дутмаг байгаагийн зэрэгцээ нэмэлт хүчин
5			зүйл болж байна. Иймд Малайз дахь AML-ийн хэрэгжилтийг сайжруулахын тулд энэ судалгаа нь юуны түрүүнд гэмт хэрэгтнүүдийн эсрэг хатуу арга хэмжээ авахын тулд засгийн газар болон холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг санал болгов. Хоёрдугаарт, санхүүгийн гэмт хэргийн талаарх олон нийтийн мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр банкууд болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах. Гуравдугаарт, ажилчдыг сургах, тогтолцооны менежментийг сайжруулах, дагаж мөрдөх нэгжийн хангалттай нөөцийг бүрдүүлэхэд хөрөнгө оруулалт хийх, эцэст нь банкны эрсдэлийн менежментийн “Гурван хамгаалалтын шугам”-ыг эрчимжүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлжээ (Abdul-Rahman, 2018).

6	Anti-money laundering and customer due diligence in finnish banking system – current state and future improvements, Tommi Laine (2019)	Судалгааны зорилго	Финландын банкууд дахь МУТ практик болон ХТМ үйл ажиллагааны өнөөгийн байдлыг судлах явдал юм. Энэхүү судалгаа нь МУТ-ийн хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд мэдээллийн системийн үүрэг ролийг ойлгох, МУТ практикийн ирээдүйн чиг хандлагыг урьдчилан таамаглах, мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр өсөн нэмэгдэж буй зохицуулалтын шаардлагыг шийдвэрлэх зорилготой юм. Нэмж дурдахад уг судалгаа нь байгууллагын хэмжээнд үр дүнтэй хэрэгжилтийг хангахын тулд банкны ажилтан бүр AML практикийн зорилго, үүргийг ойлгохын чухлыг онцлон харуулахыг зорьсон (Laine, 2019).
		Судалгааны арга зүй	Банкны салбарт ажиллаж буй МУТ мэргэжилтнүүдээс мэдээлэл цуглуулах ярилцлагын аргыг ашиглан үр дүн нь дүн шинжилгээ хийсэн. Судалгаанд МУТ үзэгдлийн өнөөгийн байдал болон ирээдүйн талаарх санал бодол, үр дүнтэй байдлын талаарх хэтийн төлөвтэй холбоотой асуултуудыг багтаасан (Laine, 2019).
		Судалгааны үр дүн	Мөнгө угаахтай тэмцэх практикийн ач холбогдлын талаар санал асуулгад оролцогчдын дунд зөвшилцөл гарсан бөгөөд энэ нь МУТ-тэй холбоотой мэдээллийн системийг боловсронгуй болгох шаардлагатай байгааг онцолжээ. Нэмж дурдахад энэхүү судалгаа нь Финландын банкны салбарын МУТ үйл явц болон практикийн цаашдын чиг хандлагыг тасралтгүй сайжруулахын ач холбогдлыг онцолсон (Laine, 2019).
7	Challenges in customer due diligence for banks in the UAE, Dina ElYacoubi (2020)	Судалгааны зорилго	Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны сул талуудыг задалж, АНЭУ-д эдгээр аюул заналхийлэлд өртөж буй тодорхой динамик байдалд дүн шинжилгээ хийх явдал юм (ElYacoubi, 2020)
		Судалгааны арга зүй	Одоо байгаа ном зохиол, янз бүрийн эх сурвалжийн нийтлэлд тулгуурлан Арабын Нэгдсэн Эмират улсын банкуудад харилцагчийн хяналт шалгалтын талаар тулгарч буй тодорхой динамик, сорилтуудыг судалж, дүн шинжилгээ хийсэн (ElYacoubi, 2020).
		Судалгааны үр дүн	Араб нэрстэй харьцахад тулгардаг бэрхшээлүүд, эцсийн өмчлөгчийг тодорхойлоход хүндрэлтэй асуудлууд, баялаг болон сангийн эх үүсвэрийг тогтооход тулгарч буй бэрхшээлүүд, улс төрийн нөлөөл бүхий хүмүүстэй холбоотой санаа зовоосон асуудлууд, зардал нэмэгдэл зэрэг нь эрсдэлийг бууруулахад сайжруулах шаардлагатай гол салбарууд гэж тодорхойлсон (ElYacoubi, 2020).

8	Overview international best practices on customer due diligence and related anti-money laundering measures, Howard Chitimira, Sharon Munedzi (2022)	Судалгааны зорилго	Харилцагчийг таньж мэдэх мөнгө угаахтай тэмцэх олон улсын шилдэг туршлагуудад дүн шинжилгээ хийх зорилготой юм. Дэлхийн хэмжээнд мөнгө угаах үйл ажиллагаатай хэрхэн үр дүнтэй тэмцэж чадах вэ гэдэгт хариулт олох судалгааны ажил (Munedzi, 2022).
		Судалгааны арга зүй	Дэлхий даяар мөнгө угаах үйл ажиллагааг таслан зогсоохын тулд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын шилдэг туршлагыг ашигласан анхны судалгаа болсон ба кейс харьцуулсан чанарын шинжилгээ хийсэн (Munedzi, 2022).
		Судалгааны үр дүн	Санхүүгийн гадуурхалт, нөөцийн хомсдол зэрэг сорилтуудын улмаас Өмнөд Африк зэрэг хөгжиж буй орнуудад ХТМ арга хэмжээг хэрэгжүүлэх нь үр дүн багатай байгаа ба хөгжиж буй орнуудад олон улсын арга хэмжээ, шилдэг туршлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн дэд бүтэц, улс төрийн хүсэл зориг үргэлж байдаггүй гэдгийг байна. ФАТФ болон BCBS нь хөгжиж буй орнуудын онцлог хэрэгцээнд нийцсэн шинэ стандартууд болон/эсвэл шилдэг туршлагуудыг боловсруулах талаар цаашид авч үзэх ёстой хэмээн дүгнэжээ (Munedzi, 2022).
9	Analysis on the significance and effectiveness of anti-money laundering policies and regulations of Financial Institutions (Investment Banks) in India, Shwetha Vasudeva Murthy (2022)	Судалгааны зорилго	Энэтхэгийн санхүүгийн байгууллагууд мөнгө угаах үйл ажиллагааг нухацтай авч үзэхгүй байгаа тул дутуу дулимаг, сайжруулах шаардлагатай нөлөөллүүдийг олохын тулд доорх судалгааг хийсэн. Мөнгө угаахтай тэмцэх бодлого, журмыг мөрдөж ажиллах явцад банкны ажилтнуудад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлоход чиглэсэн ба Энэтхэгийн хөрөнгө оруулалтын банкуудад голчлон анхаарсан (Vasudeva Murthy, 2022).
		Судалгааны арга зүй	Энэтхэгийн Карнатака мужийн Бангалор хотын Kotak Bank, HSBC, Societe Generale, Commonwealth Bank, Deutsche Bank зэрэг хувийн болон олон улсын банкуудад ажиллаж буй 100 банкны ажилтнуудаас анхан шатны мэдээллийг асуулгын хэлбэрээр цуглуулан шинжилсэн (Vasudeva Murthy, 2022).
		Судалгааны үр дүн	Банкны ажилтнуудын AML-ийн ойлголт дутмаг ба сургалт хангалтгүй байгаа нь банкуудад AML хэрэгжүүлэхэд томоохон саад болж байна. Банкны ажилтнууд МУЭ-ийн шаардлагыг дагаж мөрдөхийн ач холбогдлыг бүрэн мэддэггүй бөгөөд итгэдэггүй аж. Мөнгө угаах гэмт хэргийг таслан зогсоох арга хэрэгсэл болох

9			AML протоколуудын хэрэгжилт мэдэгдэлтэй санал нийлэхгүй байгаа нь байгууллагууд өөрсдийн байршил бүрт МУЭ-ийн нийцлийг хатуу хэрэгжүүлэхгүй байж болзошгүйг харуулж байна. Үйлчлүүлэгчид дэлгэрэнгүй мэдээлэл, өгөхийг хүсдэггүй, ХТМ мэдээллээ шинэчлэх, гүйлгээгээ тайлагнах банкуудын шаардлагыг дагаж мөрдөхөөс татгалздаг (Vasudeva Murthy, 2022).

Эх сурвалж: Судлаачдийн боловсруулснаар

II.ОНОЛЫН ТОЙМ

А. Мөнгө угаахтай холбоотой онолууд

White collar crime: Цагаан захтны гэмт хэргийн талаар хууль эрх зүйн хувьд нэг тодорхойлолт байдаггүй бөгөөд цаг хугацаа өнгөрөх тусам эдгээр гэмт хэргийн цар хүрээ өргөжиж, цахим гэмт хэрэг, эрүүл мэндийн залилангийн гэмт хэрэг, оюуны өмчийн гэмт хэрэг болон бусад зүйлийг багтаасан гэдгийг анхаарах нь чухал юм. Цагаан захтны гэмт хэргийг бүрдүүлдэг тодорхой үйл ажиллагаа нь харилцан адилгүй бөгөөд монополын эсрэг зөрчил, татварын гэмт хэрэг, зохицуулалтын зөрчил болон бусад хэлбэрийн залилан мэхлэх, хууран мэхлэх үйлдлүүд гэх мэт. (fbi.gov)

Цагаан захтны гэмт хэрэг нь өнгөлөн далдлах, хууран мэхлэх, итгэл алдах замаар санхүүгийн ашиг олох зохион байгуулалттай, хүчирхийлэлгүй шинж чанартай хууль бус арга хэрэгсэл юм. Эдгээр гэмт хэрэгтнүүд эд баялаг, нийгмийн байр сууриа ашиглан хохирогчдын итгэлийг нуун дарагдуулах, хууран мэхлэх, хуулийг зөрчих зорилгоор ашигладаг. Нийгэм, эдийн засгийн өндөр байр суурьтай хүмүүс үйлддэг ба хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийн санхүүгийн давуу талыг ашигладаг. (Wallstreet Mojo, 2024)

Зураг II.1.1 Цагаан захтны гэмт хэргийн үйл явц



Эх сурвалж: acamstoday.org, 2022

Fraud Triangle: Залилангийн гурвалжин нь хүмүүс яагаад ажлын байран дээрээ залилан хийдэг шалтгааныг тайлбарласан ойлголт юм. Энэ нь залилан мэхлэлтийн шалтгаан болдог дараах гурван элементээс бүрдэнэ.

Дарамт: Залилан хийх сэдэл, хэрэгцээг бий болгодог санхүүгийн болон сэтгэл санааны нөхцөл байдлыг хэлнэ.

Боломж: Залилан мэхлэх үйлдлийг баригдалгүйгээр хийх боломжтой нөхцөл байдлыг хэлнэ.

Оновчтой байдал: Хүмүүс өөрсдийнхөө хууран мэхлэх үйлдлээ зөвтгөх үйл явцыг хэлнэ. Тэд өөрсдийн үйлдлүүдийг зайлшгүй шаардлагатай, үндэслэлтэй, эсвэл ямар нэгэн байдлаар хууль бусаар олсон ашиг олох эрхтэй гэж өөрсдийгөө итгүүлж магадгүй юм.

Залилангийн гурвалжин нь тодорхойлогч загвар биш, харин залилан мэхлэх зан үйлд нөлөөлж буй хүчин зүйлсийг ойлгоход тусалдаг ба эдгээр элементүүдийг шийдвэрлэснээр байгууллагууд залилан мэхлэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой (CFI)

Зураг II.1.2 Залилангийн гурвалжин



Эх сурвалж: (Sujeewa, 2018)

Agent Theory: Мөнгө угаах гэмт хэргийн хүрээнд төлөөлөгч нь хууль бус мөнгө угаах үйл явцад оролцож буй хувь хүн, аж ахуйн нэгжийг хэлж болно. Эдгээр агентууд захиралд сангийн гарал үүслийг нуун дарагдуулж, хууль ёсны мэт харагдуулахын тулд өөрсдийн мэдлэг, туршлага, нөөц бололцоогоо ашиглаж болно (C.James, 2024)

Агентын онол нь ашиг сонирхлын зөрчилдөөн, үүрэг гүйцэтгэгч болон төлөөлөгчийн хоорондын мэдээллийн тэгш бус байдлыг зохицуулах тухай онол юм. Энэ онол нь төлөөлөгч болон захирлуудын хооронд маргаан болон бусад асуудлууд гарах магадлалыг багасгахын тулд агентлагийн харилцааг бий болгох талаар авч үздэг (A.Gayatri, 2023)

Зураг II.1.3 Агентын онол



Эх сурвалж: (Y.Keizer, 2018)

Game Theory: Тоглоомын онол нь ямар ч хувилбарт олон тоглогчдын хоорондын харилцан үйлчлэлийг тодорхой дүрмүүд, тоон үзүүлэлтээр илэрхийлдэг. Энэ онолыг янз бүрийн шийдвэр, хязгаарлагдмал нөөц, өөр сонголтоос үүдэлтэй өөр өөр үр дүн, тоглогчдын хоорондын өрсөлдөөн эсвэл хамтын ажиллагаа зэрэгтэй холбоотой нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд ашиглаж болно (Bhattacharyya, 2024)

Зураг II.1.4 Тоглоомын онолын хүрээ



Эх сурвалж: (Сугармаа, 2023)

Crying wolf: Хэт их тайлагнах нь мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд тайлангийн мэдээллийн үнэ цэнийг бууруулснаар чухам юу чухал болохыг тодорхойлж чадахгүй болохыг тайлбарладаг онол. Утгачилбал «Чоно уйлсан хүү» үлгэрийн зүйрлэлээр ойлгож болно. Үлгэрт хүү “Чоно ирж байна” хэмээн байнга уйлдаг байсан тул түүний уйлах нь сүүлдээ утгагүй болжээ. Мэдээлэх нь зүгээр л өгөгдлийг гүйлгэж харах бус үнэхээр чухал өгөгдлийг чадварлаг, шинжээчээр тодорхойлох явдал юм.

Банк гүйлгээг хянадаг тул гүйлгээний талаарх мэдээлэл, дохиог хүлээн авдаг. Мэдээлэлтэй банк, дохио хүлээн авснаар сэжигтэй үйл ажиллагааны тайланг гаргаж Засгийн газарт мэдээлэх боломжтой. Төрөөс банканд хяналт тавьж, сэжигтэй зүйл тайлагнаагүй тохиолдолд торгодог. (E.Takáts, 2007)

Зураг II.1.5 Crying wolf онолын загвар схем



Эх сурвалж: (E.Takáts, 2007)

Judgement and decision making

Зураг II.1.6 Шүүн тунгаах болох шийдвэр гаргалт




Эх сурвалж: (Effective judgement and decision making for business)

Мөнгө угаах эрсдэлийг үнэлэхдээ банкны байгууллагын ажилтнууд ямар шинж нь тухайн хүнийг мөнгө угаагч болохыг илтгэж болохыг тодорхойлох танин мэдэхүйн чадвартай байх шаардлагатай. Хүмүүс хэрхэн шийдвэр гаргах нь асуудлын зөвхөн нэг хэсэг боловч илүү чухал зүйл бол хүмүүсийг илүү сайн шийдвэр гаргах явдалд хөтөлж буй зан чанар болон шүүлт юм (Isaa, 2015).

Байгууллагын соёл: Системийн хандлагын онол

Гүйцэтгэлийн гурвалжин нь нийтлэг зорилготой, эрүүл харилцаатай, үр дүнтэй хамтран ажилладаг дээд албан тушаалтан болон ажилчдаар дэмжигддэг систем, манлайлал, соёлын гол төв цэгүүд бүхий динамик системийн дүрслэл юм (Alsharari, 2021).

Зураг II.1.7 Гүйцэтгэлийн гурвалжин



Эх сурвалж: (Alsharari, 2021)

Дээрх гурвалжин дараах хэмжигдэхүүнүүдээр тодорхойлогдоно.

- Зорилго – Ажилчдын байгууллагын зорилгын талаарх ойлголт нь нийтлэг.
- Харилцаа холбоо – Ажилчид болон дээд албан тушаалтнуудын хооронд итгэлцэл, зөвшилцөл бүхий эрүүл харилцаатай ба хоорондоо харилцан мэдлэгээ солилцож, өсөн дэвжихэд тусалдаг.
- Хамтын ажиллагаа - Ажилчид болон дээд албан тушаалтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа амжилтанд хүрэхийн тулд мэдлэгээ хуваалцаж, нийтлэг зорилгын төлөө хамтран ажилладаг (Alsharari, 2021).

Энэхүү онолыг банкны МУТ үйл ажиллагаатай холбож үзвэл байгууллагын дээд албан тушаалтнууд МУЭ үйл ажиллагаа болон ХТМ үйл ажиллагааны зорилгыг ажилчиддаа бүрэн ойлголтыг өгөх ба дээд албан тушаалтан болон ажилчдын хооронд илгэлцэл бүхий харилцаатай, харилцан мэдээлэл солилцон ажиллах, цаашлаад нийтлэг зорилго буюу МУЭ-ээс урьчилан сэргийлэхийн тулд хамтарч ажиллавал энэхүү эрсдэлээс байгууллагын түвшинду урьдчилан сэргийлж чадах юм.

В. Олон улсын шаардлага, дүрэм журам, зохицуулалт

Basel committee three lines of defence

Банкны хяналтын Базелийн хороо нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын эрсдэлийн засаглалын хүрээ болгон гурван шугамын хамгаалалтын (3LOD) үзэл баримтлалыг танилцуулсан. Энэхүү тогтолцоо нь үйл ажиллагааны эрсдэлийг удирдах хариуцлагыг байгууллагын доторх гурван чиг үүрэгт хуваадаг.

Хамгаалалтын нэгдүгээр шугам: Хамгаалалтын эхний шугам нь эрсдэлийг шууд эзэмшиж, удирддаг хүмүүсээс бүрдэнэ. Эдгээр хүмүүс ихэвчлэн өөрсдийн бизнесийн нэгж, чиг үүргийн хүрээнд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах үүрэгтэй.

Хамгаалалтын хоёрдугаар шугам: Хоёр дахь хамгаалалтын шугам нь эхний шугамыг хянаж, бодлогоо тодорхойлж, эрсдэлийг тэсвэрлэх чадварыг тодорхойлж, тэдгээрийг биелүүлэхийг баталгаажуулдаг. Энэхүү хамгаалалтын шугам нь эрсдэлийн удирдлагын үр дүнтэй туршлагыг баталгаажуулахын тулд эхний мөрөнд удирдамж, дэмжлэг, хяналтыг өгдөг.

Хамгаалалтын гуравдугаар шугам: Гурав дахь хамгаалалтын шугам нь дотоод аудитын чиг үүргийг гүйцэтгэдэг. Энэ нь эрсдэлийн удирдлагын арга барил, дотоод хяналтын үр нөлөөг үнэлэх замаар эхний хоёр шугамын бие даасан баталгааг хангадаг. Дотоод аудитын чиг үүрэг нь эрсдэлийн удирдлагын үйл явц төлөвлөсний дагуу ажиллаж байгаа эсэхийг баталгаажуулж, сайжруулах зөвлөмжийг өгдөг.

Зураг II.2.1 Гурван шатлалт хамгаалалт



Эх сурвалж: (T.Ken, 2020)

Хамгаалалтын эхний шугам нь үндсэн бизнесийн нэгжүүд болон үйл ажиллагааны ажилтнуудад хамаарна. Тэд өдөр тутмын үйл ажиллагаандаа эрсдэлийг тодорхойлох, удирдах, бууруулах үүрэгтэй. Үүнд:

- Тогтсон бодлого, журмыг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх.
- Гүйлгээний зөвшөөрөл, тохирол, харилцагчийн хяналт зэрэг хяналтын үйл ажиллагааг гүйцэтгэх.
- Боломжит эрсдэлтэй асуудлуудыг тодорхойлж, удирдлагад мэдээлэх.

Эрсдэлийг үр дүнтэй удирдахад хүчтэй эхний хамгаалалтын шугам чухал. Өдөр тутмын үйл ажиллагаанд хяналтыг суулгаснаар ажилтнууд гарч болзошгүй асуудлуудыг илрүүлэх эхний эгнээнд ордог. Энэ нь эрт хөндлөнгөөс оролцох боломжийг олгож, алдагдлын магадлалыг бууруулдаг. (bis.org, 2020)

Risk management 4 prisiples

Зураг II.2.2 Эрсдэлийн удирдлагын 4 арга



Эх сурвалж: (H.Micheal, 2023)

Эрсдэлийн удирдлагын хүрээнд зайлсхийх, шилжүүлэх, хүлээн зөвшөөрөх, бууруулах гэсэн дөрвөн үндсэн зарчмыг баримталж болно.

Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх нь ямар ч үр нөлөөг бууруулдаггүй. Гарах магадлал өндөргүй эрсдэлээс зайлсхийхэд их мөнгө зарцуулахыг хүсдэггүй компани эрсдэл хүлээн авах стратегийг ашиглана.

Эрсдэлээс зайлсхийх нь аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм.

Эрсдэлийг шилжүүлэх гэдэг нь эрсдэлийг хүссэн гуравдагч этгээдэд хүлээлгэн өгөх явдал юм. Хэрэв шилжүүлсэн эрсдэл нь тухайн компанийн үндсэн чадвар биш бол энэ нь компанид ашигтай байж болно. Компани үндсэн чадамжид илүү анхаарал хандуулахын тулд үүнийг бас ашиглаж болно.

Эрсдэлийг бууруулах стратеги нь зарим арга хэмжээ авах замаар компанийн өртөлтийг хязгаарладаг. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ эрсдэлээс зайлсхийх эсвэл хоёуланг нь дунджаар ашигладаг стратеги (H.Micheal, 2023)

ФАТФ-ын зөвлөмж

Хүснэгт. II.2.3 ФАТФ-ын урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зөвлөмжүүд

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	ФАТФ-ын зөвлөмж.
Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль тогтоомж	Улс орнууд санхүүгийн байгууллагын нууцын тухай хууль нь ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд саад болохгүй байх ёстой.

Харилцагчийг таньж мэдэх	Нэргүй дансыг хориглох Хэрэглэгчийн таних, баталгаажуулах Ашиг хүртэгч өмчлөгчийг тодорхойлох Хуулийн этгээдийн ард байгаа хувь хүнийг тодорхойлох Бизнесийн харилцааны зорилго, зорилгын шинж чанарыг тогтоох Гүйлгээнд байнгын хяналт, шалгалт хийх
Баримт материал хадгалах	Харилцагчийн бүртгэл, түүний гүйлгээний бүртгэлийг 5-аас доошгүй жил хөтөлнө Лавлагааны дагуу дотоодын эрх бүхий байгууллагад бүртгэлтэй байх
Улс төрд нөлөө бүхий этгээд	PEP-ийг тодорхойлох зөв систем Ахлах удирдлага нь ТТБ-тай харилцаа тогтоохыг зөвшөөрөх ёстой ХЭТ-ийн хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох оновчтой арга хэмжээ Зохих шалгалтын хяналтыг сайжруулах
Корреспондент банкны үйл ажиллагаа	Харилцаа холбоо тогтоохын өмнө хариуцагч банкны мэдээллийг бүрэн гүйцэд бөглөнө үү Хариуцагч банкны ML/CFT хяналтын үнэлгээ харилцаа тогтооход дээд удирдлагаас зөвшөөрөл авах шаардлага Бусад байгууллагын үндсэн үүрэг хариуцлагын талаархи ойлголт
	Хариуцагч банк ЦХТ-ийн арга хэмжээ авч байгаа эсэхийг баталгаажуулж, үйлчлүүлэгчийн хүсэлтээр ЦХБ-ын баримт бичгийг гаргаж өгөх боломжтой
Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ	Бүх мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч тусгай зөвшөөрөлтэй бөгөөд үр дүнтэй хяналт-шинжилгээ, дагаж мөрдөх системтэй Мөнгө эсвэл үнэ цэнийн шилжүүлгийн үйлчилгээ (MVTS) агентууд нь тусгай зөвшөөрөлтэй бөгөөд үр дүнтэй хяналт-шинжилгээ, дагаж мөрдөх системтэй
Шинэ технологи	Шинэ бүтээгдэхүүн, бизнесийн үйл ажиллагаа, хүргэх механизм зэргээс үүдэлтэй ML эрсдэлийг тодорхойлох, үнэлэх Шинэ технологитой холбоотой эрсдэлийг тодорхойлох Ийм эрсдэлийг бууруулахад чиглэсэн зохих арга хэмжээ
Цахим шилжүүлэг	Шилжүүлгийг үүсгэн байгуулагч болон хүлээн авагчийн зөв мэдээлэл Шаардлагатай үүсгэгч болон ашиг хүртэгчийн мэдээлэл дутмаг мөнгөн шилжүүлгийг тодорхойлох Зориулалтын хүмүүсийн эсрэг мөнгөн шилжүүлгийг шалгах
Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх	Гуравдагч этгээдийг таних, баталгаажуулах, байрлах улс орныг тодорхойлохдоо тухайн улсын эрсдэлийн түвшинг харгалзан үзэх Шаардлагад хяналт тавьдаг холбогдох эрх бүхий байгууллага байдаг бол холбогдох Эрх бүхий байгууллага нь улс орны өндөр эрсдэлийг тухайн нэгдлийн МУТСТ механизмууд хангалттай түвшинд бууруулах тохиолдолд) гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх угтвар нөхцөл байх албагүй хэмээн шийдвэрлэжболно.
Дотоод хяналт болон гадаад дахь салбар, охин компани	Банкуудын ХӨХГ-ын дотоод бодлого, журмыг боловсруулах Банкуудын гадаад салбарууд болон тэдгээрийн охин компаниуд ML/CFT арга хэмжээ авч байгаа эсэхийг баталгаажуулах

Өндөр эрсдэлтэй улс орнууд	ФАТФ-ын дагуу эрсдэл өндөртэй орнуудад хамаарах харилцагч/гүйлгээг сайтар нягтлах Иймм улс орнуудын эсрэг зохих арга хэмжээ авах
Сэжигтэй гүйлгээг мэдээлэх	Сэжигтэй гүйлгээг тодорхойлох системийг зөв хэрэгжүүлэх STR-ийн талаар Санхүүгийн Тагнуулын Алба (СМА) -д нэн даруй мэдээлэх.
Мэдээллийг задруулах болон нууцлал	СМА-д мэдээлэл өгөх тухай хуулиар банкны ажилтан, захирлуудыг хамгаалах Банкны ажилтан, захирлуудад лавлагаа өгөхийг хуулиар хориглосон
СББМҮҮ: Харилцагчийг таньж мэдэх	Казино, үл хөдлөх хөрөнгийн зуучлагч , үнэт металл, үнэт чулуу арилжаалагчид, өмгөөлөгч, нотариатч, бусад хараат бус хуульчид болон нягтлан бодогчид харилцагчын өмнөөс тодорхой үйл ажиллагааг бэлтгэх буюу гүйцэтгэх үед, траст, компанийн үйлчилгээ үзүүлэгчид харилцагчдын өмнөөс тодорхой үйл ажиллагааг бэлтгэх буюу гүйцэтгэх үед ХТМ үйл ажиллагаа явуулна.
СББМҮҮ: Бусад арга хэмжээ	Өмгөөлөгч, нотариатч, бусад хараат бус хуульчид болон нягтлан бодогчид харилцагчдынхаа өмнөөс буюу зааврааp хийж байгаа санхүүгийн гүйлгээг, үнэт металл, үнэт чулуу арилжаалагчид босго дүнтэй тэнцүү буюу түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг, траст, компанийн үйлчилгээ үзүүлэгч нар харилцагчдынхаа өмнөөс буюу зааврааp тодорхой гүйлгээ хийх үед сэжигтэй гүйлгээгээр мэдээлэх үүрэгтэй.

Эх сурвалж: (Irfan Hassan Jaffery, 2020)

III. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Монгол улсын банкны салбарын өнөөгийн байдал

Одоогийн Монголбанк нь 1924 онд Худалдаа аж үйлдвэрийн банк нэртэйгээр дотоодын анхны банк болж байгуулагдсан. 1991 онд улс төр, нийгэм, эдийн засгийн шинэчлэлийн үр дүнд хоёр түвшний банкны тогтолцоо бий болсон. Үүнээс хойш арилжааны 31 банк байгуулагдсан ч хэд хэдэн банк санхүүгийн эх үүсвэрээ төлж барагдуулахгүй, өөрийн хөрөнгөө нэгтгэх, татан буулгах зэрэг шалтгаанаар үйл ажиллагаагаа зогсоосон байна.

Хүснэгт III.1.1 Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын тоо, 2023




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин 2023 оны байдлаар Монгол Улсын нийт засаг захиргааны нэгж, хот, хөдөөд 12 банк, 1387 салбар нэгж үйл ажиллагаа явуулж байна. Банкны салбарын

хөрөнгийн хэмжээ манай улсын ДНБ-ий 88 орчим хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улсын дэд бүтцийн зонхилох салбар гэдгийг илтгэж байна. Санхүүгийн зах зээлд банкууд нь иргэдийн хөрөнгө оруулалтын үндсэн эх үүсвэр болж, 2023 оны байдлаар Монгол Улсын нийт санхүүгийн салбарын 75.3 хувийг эзэлж байна.


Хүснэгт III.1.2 Санхүүгийн салбарын зах зээлд эзлэх хувь, банкны салбараар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2023 оны эцсийн байдлаар системийн нөлөө бүхий таван банкны активын хэмжээ нь зах зээлийн дийлэнх хувийг эзэлж байна. Харин үлдсэн 7 банкны нийт активын хэмжээ зах зээлийн 10 хувийг бүрдүүлж байгаа бол 32 хувийг Хаан банк, 21 хувийг Худалдаа хөгжлийн банк, 19 хувийг Голомт банк дангаараа эзэлж байна.


Хүснэгт III.1.3 Арилжааны банкуудын зах зээлд эзлэх хувь, 2023 /активаар/



Эх сурвалж: Банкуудын тайлан

2023 оны байдлаарх системийн нөлөө бүхий топ 5 банкны орлогын тайланг авч үзэхэд, Хаан банкаар дамжуулж дийлэнх мөнгөн гүйлгээ хийгдэж байгаа ба дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт III.1.4 Топ 5 банкны орлогийн тайлангийн голлох үзүүлэлтүүд, 2023



Эх сурвалж: Банкуудын тайлан

2023 оны байдлаар хамгийн их харилцагчтай банкууд нь Хаан болон Төрийн банк байна. Харин нийт ажилтны тоогоор мөн л Хаан болон Төрийн банк давамгайлж байна.

Хүснэгт III.1.5 Топ 5 банкны нийт болонкомплаенсын ажилтнуудын тоо

Банкны нэр	Нийт ажилтнуудын тоо	Нийт харилцагчдын тоо	Комплаенсын ажилтнуудын тоо
Хаан банк	6500 гаруй	2.3 сая	
ХХБ	2200 гаруй	931 мянга	14
Голомт банк	2300 гаруй	1 сая	
Хас банк	1172	950 мянга	
Төрийн банк	4000 гаруй	2.3 сая	

Эх сурвалж: Банкуудын тайлан

Хүснэгт III.1.6 2016 ба 2020 онуудын эрсдэлийн үнэлгээний эрсдэлтэй бүтээгдэхүүн үйлчилгээний харьцуулалт

2020 оны эрсдэлийн үнэлгээ			2016 оны эрсдэлийн үнэлгээ	
№	Дундаас дээш эрсдэлтэй бүтээгдэхүүн үйлчилгээ	Дунд түвшний эрсдэлтэй бүтээгдэхүүн үйлчилгээ	№	Эрэмбэлэгдэх байдлаар эрсдэлийн түвшин тодорхойлогдоно.
1	Гадаад шилжүүлэг	Харилцах дансны бүтээгдэхүүн үйлчилгээ	1	Төлбөр тооцооны бүтээгдэхүүн

2	Корреспондент банкны харилцаа	Хугацаагүй хадгаламж	2	Депозитын бүтээгдэхүүн болох харилцах, хадгаламжаар хийгдэх гүйлгээ
3	Валют арилжаа	Картын бүтээгдэхүүн, үйлчилгээ	3	Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ

Эх сурвалж: Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан


Банкны салбарын МУТСТ тухайд авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд зохистой засаглалын үүднээс авч үзвэл банкны өмчийн эзэд, тэдний төлөөлөл болсон ТУЗ нь МУТС-тэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, ажиллах нөхцөл бололцоог хангах үүрэг хүлээнэ. Банкны гүйцэтгэх удирдлага ТУЗ-аас баталсан МУТС-тэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн талаар ТУЗ-д дэлгэрэнгүй тайлагнахын зэрэгцээ банкны МУТС эрсдэлийн үнэлгээг хийж авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулан ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлэх үүрэгтэй. ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагаас хараат бус хяналтын тогтолцоог бүрдүүлэн бодлого, журмын үр дүнтэй хэрэгжиж, эрсдэлийг удирдаж чадаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах шаардлагатай. (Монгол Банк, 2016)

Хүснэгт III.1.7 Банкны салбарын мөнгө угаахтай тэмцэх үндсэн хяналтын чанарын үнэлгээ

ДУНДЫН ХУВЬСАГЧИЙН ҮНЭЛГЭЭ	ҮНДСЭН ХЯНАЛТЫН ЧАНАРЫН ХУВЬСАГЧИД	ҮНЭЛГЭЭ-ОНОО
Мөнгө угаахтай тэмцэх хяналт шалгалтын чанар (Үнэлгээ – 0.70)	Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнтэй байдал	0.70
	Захиргааны хариуцлага хүлээлгэх тогтолцоо, түүний хэрэгжилт	0.80
Банкны салбарын ажиллагсдын комплаенсын түвшин (Үнэлгээ – 0.60)	Банкны салбарын ажиллагсдын ёс зүй, үнэнч шударга байдал	0.70
	Эрүүгийн хариуцлага хүлээлгэх тогтолцоо, түүний хэрэгжилт **	0.60
	Банкны салбарын ажиллагсдын МУТСТ талаарх мэдлэг, чадвар	0.60
	Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнтэй байдал *	0.70

Эх сурвалж: Харилцан үнэлгээний тайлан 2020

Хүснэгт III.1.8 Банкны мөнгө угаах эрсдэлд өртөж болзошгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ



Эх сурвалж: Харилцан үнэлгээний тайлан 2020

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудын бүтээгдэхүүн үйлчилгээний 2017, 2018, 2019 оны өгөгдөл, мэдээллийг нэгтгэн дүгнэж, 13 эрсдэлийн хүчин зүйлд үнэлгээ хийсний үндсэн дээр бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийг тодорхойлов (Харилцан үнэлгээний тайлан 2020).

1.2 Монгол улсын хууль эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

Банкны салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглан гэмт хэргийн орлогыг өөрсдөөсөө холтгох, ул мөрийг нь баллах, хууль ёсны мэт болгох боломжтойгоос гадна гэмт хэргийн орлогоор банкинд хувь эзэмших, банк байгуулах болон гэмт этгээдүүд банкны удирдлагад нэвтрэн орж хууль бус үйл ажиллагаа явуулах эрсдэлтэй. Дээрх байдлаас үүдэн олон улсын хэмжээнд банкны салбар мөнгө угаах эрсдэлийн хувьд өндөр эрсдэлтэй салбарт тооцогддог. Санхүүгийн алдагдлын хувьд банкууд мөнгө угаах гэмт хэргийн улмаас жилийн нийт орлогынхоо 1 орчим хувийг алддаг гэж Базелийн мөнгө угаахтай тэмцэх индексийн 2021 оны тайланд дурджээ. Базелийн мөнгө угаахтай тэмцэх индексийн 2024 оны байдлаар

Энэ дүн нь 1 хувь гэж хэмжигдэх хэдий ч зөвхөн АНУ-ын зах зээлд гэхэд олон тэрбум долларын алдагдалтай тэнцдэг байна. (Basel Institute on Governance, 2022) Энэ байдал манай улсын хувьд ч ижил бөгөөд нийт санхүүгийн системд банкны салбарын эзлэх хувь хэмжээ маш өндөр 2016 болон 2020 онуудад дэд ажлын хэсэг байгуулагдан тус салбарын эрсдэлийн үнэлгээг хийж байсан. Банкны үйлчилгээг авахад хялбар, түргэн шуурхай байдал, олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог, хаанаас ч үйлчилгээг нь авах боломжтой зэрэг нь

гэмт хэргийн орлогын байршил, хэлбэр, хэмжээг өөрчлөх ул мөрийг нь баллахад тохиромжтой болгодог тул хууль бусаар олсон орлогыг дамжин өнгөрүүлэх бааз болгон ашигладаг гэсэн үр дүнд хүрсэн. (Монгол Банк, МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН, 2020)

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан биет хохирогчгүй ба хохирлын хэмжээ нь бодитоор тодорхойлогддоггүй эдийн засаг, нийгэм, улс төр гэсэн гурван үндсэн харилцаанд хамгийн их хор хохирол учруулдаг тэр нь шууд бусаар эерэг сөрөг үр дагаварууд бий болгоно. Банк санхүү, хөрөнгө оруулалт, худалдаа үйлчилгээ, үнэт цаас буюу эдийн засаг, нийгмин салбар, улс төр дэх нөлөөллийн үр дагаварууд байна. (Мэндбаярын Амина, 2023)

Манай улс 2001 Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2002 мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, эрүүгийн хууль, 2006 мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль батлан хүлээсэн үүрэг, арга хэмжээ, олон улсын стандарт зөвлөмжийг баримтлан ажиллаж байна. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2006 оны 07 сарын 08-ны өдөр баталсан бөгөөд 2013 оны 05 сарын 31-ний өдөр Улсын Их Хурлаас тус хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хуулийн гол зорилт нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд энэхүү ажиллагааг хэрэгжүүлэх үндэс суурь нь хуулиар мэдээллэх үүрэг хүлээсэн этгээдүүд 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр, тооцооны гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээллэх явдал юм.

Энэхүү хуулийн гол цөм нь Санхүүгийн мэдээллийн алба юм. Санхүүгийн мэдээллийн алба нь дээрх мэдээллэх үүрэгтэй этгээдүүдээс мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага юм. Мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай - хууль нь мөнгө угаах гэмт хэргийг цогцоор нь шийдвэрлэх үндсэн хэм хэмжээ чиг баримжаа болох ёстой.

Хүснэгт III.2.1 Монгол Улсын Эрүүгийн хууль

2002.01.13 163 дугаар зүйл.	2008.02.01 268[1] дүгээр зүйл.	2009.12.24 166[1] дүгээр зүйл.	2014.01.16 166[1] дүгээр зүйл.	2015.12.03 18.6 дугаар зүйл
Илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан үйлдэл.	Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах, эсхүл хуурамч мөнгө тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого.	Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийн хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан шилжүүлсэн, хувиргасан үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцсон.	Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан эсхүл үүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч,	Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч,
			эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан үйлдэл.	эсхүл эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан үйлдэл

Эх сурвалж: Монгол Улсын Эрүүгийн хуулийн заалтууд

Мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг тулгуурлан Эрүүгийн хууль болон бусад бодлого журамд тус гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг нарийвчлан зохицуулах ёстой.

Хүснэгт III.2.2 Шүүхээс шийдвэрлэсэн банкаар дамжин гарах мөнгө угаах гэмт хэргийн тохиолдол

Шүүхээс шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэргийн товч		
Шийдвэрийн огноо	Хэргийн товч утга	Шийдвэрлэсэн байдал
Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014.08.19-ний өдрийн 1025 дугаар шийтгэх тогтоол	Шүүгдэгч М.Б нь Электрон системс ХХК-ийн Голомт банкин дахь 11...1 тоот дансаар 1.062.959.200 төгрөгийг шилжүүлэн авч завшсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хаируцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор Их Британи Виржиний арлуудад Медиа Саммит Лимитед гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж, улмаар тус компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонг Конг дахь HSBS банкин дахь 848...838 тоот харилцах дансанд 2013.01.10-ны өдөр 150.000 ам.доллар шилжүүлж, улмаар Электрон системс ХХК-ийн Голомт банкин дахь 11..7 тоот дансаар 2013.02.05-ны өдөр 144.960 ам.долларыг буцаан хүлээн авсан.	Шүүгдэгч М.Б-г мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэний улмаас онц их хэмжээний хохирол учруулан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцсон. Шүүгдэгч М.Б-д 6 жилийн хугацаагаар хоирх ял тус тус шийтгэсэн. Хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэсэн.

Эх сурвалж: Монгол улсад Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэж бу шүүхийн практик, анхаарах зарим асуудал, 2018

Дээрх хэргийн хувьд МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилллаж байсан Б.Эрдэнэбилэг, Р.Бат-Эрдэнэ, Ц.Орхон болон тус компанийн Япон улсын Токио хот дахь төлөөлөгчийн газрын ерөнхий төлөөлөгч, Санхүү, Комерийн асуудал эрхэлсэн дэд захирал Ч. Хоролсүрэн, түүний төрсөн дүү Ч. Суурьтогтох, хувийн компанийн ажилтан Н.Гантөмөр, (Г.Азжаргал, Б.Мягмарсүрэн, 2018) тэр дундаа банкны салбарын мэргэжилтнийг ашиглаж мөнгө угаасан кейс тохиолдол юм. Голомт банкны 6 дугаар салбарын эрхлэгчээр ажиллаж байсан “Г.Саранчимэг” нь “Цагаан захтны онол”-ын дагуу тайлбарлах бол хууль бусаар олсон орлогыг байршуулах үе шатанд гар бие оролцсон байна. Иймд мөнгө угаах эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйл банкны ажилтаны ёс зүйн зан төлөв байх бүрэн боломжтой бөгөөд тэдний мэргэжлийн ёс зүйд анхаарах шаардлага, хэрэгцээ өндөр байна.

3.3 Монгол улсын банкны ажилтнуудад ордог комлаенс сургалт

Нийт 12 банкны комплаенсийн газар хэлтэс гүйцэтгэх удирдлагад харьяалагддаг бөгөөд шууд гүйцэтгэх удирдлагад харьяалагдах бие даасан комплаенсын газар, хэлтэстэй 4 банк, эрсдэлийн удирдлагын дор байрлах комплаенсын хэлтэстэй 2 банк, Хуулийн дор байрлах бие даасан газартай 1 банк байна. Бие даасан

газар, нэгжгүй, банкны бусад газар нэгжийн хамт байрладаг эсвэл жижиг алба байгуулагдсан 5 банк байна.

Хүснэгт III.2.1 Монгол улсын банкны ажилтнуудад ордог комлаенс сургалт

№	Байгуул-лагын нэр	Сургалтын нэр	Сургалтын хугацаа	Сургагч багш	Хамрах хүрээ
1	MCA-Mongolian Compliance Association	Комплаенсын мэргэжилтнийг чадавхжуулах хөтөлбөр	6 сарын хөтөлбөр	МКХолбооны сургагч багш нар нь банкны салбар болон ВХҮҮ салбарт ажиллаж байгаа, комплаенс МҮТСТ чиглэлээр 5-9 жил ажилласан туршлагатай багш нар	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх суурь мэдлэг олгох хөтөлбөр
2	Санхүүгийн боловсролын ХАБ	Зөвхөн комплаенс, МҮТСТ чиглэлээр биш банкны бусад үйл ажиллагаа, soft skill, компанийн засаглал зэрэг төрөл бүрийн сэдвүүдийг хамрана.		Банк санхүүгийн салбар болон Банкуудын холбооны сургагч багш нар	МКХолбоо нь Санхүүгийн боловсролын Хабтай комплаенс МҮТСТ сургалт ороход хамтарч ажилладаг.
3	Монголын банкуудын холбооны дэргэдэх Банк санхүүгийн академи нь	Комплаенс, МҮТСТ чиглэлээр сургалт зохион байгуулдаг.		Банкуудын комплаенс болон Монголбанк, СЗХорооны мэргэжилтнүүдийг урьж сургагч багшаар ажиллуулдаг / гэрээт/	Банк санхүүгийн салбар
4	СЗХороо	Комплаенс, МҮТСТ чиглэлээр сургалт зохион байгуулдаг.		Монголбанк, СЗХороо, Санхүүгийн мэдээллийн албанаас мэргэжилтнүүд хамрагддаг.	ББСБ-ын холбоо

5	Банкуудын холбооны дэргэд Комплаен-сийн мэргэжлийн зөвлөл	Сургалт ордоггүй ч энэ жилийн төлөвлөгөөндөө иргэдийн комплаенсийн боловсролыг дээшлүүлэх талаар зарим ажлуудыг зохион байгуулах гэж байгаа.		Хурал форум хэлэлцүүлэг зохион байгуулдаг.	Бүх арилжааны банкуудын комплаенсийн мэргэжилтнүүд гишүүнээр хамрагддаг.
6	МХАҮ Танхим, Ёс зүйн болон комплаен-сийн хороо	Бизнесийнёс зүйн соёлыг нийт танхимын гишүүн байгууллага, компанид түгээх зорилготой гэж харсан.			МУТСТ гэхээсээ илүү Ёс зүй талруугаа анхаардаг.
7	ICA International Compliance Association	Бүх төрлийн англи хэл дээр сургалтууд орно.	1 жил	Олон улсын сургагч багш нар	MCA-Mongolian Compliance-тай хамтран суурь онолын нэг сургалтыг Монгол хэл дээр орж сертификат олгоно.

Хүснэгт III.2.2 Олон улсын сайн туршлага дахь хүний нөөц бэлтгэх сургалт

№	Улсын нэр	Зохицуулагч байгууллага/ мэргэжлийн холбоо	Сургалтын хөтөлбөр
1	АНУ	АНУ-ын Валютын хяналтын алба (OCC)	Банкны хууль тогтоомжийг дагаж мөрдөх ажилтнуудад зориулсан төрөл бүрийн сургалтын хөтөлбөр, нөөцийг санал болгодог. Эдгээр хөтөлбөрүүд нь хууль тогтоомжийн тогтолцооны талаарх ойлголтыг нэмэгдүүлж, үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвараар хангах зорилготой юм.
		Америкийн банкны холбоо (ABA)	Тус холбооноос олон сургалт явуулдаг бөгөөд МУТСТ-тэй холбоотойгоор дараах хөтөлбөрийг санал болгодог. - Certified AML and Fraud Professional (CAFP) and Certified Regulatory - Certified Regulatory Compliance Manager (CRCM)
		Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар (FinCEN)	Bank Secrecy Act (BSA) Training – Энэхүү сургалт нь банкуудад МУТС, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд шаардлагатай хяналтыг бий болгоход туслах зорилгоор байгуулагдсан.
2	Их Британи	Олон улсын комплаенсын нийгэмлэг (ICA)	Мөнгө угаахтай тэмцэх диплом (DipAML)-ийг Их Британийн Санхүүгийн Зохицуулалтын Газар (FCA) хүлээн зөвшөөрч санал болгодог байна.
		The London Institute of Banking and Finance	Банк санхүүгийн болон комплаенсын чиглэлээр сургалт явуулдаг.
3	Канад	FINTRAC	Canada’s Anti-Money Laundering and Anti-Terrorist Financing (AML/ATF) Regime Training – энэхүү сургалтыг заавал дуусгахыг шаарддаг.
4	Австрали	AUSTRAC	AUSTRAC Compliance Officer (ACO) сертификат нь тусгайлсан тайлагнадаг байгууллагуудад ажилладаг хүмүүст зориулагдсан. МУТСТ үүрэг, комплаенс мэдлэг, ойлголтыг баталгаажуулах зорилгоор олгодог.
5	Сингапур	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх салбарын түншлэл (ACIP)	Сингапурын мөнгө угаахтай тэмцэх мэргэшсэн мэргэжилтэн (SGCAM)- сертификат Сингапурын Мөнгө угаах газар (MAS) болон Худалдааны асуудал эрхэлсэн газар (CAD) дэмждэг.

IV. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

4.1 Кейс харьцуулалт

Монгол улсын МУТС-тэй тэмцэж буй арга барилыг олон улсын бусад урд болон хойно явж буй улсуудтай харьцуулах замаар ямар хөгжүүлэлтийг хийх шаардлагатайг тодорхойлох зорилготойгоор Базелиас гаргадаг дэлхийн МУТС эрсдэлийг үнэлдэг бие даасан үнэлгээ болох Базелийн AML индексийг ашиглан судалгааны үр дүнг тайлбарласан болно.

Базелийн засаглалын хүрээлэнгээс энэхүү баримт бичигт Санхүүгийн үйл ажиллагааны ажлын хэсэг (FATF), Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг олон нийтэд нээлттэй 15 эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн эрсдэлийн оноог өгдөг. ФАТФ-ын улс орнуудын эрсдэлийн оноо нь дараах таван чиглэлийг хамардаг:


1. AML / CFT хүрээний чанар
2. Хээл хахууль ба авлига
3. Санхүүгийн ил тод байдал, стандарт
4. Олон нийтийн ил тод байдал, хариуцлага
5. Хууль эрх зүйн болон улс төрийн эрсдэл

Монгол улс Зүүн Ази, Номхон далайн бүсэд харьяалагддаг бөгөөд Базелийн засаглалаас энэ бүсийн МУТС-тэй холбоотой дараах дүгнэлтийг гаргасан байдаг. Авлига, хээл хахууль, хүний наймаа, байгаль орчны гэмт хэрэг, олон нийтийн болон санхүүгийн ил тод байдал, түүнчлэн энэ бүс нутгийн улс төр, хууль эрх зүйн тогтолцоо зэрэг янз бүрийн зүйлд эрсдэлийн түвшний ялгаа мэдэгдэхүйц өөр буйг дурдсан. Харьяаллын гуравны нэг орчим нь өндөр эрсдэлтэй байна хэмээсэн ба Латин Америкийн нөхцөл байдалтай адил кэйстэй улсуудын хар тамхины наймаанаас олсон ашиг нь онцгой анхаарал татаж байгаа бөгөөд АНУ-ын Олон улсын хар тамхины хяналтын стратегийн тайланд улс орнуудын 40 хувь нь энэ хүрээнд мөнгө угаах томоохон хууль тогтоомжид тооцогддог байна. Үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ХО/CFT арга хэмжээний үр нөлөө нь ерөнхийдөө ашиг тустай байгаа хэдий ч өмчлөхөөс урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангахтай холбоотой арга хэмжээнүүдийн үр дүн бага байна.

Нийт эрсдэлийн оноо бүс нутгийн хувьд 5.47 гарсан байна: Үүнд,

1. AML / CFT хүрээний чанар нь 5.95
2. Хээл хахууль, авлига 4.55
3. Санхүүгийн ил тод байдал, стандарт 5.13
4. Олон нийтийн ил тод байдал, хариуцлага 4.44
5. Хууль эрх зүйн болон улс төрийн эрсдэл 3.90

Зураг IV.1.1 Зүүн Ази, Номхон Далайн бүсийн МУТС эрсдэлийн үнэлгээ



JURISDICTION	OVERALL SCORE
Hong Kong SAR, China	4.93
Samoa	4.95
Mongolia	5.00
Indonesia	5.01
Malaysia	5.21

Эх сурвалж: Базелийн тайлан, 2023

Кэйс харьцуулалтын шинжилгээг хийж гүйцэтгэхдээ МУТС эрсдэл хамгийн бага орнуудаас Шинэ Зеланд, Норвеги улсуудыг сонгож харин хойно явж буй улсуудаас Индонези, Малайз улсуудыг сонгон авлаа. МУТС эрсдэлээр эдгээр улсуудыг жагсаавал,

Хүснэгт IV.1.1 Кэйс харьцуулалтын улсууд дахь арга барил

№	Улс	МУТС-тэй тэмцдэг арга барил	МУТС эрсдэл
1	Шинэ Зеланд	● МУТС тэмцэх журам нь салбар бүрийн үйл ажиллагаанд тохирсон байдаг. ● Санхүүгийн байгууллагууд сэжигтэй үйл ажиллагааг эрх бүхий байгууллагад мэдээлэх шаардлагатай. ● Банкууд болон бусад байгууллагууд харилцагчдынхаа хэн болохыг шалгаж, хөрөнгийн эх үүсвэрийг ойлгох ёстой. ● Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн янз бүрийн байгууллагууд хамтран ажилладаг.	3.38
2	Норвеги	● Норвегид сэжигтэй үйл ажиллагааны тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийж, түгээдэг Санхүүгийн тагнуулын алба байдаг. ● Олон улсын хориг арга хэмжээний жагсаалтыг чанд мөрдөж, хориг арга хэмжээ авсан улс орон эсвэл хувь хүмүүсээр дамжуулан мөнгө угаахаас урьдчилан сэргийлдэг. ● Төр хуийн хэвшил, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа маш сайн.	3.45

3	Индонези	• Индонез улсад PL/CFT зохицуулалтууд байдаг. • Сэжигтэй гүйлгээний тайлан, дүн шинжилгээг тогтмол хийдэг. • Их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээний зохицуулалтыг чангатгахаар ажилладаг.	5.01
3	Малайз	• Зохицуулах байгууллагууд санхүүгийн байгууллагад хяналт тавихдаа эрсдэлд суурилсан арга барилыг хэрэгжүүлдэг. • Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах байгууллага, санхүүгийн байгууллага, олон улсын түншүүдийн хамтын ажиллагааг сайжруулахаар ажилладаг.	5.21

Эх сурвалж: Судлаачдийн боловсруулсанаар

Дээрх кэйс харьцуулалтыг дүгнэвэл, Шинэ Зеланд, Норвеги зэрэг өндөр хөгжилтэй орнууд хууль сахиулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтралыг хүчтэй хэрэгжүүлдэг бөгөөд илүү бат бөх тогтолцоотой байдаг байна. Харин, Монгол, Индонез, Малайз зэрэг хөгжиж буй орнуудад ижил төстэй хууль тогтоомжтой байж болох ч нөөцийн хязгаарлалтын улмаас хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй тулгардаг байна.

4.2 Асуулгын судалгаа

Судлагдсан байдлын тоймоос харахад МУЭ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд банкны ажилтнуудын МУЭ-ын тухай мэдлэг чухал нөлөөтэй. Чадвартай боловсон хүчний хомсдол, санал хүсэлт дутмаг, хэрэглэгчийн дэмжлэг дутмаг, хууль эрх зүйн хязгаарлалт зэрэг бусад хүчин зүйлүүд нь МУЭ-ээс урьдчилан сэргийлэхэд нөлөөлдөг. Тиймээс ажилтны мэдлэг, хандлага, туршлага, хяналтын цар хүрээг ойлгох нь банкны удирдлага, зохицуулагчид болон бодлого боловсруулагчид МУЭ-ээс урьдчилан сэргийлэх стратегийг дахин боловсруулахад туслах ба улмаар банкны МУЭ-д нийцэх байдлыг сайжруулна. Үүний дагуу энэ бүлэгт энэхүү судалгааны ажлын 1-р бүлэгт дурдсан зорилтыг биелүүлэхийн тулд хийсэн судалгааны үр дүнг тайлбарласан болно.

Санал асуулгыг гүүгл форм хэлбэрээр онлайнаар тараасан ба банкуудын 25 ажилтан хариулсан байна. Хүснэгт IV.2.1-д судалгаанд оролцогчдын товч танилцуулгыг үзүүлэв.

Хүснэгт IV.2.1 Судалгаанд оролцогчдын товч танилцуулга

Хариултын ангилал		Хариулагчдын тоо (%)
Таны ажлын байрны чиг үүрэг	1. Фронт оффис буюу салбар тооцооны төв	15 (60)
	2. Комплаесын нэгж	10 (40)

Банкны салбарт ажил эрхэлсэн хугацаа	1. 1-5 жил	15 (60)
	2. 6-10 жил	8 (32)
	3. 16-20 жил	2 (8)

Жич: Хаалтанд байгаа тоонууд нь судалгаанд оролцогчдын тоог хувиар илэрхийлнэ.

Асуулгад оролцогчдын талаас илүү хувь нь (60%) нь фронт оффис буюу салбар тооцооны төв, харин үлдсэн 40% нь комплаесын нэгж судалгаанд оролцогчид байна. Ажлын туршлагыг харгалзан үзвэл судалгаанд оролцогчдын 60% нь 1-5 жил, 32% нь 6-10 жил, 21.4 хувь нь нэг жилээс доош, 8% 16-20 жил ажилласан туршлагатай байна.

Тус судалгааны хүрээнд банкуудын ажилтнуудаас авах судалгааг Доктор Вириттагийн боловсруулсан асуултаас түүвэрлэн авсан ба мэдлэг, хандлага, хяналт, туршлага гэсэн бүлгийн хүрээнд 5 тодорхойлох, 20 үндсэн нийт 25 асуулттай юм

4.2.1 Үнэн зөв байдлын шинжилгээ

Хүснэгт IV.2.1.1 Үнэн зөв байдлын шинжилгээ 1

Reliability Statistics

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.750	.792	19

Item-Total Statistics

Асуулт	Cronbach's Alpha if Item Deleted
МУТСТ болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны талаар сургалтанд тогтмол хамрагддаг уу?	.733
Танай банк ажилтнууддаа зориулан харилцагчийг таньж мэдэх сургалтыг хэр давтамжтай зохион байгуулдаг вэ?	.747
МЭДЛЭГ	
Мөнгө угаах нь гэмт хэрэг үйлдэх замаар олсон "бохир" мөнгийг "цэвэр" буюу хууль ёсны болгох мэт харагдуулах үйлдэл ба хээл хахууль, авлигыг өдөөх замаар эдийн засаг, улс үндэстэнд сөргөөр нөлөөлнө.	.739
Танай банк МУТСТ хуулийг үйл ажиллагаандаа тогтмол уялдуулан ажилладаг.	.735
Мөнгө Угаахтай Тэмцэх зохицуулалт нь олон улсын болон олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг тул банкны үйл ажиллагаанд үнэ цэн бий болгоно.	.743
Харилцагчийг Таньж Мэдэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагын дагуу МУТС асуумжаас шалтгаалан харилцах данс нээлгэхээс татгалзах тохиолдол илэрдэг.	.742

ХАНДЛАГА	
Манай улс мөнгө угаасан хэргээр ял шийтгэл ноогдуулсан хүмүүсийн тоо бараг байхгүй ба гэмт хэрэг үйлдэх замаар олсон “бохир” мөнгийг хураах нийтэд ил тод мэдээлэх нь маш бага байдаг.	.749
Банк нь улс төрийн нөлөө бүхий этгээдийн талаар хангалттай мэдээлэл (хувь хүний мэдээлэл, хөрөнгийн эх үүсвэр) цуглуулж чадахгүй байгаа.	.736
Банк нь 20 сая ба түүнээс дээш дүнтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээний тайланг Санхүү мэдээллийн албанд илгээдэг.	.737
Мөнгө Угаахтай Тэмцэх бодлого идэвхигүй байдалд байгаа бөгөөд шинээр гарч ирж буй эрсдэлт хүчин зүйлсийн эсрэг урьдчилан сэргийлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулаагүй удсан.	.729
Мөнгө Угаахтай Тэмцэх зохицуулалт нь олон улсын болон олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг тул банкны урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үнэ цэн бий болгож байна.	.734
Манай банк харилцагчийн холбогдох бүх баримт бичиг/мэдээлэл цуглуулж, баталгаажуулан хориглогдсон хүн/улсын жагсаалтад хамрагдсан эсэхийг тулгасны дараа данс нээдэг.	.721
Одоо хэрэгжүүлж буй Мөнгө Угаахтай Тэмцэх арга хэмжээ болон дүрэм журам нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх шийдвэр гаргасан оролцсон хүмүүс, улс төрийн нөлөө бүхий этгээдийг мөнгө угаах эрсдэлд оролцохоос сэргийлж чадахгүй байна.	.741
	.747
	.755
ХЯНАЛТ	
Харилцагчийн эрсдэлээс үл хамааран үйл ажиллагааны тав тухыг хангах үүднээс бүх хэрэглэгчийн дансанд хяналт бага тавьдаг.	
Харилцагчийг Таньж Мэдэх үйл ажиллааны тайланг банкны аудитын хороонд тодорхой тогтсон хугацаанд хүргүүлж ажиллаж байна.	.753
ТУРШЛАГА	.742
Банкны харилцагч нь Харилцагчийг Таньж Мэдэх үйл ажиллагааны дагуу шаардлагатай бичиг баримт бүрдүүлэхээс татгалздаг бөгөөд жилийн орлого, дансны үлдэгдэл, хөрөнгө орлогы дэлгэрэнгүй мэдээлэл ил тод өгөхөөс татгалзах, худал мэдээлэл өгөх тохиолдол гардаг.	.724
Харилцагчийг Таньж Мэдэх журам нь эцсийн өмчлөгчийг тодорхойлох үед, улс төрийн нөлөө бүхий этгээд болон түүний гэр бүлийн гишүүд/ хамаатан/ байгууллагын албан тушаалтнууд хоорондын холбоог илрүүлхэд хангалттай бус байдаг.	.741
Сэжигтэй гүйлгээнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх журам нь тодорхойгүй, ойлгомжгүй ба сэжигтэй гүйлгээг цаг тухайд нь илрүүлэх нь нь хэцүү ажил юм.	
Банкууд хоорондоо хууль зөрчигчид, сэжигтэй харилцагчдын талаар албан ёсоор мэдээлэл солилцож чадахгүй байна.	

Эх сурвалж: Судлаачдийн боловсруулснаар

Хүчин зүйлүүдийн үнэн зөв байдлын шинжилгээ хийхэд ажилласан жилийг хассанаар найдвартай байдал 0.7-с дээш болох байсан тул хасаж шинжилгээ хийсэн.

Хүснэгт IV.2.1.2 Үнэн зөв байдлын шинжилгээ 2

Reliability Statistics

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.735	.746	5

Item-Total Statistics

Асуулт	Cronbach's Alpha if Item Deleted
МУТСТ болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны талаар сургалтанд тогтмол хамрагддаг уу?	.691
Мөнгө угаах эрсдэлээс урьчилан сэргийлэх тухай мэдлэгийн тухай асуултууд	.706
Мөнгө угаах эрсдэлээс урьчилан сэргийлэхэд хандах хандлагын тухай асуултууд	.624
Мөнгө угаах эрсдэлээс урьчилан сэргийлэх хяналтын тухай асуултууд	.771
Мөнгө угаах эрсдэлээс урьчилан сэргийлэх туршлагын тухай асуултууд	.640


Эх сурвалж: Судлаачдийн боловсруулснаар

Хүчин зүйлүүдийн бүлэг хоорондын хамаарлыг шалгахын тулд медиануудыг олж, шинжилгээ хийхэд сургалтын давтамжийг хассанаар 0.7-с дээш болох байсан тул хасаж шинжилгээ хийсэн.

4.2.2 Пирсоны корреляцийн коэффициент

Пирсоны корреляцийн коэффициент "-1"-ээс "1"-ийн хооронд утга авах бөгөөд хоёр хувьсагч хоорондоо шугаман хамаарлын хүчийг хэмждэг. Корреляцийн коэффициент 1 байх үед хоёр хувьсагч эерэг хамааралтай бөгөөд энэ нь нэг хувьсагчийн өсөлт нөгөө хувьсагчийн өсөлт дагалддаг. Хэрэв корреляцийн коэффициент тэг бол хоёр хувьсагчийн хооронд огт холбоо байхгүй гэсэн утгатай ба -1 утга нь хүчтэй сөрөг хамаарлыг харуулдаг байна. SPSS программ дээрх үр дүнгийн Sig.2 (tailed) хэсэгт ач холбогдлын түвшин илэрхийлэгдэх ба стандарт альфа утга 0.05-с бага заах үед статистикийн хувьд өндөр ач холбогдолтой гэж дүгнэх боломжтой. Эсрэг тохиолдолд статистикийн хувьд 2 хувьсагчийн хооронд ач холбогдол байхгүй гэж үзнэ.

Зураг IV.2.2.1 Корреляцийн коэффициентийн хүрээ



Эх сурвалж: (Maitily Parathi Tasan, 2023)

Хүснэгт IV.2.2.2 Корреляцийн коэффициент

Correlations

		Сургалт	Туршлага	Хандлага	Мэдлэг
Сургалт	Pearson Correlation	1	.407*	.514**	.360
	Sig. (2-tailed)		.043	.009	.077
	N	25	25	25	25
Туршлага	Pearson Correlation	.407*	1	.700**	.233
	Sig. (2-tailed)	.043		.000	.262
	N	25	25	25	25
Хандлага	Pearson Correlation	.514**	.700**	1	.512**
	Sig. (2-tailed)	.009	.000		.009
	N	25	25	25	25
Мэдлэг	Pearson Correlation	.360	.233	.512**	1
	Sig. (2-tailed)	.077	.262	.009	
	N	25	25	25	25

**. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).*

***. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).*

Эх сурвалж: Судлаачдийн боловсруулснаар

Ажиглалтаас харахад тогтмол сургалтанд хамрагддаг хүчин зүйл нь МУЭ-ээс урьчилан сэргийлэх үйл ажиллагааны хандлагатай 0.514, туршлагатай 0.407 корреляцийн коэффициенттэй буюу шууд хамааралтай гарчээ. Мөн МУЭ-ээс урьчилан сэргийлэх үйл ажиллагааны хандлага нь туршлагатай 0.700 буюу өндөр хамааралтай, мэдлэгтэй 0.512 корреляцийн коэффициенттэй буюу шууд хамааралтай гарлаа. Үүнээс харахад Та МУТСТ болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны талаар сургалтанд тогтмол хамрагдсанаар МУЭ-ээс урьдчилан сэргийлэх хандлага нэмэгдэж, илүү туршлага суудаг. Цаашлаад хандлага сайжирснаар мэдлэг мөн нэмэгдэж МУЭ-ийн эсрэг чадварлаг боловсон хүчин болох боломжтой гэж дүгнэлээ.

4.3 Фокус ярилцлага

Ганцаарчилсан ярилцлагыг гадаад хувьцаа эзэмшигчид дийлэнх хувийг эзэлдэг Хасбанк болон 100% дотоодын хувьцаа эзэмшигчид бүхий Төрийн банкны комплаенсийн мэргэжилтнүүдээс авлаа. Хүснэгт IV.3.1, Хүснэгт IV.3.2-д 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаарх Хасбанк болон Төрийн банкны хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг харуулав.

Хүснэгт IV.3.1 Хасбанкны хувьцаа эзэмшигчид

#	Хувцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Хувь	#	Хувцаа эзэмшигчид	Хувь
1	ТСН	1,000,000,000	94.99%	1	MAK Invest Kft	19.37%
				2	International Finance Corporation (IFC)	16.63%
				3	ORIX Corparation	16.28%
				4	European Bank for Reconstruction and Development (EBRD)	12.50%
				5	National Bank of Canada (NBC)	10.18%
				6	Ronoc Partners Kft	9.83%
				7	Mongolia Financial Services Pte Ltd	6.42%
				8	Triods Fair Share Fund	3.61%
				9	М.Болдоо	0.10%
				10	Ч.Ганболд	0.09%
2	Олон нийт	52,700,000	5.01%			
	Нийт	1,052,700,000	100.00%			

Эх сурвалж: (Хасбанкны жилийн үйл ажиллагааны тайлан, 2024)

Хүснэгт IV.3.2 Төрийн банкны хувьцаа эзэмшигчид

#	Хувцаа эзэмшигчид	Хувь
1	Сангийн яам	49.26%
2	Хадгаламжийн даатгалын корпораци	45.03%
3	Олон нийт	5.71%
	Нийт	100.00%

Эх сурвалж: (Төрийн банкны жилийн үйл ажиллагааны тайлан, 2024)

Хасбанкны хувьцаа эзэмшигчид нь Дэлхийн банкны группын гишүүн International Finance Corporation, Японы ORIX Corparation, Европ, Канадын банк гэх мэт дийлэнх хувь нь гадаадын хөрөнгө оруулагчид байдаг бол Төрийн банк нь 100% дотоодын хувьцаа эзэмшигчдээр санхүүжүүлэгддэг аж.

Ганцаарчилсан ярилцлагын судалгааны үр дүн 2 банкны комплаенсийн мэргэжилтнүүдээс ярилцлагын аргыг ашиглан дараахь 4 асуулт бүхий дэлгэрэнгүй ярилцлага авсан. Үр дүнг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт IV.3.3 Ганцаарчилсан ярилцлагын судалгааны үр дүнгийн нэгтгэл

ХАСБАНК	ТӨРИЙН БАНК
Монгол улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын гаргасан журмаас гадна олон улсын гэрээ конвенц, корреспондент банкуудын шаардлага, гадаадын зээлдүүлэгч байгууллагуудтай хийсэн гэрээний холбогдох заалтуудыг мөрдөж ажилладаг.	Саарал жагсаалтанд орсоноос хойш ажлын хэсэг байгуулаад СМА, Монголбанкны мөнгө угаахтай тэмцэх хэлтэс, Терроризмын үндэсний зөвлөл гэх мэт байгууллагууд хамтран ажиллаж холбогдох хууль тогтоомжуудаа дор бүр нь шинэчилсэн ба хууль тогтоомж, журмуудад нийцэж ажилладаг.
Тайланг гүйцэтгэх захирал болон эрсдэл хариуцсан захиралдаа давхар тайлагнадаг.	Тайланг эрсдэлийн албанаас салангид буюу дэд захиралд тайлагнаж, дэд захирал нь гүйцэтгэх захиралд тайлагнадаг.
УТНБЭ-ийн жагсаалтын мэдээллийг банкуудад өгдөггүй. Банкнууд болон зохицуулах байгууллагууд мэдээллээ солилцож ажиллах хэрэгцээтэй.	Монголбанкны гарын авлага дээрх банкинд бүртгэлтэй улс төрд нөлөө бүхий этгээд одоо хашиж буй албан тушаал, нөлөөллөөр нь дахин үнэлгээ хийх гэж байдаг. Хуулинд улс төрд нөлөө бүхий этгээдийн автоматаар өндөр эрсдэлтэй харилцагч гэж үзнэ хэмээн тусгасан байдаг. Аль 90 онд улс төрд байсан хүнийг одоог хүртэл хянах нь дэмий ажил тул УТНБЭ-ийг тодорхойлсон хуулийн заалтыг нарийвчлах хэрэгтэй.
Харилцагчийн мэдээллийг дор бүр нь авч ажилладаг ба мэдээллээ өгөхөөс татгалзсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэхгүй юм. Банк нь мэдээлллийг шаарддаж аваагүй, үйлчилгээ үзүүлэх нөхцөл нь өөрөө ийм тул хувь хүний мэдээллийн нууцын хуулийг зөрчсөн болохгүй.	Саарал жагсаалтанд орсоноос үүдэн харилцагчид тодорхой хэмжээний мэдлэгтэй болсон ч хувь хүний мэдээллийн нууцын тухай хууль гарсанаас хойш зөрчилдөх тохиолдол их байсан. Хуулинд банк харилцагчаас шаардсан мэдээллийг харилцагч татгалзах эрхтэйн улмаас банкны ажилтан ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлж чаддаггүй ойлголтын зөрүүтэй тохиолдол бий.
Манай улсын хувьд банкны салбарын хэмжээнд дийлэнх гарч байгаа кейсүүд нь удирлагын дэмжлэггүйгээс шалтгаалж фронт оффисын ажилчид МУЭ-ийг үл ойшоох тохиолдол бий.	Харилцагчийн мэдээллийг шинэчлэх үйл ажиллагааны хувьд харьцангуй сайн үйл явцтай байгаа. Мэдээллүүдээ авах ёстойг ойлгосон боловч зарим хариуцлагагүй,

Харин дэмжлэгэтэй тохиолдолд хэрэгжүүлэхгүй тохиолдол нь хувь хүний хандлага, ёс зүйгүй байдал ч гэсэн маш цөөн тохиолдол гардаг..	залхуу гэх мэт хувийн ёс зүйгүй байдлын улмаас мэддэг мөртлөө ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлдэггүй.
Салбарын захирлууд харилцагчаа таньж мэдэхийг зөвлөхөөс илүү борлуулалтад анхаарах тохиолдол бий. Фронтын ажилтнуудад буруу өгөх хэрэггүй.	Фронт оффисын ажилтнуудаас гадна салбарын захирал зэрэг дээд албан тушаалтнуудын мэдлэг дутагдалтай. Мөн ажлын ачааллаас шалтгаалж фронт оффисын ажилтнууд ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй ажиллах нь их байдаг. ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй ажилтанд арга хэмжээ авдагаас шалтгаалж энэхүү нөлөө нь жил бүрээр буурч байгаа.
Хувь хүний зан чанараас илүү тухайн банкны дээд албан тушаалтан, ТУЗ-ын гишүүд МУЭ-ээс урьдчилан сэргийлэх зорилгыг ажилчдадаа хүргэж, холбоо хамааралтай, хамтран ажилласнаар энэхүү эрсдэлээс зайлсхийх боломжтой.	МУЭ-ээс урьдчилан сэргийлэхэд хувь хүний зан характер нөлөөлдөг. Фронтын ажилтнууд нь Үүнийг засах нь хэцүү ч ажилтнуудын ойлголтыг нэмэгдүүлэх сургалтуудыг зөв орсоноор эрсдэлийг бууруулах боломжтой.

Эх сурвалж: судлаачдийн боловсруулснаар

Хасбанк нь гадаад хувьцаа эзэмшигчдийнхээ улсын мөрддөг дүрэм журамд тодорхой хэмжээнд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг бол Төрийн банк ихэвчлэн Монгол улсын хууль тогтоомж, Монголбанкны журамд нийцүүлэн ажилладаг билээ. Үүнээс харахад Хасбанканд хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн улсуудын стандартад нийцүүлэх гэсэн шаардлагыг Монгол улсын хувьд зохимжтой байдлаар нутагшуулан ажилладаг. Саарал жагсаалтанд орсоноос хойш олон улсын журам, үнэлгээний Энэ нь Хасбанкны комплаенсийн соёлыг ингэж ингэж бүрдүүлж байна. Ингэснээрээ дээрээсээ доош банкны бүх шатанд ингэж явах хэрэгтэй. ТУЗ-ын оролцоо их чухал байдаг юм байна. Хэдий комплаенсийн алба нь чиг үүргийн дагуу ажиллаж байгаа ч энэхүү эрсдэл нь чухал биш гэж бодсон удирдлага дээр очоод гацдаг. Банкны фронтын ажилчдаас гадна дээд удирдлагаас эхлэн МУЭ-ийн эсрэг үйл ажиллагаанд нийцүүлж явах хэрэгцээтэй.

Тус ярилцлагынхаа хүрээнд мөнгө угаах эрсдэлд нөлөөлөх банкны ажилчдын хүчин зүйлүүдийг тодорхойлох ямар анхаарах зүйл байгааг онцлон асуусан. Фронтын ажилтны эрсдэлийг үл ойшоосон ёс зүйн асуудал гэхээсээ удирдлагын нөлөө их ба. ТУЗ-ын гишүүд нь гүйцэтгэх захиралдаа, захирал нь бусад ажилчиддаа гэх зэргээр дээрээс доош чиглэлд МУЭ-ээс урьдчилан сэргийлэх талаар хүргэх хэрэгтэй. Захирал буюу дээд албан тушаалтан нь комплаенсийн нэгжийг дэмжих хэрэгтэй ба фронтын ажилтан мэдлэггүйдээ биш мэдлэгээ ашиглах байгууллагын соёл шаардлагатай байгаа юм.. Удирдлага нь зааж чиглүүлэх хэрэгтэй.

V.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 Дүгнэлт

Кэйс харьцуулалтыг дүгнэвэл, Шинэ Зеланд, Норвеги зэрэг өндөр хөгжилтэй орнууд хууль сахиулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтралыг хүчтэй хэрэгжүүлдэг бөгөөд илүү бат бөх тогтолцоотой байдаг байна. Харин, Монгол, Индонез, Малайз зэрэг хөгжиж буй орнуудад ижил төстэй хууль тогтоомжтой байж болох ч нөөцийн хязгаарлалтын улмаас хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй тулгардаг байна.

Асуулгын судалгаанаас харахад тогтмол сургалтанд хамрагддаг хүчин зүйл нь МУЭ-ээс урьчилан сэргийлэх үйл ажиллагааны хандлагатай 0.514, туршлагатай 0.407 корреляцийн коэффициенттэй буюу шууд хамааралтай гарчээ. Мөн МУЭ-ээс урьчилан сэргийлэх үйл ажиллагааны хандлага нь туршлагатай 0.700 буюу өндөр хамааралтай, мэдлэгтэй 0.512 корреляцийн коэффициенттэй буюу шууд хамааралтай гарлаа. Үүнээс харахад Та МУТСТ болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны талаар сургалтанд тогтмол хамрагдсанаар МУЭ-ээс урьдчилан сэргийлэх хандлага нэмэгдэж, илүү туршлага суудаг. Цаашлаад хандлага сайжирснаар мэдлэг мөн нэмэгдэж МУЭ-ийн эсрэг чадварлаг боловсон хүчин болох боломжтой гэж дүгнэлээ.

Ярилцлагын судалгааны хүрээнд мөнгө угаах эрсдэлд нөлөөлөх банкны ажилчдын хүчин зүйлүүдийг тодорхойлох ямар анхаарах зүйл байгааг онцлон асуусан. Фронтын ажилтны эрсдэлийг үл ойшоосон ёс зүйн асуудал гэхээсээ удирдлагын нөлөө их ба. ТУЗ-ын гишүүд нь гүйцэтгэх захиралдаа, захирал нь бусад ажилчиддаа гэх зэргээр дээрээс доош чиглэлд МУЭ-ээс урьдчилан сэргийлэх талаар хүргэх хэрэгтэй. Захирал буюу дээд албан тушаалтан нь комплаенсийн нэгжийг дэмжих хэрэгтэй ба фронтын ажилтан мэдлэггүйдээ биш мэдлэгээ ашиглах байгууллагын соёл шаардлагатай байгаа юм.. Удирдлага нь зааж чиглүүлэх хэрэгтэй.

5.2 Зөвлөмж

- Улсын нөөцийн бодлогод анхаарч эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай уялдуулах
- Банкны ажилтнуудыг мэргэшүүлэх үүднээс олон улсын ФАТФ, APG зэрэг байгууллагуудын сертификаттай сургалтанд хамруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг судалж, банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Мөнгө угаалт, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх үүднээс гадаадаас орж буй гүйлгээ, түүний зарцуулалт нь сэжигтэй эсэх, тухайн мөнгөнийг зарцуулж буй харилцагчийн таних ажиллагааг нэмэх шаардлагатай. Ингэснээр бохир мөнгө монголд угаагдахаас урьдчилан сэргийлэх боломжтой болно.

- Тухайн байгууллагын дээд удирдлагуудын түвшинд МУЭ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг байгууллагын зорилгод хамааруулан ажиллах. ТУЗ-ын гишүүд нь гүйцэтгэх захиралдаа, захирал нь бусад ажилчиддаа гэх зэргээр дээрээс доош чиглэлд МУЭ-ээс урьдчилан сэргийлэх талаар хүргэх хэрэгтэй.

VI.НОМЗҮЙ

A.Gayatri. (2023). Agency Theory. https://www.wallstreetmojo.com/agency-theory/-ээс Гаргасан

Abbott, R. J. (2005). Deterring Abuse of the Financial System: Elements of an Emerging International Integrity Standard. https://books.google.mn/books?hl=en&lr=&id=MEgZEAAAQBAJ&oi=fnd&pg=PA3&d q=Johnston,+R.Barry+and+John+Abbott(2005).+Deterring+Abuse+of+the+Financial+Sy stem:+Elements+of+an+Emerging+International+Integrity+Standard,&ots=EwVZsztXUW&sig=3iOMUpNqzySNOEMLcxiAFNV-ээс Гаргасан

Abdul-Rahman, A. M. (2018). Combating Money Laundering in Malaysia: Current Practice, Challenges and Suggestions. https://journalarticle.ukm.my/19728/1/28741-90593-2-PB.pdf-ээс Гаргасан

Alsharari, N. M. (2021). Accounting and Finance Innovations. https://books.google.mn/books?hl=en&lr=&id=27ZaEAAAQBAJ&oi=fnd&pg=PP14&d q=Accounting+and+Finance+Innovations&ots=FWwSkMpxGr&sig=d52k7EGFIhTCHUAfNoaCKbUB-eQ&redir_esc=y#v=onepage&q&f=false-ээс Гаргасан

Basel. (2020). Revisions to the principles for the sound management of operational risk. https://www.bis.org/bcbs/publ/d508.pdf-ээс Гаргасан

Bhattacharyya, R. (2024). Game Theory. https://www.wallstreetmojo.com/game-theory/-ээс Гаргасан

C.James. (2024). What Is Money Laundering. https://www.investopedia.com/terms/m/moneylaundering.asp -ээс Гаргасан

CFI. (огноо байхгүй). Fraud Triangle. CFI: https://corporatefinanceinstitute.com/resources/accounting/fraud-triangle/-ээс Гаргасан

Durrieu, R. (2013). Rethinking Money Laundering and Financing of Terrorism in InternationalLaw.хууд.13.https://books.google.mn/books?hl=en&lr=&id=4xVs_PGt3ocC&oi=fnd&pg=PR5&dq= Durrieu,+R.+(2013)+Rethinking+Money+Laundering+and+Financing+of+Terrorism+in+International+Law.+free+read&ots=2CJqwWYlaz&sig=EcFqlvXmMmmeVsqUrh1mf wShHtw&redir_esc=y#v=onepage&q&f=fal-ээс Гаргасан

E.Takáts. (2007). A Theory of “Crying Wolf”: The Economics of Money Laundering Enforcement. https://www.imf.org/external/pubs/ft/wp/2007/wp0781.pdf -ээс Гаргасан

ElYacoubi, D. (2020). Challenges in customer due diligence for banks in the UAE. https://www.emerald.com/insight/content/doi/10.1108/JMLC-08-2019-0065/full/html-ээс Гаргасан

Effective judgement and decision making for business. (огноо байхгүй). ABSTRACT: https://www.abstractuk.co.uk/effective-judgement-and-decision-making-for-business-ho w-to-make-the-right-decisions-ээс Гаргасан

H.Micheal. (2023). What is Risk Mitigation? The Four Types and How to Apply Them. https://www.mha-it.com/2013/05/17/four-types-of-risk-mitigation/ -ээс Гаргасан

Irfan Hassan Jaffery, R. A. (2020). Money-laundering risk and.

Irfan Hassan Jaffery, R. A. (2020). Money-laundering risk and preventive measures in Pakistan. https://www.emerald.com/insight/content/doi/10.1108/JMLC-02-2020-0016/full/html#:~:text=regulations%20of%20Pakistan.-,Findings,effect%20on%20money%2Dlaundering% 20risk.-ээс Гаргасан

Koker, L. d. (2006). Money laundering control and suppression of financing of terrorism: Some thoughts on the impact of customer due diligence measures on financial exclusion. https://www.emerald.com/insight/content/doi/10.1108/13590790610641206/full/html-ээс Гаргасан

Laine, T. (2019). Anti-money laundering and customer due diligence in Finnish. https://lutpub.lut.fi/handle/10024/160308-ээс Гаргасан

Maitily Parathi Tasan, S. B. (2023). Determinants of money laundering: a study among commercial banks in Malaysia. https://www.researchgate.net/publication/371174580_Determinants_of_money_launderin g_a_study_among_commercial_banks_in_Malaysia-ээс Гаргасан

Morris-Cotterill, N. (1999). *A brief history of money laundering*. Anti money laundering: https://www.antimoneylaundering.net/public/Counter-Money_Laundering/brief-history- money-laundering-ээс Гаргасан

Munedzi, H. C. (2022). Overview international best practices on customer due diligence and related anti-money laundering measures. https://www.emerald.com/insight/content/doi/10.1108/jmlc-07-2022-0102/full/html-ээс Гаргасан

Mse.mn. (2024). Төрийн банкны жилийн үйл ажиллагааны тайлан. Mse.mn: https://mse.mn/issuers/activityreport/564_20240403072606report.pdf-ээс Гаргасан

Mse.mn. (2024). Хасбанкны жилийн үйл ажиллагааны тайлан. https://mse.mn/issuers/activityreport/568_20240430084603report.pdf-ээс Гаргасан

Naheem, M. A. (2015). Money laundering: A primer for banking staff. хууд. 2. https://link.springer.com/article/10.1057/jdg.2015.10-ээс Гаргасан

Naheem, M. A. (2015). Money laundering: A primer for banking staff. https://www.researchgate.net/publication/282402721_Money_laundering_A_primer_for_banking_staff-ээс Гаргасан

Overview international best practices on customer due diligence and related anti-money laundering measures. (огноо байхгүй). https://www.emerald.com/insight/content/doi/10.1108/jmlc-07-2022-0102/full/html-ээс Гаргасан

Sarigul, H. (2012). Money laundering and abuse of the financial system. https://www.researchgate.net/publication/256040462_Money_Laundering_and_Abuse_of_the_Financial_System-ээс Гаргасан

Sujeewa, G. M. (2018). The new fraud triangle theory - integrating ethical values of employees. https://ijbel.com/wp-content/uploads/2018/08/ijbel5_216.pdf -ээс Гаргасан

T.Ken. (2020). Three Lines Model for risk management gets major update. https://www.journalofaccountancy.com/news/2020/jul/3-lines-of-defense-model-for-risk- management-gets-major-update.html-ээс Гаргасан

Vasudeva Murthy, S. (2022). Analysis on the significance and effectiveness of anti-money laundering policies and regulations of Financial Institutions (Investment Banks) in India. https://norma.ncirl.ie/5831/ -ээс Гаргасан

Viritha, B. (2016). Anti-money laundering regulation and practices in Indian commercial banks: the banker and customer perspective. https://d1wqtxts1xzle7.cloudfront.net/55549670/PhD_Thesis_-_Anti_Money_Launderin g_Regulation_-_VIRITHA-libre.pdf?1516090441=&response-content-dispositio n=inline%3B+filename%3DPhD_Thesis_Anti_Money_Laundering_Regulat. pdf&Expires=17134 20641&Signature=Nr3l57-ээс Гаргасан

William Gaviyau, A. B. (2023). Anti-money laundering and customer due diligence: empirical evidence from South Africa. https://www.emerald.com/insight/content/doi/10.1108/JMLC-06-2023-0103/full/html-ээс Гаргасан

Y.Keizer. (2018). The influence of contracting choices on client-contractor collaboration. https://www.semanticscholar.org/paper/The-influence-of-contracting-choices-on-Keizer/7 b78d6e0a742bc9562be12b20c97302f3e12ba5b -ээс Гаргасан

Сугармаа, М. (2023). Монгол улсын банкны салбарын гадаад худалдаанд суурилсан мөнгө угаах эрсдэлийн нөлөөллийг бууруулах арга зам. http://repository.ufe.edu.mn:8080/xmlui/bitstream/handle/8524/3426/%d0%9c.%d0%a1%d1%83%d0%b3%d0%b0%d1%80%d0%bc%d0%b0%d0%b0_b19fa1009.pdf?sequenc e=1&isAllowed=y-ээс Гаргасан

VII. ХАВСРАЛТ

Хавсралт 1: Банкны комплаенсийн мэргэжилтнүүдээс авсан ярилцлагын асуултууд

1. Олон улсын байгууллагуудын гаргасан мөнгө угаалт терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, Монгол Улсын хуульд танай банкны үйл ажиллагаа нийцэж ажиллаж байгаа гэж бодож байна уу? Яагаад?

2. Таны туршлагаас харахад мөнгө угаахтай тэмцэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны талаар банкны ажилтнуудын мэдлэг, ойлголтын хамгийн том дутагдал, төөрөгдөл юу вэ?

3. Та ажлын ачаалал, харилцагчийн зан байдал, удирдлагын зүгээс тодорхой харилцаа холбоогүй байх зэрэг хүчин зүйлс банкны ажилтнууд ХТМ үйл ажиллагааг үл тоомсорлох магадлалд нөлөөлдөг гэж бодож байна уу?

4. Мэдлэгийн хомсдол, ажлын нөхцөлөөс гадна таны туршлагаас харахад ажилтны мөнгө угаах үйл ажиллагаанд оролцоход өртөмтгий байдлыг нэмэгдүүлэх хувь хүний онцлог шинж чанар, ёс зүйн асуудал нөлөөлдөг гэж бодож байна уу?

Хавсралт 2. Банкны ажилчдаас авсан судалгааны асуултууд

1. Та банкны ажилтан уу?

Тийм *Үгүй*

2. Хүйс

Эрэгтэй *Эмэгтэй*

3. Таны нас?

18-24 25-30 31-34 35-40 41-44 45-50

4. Таны банкны салбарт ажил эрхэлсэн хугацаа?

1-5 жил *6-10 жил* *11-15 жил*
16-20 жил *20 ба түүнээс дээш жил*

5. Таны ажлын байрны чиг үүрэг аль вэ?

Фронт оффис буюу салбар тооцооны төв
Төлбөр тооцоо /Гадаад ба Дотоод/
Комплаесын нэгж
Дотоод аудитын нэгж
Харилцагчын үйлчилгээний нэгж
Бизнесийн байгууллагын зээлийн газар нэгж
Удирдах түвшиний банкны ажилтан
Эрсдэлийн удирдлагын нэгж /Үйл ажиллагааны эрсдэл болон зээлийн эрсдэл/
Бусад

6. Мөнгө угаах нь гэмт хэрэг үйлдэх замаар олсон “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны болгох мэт харагдуулах үйлдэл ба хээл хахууль, авлигыг өдөөх замаар эдийн засаг, улс үндэстэнд сөргөөр нөлөөлнө.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

7. Танай банк МУТСТ хуулийг үйл ажиллагаандаа тогтмол уялдуулан ажилладаг.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

8. Мөнгө Угаахтай Тэмцэх зохицуулалт нь олон улсын болон олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг тул банкны үйл ажиллагаанд үнэ цэн бий болгоно.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

9. Та МУТСТ болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны талаар сургалтанд тогтмол хамрагддаг уу?

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

10. Танай банк ажилтнууддаа зориулан харилцагчийг таньж мэдэх сургалтыг хэр давтамжтай зохион байгуулдаг вэ?

Зөвхөн банкинд шинээр ажилд орох үед *Жил бүр*

Хоёр жилд нэг удаа *Зөвхөн шаардлагатай үед*

Зохион байгуулдаггүй

11. Харилцагчийг Таньж Мэдэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагын дагуу МУТС асуумжаас шалтгаалан харилцах данс нээлгэхээс татгалзах тохиолдол илэрдэг.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

12. Манай улс мөнгө угаасан хэргээр ял шийтгэл ноогдуулсан хүмүүсийн тоо бараг байхгүй ба гэмт хэрэг үйлдэх замаар олсон “бохир” мөнгийг хураах нийтэд ил тод мэдээлэх нь маш бага байдаг.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

13. Банк нь улс төрийн нөлөө бүхий этгээдийн талаар хангалттай мэдээлэл (хувь хүний мэдээлэл, хөрөнгийн эх үүсвэр) цуглуулж чадахгүй байгаа.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

14. Банк нь 20 сая ба түүнээс дээш дүнтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээний тайланг Санхүү мэдээллийн албанд илгээдэг.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

15. Мөнгө Угаахтай Тэмцэх бодлого идэвхигүй байдалд байгаа бөгөөд шинээр гарч ирж буй эрсдэлт хүчин зүйлсийг хангах урьдчилан сэргийлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

16. Мөнгө Угаахтай Тэмцэх зохицуулалт нь олон улсын болон олон нийтийн

итгэлийг нэмэгдүүлдэг тул банкны урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үнэ цэн бий болгож байна.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

17. Манай банк холбогдох бүх баримт бичиг/мэдээлэл цуглуулж, баталгаажуулан хориглогдсон хүн/улсын жагсаалтад хамрагдаагүйг тулгасны дараа данс нээдэг.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

18. Одоо хэрэгжүүлж буй Мөнгө Угаахтай Тэмцэх арга хэмжээ болон дүрэм журам нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх шийдвэр гаргасан оролцсон хүмүүс, улс төрийн нөлөө бүхий этгээдийг мөнгө угаах эрсдэлд оролцхоос сэргийлж чадахгүй байна.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

19. Харилцагчийн эрсдэлээс үл хамааран үйл ажиллагааны тав тухыг хангах үүднээс бүх хэрэглэгчийн дансанд хяналт бага тавьдаг.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

20. Харилцагчийг Таньж Мэдэх үйл ажиллааны тайланг банкны аудитын хороонд тодорхой тогтсон хугацаанд хүргүүлж ажиллаж байна.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

21. Банкны харилцагч нь Харилцагчийг Таньж Мэдэх үйл ажиллагааны дагуу шаардлагатай бичиг баримт бүрдүүлэхээс татгалздаг бөгөөд жилийн орлого, дансны үлдэгдэл, хөрөнгө орлогы дэлгэрэнгүй мэдээлэл ил тод өгөхөөс татгалзах, худал мэдээлэл өгөх тохиолдол гардаг.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

22. Харилцагчийг Таньж Мэдэх журам нь эцсийн өмчлөгчийг тодорхойлох үед, улс төрийн нөлөө бүхий этгээд болон түүний гэр бүлийн гишүүд/хамаатан/байгууллагын албан тушаалтнууд хоорондын холбоог илрүүлхэд хангалттай бус байдаг.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

23. Сэжигтэй гүйлгээнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх журам нь тодорхойгүй, ойлгомжгүй ба сэжигтэй гүйлгээг цаг тухайд нь илрүүлэх нь нь хэцүү ажил юм.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

24. Банкууд хоорондоо хууль зөрчигчид, сэжигтэй харилцагчдын талаар албан ёсоор мэдээлэл солилцож чадахгүй байна.

Огт санал нийлэхгүй 1 2 3 4 5 Бүрэн санал нийлнэ

25. Мөнгө угаах эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад шаардлагатай дутагдаж байгаа зүйл юу вэ?

Төсөв Боловсон хүчин Програм хангамж Байхгүй

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Г.Болор-Эрдэнэ, Н.Мөнхцэцэг***

**Санхүү эдийн засгийн их сургууль, Санхүү удирдлагын тэнхим, Цагийн хөтөлбөрийн оюутан, И-мэйл: b22ps2020@ufe.edu.mn*

***Санхүү эдийн засгийн их сургууль, Санхүү удирдлагын тэнхим, Цагийн хөтөлбөрийн оюутан, И-мэйл: b23ps1049@ufe.edu.mn*

ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улс Ази, номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүнээр 2004 онд элсэж улмаар 2006 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталснаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулж байгаа билээ. Дэлхий дахинд мөнгө угаах гэмт хэрэг нь улс орны эдийн засаг, улс төрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг томоохон хүчин зүйл болох төдийгүй түүнийг хууль эрх зүйн зохицуулалтын түвшинд боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Иймд, энэхүү судалгааны ажлаар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийг Монгол Улс дахь эрх зүйн орчин, хууль сахиулах байгууллага мөнгө угаах гэмт хэргийг зөв илрүүлэн ял оноож чадаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх замаар мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх боломжтой олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх боломжийн талаар саналаа дэвшүүллээ.

ТҮЛХҮҮР ҮГС:

Мөнгө угаах гэмт хэрэг, мөнгө угаах эрсдэл, сэжигтэй гүйлгээ, хиймэл оюун ухаан дээр суурилсан платформ

I. УДИРТГАЛ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх нь улс орны санхүүгийн салбарын тогтвортой байдал, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж, улмаар олон улсын санхүүгийн системд аюул заналхийлэл учруулах өндөр эрсдэлтэй байдаг. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого нь санхүүгийн салбарын хямрал үүсгэх, татварын орлогыг бууруулах, төр засгийн бодлогыг сулруулах, санхүүгийн байгууллагуудын нэр хүндэд халдах зэрэг нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг өдөөж, санхүүгийн системийн тогтворгүй байдлыг үүсгэдэг.

Олон Улсын Валютын сангийн мэдээллээснээр дэлхийн санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жил бүр хоёр их наяд гаруй ам.доллар мөнгө угаах гэмт хэргээр дамжин угаагддаг гэж үзсэн бөгөөд мөнгө угаах гэмт хэрэг нь дэлхийн

хэмжээнд 3.2 их наяд доллар буюу дэлхийн ДНБ-ий 3%-тай тэнцдэг. Үүнээс үзвэл мөнгө угаах нь дэлхийн хамгийн том зах зээлийн нэг болж байна.[1]

Дэлхийн улс орнууд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн нэг нь Базелийн Засаглалын Институци бөгөөд 2012 оноос эхлэн жил бүр дэлхийн улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэн Базелийн Мөнгө Угаахтай Тэмцэх Индекс (Basel AML Index)-ийг эрхлэн гаргасаар иржээ. “Мөнгө угаахтай тэмцэх индекс 2023” оны тайлангаар олон улсын дундаж мөнгө угаахтай тэмцэх индекс 5.31 байсан нь өмнөх жилээс 0.06%-иар өссөн.[2] Харин манай улсын хувьд 2023 оны байдлаар 5.00 үнэлгээ авсан нь мөнгө угаах эрсдэл өндөр буйг илэрхийлж байна.

Түүхэн мэдээллээс харвал манай улс 2011 онд анх ФАТФ (The Financial Action Task Force)-ын «Саарал жагсаалт»-д орсноос хойш 2019 оны 10-р сарын 18 өдрийн ФАТФ-ын хуралдаанаар Монгол улсыг ахин саарал жагсаалтад оруулсан байдаг.

2019 онд ФАТФ-ын 40 зөвлөмжөөс 5 нь хангалтгүй, 15 нь зарим нь хангалтгүй, 5 нь дийлэнх нь хангагдсан, 5 нь бүрэн хангасан үндэслэлээр ФАТФ-ын саарал жагсаалтад орж байсан[3] бол 2023.07.13-ны өдөр Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс ФАТФ-ын 40 Зөвлөмжтэй холбоотой Монгол Улсын явцын тайланг хэлэлцсэн. Тус хурлаар манай улс техник хэрэгжилтийн үнэлгээгээ ахиулснаар ФАТФ-ын 40 Зөвлөмжийг бүрэн биелүүлсэн үнэлгээтэй Ази, Номхон далайн орнуудаас анхны орон, дэлхийн улсуудаас 5 дахь орон болсон.[4] Үүнээс үзвэл манай улс техник хэрэгжилтээ хангаж чадаж байгаа ч үр ашигт хэрэгжилт хангагдаж чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Мөнгө угаах гэмт хэрэгт хамгийн ихээр өртөж болох салбараар Монгол Улсын хэмжээнд санхүүгийн салбарын дийлэнх их хувийг эзэлж байгаа банкны салбар зүй ёсоор багтаж байгаа бөгөөд үл хөдлөх хөрөнгийн салбар хоёрдугаарт орсон. Үүнтэй холбогдуулан банкны салбар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байгаа бөгөөд энэ арга хэмжээний хүрээнд өөрийн харилцагч, тэдгээрт үзүүлж байгаа үйлчилгээ, бүтээгдэхүүний төрлүүдийг эрсдэлээр ангилж эрсдэлийг бууруулах тодорхой ажлуудыг зохион байгуулж эхэлсэн байна. Гэмт хэрэг үйлдэж олсон эсхүл түүнд зориулагдсан хөрөнгө мөнгийг бэлнээр хил, гаалиар хяналтгүй нэвтрүүлэх эрсдэл маш өндөр байна.

Иймд, энэхүү судалгааны ажлаар дамжуулан Монгол Улсын эрүүгийн эрх зүйн

---

[1] Muhammad Zain Malik, Shah Nazir, Transforming the competencies of Artificial Intelligence to ensure the Cyber Threats: A Systemic Literture Review of Busniess Sectors, 2022 1st International Conference on AI in Cybersecurity (ICAIC), Холбоос: https://ieeexplore.ieee.org/document/9897051 Сүүлд үзсэн огноо: 2024.04.27

[2] Basel Institute on Governance, Basel AML index, 2023.04.05, Холбоос: https://index.baselgovernance.org/ranking, Сүүлд үзсэн огноо: 2024.05.01.

[3] Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага, Монгол Улсын хоёр дахь шатны дахин үнэлгээний тайлан, (2019) 23 дахь тал.

[4] Б.Билэгсайхан, Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад орсноос хойш дахин АНУ-ын банктай хамтарч эхэллээ: Холбоос: https://news.mn/r/2696016/ Сүүлд үзсэн огноо: 2024.03.05

салбарт мөнгөж угаах гэмт хэргийн илрүүлэлт хэр оновчтой явагдаж байна, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгчийг зөв олж тогтоон тохирсон ялыг нь оногдуулж чадаж байгаа эсэхийг судлах, улмаар олон улсын сайн туршлагын талаар нэвтрүүлэх боломжийн талаар судлахыг зорьлоо.

II.ҮНДСЭН ХЭСЭГ

1. Мөнгө угаах гэмт хэргийн тухай ойлголт

Мөнгө угаах (англ. “money laundering”, ор. “отмывание денег”) гэдэг нэршил нь АНУ-д 1930-аад оны үед үүссэн. Тухайлбал, 1920-1930 оны хооронд АНУ-д архины төрлийн бүтээгдэхүүн худалдах савлах, газнаас оруулж ирэх, тээвэрлэхийг хориглосон “Хуурай хууль” хэрэгжиж байх үед Чикагогийн мафийн толгойлогч[5] Аль Копоне болон түүний бүлэглэлийн гишүүд Чикаго хотын дотор, мөн түүний эргэн тойронд хэдэн зуун угаалгын газруудыг эзэмшиж, хууль бус согтууруулах ундааны бизнесээс олсон орлогыг угаалгын газрын ашиг хэмээн халхалдаг байжээ.

Олон улсад хууль бус эх сурвалжтай мөнгийг “бохир мөнгө – dirty money”, “хар мөнгө – black money” гэсэн нэр томьёогоор нэрлэдэг. Хар мөнгө гэдэгт татвар ногдох боловч татварын албанд мэдээлдэггүй орлогыг авч үздэг.[6] Өөрөөр хэлбэл гэмт хэргийн замаар биш ч хууль тогтоомжоос гадуур олсон, эх сурвалж нь ноцтой биш бөгөөд эдийн засагт албан ёсны бүртгэлгүй, татвар төлөөгүй орлогыг хэлнэ.

Хүснэгт 1. Мөнгө угаах гэмт хэргийн үндсэн элементийн онцлог[7]

Хөрөнгийн хууль бус эх үүсвэр	→	**Тэдгээрийг хууль ёсны мэт харагдуулах**

Үүнээс үзэхэд, мөнгө угаах үйл ажиллагааны зорилго нь богино хугацаанд их хэмжээний ашиг олох гэхээсээ илүү гол нь гэмт хэрэг үйлдэж олсон гэх ул мөр үлдээхгүй байх нь чухал байдаг тул хуулийн байгууллагуудын ажилтнуудыг төөрөгдүүлэхэд чиглэсэн, ойлгоход төвөгтэй олон хэлбэр, хувилбараар үргэлжлэн явагддаг учраас илрүүлэхэд ихээхэн бэрхшээл учирдаг. Тухайлбал судлаагчдын үзэж буйгаар мөнгө угаах гэмт хэрэг нь дараах үе шатыг дамжин хийгддэг гэж үздэг.


---

5 *хууль ёсны нэршлээр “зохион байгуулалттай гэмт бүлэг”

6 Association for Democratic Reforms, “Black money and its Estimation”, https://adrindia.org/sites/default/files/%5BAnnexure%2030%5D.pdf, Сүүлд үзсэн: 2024.04.28

7 Benjámin Villányi, Money laundering: History, Regulations, and Techniques, https://www.semanticscholar.org/paper/Money-Laundering%3A-History%2C-Regulations%2C-and-Vill%C3%A1nyi/d9aea5d649e48d6f34b628688c4ccfd78d4ec945 Сүүлд үзсэн: 2024.04.28

Зураг 1. Мөнгө угаах гэмт хэргийн үе шатууд



Эх сурвалж: Michael Levi, M. D. (2007). Money laundering and Corruption.


Эдгээр шат дамжлагыг мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгч дангаар, хавсран, бүхэлд нь хамруулан үйлдэж мөнгө угааж болно. Үүнээс үзэхэд мөнгө угаах гэмт хэрэг гэдэг нь хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгө, мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нуух зорилгоор өөр хөрөнгө болгох, өөр хөрөнгөөр солих үйл явцыг ойлгож болно.

III. ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

1. Монгол улсын санхүүгийн салбарын өнөөгийн байдал

Монгол Улсын хувьд санхүүгийн зуучлалын үүргийг голчлон банкны систем гүйцэтгэж байна. Тодруулбал, сүүлийн 9 жилийн дунджаар санхүүгийн байгууллагуудаас эдийн засагт олгосон нийт зээлийн 96 хувийг банкууд, 3 хувийг банк бус санхүүгийн байгууллагууд, 1 хувийг хадгаламж зээлийн хоршоод бүрдүүлжээ.[8]

График 1. Банкны салбарын 2015-2023 оны Активын өсөлт




Эх сурвалж: Монголбанк, Банкны салбарын өнөөгийн нөхцөл байдал, бодлогын зорилтууд, 2023 оны 2-р улирал

[8] Монголбанк, “Санхүүгийн салбарын төлөв байдал, цаашид анхаарах асуудал”, Монголбанк Судалгааны ажил "Товхимол 15", 236 дахь тал

2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй банкнуудын нийт активын хэмжээ 47.7 их наяд төгрөг байв. 2019-2013 оны хооронд нийт активын хэмжээ нэрлэсэн дүнгээр 17.2 их наяд төгрөгөөр буюу 59.7%-иар өсжээ.[9]

График 2. Банкны салбарын 2015-2023 оны цэвэр ашиг



Эх сурвалж: Монголбанк, Банкны салбарын өнөөгийн нөхцөл байдал, бодлогын зорилтууд, 2023 оны 2-р улирал

Дотоодын санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 90 гаруй хувийг дангаараа бүрдүүлдэг банкны салбарын цэвэр ашиг 2023 онд 606 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийн ашгаас 2 дахин байна.


Үүнээс үзвэл банк, санхүүгийн салбар нь зах зээл дээр эзэлж буй активын дүн, цэвэр ашиг зэргээрээ маш өндөр байдаг ч үүнийг дагаад мөнгө угаах эрсдэл нэмэгддэг. Мөнгө угаах эрсдэлийг банк, санхүүгийн салбарын үүднээс судалдаг судлаачдын хувьд банкны салбар нь хадгаламж, зээл, хөрөнгө оруулалт, гадаад валют зэрэг үйлчилгээгээрээ дамжуулан мөнгө угаагчийн нэгдүгээр түвшний холбоо барих цэг болдог гэж үздэг.[10]

2. Мөнгө угаахтай тэмцэх олон улсын гэрээ, конвенцын түүхчилсэн судалгаа

Зураг 2. Монгол Улс Олон улсын өмнө мөнгө угаахтэй тэмцэх хууль тогтоомжийг батлах үүрэг хүлээсэн үеэс эхлүүлэн ФАТФ-ын саарал эагсаалтнаас гарах хүртэлх түүхчилсэн он цагийн дарааллаарх зураглал

[9] Монголбанк, Банкны салбарын өнөөгийн нөхцөл байдал, бодлогын зорилтууд, (2023 оны 2-р улирал). 4 дэх тал

[10] Yusarina Mat Isa, Z. M. (2015). Money Laundering Risk: From the Bankers' and Regulators Perspectives, Холбоос: https://www.infona.pl/resource/bwmeta1.element.elsevier-29e907ed-fea4-3445-b1fd-5d46263e390f, Сүүлд үзсэн огноо: 2024.04.15



Эх сурвалж (Судлаагчийн боловсруулалт)

3. Мөнгө угаах гэмт хэргийн Олон улсын конвенц дахь зохицуулалт

ФАТФ-ын зөвлөмжийн 3-д *"Улс орнууд мөнгө угаахыг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенц (Венийн конвенц) болон НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенц (Палермо конвенц)-ийн дагуу гэмт хэрэгт тооцно"* хэмээн заасан байна.

(1) НҮБ-ын Венийн конвенцын 3 (1)(b),(c) заалтуудад улс орнуудад санаатайгаар үйлдэгддэг дараах үйлдлийг гэмт хэрэгт тооцох арга хэмжээ авахаар зохицуулан. Үүнд:

- Аливаа гэмт хэрэг үйлдсэний үр дүнд дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж

хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах болон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагаврааc зайлсхийхэд нь туслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах, шилжүүлэх;

- Гэмт хэрэг үйлдэхэд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байрлал, захиран зарцуулах арга, хөдөлгөөн, хөрөнгөтэй холбоотой жинхэнэ эрх эсхүл эзэмшигчийг халхавчлах, нуун дарагдуулах;
- Гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагаврааc зайлсхийхэд туслах зорилгоор дээр дурдсан хууль бус хөрөнгө, орлогыг хувиргах, шилжүүлэх;
- Гэмт хэрэг үйлдсэн, эсхүл түүнд оролцсон үйлдлийн үр дүнд бий болсон хөрөнгө, орлогыг хүлээн авахдаа энэ тухай мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан;
- Конвенцын Хавсралтын Хүснэгт 1-т заасан тоног төхөөрөмж, эд зүйлс болон бодисыг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэх, ашиглаж байгаа эсхүл тийм зорилгоор ашиглахад зориулагдсан бодисыг мэдсээр байж эзэмших, мансууруулах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон нийтийг аливаа хэлбэрээр өдөөн хатгах, уриалах;

(2) Мөн НҮБ-ын Палермогийн конвенцын 6 (1), (2) дахь заалтын хүрээнд улс орнууд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг угаах дараах санаатай үйлдлийг гэмт хэрэгт тооцох шаардлагатай байдаг. Үүнд:

- Эд хөрөнгийн хууль бус гарал үүслийг нуун дарагдуулах, нуун далдлах, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд оролцсон этгээдийг гэмт хэргээс зайлсхийхэд нь туслах зорилгоор гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг хөрвүүлэх, шилжүүлэх;
- Эд хөрөнгийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж жинхэнэ мөн чанар, эх сурвалж, байршил, захиран зарцуулалт, шилжилт хөдөлгөөн, өмчлөх эрх, эсхүл эд хөрөнгийн талаарх эрхийг нуун дарагдуулах, далдлах;
- Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хүлээж авахдаа гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан.

Хүснэгт 3. Монгол Улсын Эрүүгийн хууль дахь мөнгө гуаах гэмт хэргийн зохицуулалтын түүхчилсэн тойм

2002.01.03	Эрүүгийн хууль /2002/	2002 оны ЭХ-ийн 155-д *"Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах"* мөнгө угаах гэмт хэрэгтэй ойролцоо үйлдлийн шинжтэй гэмт хэргийг хуульчилсан. Тухайлбал, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг **мэдсээр байж** авсан, хадгалсан борлуулсан үйлдлийг энэ гэмт хэрэгт хамруулан ойлгодог. Тухайн үед одоо мөнгө угаахаар зүйлчлэгдээд буй хулгай, малын хулгайн гэмт хэрэгт оролцсон этгээд буюу гэмт хэрэг үйлдэж олсон гэдгийг мэдсээр байж авсан, борлуулсан этгээдэд энэ гэмт хэргээр ял оноодог байсан.
2008.02.01	Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	ЭХ-ийн 268[1]-д мөнгө угаах гэмт хэргийг анх удаа Албан тушаалын гэмт хэрэгт хамруулан зааж өгсөн. 268[1]-д *"Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах, эсхүл хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэх зорилготой, илт хууль бус эд хөрөнгө гэдгийг **мэдсээр байж**, эх үүсвэрийг нь халхавчлах буюу нуун далдлах, эсхүл уг эд хөрөнгийг хууль ёсны болгох, зорилгоор гүйлгээнд оруулсан бол"* гэж гэмт хэргийн шинжийг заасан байна.
2009.12.24	Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	• ЭХ-ийн 268[1]-д 2008 онд нэмэлтээр оруулсан мөнгө угаах гэмт хэргийг хүчингүй болгосон. • Улмаар ЭХ-ийн 166[1]-д "Мөнгө угаах" гэмт хэргийг шинээр нэмсэн. Тухайлбал *"Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийн хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд заасан бусад хүндэвтэр, хүнд онц хүнд гэмт хэрэг үйлдэж, олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан ашигласан шилжүүлсэн, хувиргасан"* үйлдлийг гэмт хэрэгт тооцхоор хуульчилжээ.
2014.01.16	Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	ЭХ-ийн 166[1]-д заасан мөнгө угаах гэмт хэргийн шинжид өөрчлөлт оруулж 166[1]-д заасан бүх гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, мөнгө орлогыг угаах, хэд хэлэн үйлдлийг зорилгоор нь ялган гэмт хэрэгт тооцохоор зохицуулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөс эхлэн суурь гэмт хэргийн босго тогтоолгүйгээр бүх гэмт хэрэг үйлдсэнээр олсон хөрөнгө, мөнгө, орлогыг олж авсан, эзэмшсэн, ашигласан, эзэмшсэн, захиран зарцуулсан болон бусад үйлдэл нь мөнгө угаах гэмт хэрэгт буруутгагдах, давхар зүйлчлэгдэх, ял шийтгэгдэх эрх зүйн үндэс бүрдсэн байна. (М.Тамир, 2023)


2015.12.03	Эрүүгийн хууль / Шинэчилсэн найруулга/	ЭХ-ийн 18.6-д *“Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан”* үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан.

Эх сурвалж: Legalinfo.mn

IV. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛ, ШҮҮХИЙН ПРАКТИК

Монгол Улсад мөнгө угаах гэмт хэргийн 2002 оны эрүүгийн хуульд анх хуульчилсан ч 2013 оныг хүртэл нэг ч ял оногдуулаагүй байна. 2013 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд анхан шатны шүүхэд 279 гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэн ял оногдуулсан байна. Үүнд:

График 3. Эрүүгийн хуулийн 18.6-д заасан Мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдсэн гэмт хэргийн тоо



Эх сурвалж: Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2013-2024

Манай Улс 2014 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөс эхлэн мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлох босго тогтоохоос татгалзаж улмаар

Эрүүгийн хуульд заасан бүх гэмт хэрэг үйлдсэнээр олсон хөрөнгө, мөнгө орлогыг олж авсан, эзэмшсэн, ашигласан, захиран зарцуулсан болон бусад үйлдэл нь мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдэх, ял шийтгэгдэх эрх зүйн үндэс бүрдсэн нь дээрх шүүхийн шийдвэрийн цахим сангаас авсан тоон мэдээллээр харагдаж байна.

Тухайлбал, 2013-2014 оны хооронд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн нийт гэмт хэргийн 78.4%-ийг Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Үүнээс 67.1%-ыг хулгай, малын хулгайн гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд 95.2% нь хулгайлах, мал хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн буюу гэмт хэргийн санкцын хувьд 240-720 цаг хүртэлх хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, 6 сараас 5 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэх буюу ЭХ-ийн 2 дугаар зүйлийн 2.6.1-д заасан хөнгөн ял оногдуулж байгаа нь ФАТФ-ын зөвлөмжтэй нийцээгүй гэж дүгнэж болохоор байна.

Хулгай, малыг хулгайн гэмт хэргийг үйлдэгчид нь мөнгө угаах гэмт хэргийг тайлбарладаг цагаан захтны гэмт хэргийн онолоор нийгмийн доод давхаргад орох бөгөөд цагаан захтны гэмт хэргийг үйлдэх боломжгүй атал цагаан захтны гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдэд оноодог мөнгө угаах гэмт хэргийг оноож байгаа нь Монгол улсын Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлд заасан *“Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”* гэсэн заалтыг алдагдуулж байна.

1. Хулгайлах, мал хулгайлах гэмт хэргийн мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргээс ялгарах онцлог

Хулгайлах, мал хулгайлах гэмт хэрэг нь эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан өмчлөх эрхийн эсрэг гэм хэрэг манай улсад үйлдэгддэг гол шалтгаан нь ажилгүйдэл, ядуурал байдаг.[11] Хулгайлах гэмт хэргийг үйлдсэн этгээд нь хулгайлсан эд хөрөнгийг эзэмшилдээ авч өөрийн болгон захиран зарцуулах[12] буюу хууль бус аргаар олсон гэдгийг мэдсээр байж цааш худалдан борлуулж ашиг олох зорилготой байдаг.

Жишээ: Д нь айлын цасан шуурган уруудаж явсан 5 үхрийг мотоцикл ашиглан хулгайлан өөрийн эзэмшлийн үхэр сүрэгт нийлүүлсэн. А нь мал хулгайлах гэмт хэргийн үйлдсэнийг мэдсээр байж тус үхрийг махлан гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах аргыг өөрчилж мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн.

Эх сурвалж: Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сайт

НҮБ-ын Венийн конвенц: “аливаа гэмт хэрэг үйлдсэний үр дүнд дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг

[11] Т.Очирбат, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилсан сэргийлэхэд шинжлэн магадлахуйн дүгнэлт үзүүлэх нь, (2023), https://legaldata.mn/buteel/pdf?id=423, Сүүлд үзсэн огноо: 2024.04.27

[12] Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Монгол Улсын Дээд шүүх, (УБ, 2013), ХЗҮХ, 73 дахь тал.

мэдсээр байж хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах болон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагаврааc зайлсхийхэд нь туслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах, шилжүүлсэн үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэг гэж үзнэ.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 18.6-д заасан мөнгө угаах гэмт хэргийн зохицуулалт, нь НҮБ-ын Венийн конвенцд заасантай үг үсгийн хувьд ижил байгааг шууд мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж болохгүй бөгөөд үүнийг онолоор тайлбарлах нь чухал юм.

Мөнгө угаах гэмт хэргийн үе шат: Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэгч нь суурь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө орлогыг **байршуулах**, тухайлбал өөрийн болон бусдын нэр дээр банканд данс нээх, үнэт цаас, бонд, чек зэрэг санхүүгийн хэрэгсэл худалдан авах. Үүний дараагаар байршуулсан мөнгөн хөрөнгөө хууль ёсны мэт харагдуулах зорилгоор зохиомол байдлыг бий болгох буюу байршуулсан зүйлээрээ бусдын нэр дээр эд хөрөнгө худалдан авах, зээл хандив тусламжийн хэлбэрт оруулах. Эцэст нь гарал үүслийг нь нуун далдалсан хөрөнгө, мөнгөө хууль ёсны эдийн засгийн эргэлтэд оруулах буюу худалдан авсан хөрөнгөө зарах, түрээслэх, хувьцаа бонд авах гэх мэт үйл ажиллагаа явуулснаар бохир мөнгө цэвэр болдог.

Гэтэл мал хулгайлах гэмт хэрэгт байрлуулах, нуун далдлах, эргэлтэнд оруулах үйлдлийн аль нь ч байдаггүй.


Цагаан захтны гэмт хэрэг нь бусад доод давхаргын гэмт хэргээс ялгардаг. Өөрөөр хэлбэл доод давхаргынхан нь гудамжны гэмт хэрэг /хулгай, дээрэм/-т түлхүү холбогдож байхад цагаан захтнууд нь татвараас зайлсхийх, мөнгө угаах гэмт мэт эдийн засгийн гэмт хэрэгтэй түлхүү холбогддог. Цагаан захтнууд нь хууль бус гэмт хэргээс олсон орлогоо банканд данс нээх зэргээр байршуулж улмаар хэлбэрийг нь өөрчлөн гадаад улс руу гаргаж цэвэр мөнгө мэтээр, үл хөдлөх худалдан авдаг бол мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд гэмт хэргээс олсон орлогоо банкаар дамжуулах, тухайн хууль бус мөнгийг цэвэр болгож үл хөдлөх хөрөнгө худалдаж авах туйлын хүсэл зориг байдаггүй юм.

Ялгаатай байдал: Үүнээс дүгнэж үзвэл мал хулгайлах гэмт хэргийн үүднээс олсон орлогыг зарцуулсан этгээдийн гэмт үйлдэл нь мөнгө угаах гэмт хэргийн үе шат болон мөнгө угаах гэмт хэргийг тайлбарладаг цагаан захтны гэмт хэргийн онолоор мөнгө угаах гэмт хэрэгт хамааралгүй бөгөөд эрүүгийн хуулийн 18.6-д гэмт хэргийн зорилго, үйлдэх арга барил, учрах хохирлын хэмжээ, суурь гэмт хэрэг зэргийг ялгаатай зааж өгөөгүйгээс үүдэн учруулсан хор уршигт нь тохирохгүй хүн ял оногдуулж байгаа нь үүнээс харагдаж байна.

V. МОНГОЛ УЛС ДАХЬ МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Мөнгө угаах гэмт хэргийн зорилго нь гэмт хэрэг үйлдэж олсон гэх ул мөр үлдээхгүй байх нь чухал байдаг тул хуулийн ажилтнуудыг төөрөгдүүлэхэд чиглэсэн, ойлгоход төвөгтэй, олон хэлбэр, хувилбараар үргэлжлэн явагддаг. Иймд мөнгө угаах гэмт хэрэг нь илрүүлэхэд төвөгтэй бөгөөд банкны ажилтан, хууль хяналтын байгууллагын ажилтнаас илрүүлэхэд өндөр ур чадвар шаарддаг.

Зураг 3. Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх үе шат



Эх сурвалж (Судлаачийн боловсруулалт)

***График 4**. Сэжигтэй гүйлгээний тоо (2017-2023)*



	2023 он	2022 он	2021 он	2020 он	2019 он	2018 он	2017 он
СМА-ны хүлээн авсан сэжигтэй гүйлгээний статистик мэдээлэл	1799	2626	1801	3014	2385	1596	203
СМА-ны дүн шинжилгээ хийсэн сэжигтэй гүйлгээний тоо	795	354	551	509	84	151	35
СМА-ны шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний тоо	765	324	539	505	48	181	15

Эх сурвалж: СМА-ны 2023 оны 4-р улирлын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой нэгдсэн статистик мэдээлэл

Монгол улсын хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар банк нь сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг Санхүүгийн

мэдээллийн албанд мэдээлэх үүргийг хүлээдэг. Санхүүгийн мэдээллийн алба нь холбогдох байгууллагуудаас сэжигтэй гүйлгээний мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийсний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлдэг.

Цагдаагийн байгууллага нь СМА-аас ирүүлсэн сэжигтэй гүйлгээний мэдээлэл дээр үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэх саналаа прокурорт хүргүүлэх бөгөөд мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд төвөгтэй нөхцөл байдлаас шалтгаалан дийлэнхдээ прокурор эрүүгийн хэрэг үүсгэхгүй байх нь элбэг байдаг. 2017-2023 оны хооронд СМА нь хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тооноос үзэхэд мэдээллэх үүрэгтэй этгээдүүд нь үүргээ гүйцэтгэж байгаа бөгөөд СМА нь сэжигтэй гүйлгээ дээр дүн шинжилгээ хийсний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлдэг. График 4 дээрх тоон мэдээллээс үзэхэд СМА нь сэжигтэй гүйлгээг хүлээн авах, илрүүлэх үүргээ гүйцэтгэж чадаж байна.

Гэтэл 2013-2024 оны хооронд анхан шатны шүүх дээр мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдсэн 279 гэмт хэргээс 78.4%-ийг Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг байгаа нь СМА-ны сэжигтэй гүйлгээ буюу мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй үйлдэл байж болзошгүй гэсэн гүйлгээг хууль сахиулах байгууллага (ЦЕГ, АТГ, ТЕГ) нотолж чадахгүй байна. Үүнээс шалтгаалан шүүх дээр мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдэн ял авч байгаа нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтнүүд байна.

Иймхүү СМА-наас мэдээллэсэн мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй үйлдэл нь хууль сахиулах байгууллага дээр нотлогдож чадахгүй байгаа байдал нь мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд төвөгтэй буюу СМА-аас ирүүлсэн гүйлгээний мэдээллийг мөнгө угаах гэмт хэрэгт хамааруулан нотлох нь хэцүү байдгаас шалтгаалан гэмт хэрэг үйлдэгч нь мөнгөө хурдан хугацаанд гадаадруу гаргах, хэлбэрийг нь өөрчлөх боломжтой болох юм. Иймд мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд цаг хугацаа чухал бөгөөд гэмт хэрэгтний хурдан хугацаанд илрүүлснээр шүүхийн шатанд ял оноох боломжтой болох юм

VI.ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1. Бүгд Найрамдах Зимбабве Улс

Зимбабве улс санхүүгийн зах зээл, санхүүгийн байгууллагууддаа мөнгө угаах, банкны луйвар, терроризмыг санхүүжүүлэхийг таслан зогсоох зорилгоор Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль, Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль зэрэг хууль тогтоомжийг баталсан.

а) Банкны хэрэглээг дэмжих, мөнгө угаах гэмт хэргийг таслан зогсоох тухай хууль

Тус хуулиар албан ёсны банкны системийг ашиглахыг дэмждэг бөгөөд мөнгө угаах, банкны луйвар зэрэг банкны албан бус, болгоомжгүй үйлдлээс үүдэлтэй санхүүгийн хямралаас хамгаалах зорилгоор батлагдсан хууль юм.

b) Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль

Тус хууль нь хар тамхины наймаа, мөнгө угаах зэрэг бүх хүнд гэмт хэргийн хууль бус, олсон орлогыг илрүүлж, хураан авах зорилгоор Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийг (Мөнгө угаах алба- Money Laundering Unit) байгуулсан.

c) Мөнгө угаах, гэмт хэргийн орлогын хууль

Мөнгө угаах, залилан мэхлэх болон бусад санхүүгийн гэмт хэргүүдийг таслан зогсооход Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх албаны хамтын ажиллагаа, чиг үүргийг Гэмт хэргээс олсон орлогын тухай хуульд заасан.

Мөн мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хиймэл оюун ухаан дээр суурилсан платформыг нэвтрүүлж байна. KYC Үйлчлүүлэгчдээ бодитой байлгах, эрсдэлийг үнэлэх, хянахад шаардлагатай бүх арга хэмжээг багтаадаг. Үйлчлүүлэгчийг танин мэдэх үйл явц нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад хууль бус авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд тусалдаг. KYC процесс нь иргэний үнэмлэх баталгаажуулалт, нүүр царайны баталгаажуулалт, хаягийн баталгаа болох нийтийн үйлчилгээний төлбөр гэх мэт баримт бичгийн баталгаажуулалт, биометрийн баталгаажуулалт зэрэг орно. Үйлчлүүлэгч нь KYC-ийн хамгийн бага шаардлагыг хангаагүй тохиолдолд банкууд данс нээхээс татгалзаж эсвэл бизнесийн харилцаагаа зогсоож болно.

2. Бүгд Найрамдах Сингапур Улс

Сингапур Улсын Төв банк (MAS) нь мөнгө угаах гэмт хэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг. Сингапур нь ихэвчлэн гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан томоохон бизнесийн төв учраас олон улсын байгууллагуудын мөнгө угаах гэмт хэргийн эсрэг дүрмийг дагаж мөрддөг.

Сингапур дахь мөнгө угаах гэмт хэргийн хүрээг хэд хэдэн хууль баталж байгаа бөгөөд тус бүр нь санхүүгийн гэмт хэргийн өөр өөр талуудыг авч үздэг.

a) Авлига, Мансууруулах бодисын хууль бус эргэлт болон бусад хүнд гэмт хэргийн тухай хууль (CDSA)

Авлига, хар тамхины наймаа болон бусад хүнд гэмт хэрэгтэй тэмцэх эрх бүхий байгууллагад эрх зүйн цогц арга хэмжээ авах замаар эрх мэдлийг олгох тухай;

b) Терроризм (Санхүүжилтийг таслан зогсоох) тухай хууль (TSOFA):

Терроризмын үйл ажиллагааг санхүүжүүлэхийг урьдчилан сэргийлэх замаар таслан зогсоох тухай;

c) **Үнэт чулуу, үнэт металлын тухай хууль (PSMTFA):**

Үнэт чулуу, металлын худалдааг зохицуулах, ил тод байдлыг хангах, энэ салбарын хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх тухай;

d) **Үнэт цаас ба фьючерсийн тухай хууль (SFA):**

Үнэт цаас, фьючерсийн зах зээлийн зохицуулалтын тогтолцоог бүрдүүлж, зах зээлийн шударга байдал, хөрөнгө оруулагчдын хамгаалалт, шударга практикийг дэмжих тухай;

e) **Компьютерын зүй бус хэрэглээ ба кибер аюулгүй байдлын тухай хууль (CMCA):** Компьютерын систем, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах хууль эрх зүйн арга хэмжээ авах замаар кибер аюул занал, зөвшөөрөлгүй хандалтыг шийдвэрлэх тухай;

f) **Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (PDPA):**

Хувь хүний мэдээллийг цуглуулах, ашиглах, задруулахыг зохицуулж, мэдээллийн хариуцлагатай менежментийн туршлагыг дэмжин хамгаалдаг.

Түүнчлэн Сингапур улсын хувьд Санхүүгийн байгууллагуудад сэжигтэй үйлчлүүлэгчид болон гүйлгээний талаарх мэдээллийг хуваалцах зэрэг мөнгө угаах гэмт хэргийн эсрэг хиймэл оюун ухаан дээр суурилсан платформыг нэвтрүүлж байна. Мэдээлэл солилцохыг «масштабтай, бүтэцтэй хэлбэрээр явуулах, сэжигтэй гүйлгээний тайлангийн алба буюу санхүүгийн мэдээлэл хүлээн авч, дүн шинжилгээ хийж, түгээдэг байгууллага нэгж нь COSMIC-ийн мэдээлэлд шууд хандах боломжтой. COSMIC-ийн дагуу үйлчлүүлэгчийн зан байдал, гүйлгээ нь тогтоосон босгыг давсан улаан тугийг харуулсан тохиолдолд л мэдээлэл хуваалцахыг зөвшөөрдөг.Кибер аюулгүй байдлын хатуу арга хэмжээнүүдийг ашиглан мэдээлэл солилцож, найдвартай хадгалах үүргийн дагуу хяналтыг үр дүнтэй болгохын тулд дотоод болон гадаад аудитын шалгалт хийдэг. Санхүүгийн байгууллагууд өөрсдийн зүгээс зөвхөн цөөн тооны эрх бүхий албан тушаалтнуудад COSMIC-д нэвтрэхэд зөвшөөрөгдсөн этгүүдүүд мэдээлэл солилцох журмаар хамгаалалтын арга хэмжээн дор хэрэгжүүлэх зорилготой.

3. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

Их Британи дахь мөнгө угаах гэмт хэргийн эсрэг зохицуулалтыг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мөнгө журам (MLR 2017)-аар зохицуулдаг. Энэхүү журам нь бизнес эрхлэгчдэд үйлчлүүлэгчидтэй харилцах, эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэл хөтлөх зэрэгт тавигдах шаардлагыг тусгаснаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилготой юм.

Их Британи дахь Гэмт хэргийн орлогын тухай хууль (POCA) нь мөнгө угаахтай тэмцэх үндсэн хууль тогтоомжийн нэг юм. POCA нь 2002 онд хэрэгжиж эхэлснээс хойш тус улсад санхүүгийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж ирсэн. Энэхүү хууль нь мөнгө угаах гэмт хэрэгт онцгойлон чиглэгддэг бөгөөд банк болон бусад

санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах гэмт хэргийн эсрэг үүргийг зохицуулдаг

2022 оны Эдийн засгийн гэмт хэргийн тухай хууль (Ил тод байдал ба хэрэгжилт) нь эдийн засгийн гэмт хэрэг, тэр дундаа мөнгө угаах гэмт хэргийн хэрэгжилтийг ил тод, хариуцлагыг дээшлүүлэх шинэ арга хэмжээг нэвтрүүлэх замаар бэхжүүлэх зорилготой юм.

Тус улсын хувьд Sanction Scanner гэх платформыг нэвтрүүлж эхэлж байна. Хувь хүн болон аж ахуйн нэгжүүдийг дэлхийн хориг арга хэмжээний жагсаалтаас шалгах

НҮБ,OFAC, Их Британийн Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх алба (OFSI) болон бусад олон хориг арга хэмжээнүүдийг багтаасан 1000 гаруй хориг арга хэмжээ, хяналтын жагсаалтыг бодит цаг хугацаанд нь шалгадаг. Sanction Scanner нь хориг арга хэмжээ авахаас гадна гүйлгээний хяналтыг санал болгодог бөгөөд энэ нь бизнес эрхлэгчдэд бодит цаг хугацаанд сэжигтэй гүйлгээг илрүүлэх, урьдчилан сэргийлэх боломжийг олгодог.

Дээрх улсуудын жишээнээс харахад мөнгө угаах гэмт хэргийн эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтээс гадна хиймэл оюун ухаан дээр суурилсан платформыг нэвтрүүлж байна. Энэ нь хүний нөөцийн эрсдэлд орох болон олон мянган сэжигтэй гүйлгээг цаг алдалгүй илрүүлж, дамжуулахад чухал ач холбогдол бүхий технологийн дэвшил юм.

Мөнгө угаах гэмт хэрэг нь улс орон бүрт тодорхой хэмжээгээр үйлдэгдэж, нийгэм эдийн засгийн хүнд нөхцөл байдлыг үүсгэдэг. Дэлхий нийтээр мөнгө угаах гэмт хэргийн эсрэг авч хэрэгжүүлж буй шийдлийн нийтлэг нь хиймэл оюун ухаан дээр суурилсан платформ байгаа ба одоогоор үүнээс илүүтэй урьдчилан сэргийлэх аргийг олж чадаагүй байна.

VI. ДҮГНЭЛТ, САНАЛ

Мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хуульдаа хуульчлах үүргийг олон улсын өмнө хүлээснээс хойш өдгөө 23 жилийн нүүрийг үзэж байгаа ч цагаан захтны гэмт хэргийн онолын дагуу нийгмийн дээд давхаргынхан үйлддэг гэх мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгч этгээдэд ял шийтгэл оноож чадалгүйгээр зөвхөн нийгмийн доод давхаргынхан түлхүү үйлддэг хулгай, дээрэм, малын хулгай гэх мэт нийгмийн гарал байдал, ажилгүйдлээс шалтгаалж бий болдог өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтнүүдэд мөнгө угаах гэмт хэргээр ял оногдуулсан нь эрүүгийн хуулийн суурь зарчим болох оногдуулсан ял нь үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон байх зарчмыг алдагдуулсан байна.

Иймд энэхүү судалгааны ажлаар дараах санал, зөвлөмжийг боловсруулж байна.

- Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг зааж өгөөгүйгээс үүдэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болох хулгай, малын хулгай, дээрмийн гэмт

хэрэгт мөнгө угаах гэмт хэргээр ял оногдуулж байгаа нь гэмт этгээдийн эрх зүйн байдлыг дордуулж байна. Иймд мөнгө угаах гэмт хэрэгт суурь гэмт хэргийг хуульчилж өгөх шаардлагатай байна.

- Мөнгө угаах гэмт хэрэг нь үйлдэгдэх аргын хувьд хуулийн байгууллагуудын ажилтнуудыг төөрөгдүүлэхэд чиглэсэн, ойлгоход төвөгтэй олон хэлбэр, хувилбараар явагддаг бөгөөд мөнгө угаагчийг илрүүлэхэд цаг хугацаа хамгийн чухал байдаг. Хиймэл оюун ухаан нь хүмүүсээс ялгаатай нь алдааг багасгах, даалгавруудыг хурдан гүйцэтгэх, байнгын бэлэн байдалд байдаг зэрэг нь олон давуу талуудыг үүсгэж мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор зохион бүтээж, сайжруулж байна.
- Хэрэглэгчдийг эрсдэлийн түвшингээр нь ангилснаар бизнесүүд ердийн бус гүйлгээг илүү хурдан илрүүлдэг. Мөнгө угаах гэмт хэргийн эсрэг гүйлгээний хяналтын программ хангамж нь компаниудад өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дүрэм журам, хувилбаруудыг бий болгох боломжийг олгосноор мөнгө угаахтай тэмцэх гүйлгээний хяналтын үйл явцыг автоматжуулах боломжтой. Хиймэл оюун ухаанаар ажилладаг гүйлгээний хяналтын систем нь секундэд хэдэн сая гүйлгээнд дүн шинжилгээ хийж, болзошгүй мөнгө угаах гэмт хэргийн эсрэг эрсдэлийг тэмдэглэж, дагаж мөрдөх банкуудад анхааруулга өгдөг.
- Иймд Манай улсын хувьд Зимбабве, Сингапур, Их Британи, Герман зэрэг бусад орнуудын туршлагаас суралцан хиймэл оюун ухаан дээр суурилсан платпормыг нэвтрүүлж, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой. Энэ нь арилжааны банкууд болон хууль сахиулах байгууллага хооронд өндөр шалгуур дор мэдээлэл солилцох боломжийг үүсгэж, сэжигтэй гүйлгээг цаг алдалгүй илрүүлэх зэрэг олон давуу талуудыг бий болгож байгаа нь мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх явцыг хурдасгах юм.

VII. НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

Улс орнууд мөнгө угаахыг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенц (Венийн конвенц

НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенц (Палермо конвенц)

Эрүүгийн хууль (2002 он)

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга (2015 он)

Ном, өгүүлэл, нийтлэл

Очирбат, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилсан сэргийлэхэд шинжлэн магадлахуйн дүгнэлт үзүүлэх нь, (2023), https://legaldata.mn/buteel/pdf?id=423

Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага, Монгол Улсын хоёр дахь шатны дахин үнэлгээний тайлан, (2019)

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Монгол Улсын Дээд шүүх, (УБ, 2013), ХЗҮХ

Ц.Цэлмэг, Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэж буй практикт хийсэн дүн шинжилгээ, (2023), Холбоос: https://legaldata.mn/b/1723,

Монголбанк, “Санхүүгийн салбарын төлөв байдал, цаашид анхаарах асуудал”, Монголбанк Судалгааны ажил «Товхимол 15»,

Монголбанк, Банкны салбарын өнөөгийн нөхцөл байдал, бодлогын зорилтууд, (2023 оны 2-р улирал).

Гадаад эх сурвалж

Muhammad Zain Malik, Shah Nazir, Transforming the competencies of Artificial Intelligence to ensure the Cyber Threats: A Systemic Literture Review of Busniess Sectors, 2022 1st International Conference on AI in Cybersecurity (ICAIC), Холбоос: https://ieeexplore.ieee.org/document/9897051

Basel Institute on Governance, Basel AML index, 2023.04.05, Холбоос: https://index.baselgovernance.org/ranking,

Association for Democratic Reforms, “Black money and its Estimation ”, https://adrindia.org/sites/default/files/%5BAnnexure%2030%5D.pdf,

Benjámin Villányi, Money laundering: History, Regulations, and Techniques, https://www.semanticscholar.org/paper/Money-Laundering%3A-History%2C-Regulations%2C-and-Vill%C3%A1nyi/d9aea5d649e48d6f34b628688c4ccfd78d4ec945

Yusarina Mat Isa, Z. M. (2015). Money Laundering Risk: From the Bankers' and Regulators Perspectives, Холбоос: https://www.infona.pl/resource/bwmeta1.element.elsevier-29e907ed-fea4-3445-b1fd-5d46263e390f,

Цахим хаяг

Б.Билэгсайхан, Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад орсноос хойш дахин АНУ-ын банктай хамтарч эхэллээ: Холбоос: https://news.mn/r/2696016/

МонголБанк, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь, 2020 он.

ДОТООДЫН БОЛОН ОЛОН УЛСЫН УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САНГ ХӨГЖҮҮЛЭХ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Л.Болормаа, Т.Мөнхзаяа**, О.Маралмаа****

**Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, 5 дугаар түвшин, Эрх зүй хөтөлбөр. И-мэйл: luthvvbolormaa@gmail.com*

***Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, 5 дугаар түвшин, Эрх зүй хөтөлбөр. И-мэйл: Zaya.Tumenbat@gmail.com*

****Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, 5 дугаар түвшин, Эрх зүй хөтөлбөр. И-мэйл: maralmaralaa090@gmail.com*

ТОВЧ ХУРААНГУЙ

Олон Улсын Базелийн хорооноос жил бүр гаргадаг улс орнуудын мөнгө угаахтай тэмцэх тогтолцооны индексийн 2023 оны тайланд манай улс нийт 152 орноос 83, Зүүн Азийн орнуудаас 14 дүгээр байранд жагссан бөгөөд нийт 10 онооноос 5 оноогоор дүгнэгдсэн байгаа нь мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл харьцангуй өндөр орнуудын тоонд орж байгааг харуулж байна.[1] Мөнгө угаах гэмт хэргийн субъект нь "улс төрд нөлөө бүхий этгээд" байх эрсдэл өндөр байдаг тул дэлхий даяар уг этгээд болон түүний хамаарал бүхий этгээдүүдийн жагсаалт хөтлөн тэдгээрийн гүйлгээнд хяналт тавих замаар "мөнгө угаах" гэмт хэргийн гаралтад хяналт тавих хандлагатай байдаг.

Улс төрд нөлөө бүхий этгээд, тэдгээрийн гэр бүл, ойр дотно харилцаатай хүмүүс авлига хээл хахууль, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, бусад санхүүгийн гэмт хэрэгт холбогдох эрсдэл өндөр этгээдэд хамаардаг. Энэхүү судалгааны ажлаар улс төрд нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт, олон улсын байгууллага болон улс орнууд тэдгээрийг хэрхэн илрүүлдэг, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах зорилгоор улс төрд нөлөө бүхий этгээдийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэхийн ач холбогдол, эрх зүйн зохицуулалтыг судалсан болно.

ТҮЛХҮҮР ҮГ

Улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх (МУТС), Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/, мэдээлэх үүрэг бүхий этгээд, санхүүгийн мэдээллийн алба, УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн сан

[1] Public Ranking - Basel AML Index (baselgovernance.org)

УДИРТГАЛ

Судалгааны ажлын бүтэц:

I. Улс төрд нөлөө бүхий этгээдийн тухай ойлголт

II. Улс төрд нөлөө бүхий этгээдийн талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

2.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох журмуудад зааснаар

2.2. Эрүүгийн хуульд зааснаар

III. Улс төрд нөлөө бүхий этгээдийн талаарх бусад улс, олон улсын байгууллагын зохицуулалт

3.1. The Financial Action Task Force (FATF) буюу Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/

3.2. Америкийн Нэгдсэн Улс /АНУ/

3.3. Швейцар улс

IV. Улс төрд нөлөө бүхий этгээдийн нэгдсэн мэдээллийн сан

ДҮГНЭЛТ

НОМ ЗҮЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

I. УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ


Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас /FATF/ өөрийн 12 дугаар зөвлөмжид "улс төрд нөлөө бүхий этгээд (цаашид "**УТНБЭ**" гэх) гэж нийтийн албанд нөлөө бүхий албан тушаалд томилогдсон этгээдийг ойлгоно"[2] хэмээн тодорхойлсон байдаг. Уг этгээд нь өөрийн ажил мэргэжлийн онцлог, эрх мэдлээр дамжуулан мөнгө угаах, түүнтэй холбоотой бусад авлига, хээл хахуулийн гэмт хэргүүдийг үйлдэх, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцох өндөр эрсдэлтэй байдаг байна.[3] Энэхүү эрсдэлийг урьдчилан тогтоож түүнээс сэргийлэхийн тулд улс орнууд банк, санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн байгууллагуудад уг эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, нэгэнт бий болсон зөрчлийг нээн илрүүлж, мэдээлэх арга хэмжээ авахыг даалгах механизмыг бий болгодог. Иймд дэлхийн ихэнх улс орнуудад "улс төрд нөлөө бүхий этгээд"-ийг тодорхойлж, банк, санхүүгийн болон санхүүгийн бус бусад бизнесийн үйл ажиллагаа эрхлэгчид харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулан уг этгээдийг тогтоох замаар түүнийг сэжигтэй гүйлгээ бүрийг хянан, тухай бүр мэдээлэхийг даалгах замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх

[2] Financial Action Task Force, Politically Exposed Persons (Reccommendations12 and 22), 2013. https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/guidance/Guidance-PEP-Rec12-22.pdf.coredownload.pdf

[3] Мөн тэнд

механизмыг бүрдүүлээд байна.

УТНБЭ-ийг практик хэрэглээнд тулгуурлан эрсдэлийн түвшнээр нь дараах байдлаар ангилан авч үзэж болдог байна:[4]



Өндөр эрсдэл бүхий буюу 1-р зэрэглэлийн УТНБЭ- Төр засгийн тэргүүн, ЗГ болон парламентын гишүүн, дээд шүүхийн шүүгч, цэрэг, хүчний байгууллагын удирдах албан тушаалтан, цолтон, төв банк болон улс төрд нөлөө бүхийн намын дарга нар.
Цэрэг арми, шашны байгууллагын өндөр албан тушаалтан, ахлах комиссар, консул, элчин сайд нар.
Төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал.
Олон улсын болон үндэстэн дамнасан байгууллагын ажилчид, сум, дүүрэг, аймаг, хотын засаг дарга, удирдах албан тушаалтнууд.

II. УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ:

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох журмуудад зааснаар:

Олон улсад УТНБЭ-ийг “дотоодын”, “гадаадын”, “олон улсын” хэмээн төрөлжүүлэн үздэг[5] бөгөөд манай улсын хувьд ч мөн ерөнхий төрлүүдийг ашиглан УТНБЭ-ийг таних, түүний гүйлгээнд хяналт тавих талаарх зохицуулалт,гарын авлага, зөвлөмжүүдийг боловсруулж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд “улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн3 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг ойлгоно гэж заасан байдаг.[6] Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасны дагуу УТНБЭ-д дараах этгээдүүд хамаарч байна. Үүнд:

---

4 Politically Exposed Person - An unsaid threat to Businesses (shuftipro.com)

5 Мөн тэнд

6 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.5 дахь заалт

Хүрээ	***Чиглэл***	***Этгээд***
Дотоодын УТНБЭ	Хууль тогтоох байгууллага	УИХ-ын гишүүн;
	Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага	Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн (сайд, дэд сайд), яамны төрийн нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засгийн газрын агентлагийн дарга;
	Шүүх эрх мэдлийн байгууллага	Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор; Орон нутгийн гүйцэтгэх засаглалын, прокурорын, тагнуулын байгууллагын дарга нар, давж заалдах шатны болон дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгч нар; Ерөнхий прокурор, түүний орлогчид; Тагнуулын ерөнхий газрын дарга, түүний орлогчид;
	УИХ-аас томилогддог байгууллага	Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Хүний эрхийн үндэсний комиссын дарга, тэдгээрийн тэргүүн дэд, дэд дарга, орлогч дарга;
	Улс төрийн нам	УИХ-д суудал бүхий намын дарга
	Төрийн өмчит компани, Олон улсын байгууллага	Төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн;
	Гэр бүлийн гишүүн	Гэр бүлийн гишүүд гэж УТНБЭ-тэй шууд эсвэл гэр бүлийн харилцаагаар нягт холбоотой хүмүүсийг хэлнэ. Үүнд:[7] - эхнэр, нөхөр болон хамтран амьдрагч; - хүүхэд (үрчилж авсан, дагавар хүүхэд мөн багтана); - төрсөн болон хойд эцэг, эх; - эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн эцэг, эх; - төрсөн болон хойд эцэг, эхийн хүүхэд. Ойрын хүрээний хүн гэж улс төрд нөлөө бүхий этгээдтэй нийгмийн, хувь хүний, мэргэжлийн, аль эсвэл бизнесийн харилцаагаар нягт холбоотой,[8] харилцаа хамаарал бүхий хүнийг мөн ойлгодог.

[7] “Улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох талаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан гарын авлага”-ын 2 дугаар зүйлийн 2.1.7 дахь заалт

[8] “Улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох талаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан гарын авлага”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт

	Нэгдмэл сонирхолтой этгээд	"Нэгдмэл сонирхолтой этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.[9] Төрийн өмчит компани, Олон улсын байгууллагын дарга, захирлын хувьд түүнтэй хамаарал бүхий этгээд.[10]
Гадаадын УТНБЭ	Дээр дурдсан этгээдүүдтэй адил чиг үүргийг хэрэгжүүлж буй гадаадын иргэдийг хэлнэ. Гадаадын улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн үүрэг функц нь дээр дурдсанаар хязгаарлагдах албагүй.	
Олон Улсын байгууллагын УТНБЭ	Дараах иргэдийг олон улсын байгууллагын улс төрд нөлөө бүхий этгээд гэж үзнэ. Үүнд: - Сүүлийн хэдэн жил олон улсын байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан/байгаа (тухайлбал, захирал, зөвлөлийн тэргүүн, тэдгээрийн орлогч нар) хүн; - Удирдлагын бусад чиг үүргийг дээд түвшинд хэрэгжүүлж байгаа/байсан (ялангуяа олон улсын эсвэл засгийн газар хоорондын байгууллагад) хүн; - Олон улсын парламентын ассамблейн гишүүд; - Олон улсын шүүхийн шүүгчид болон удирдах албан тушаалтнууд.	

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу дээр тодорхойлсон УТНБЭ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй харилцагчид хамаардаг.[11] Тийм ч учраас мэдээлэх үүрэгтэй этгээд[12] нь УТНБЭ-ийн нэр дээр хийсэн гүйлгээнд тусгайлан хяналт тавьж, Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй байдаг.[13] Иймд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан "мэдээлэх үүрэгтэй этгээд"-үүд нь дараах байдлаар харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулан УТНБЭ болон түүний гэр бүл, нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг таньж мэдэн, гүйлгээнд тусгайлан хяналт тавьж байна.

УТНБЭ болон тэдний гэр бүл, ойрын хүрээний хүнийг таньж мэдэх үйл ажиллагаа

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн харилцагчийг таньж мэдэх ажиллагаа нь дараах 2 төрөлтэй:

- Стандарт таньж мэдэх үйл ажиллагаа буюу бүх харилцагчид хамааралтай.
- Нарийвчилсан таньж мэдэх ажиллагаа буюу өндөр эрсдэлтэй харилцагч болон гүйлгээнд хамааралтай.

[9] Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт

[10] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны нийлүүлэгч, гүйцэтгэгч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч

[11] Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйлийн 5.9.1 дэх заалт

[12] Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг

[13] Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт

Стандарт таньж мэдэх ажиллагааны хүрээнд тухайн харилцагчийг УТНБЭ мөн эсэхийг дараах байдлаар анхлан тогтоох боломжтой байдаг. Үүнд:

Харилцагчийг улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тогтоох[14]
Дотоодын болон олон улсын байгууллагын улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тогтоох: Мэдээлэх үүрэг бүхий этгээд нь тухайн харилцагч буюу эцсийн өмчлөгч нь дотоод болон олон улсын байгууллагын улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тогтоохдоо улс төрд нөлөө бүхий этгээдийн талаарх харилцагчийг таньж мэдэх мэдээлэл, нийтэд нээлттэй мэдээлэл, мэдээллийн сан, арилжааны мэдээллийг ашиглана. Энэхүү процедурыг дараах тохиолдолд хэрэгжүүлнэ: - Бизнесийн харилцаа тогтоох үед; - Хуульд заасан босго үзүүлэлтээс дээш дүнтэй гүйлгээ хийх үед; - Хуульд заасан босго үзүүлэлтээс дээш дүнтэй хил дамнасан болон дотоодын цахим шилжүүлэг хийх үед; - Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлж байна гэх сэжиг төрсөн бол; - Харилцагчийн талаар өмнө нь олж авсан мэдээллийн үнэн зөв, бодит байдалд эргэлзээ төрсөн бол.
Гадаадын улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тогтоох: - Харилцагчийг эрсдэлийн шалгуур, эрсдэлийн зураглал болон бизнесийн загварт суурилан үнэлнэ; - Харилцагчийг таньж мэдэх мэдээллийг шалгана; - Тухайн этгээдийн талаарх судалгаа хийнэ.

Хэрэв стандарт буюу бүх харилцагчид хамаарах таньж мэдэх ажиллагаагаар тухайн харилцагч УТНБЭ байх тохиолдолд Үйлчлүүлэгч нь нарийвчилсан таньж мэдэх ажиллагаа явуулах шаардлагатай. Тухайлбал, УТНБЭ хэмээн тогтоосон тохиолдолд Монгол банкнаас баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”[15]-д заасны дагуу эрсдэлийг бууруулах дараах арга хэмжээг авах боломжтой байдаг.

2. Монгол улсын Эрүүгийн хуульд (2015 он) зааснаар:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.6.2 дахь хэсгийн тайлбар хэсэгт *“Улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн*

[14] “Улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох талаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан гарын авлага”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлин 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг

[15] Монгол банк, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”, (2023 оны нэмэлт, өөрчлөлт орсон, https://fiu.mongolbank.mn/file/files/documents/cma/20230125_A26.pdf)

Төлөөлөгчдийн Хурлын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргыг ойлгоно." гэж заасан бөгөөд дараах гэмт хэргүүдийг УТНБЭ үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдалд хамаарахаар зохицуулсан. Үүнд:

1) ЭХ-ийн 21.6 дугаар зүйл. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх
2) ЭХ-ийн 22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах
3) ЭХ-ийн 22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах
4) ЭХ-ийн 22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
5) ЭХ-ийн 29.2 дугаар зүйл.Түрэмгийлэл, эсхүл дайн өдөөхийг нийтэд уриалах

III. УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ БУСАД УЛС, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЗОХИЦУУЛАЛТ

3.1. The Financial Action Task Force (FATF) буюу Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/

The Financial Action Task Force (FATF) буюу Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /ФАТФ/ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх дэлхий нийтийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус бүлэг юм. Уг байгууллагын зөвлөмж нь дэлхий нийтийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрөгддөг.[16] Уг байгууллагаас 2013 онд "Улс төрд нөлөө бүхий этгээд: Зөвлөмж 12 ба 22" гэх зөвлөмжийг /цаашид **"Гарын авлага"** гэх/ гаргасан байна.[17] Энэхүү зөвлөмжид "улс төрд нөлөө бүхий этгээд"-ийг дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

А. УТНБЭ болон түүний гэр бүлийн гишүүн, хамаарал бүхий этгээдүүдийн тодорхойлолт:

1) Улс төрд нөлөө бүхий этгээдийн төрөл, түүний тодорхойлолт:
   a) Гадаадын улс төрд нөлөө бүхий этгээд - Гадаад улсын нийтийн албанд нөлөө бүхий албан тушаалд томилогдсон этгээдийг ойлгоно. Жишээлбэл,төр засгийн тэргүүн, улс төрчид, шүүх, цагдаагийн өндөр албан тушаалтнууд , төрийн өмчит компаниудын удирдах албан тушаалтан, улс төрийн нөлөө бүхий намын дарга зэрэг хамаарч болно.
   b) Дотоодын улс төрд нөлөө бүхий этгээд - Дотоодын нийтийн албанд нөлөө бүхий албан тушаалд томилогдсон этгээдийг ойлгоно.

[16] Ө.Хулан, "Эрх бүхий байгууллагаас улс төрд нөлөө бүхий этгээдийн нэгдсэн жагсаалт гаргах шаардлага, ач холбогдол" илтгэл, УБ, 2018 он

[17] The Financial Action Task Force (FATF), "Politically Exposed Person (Recommendations 12 and 22)", 2013. Guidance-PEP-Rec12-22.pdf.coredownload.pdf (fatf-gafi.org)

c) Олон улсын улс төрд нөлөөл бүхий этгээд - Олон улсын байгууллагын нөлөө бүхий, өндөр албан тушаалд томилогдсон этгээдийг ойлгоно. Үүнд, гүйцэтгэх захирал, орлогч захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гэх мэт удирдах албан тушаалтнууд болон түүнтэй адилтгах бусад албан тушаалтнууд хамаарч болно.

d) Улс төрд нөлөө бүхий этгээдийн гэр бүлийн гишүүд- УТНБЭ-тэй шууд ураг төрлийн болон гэрлэлт эсхүл түүнтэй адилтгах хамтын амьдралын харилцаагаар холбогдон этгээдүүдийг ойлгоно.

e) Улс төрд нөлөө бүхий этгээдийн ойрын хамаарал бүхий хүн- УТНБЭ-тэй нийгмийн болон ажил хэргийн шугамаар ойр дотно хамтран ажилладаг этгээдүүдийг ойлгоно.

В. УТНБЭ-ийн мэдээллийн сангийн талаар

Зөвлөмжид дурдсанаар УТНБЭ-ийн холбогдсон гэмт хэргүүд мэдээ, хяналтын зөвлөлөөс гаргасан мэдээгээр ихэнх гэмт хэргийн тохиолдолд мэдээлэх үүрэг бүхий этгээдүүд тухайн харилцагчийг УТНБЭ байсан болохыг хамгийн багадаа нэг жилийн дараа мэддэг бөгөөд учирч болох гэмт хэргийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж чадаагүй байдаг байна. Иймээс мэдээлэх үүрэг бүхий этгээд нь өөрийн харилцагчийн мэдээллийн сангийн мэдээллийг дотоод болон дэлхий дахинд УТНБЭ-үүдийн өөрчлөлт бий болох тухай бүр шинэчилж, хянан шалгаж байх нь чухал бөгөөд хэрэглэгчийг таних ажиллагааны үр нөлөөг сайжруулахын тулд УТНБЭ-ийн “мэдээллийн сан” зэрэг гуравдагч мэдээллийн эх сурвалжуудаас бусад хэрэгцээт мэдээллийг цуглуулах нь чухал болох тухай дурджээ.

Зөвлөмжийн 60 дахь хэсэгт, ихэнх мэдээлэх үүрэг бүхий этгээдүүд харилцагчийг УТНБЭ болохыг таньж мэдэх ажиллагаанд интернэт, цахим орчин дахь мэдээллийн эх сурвалжийг ашиглах нь түгээмэл боловч нээлттэй хайлт нь төдийлөн оновчгүй бөгөөд давхар шалгалт шаардлагатай байдаг тул тухайлсан “AML-website”-ууд руу хандах нь илүүтэй оновчтой байдаг талаар дурдсан байна. Тухайлбал, гадаадын УТНБЭ-ийг таньж мэдэх ажиллагаанд тухайн харилцагчийн улсын тухайлсан “AML-website”, болон мэдээллийн санг судлах нь гадаадын харилцагчийг таньж мэдэх хамгийн оновчтой аргад хамаардаг. Иймд улс орон бүр тухайлсан “AML-website”-уудыг хөгжүүлэх, УТНБЭ-ийн мэдээллийн санг үр нөлөөтэйгөөр хөтлөх нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд маш чухал ач холбогдолтой байгаа юм. Иймд зөвлөмжид дурдсанаар улс орнуудад дараах УТНБЭ-ийн мэдээллийн сангийн төрлүүдийг хөтлөн ашиглаж байна. Үүнд:

Төлбөртэй мэдээллийн сан /Commercial database/

Зөвлөмжийн 61 дэх хэсэгт, мэдээлэх үүрэг бүхий этгээдүүд “commercial database” буюу төлбөртэй мэдээллийн санг ашиглах нь харилцагчийг таньж мэдэх ажиллагаанд үр нөлөөтэй байдаг талаар дурджээ. Хэдийгээр тухайн мэдээллийн

сангийн төлбөр нь зарим мэдээлэх үүрэг бүхий байгууллагуудад хэт өндөр байж болох боловч, төлбөрийн хэмжээгээр тухайн үйлчилгээ үзүүлэгч нь мэдээллийн санг төдий чинээ сайн хөгжүүлсэн байдаг байна. Мөн Зөвлөмжид "хэдийгээр төлбөртэй мэдээллийн сангаас үйлчилгээ авах нь зарим мэдээлэх үүрэг бүхий этгээдэд хэт өндөр байж болох ч уг үйлчилгээг зайлшгүй УТНБЭ-ийг таних ажиллагааны явцад авч хэрэгжүүлэх арга хэмжээг анхааралдаа авах нь чухал байна" хэмээн тусгайлан дурджээ.

Зөвлөмжийн 62 дахь хэсэгт, хэдийгээр олон улсын төлбөртэй мэдээллийн сангийн үйлчилгээг авах нь хэрэглэгчийг таньж мэдэх ажиллагаанд авч хэрэгжүүлэх чухал арга хэмжээнүүдийн нэг байж болох ч дотоодын "харилцагчийг таньж мэдэх ажиллагаа"-г хэзээ ч орлохгүй бөгөөд зөвхөн нэмэлт байдлаар авч хэрэгжүүлэх нь эрсдэлийг бууруулахад маш нөлөөтэй тухай дурджээ.

Засгийн газраас гаргах УТНБЭ-ийн жагсаалт /Government Issued PEP-Lists/

Зөвлөмжийн 64 дэх хэсэгт, зарим улс орнуудын хувьд ФАТФ стандартаар шаардаагүй боловч дотоодын УТНБЭ-үүдийн нэрс эсхүл албан тушаалуудын жагсаалтыг нийтлэх түгээмэл хандлага ажиглагддаг бөгөөд улс орнууд дараах 2 байдлаар уг жагсаалтыг хөтөлдөг гэжээ. Үүнд:

1) УТНБЭ-д тооцогдох этгээдүүдийн нийтийн албан тушаалын жагсаалтыг гаргах;
2) УТНБЭ-үүдийн нэрсийн жагсаалтыг гаргах.

Нэрсийн жагсаалт гаргах аргын хувьд УТНБЭ нь тогтмол солигдох боломжтой бөгөөд тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг гаргадаггүй гэх мэт нэлээдгүй асуудал дагуулдаг учир ФАТФ-с уг аргыг төдийлөн дэмждэггүй байна. Харин ажил, албан тушаалын жагсаалтыг гаргах нь дотоодын болоод гадаадын УТНБЭ-ийг танихад нэлээдгүй үр нөлөөтэй аргад хамаардаг гэжээ. Мөн зөвлөмжид "Хэдийгээр УТНБЭ-ийн гэр бүлийн гишүүд болон ойрын хамаарал бүхий этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргах боломжгүй боловч 12 дугаар зөвлөмжийн дагуу УТНБЭ-д хамаарсаар байх болно" гэжээ.

Байгууллагын дотоодын мэдээллийн сан /In-house Database/

Зөвлөмжийн 69 дэх хэсэгт зааснаар зарим байгууллагууд УТНБЭ-ийг таньж мэдэх зорилгоор өөрийн дотоодын "УТНБЭ-ийн мэдээллийн сан"-г хөгжүүлэх хандлагатай байдаг байна. Энэхүү санг төлбөртэй мэдээллийн сангийн адилаар тогтмол шинэчилж, тордож байх шаардлагатай. Уг аргын хамгийн том давуу тал нь байгууллагууд хоорондоо мэдээллийн сан дахь мэдээллээ солилцоход оршдог бөгөөд ялангуяа гадаадын УТНБЭ-ийг таньж мэдэхэд, улс хооронд байгууллагууд өөрсдийн мэдээллийн сангийн мэдээллээ солилцох нь хамгийн үр нөлөөтэй аргад хамаардаг байна. Гэвч уг арга нь зарим улс орнуудын хүний хувийн мэдээллийг олон улсад дамжуулах эрх зүйн хязгаарлалт зэргээс үүдэн хэрэгжих боломжгүйд нөхцөл байдалд хүрдэг ажээ.

3.2. Америкийн Нэгдсэн Улс /АНУ/

А. АНУ-ын УТНБЭ-ийн талаарх эрх зүйн зохицуулалт

АНУ-ын хувьд УТНБЭ-д дотооддоо болон олон улсын хэмжээнд төрийн нэр хүндтэй эрх мэдэл бүхий албан тушаал хашиж байгаа хүмүүсийг багтаадаг бөгөөд тэдгээрийг дараах байдлаар авч үздэг.[18]

Дотоодын УТНБЭ	Гадаадын УТНБЭ этгээд
● Төрийн албан тушаалтан: Засгийн газрын өмнөх болон одоогийн гишүүд, төрийн албан тушаалтнууд; ● Цэргийн албан тушаалтан: Цэргийн ахлах офицерууд, төрийн өмчит батлах хамгаалахын компаниудын удирдлагууд; ● Улс төрийн намын дарга, өндөр албан тушаалтан: Улс төрийн намуудын дарга, намын бусад өндөр албан тушаалтан; ● Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдах албан тушаалтнууд: Төрийн өмчит болон засгийн газрын мэдэлд байдаг корпорацуудын удирдах албан тушаалтан, корпорацуудын гүйцэтгэх удирдлага, томоохон албан тушаалтан Дээр дурдагдсан этгээдүүдийн гэр бүлийн гишүүд ба ойр дотно хүмүүс: УТНБЭ-ийн гэр бүлийн гишүүд, тэдгээрийн ойр дотно хүмүүс	● Гадаадын төрийн болон засгийн газрын тэргүүлэгчид: Одоогийн болон өмнөх ерөнхийлөгч, ерөнхий сайд, түүнтэй адилтгах бусад удирдагчид/зарим улсын хувьд хаан/; ● Төрийн албан хаагчид: Засгийн газрын гишүүд, болон засгийн газрын бусад өндөр албан тушаалтнууд, хууль тогтоогчид, шүүгчид, цэргийн офицерууд; ● Улс төрийн намын дарга нар: Улс төрийн намын дарга, өндөр алба хашдаг хүмүүс; ● УТНБЭ гэж тодорхойлсон хүмүүсийн гэр бүлийн гишүүд хамтран ажиллагсад

АНУ нь УТНБЭ-ийн мэдээллийн санг зохицуулах, санд холбогдох этгээдийг бүртгүүлэхтэй холбоотой бие даасан хууль байдаггүй. Харин хэд хэдэн хууль, дүрэм, зөвлөмжөөр холбогдох байгууллагуудыг үйлчлүүлэгчдээ зохих шалгалт хийх, УТНБЭ мөн эсэхийг тодорхойлох, эрсдэлийг үнэлэхийг зохицуулсан. Үүнд дараах зохицуулалт хамаарч байна. Үүнд:

1) USA PATRIOT Act[19]- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүгийн байгууллагаас “ Гадаадын УТНБЭ”-д зохих шалгалтыг хийхэд зориулсан нэмэлт хяналт шалгалт (Enhanced due diligence)-ыг гүйцэтгэхийг зохицуулсан журам юм.
2) Банкны нууцын тухай хууль[20] (Bank Secrecy Act)-Мөнгө угаах тэмцэх (AML), сэжигтэй гүйлгээг хянах зорилгоор Санхүүгийн байгууллагаас харилцагчдынхаа хувийн мэдээллийг баталгаажуулах, данстай холбоотой эрсдэлийг үнэлдэг. Ингэхдээ УТНБЭ тодорхойлох, хэрэглэгчийг шалгахтай холбоотой зохицуулалт тусгагдсан байдаг.

[18] https://www.ffiec.gov/press/PDF/Politically-Exposed-Persons.pdf
[19] USA PATRIOT Act, (2001), https://www.fincen.gov/resources/statutes-regulations/usa-patriot-act (last accessed: 28 April, 2024)
[20] The Bank Secrecy Act, https://www.fincen.gov/resources/statutes-and-regulations/bank-secrecy-act (last accessed: 28 April, 2024)

3) Гадаадын Хөрөнгийн удирдлагын албаны (Office of Foreing Assets Control) журам[21]- Энэ журмын хувьд АНУ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдалд харш үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдэд эдийн засгийн хориг арга хэмжээ авах зорилготой ч УТНБЭ-тэй холбоотой зарим зохицуулалтыг өөртөө агуулдаг. Санхүүгийн байгууллага УТНБЭ болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүд хориглосон үйл ажиллагаанд оролцсон, хориотой гүйлгээ хийх эсэхэд хяналт тавих, мэдээлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг.
4) Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (Financial Crimes Enforcement Network)-ний зөвлөмж- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой зөвлөмжийг батлах бөгөөд үүнд УТНБЭ-ийг тодорхойлох зөвлөмж багтсан байдаг.

В. АНУ-ын УТНБЭ-ийн мэдээллийн сан

УТНБЭ-ийн мэдээллийн сантай улсын томоохон төлөөлөл бол АНУ юм. АНУ-ын Сангийн яам нь санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээг (Financial Crimes Enforcement Network/FinCEN)[22] хариуцан удирддаг. Гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (FinCEN) нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор УТНБЭ-ээс гадна аж ахуй нэгжийн талаарх мэдээллийг агуулсан мэдээллийн сантай.

3.3. Швейцар улс

А. Швейцар улсын УТНБЭ-ийн талаарх эрх зүйн зохицуулалт

Швейцар улс нь УТНБЭ-ийг дараах 3 төрлөөр тодорхойлсон:

Гадаад	Дотоод	Олон улсын
Гадаад улсын төрийн томоохон чиг үүргийг бүхий хүмүүс, тодруулбал төрийн болон засгийн газрын тэргүүнүүд, үндэсний хэмжээний улс төрчид, засгийн газар, шүүх, цэрэг, улс төрийн намын өндөр албан тушаалтнууд, төрийн өмчит компанийн удирдах албан тушаалтнууд	Швейцар улсын улс төр, засгийн газар, зэвсэгт хүчин, шүүх эрх мэдлийн төрийн нэр хүндтэй үүрэг хүлээсэн эсвэл итгэмжлэгдсэн хүмүүс, эсхүл үндэсний хэмжээний төрийн өмчит компанийн удирдах албан тушаалтнууд	Засгийн газар хоорондын байгууллага эсхүл олон улсын спортын холбооны[23] ерөнхий нарийн бичгийн дарга, захирал, дэд захирал, удирдах зөвлөлийн гишүүд, түүнтэй адилтгах чиг үүрэг бүхий албан тушаалтнууд

УТНБЭ болон тэдний гэр бүлийн гишүүд эсхүл ойр дотно хүмүүстэй хийсэн

[21] Specially Designated Nationals List - Data Formats & Data Schemas, https://ofac.treasury.gov/, https://ofac.treasury.gov/specially-designated-nationals-list-data-formats-data-schemas (last accessed: 28 April, 2024)

[22] Financial Crimes Enforcement Network, https://www.fincen.gov/ (last accessed: 27 April, 2024)

[23] Олон улсын олимпийн хороо, нэг буюу түүнээс дээш спортын төрлийг албан ёсоор дэлхийн хэмжээнд зохион байгуулдаг төрийн бус байгууллага

бизнесийн харилцааг аль ч тохиолдолд өндөр эрсдэлтэй бизнесийн харилцаа гэж үздэг бөгөөд[24] дээрхээс гадна дараах этгээдийг УТНБЭ-д хамаарахаар заасан. Үүнд:

- УТНБЭ-тэй гэр бүл, эсхүл нийгэм болон мэргэжлийн шалтгаанаар нягт холбоотой хүмүүс;
- Үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн бенефициар өмчлөгч буюу тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн 25-аас доошгүй хувийг буюу саналын эрхийг шууд болон шууд бусаар, дангаараа болон гуравдагч этгээдтэй хамтран эзэмшиж, тухайн хуулийн этгээдийг хянадаг хувь хүн хамаарна. Хэрэв бенефициар өмчлөгчийг тодорхойлох боломжгүй бол тухайн хуулийн этгээдийн хамгийн дээд албан тушаал бүхий гүйцэтгэх удирдлага.

Харин дотоодын УТНБЭ-д тооцогдох албан тушаалтныг нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс 18 сар хүртэл хугацаагаар, гадаад болон олон улсын УТНБЭ-ийг хугацаагүйгээр УТНБЭ-д гэж тооцдог байна.[25]

IV. УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН

УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн сан гэдэг нь эдгээр хүмүүсийн мэдээллийг нэгтгэсэн, ихэвчлэн мэдээлэх үүрэгтэй этгээдүүд ашиглах эрхтэй, зарим тохиолдолд олон нийтэд нээлттэй байдлаар үйл ажиллагаа явуулдаг веб сайтууд юм. УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн сан нь зөвхөн өөрийн улсаас гадна дэлхийн олон орны УТНБЭ-ийн мэдээллийг агуулсан байдаг тул мэдээлэх үүрэгтэй этгээдүүд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн санг хувийн, ашиг олох зорилготой компаниуд хөгжүүлэхээс гадна, төрийн байгууллагын харьяа сан мөн зэрэгцэн оршиж байна. Аль ч тохиолдолд УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн сан нь мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлж, УТНБЭ-г амар, хялбар тогтоож, түүнд тавих хяналт сайжрах тул төрийн байгууллага, олон улсын байгууллагуудын дэмжлэгээр хурдацтай хөгжиж байна. Иймд Монгол Улс болон олон улсад ашиглагдаж буй мэдээллийн сангуудын жишээг дараах байдлаар авч үзлээ.

А. МОНПЭП ДАТА ХХК[26]


Манай улсын хувьд “Монпэп дата” ХХК “Sanction Compliance” программыг ашиглан мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд төлбөртэй УТНБЭ-ийн мэдээллийн

[24] Switzerland, Federal Act on Combating Money Laundering and Terrorist Financing, 1997, Art. 6, https://www.fedlex.admin.ch/eli/cc/1998/892_892_892/en (last accessed: 28 April, 2024)

[25] Switzerland, Federal Act on Combating Money Laundering and Terrorist Financing, 1997, Art. 2a, https://www.fedlex.admin.ch/eli/cc/1998/892_892_892/en (last accessed: 28 April, 2024)

[26] https://www.monpep.mn

сангийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхэлж байна. “Sanction Compliance” нь олон улсын хориг, улс төрд нөлөө бүхий этгээд, тэдгээрийн хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг агуулсан хайлтын программ юм. Уг программын тусламжтай мэдээлэх үүрэгтэй этгээдүүд УТНБЭ-ийг хурдан хугацаанд илрүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна.



B. OFAC[27]

АНУ-ын Сангийн яамны харьяа Гадаад хөрөнгийн хяналтын алба (“**OFAC**”) нь АНУ-ын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын зорилгод тулгуурлан террористууд, олон улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын наймаачид, үй олноор хөнөөх зэвсэгтэй холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс болон үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй бусад аюул занал, эдийн засагт заналхийлсэн бусад үйл ажиллагаа, гадаад улс орон, дэглэмийн эсрэг чиглэсэн эдийн засаг, худалдааны хориг арга хэмжээг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлдэг.[28] Эдгээр мэдээллийн санд орсон хүмүүс нь ихэвчлэн УТНБЭ гэж төрийн байгууллагуудаас тодорхойлсон хувь хүмүүс байдаг. АНУ-ын Сангийн

[27] https://sanctionssearch.ofac.treas.gov/
[28] https://ofac.treasury.gov/

яамны харьяа Гадаад хөрөнгийн хяналтын алба (“**OFAC**”)-д хориглогдсон хүмүүсийн жагсаалт (Sanction List Search “**SDN**”)-ын дагуу эдийн засгийн хориг арга хэмжээ авагдсан УТНБЭ-үүдийг багтаасан байдаг.[29]

C. OpenCorporates[30]

OpenCorporates нь Open Database License-ийн дагуу корпорацуудын мэдээллийг хуваалцдаг веб сайт юм. OpenCorporates Ltd компанийг 2010 оны 12-р сарын 18-ны өдөр Крис Таггарт, Роб МакКиннон нар үүсгэн байгуулсан.Мэдээллийг 140 улсын бизнесийн үндэсний бүртгэлээс авч, стандартчилсан хэлбэрээр танилцуулсан. Цуглуулсан мэдээлэлд аж ахуйн нэгжийн нэр, үүсгэн байгуулагдсан огноо, бүртгэлтэй хаяг, захирлуудын нэр багтана. Өмчлөлийн бүтэц гэх мэт зарим өгөгдлийг хэрэглэгчид оруулах боломжтой байдаг. АНУ, Их Британи, Бразил улсын төрийн байгууллага, Европын холбоо, НҮБ зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж өөрийн мэдээллийн санг бүрдүүлдэг.

D. OpenSanctions[31]

OpenSanctions нь улс төр, гэмт хэрэг, эдийн засгийн сонирхол бүхий хүмүүс, компаниудын олон улсын мэдээллийн сан юм. 120 гаруй мэдээллийн эх сурвалжаас авсан аж ахуйн нэгжийн давхардлыг арилгах үйл явц, УТНБЭ-ийн төрсөн огноо, улс, хаяг, татвар гэх мэт өгөгдлийн мэдээллийг нэгтгэж, хориг арга хэмжээ, гэмт хэрэгтэй холбоотой байгууллагуудыг нэгтгэсэн сан юм. Хориг арга хэмжээний жагсаалт, УТНБЭ-ийн мэдээллийн санг хэрэглэхэд хялбар мэдээллийн багц болгон нэгтгэдэг. Уг сан нь дараах ач холбогдолтой:

- Мэдээллийн сангаас ашиг сонирхлын зөрчил, хууль бус үйл ажиллагааны явуулсан эсэхийг шалгах;
- Олон улсын боломжит үйлчлүүлэгчид болон түншүүдийг шалгах;
- Улс төрийн зөрчилдөөнийг хянаж, үндэсний хориг арга хэмжээний бодлогыг харьцуулах;
- Өгөгдлийн дагуу хориг арга хэмжээ болон сонирхлын зөрчилтэй хүмүүсийн графикийг нэгтгэх.

OpenSanctions-ийн хөгжүүлэлт, засвар үйлчилгээг ашгийн төлөө байгууллага (OpenSanctions Datenbanken GmbH) хариуцдаг. Гэхдээ уг мэдээллийн нэгдсэн сангийн төслийг 2021 оны 9 дүгээр сараас 2022 оны 2 дугаар сар хүртэл Германы Боловсрол, судалгааны яамнаас (Bundesministerium für Bildung und Forschung, BMBF) санхүүжүүлсэн.

---

[29] https://www.sanctions.io/blog/what-are-politically-exposed-person-pep-checks#:~:text=All%20individuals%20included%20in%20these%20databases%20have%20already,List%20%28SDN%29%20contains%20PEPs%20subject%20to%20economic%20sanctions.

[30] https://opencorporates.com

[31] https://www.opensanctions.org

E. NameScan[32]

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилготой Австрали улсад үйл ажиллагаа явуулдаг компани юм. Үйл ажиллагааны зорилго нь бизнес эрхлэгчдэд мөнгө угаахаас сэргийлэх эрх зүйн зохицуулалтын дагуу хэрэглэгчид шаардлагатай үйлчилгээг үзүүлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд туслах юм.

Үйлчлүүлэгчээ таньж мэдэх нь бизнесийн үйл ажиллагаанд улам бүр чухал үйл явц болж байна. УТНБЭ болон эдийн засгийн хориг арга хэмжээ авагдсан этгээдүүдийн мэдээллээр дамжуулан үйлчлүүлэгчээ таньж мэдэх, бизнесүүдийг дагаж мөрдөж байгаа эсэхийг нь баталгаажуулахад тусалдаг. Олон мэдээллийн эх сурвалжийг ашиглаж хэрэглэгчдээ эрсдэлээс сэргийлдэг.

[32] https://app.namescan.io/

ДҮГНЭЛТ

УТНБЭ, тэдгээрийн гэр бүл, ойр дотно харилцаатай хүмүүс авлига хээл хахууль, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, бусад санхүүгийн гэмт хэрэгт холбогдох эрсдэл өндөр этгээдэд хамаардаг. Тийм ч учраас улс орнууд УТНБЭ, гэр бүлийн гишүүд, ойр дотно харилцаатай хүмүүс, бизнес хамтрагчид, тэдний оролцоотой, хувьцаа эзэмшдэг, нөлөө бүхий компаниудын аливаа санхүүгийн үйл ажиллагаанд мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нэмэлт, тусгай хяналт шалгалт хийж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлдэг.

УТНБЭ-ийн талаарх Монгол улс, гадаад улс буюу сайн туршлага бүхий АНУ болон Швейцар улсын зохицуулалт, олон улсын байгууллага буюу ФАТФ-ын зөвлөмж, УТНБЭ-г хэрхэн тодорхойлдог, ямар хугацаанд УТНБЭ-дэд хамаардаг тухай харьцуулан судалсан .

УТНБЭ-г таньж мэдэхийн тулд олон улсад УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн сан ажиллуулдаг. Төлбөртэй мэдээллийн сан, Засгийн газраас гаргах УТНБЭ-ийн жагсаалт, Байгууллагын дотоодын мэдээллийн сан зэрэг УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн сангийн төрлүүд байна. УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн сан нь технологийн тусламжтай УТНБЭ-ийг хурдан, хялбар илрүүлэх онцгой ач холбогдолтой тул төрийн байгууллагын эрхлэн үйл ажиллагааг нь явуулахаас гадна хувийн компаниуд ч энэ төрлийн үйл ажиллагааг эрхэлж байна. Хувийн компаниуд УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн санг эрхлэн явуулах нь түгээмэл ч төрийн байгууллага, олон улсын байгууллагууд санхүүжүүлж үйл ажиллагааг нь дэмждэг. Монгол улсад Монпэп дата ХХК нь УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн сангийн үйл ажиллагаа явуулж байна. Хувийн, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллага УТНБЭ-ийн нэгдсэн мэдээллийн санг явуулж буй тул энэхүү байгууллагын үйл ажиллагаанд төрийн байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлснээр Монгол улсад УТНБЭ-д тавих хяналт сайжирч, үр дүнд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг багасах чухал ач холбогдолтой юм.

НОМ ЗҮЙ

Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт

1. Эрүүгийн хууль (2015 он)
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013 он)
3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012 он)
4. Монгол банк, "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам", (2019), https://fiu.mongolbank.mn/file/files/documents/cma/20230125_A26.pdf)

Бусад улс орны хууль

1. Bank Secrecy act, 1970, https://www.fincen.gov/resources/statutes-and-regulations/bank-secrecy-act
2. Switzerland, Federal Act on Combating Money Laundering and Terrorist Financing, 1997 https://www.fedlex.admin.ch/eli/cc/1998/892_892_892/en
3. USA PATRIOT Act, Oct. 26, 2001 https://www.fincen.gov/resources/statutes-regulations/usa-patriot-act

Гарын авлага, илтгэл, олон улсын байгууллагын зөвлөмж

1. Улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох талаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан гарын авлага, https://fiu.mongolbank.mn/file/files/documents/cma/guide_20190628.pdf
2. Ө. Хулан, "Эрх бүхий байгууллагаас улс төрд нөлөө бүхий этгээдийн нэгдсэн жагсаалт гаргах шаардлага, ач холбогдол" илтгэл, УБ, 2018 он.
3. The Financial Action Task Force (FATF), "Politically Exposed Person (Recommendations 12 and 22)", 2013. Guidance-PEP-Rec12-22.pdf. coredownload.pdf (fatf-gafi.org)

Цахим эх сурвалж

1. Public Ranking - Basel AML Index (baselgovernance.org)
2. https://shuftipro.com/blog/politically-exposed-person-an-unsaid-threat-to-businesses/#Defining-Politically-Exposed-Persons
3. https://ofac.treasury.gov/
4. https://ofac.treasury.gov/specially-designated-nationals-list-data-formats-data-schemas
5. https://www.fincen.gov/
6. https://sanctionssearch.ofac.treas.gov/
7. https://opencorporates.com
8. https://www.opensanctions.org
9. https://app.namescan.io/
10. https://www.monpep.mn

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН САЛБАРААР ДАМЖУУЛАН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГА

Э.Амирлан, М.Мөнгөнзул***

**Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн олон улсын эрх зүй ангийн 5-р түвшний оюутан, И-мэйл: amirlanenkhbileg@gmail.com, Утас: 95713701*

***Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн олон улсын эрх зүй ангийн 5-р түвшний оюутан, И-мэйл: mungunzul0316@gmail.com, Утас:95621111*

ТОВЧ ХУРААНГУЙ

Виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд аливаа улсын дотоодын хууль тогтоомж, олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын конвенц, гэрээнд нэгдэн орох нь тухайн улсын олон улсын хамтын ажиллагаанд чухал нөлөөтэй ба Мөнгө угаах гэмт хэргийн эсрэг Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг конвенц, Палермогийн конвенц, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2462 тоот тогтоол зэрэг олон баримт бичиг гарсан байна. Эдгээрээс хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага болох ФАТФ ба улс орнууд тус байгууллагын зөвлөмжийг тогтмол дагаж мөрддөг. Монгол Улс 2023 онд ФАТФ-ын зөвлөмжийг бүрэн биелүүлсэн улсын тоонд нэгдсэн ба энэ нь мөнгө угаах гэмт хэргийн эсрэг манай улсын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хууль эрх зүйн орчин сайжирч буйн илрэл юм. Гэвч аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хууль, эрх зүйн орчныг тогтмол сайжруулах хэрэгтэй ба олон улсын стандарт, жишигтэй нийцүүлэх нь дотоодын эрх зүйн орчин төдийгүй олон улсын хамтын ажиллагаанд эерэг нөлөөтэй. Иймд тус судалгаагаар виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэргийн олон улсын жишиг, түүнтэй Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан хоёр улсын жишээг авч үзлээ.

УДИРТГАЛ

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээлснээр дэлхийн ДНБ-ий 2-5% буюу 800 тэрбумаас 2 их наяд ам.доллар бүхий мөнгө жил бүр угаагддаг байна.[1] Үүний яг хэчнээн нь виртуал хөрөнгө ашиглан үйлдэгдэж байгааг тооцоолоход хүндрэлтэй ч блокчэйнд дүн шинжилгээ хийдэг Chainalysis[2]

[1] United Nations Office on Drugs and Crime. (2024). *Overview of money-laundering & global efforts to combat it*. UNODC. https://www.unodc.org/unodc/en/money-laundering/overview.html Accessed April 30, 2024.

[2] Chainalysis. (2024). *Analysis tool*. https://www.chainalysis.com/

компанийн дурдагдсанаар 2017 онд 200 сая ам.доллар, 2018 онд 700 сая ам.доллар,[3] 2020 онд 1.3 тэрбум ам.доллар, 2022 онд 23.8 тэрбум ам.доллар бүхий криптовалют угаагдсан[4] гэж тооцоолжээ. Үүнээс үзэхэд жил ирэх тусам криптовалютаар угаагдах мөнгөний хэмжээ үлэмж хэмжээгээр нэмэгдэж байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь ахуйн хүрээнд үйлдэгддэг хохирол багатай гэмт хэрэг биш. Харин энэ нь албан тушаал, авлига, татвар төлөхөөс зайлсхийх, хүн худалдаалах, хууль бус зэвсэг, мансууруулах бодисын худалдаа, үндэстэн дамнасан гэмт хэргүүд, терроризм, байгалийн баялагтай холбоотой гэмт хэргээс олсон орлогын хууль бус байдлыг арилгаж, эдийн засгийн эргэлтэд оруулдаг асар хор хөнөөлтэй гэмт хэрэг юм.[5] Виртуал хөрөнгө эрчимтэй хөгжиж эхэлсэн 2008 оноос хойш виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах орчин нөхцөл аль хэдийн бүрдсэн байхад өдгөө олон улсад виртуал хөрөнгөтэй холбоотой харилцаа эрх зүйн зохицуулалтгүй хэвээр байна. 2023 онд Эгмонт группийн явуулсан судалгаанд оролцсон гишүүн улсуудын 45 хувь нь зохицуулалтгүй болохыг дурджээ.[6]

Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчин саяхнаас бүрдэж эхэлсэн бөгөөд 2021 онд "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай" хуулийг ФАТФ-ын зөвлөмжийн дагуу баталсан. Виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэрэг нь дан ганц улсын хүрээнд бус олон улсын түвшинд үйлдэгдэх боломжтой гэмт хэрэг бөгөөд Монгол Улс тус гэмт хэргийг зохицуулах, эрх зүйн орчноо сайжруулах, олон улсын байгууллагатай хамтран ажиллах нь тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чухал ач холбогдолтой юм. Иймд тус сэдвийн хүрээнд судалгаа хийх нь Монгол Улсын эрх зүйн орчинд эергээр нөлөөлөхийн хувьд энэхүү сэдвийг сонгосон болно. Ийнхүү тус судалгааны хүрээнд Виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэргийн эсрэг олон улсын чиг хандлага, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын түвшнийг авч үзэн асуудлыг томьёолж, дүгнэлт, санал дэвшүүлэх нь тус судалгааны ажлын зорилго юм.

---

[3] Kolachala, K., Simsek, E., Ababneh, M., & Vishwanathan, R. (2021). SoK: Money laundering in cryptocurrencies. In *Proceedings of the 16th International Conference on Availability, Reliability and Security (ARES 2021)* (pp. 1). August 17–20, 2021, Vienna, Austria: ACM. ("*Kolachala*") https://doi.org/10.1145/3465481.3465774 Accessed April 30, 2024.

[4] Al Jazeera. (2021, February 11). *Crypto's dirty side: 270 addresses laundered $1.3bn in 2020*. https://www.aljazeera.com/economy/2021/2/11/cryptos-dirty-side-270-addresses-laundered-1-3bn-in-2020 Accessed May 1, 2024.

[5] Gjoni, M., Gjoni, A. (Karameta), & Kora, H. (Bako). (2015). Money laundering effects. In *Proceedings of the UBT International Conference* (p. 15). https://knowledgecenter.ubt-uni.net/conference/2015/all-events/16 Accessed May 1, 2024.

[6] Egmont Group. (2023). *Abuse of virtual assets for terrorism financing summary* (p. 7). ("*Egmont*") https://egmontgroup.org/wp-content/uploads/2023/12/2023-July-HoFIU-06-IEWG-Project-Abuse-of-VA-for-TF-Summary-1.pdf Accessed May 1, 2024.

НЭГ. ВИРТУАЛ ХӨРӨНГӨӨР ДАМЖУУЛАН МӨНГӨ УГААХ ХАНДЛАГА

1.1. Криптовалютын онцлог

Мөнгө угаах гэмт хэрэгт ашиглагддаг виртуал хөрөнгийн хамгийн түгээмэл төрөл нь криптовалют.[7] Криптовалют нь блокчэйн шифрлэлтийн технологи ашиглан хамгаалагдсан дижитал хөрөнгө болох "койн" юм.[8] Криптовалют нь блокчэйн буюу гүйлгээг бүртгэх, виртуал хөрөнгийг шилжүүлэх, хадгалах үүрэгтэй төвлөрсөн бус, хуваарилагдсан компьютерын сүлжээнд суурилдаг.[9] Блокчэйн технологид мэдээллийг үүсгэх, устгах, эзэмшлийн өөрчлөлт гэх мэт гүйлгээний бүх өгөгдөл бүртгэгдэж байдаг.[10] Криптовалют бүр өөр технологийн дагуу бүтээгддэг тул тэдгээрийн блокчэйн мөн өөр хоорондоо ялгардаг.[11] Жишээ нь Биткойн болон Монеро, Zcash койнуудын блокчэйн ялгаатай. Биткойны блокчэйнээс 2009 оны 01 дүгээр сарын 03-нд бий болсон өдрөөс хойшхи хамгийн сүүлийн нэг данснаас нөгөө данс руу хийгдсэн бүх гүйлгээг харах боломжтой. Харин илүү өндөр нууцлалтай Монеро криптовалютын хувьд криптографик протоколууд нь харилцагчийн мэдээлэл төдийгүй гүйлгээний мэдээллийг хүртэл будлиантуулах боломжтой болохыг харуулдаг.[12] Харилцагч бөгжин гарын үсэг гэх хэрэглүүрийн тусламжтайгаар өөрийн мэдээллийг илүү нуудаг. Тус койны блокчэйн автоматаар санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон түлхүүрүүдтэй харилцагчийн түлхүүрийг хольдог.[13] Үүний үр дүнд гарын үсэг зурсан жинхэнэ этгээдийг олоход хүндрэл учирдаг. Мөн түүнчлэн гүйлгээг нууц хаягуудыг (stealth addresses) үүсгэж хийдэг. Үүний ачаар харилцагчаас хүлээн авагчид шилжүүлсэн бүх төлбөр завсрын энэ хаягаар дамжин, блокчэйнд харилцагч болон хүлээн авагч хооронд гүйлгээ хийгдсэн ямар нэг ул мөргүй болж харагддаг.[14] Иймээс нууцлалын криптовалют гүйлгээний ул мөр үлдээхгүй байх, харилцагч нууцлаг хэвээр үлдэх баталгааг өгдөг.

Угийн нууцлаг мөн чанар дээр нэмэгдээд криптовалютын гүйлгээний ул мөрийг баллах зорилготой "холигч (mixer, tumbler)" гэх аргыг ашиглаж, олон төрлийн

---

7 *Kolachala*, p. 2.

8 М.Болор-Эрдэнэ, *Блокчэйн болон криптовалютын хууль, эрх зүйн орчин*, Хууль дээдлэх ёс, 2022 №1, 87, 137-149, 138 дахь тал.

9 *Ibid*.

10 Velkes, G. C. (2020). International anti-money laundering regulation of virtual currencies and assets. *Journal of International Law and Politics*, 52(3), 875-897. https://egmontgroup.org/wp-content/uploads/2023/12/2023-July-HoFIU-06-IEWG-Project-Abuse-of-VA-for-TF-Summary-1.pdf Accessed May 1, 2024.

11 Marko, N. F. (2021). Anonymity technology in virtual assets: Scope, limitations, and emerging strategies. *PUBB 763, Fall 2021*, 15. ("*Marko*") https://traccc.gmu.edu/wp-content/uploads/2022/06/Marko_Anonymity-Technology-in-Virtual-Assets-Scope-Limitations-and-Emerging-Strategies.pdf Accessed May 1, 2024.

12 *Ibid*.

13 *Ibid*.

14 *Marko, p.16.*

гүйлгээг хольдог.[15] Энэхүү холигч нь миксэртэй ижил аргаар ажилладаг. Олон харилцагчдад хамаарах криптовалютыг хооронд нь хольж, гүйлгээний оролт, гаралтыг сольсны дараа буцаан хуваарилдаг.[16] Үүний үр дүнд холигч нь гүйлгээг араас нь мөшгих боломжийг бууруулдаг.[17] 2019 оны 5 сард Нидерландын эрх баригчид Европол болон Люксембургтэй хамтран "Bestmixer.io" гэх цахим хуудасны үйл ажиллагааг хаасан. Энэ нь жилд 200 сая ам.доллараас дээш орлоготой гурван том криптовалют холих үйл ажиллагаа үзүүлдэг цахим хуудасны нэг юм.[18]

Ийнхүү криптовалютын гүйлгээнд оролцогчид нуугдмал байх, төрийн байгууллагын оролцоогүйгээр аливаа хяналт шалгалтаас гадуур гүйлгээ хийх боломжтой учраас криптовалютыг ашиглан мөнгө угааж байна. Криптовалют ашиглан мөнгө угаах хоёр хэлбэр байдаг. Үүнд:

- Хууль бус эх үүсвэртэй цаасан мөнгийг койн болгох;
- Хууль бус эх үүсвэртэй койныг өөр койноор солих замаар угаах.

1.2. Гэмт хэргийг илрүүлэх онцлог

Криптовалютыг ашиглан мөнгө угааж буй гэмт хэргийг мөрдөх, илрүүлэх боломжгүй биш. Дэлхий даяар криптовалютаар мөнгө угаахтай тэмцэх ажиллагаа эрх бүхий төрийн байгууллагад бүртгэгдсэн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн (Цаашид "ВХҮҮ" гэх) үйл ажиллагаанд тулгуурлаж байна. Өөрөөр хэлбэл, ВХҮҮ-ийн оролцоогүйгээр явагддаг криптовалютын гүйлгээ, тухайлбал, хэрэглэгчид хоорондоо гүйлгээ хийх, олборлох, холигчийн үйлчилгээ зэргийг ашиглах гэх мэт тохиолдолд олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтаас ангид үлдэж байна. Эгмонт группийн 2023 оны судалгаагаар ихэнх улсуудын санхүүгийн мэдээллийн алба хууль бус захуудад төлбөрийн хэрэгслээр криптовалют хэрэглэдэг болохыг тогтоосон.[19]

ХОЁР. ВИРТУАЛ ХӨРӨНГӨ АШИГЛАН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХАНДЛАГА

2.1. Олон улсын байгууллагын эрх зүйн зохицуулалт

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх нь хил дамнан үйлдэгддэг гэмт хэрэг тул олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын хамтын ажиллагаа зайлшгүй чухал юм.[20] Энэ хүрээнд Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг конвенц, Палермогийн конвенц, Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2462 тоот тогтоол зэрэг олон баримт бичгийг гаргасан.

[15] *Covolo*, p. 243.
[16] Covolo, V. (2020). The EU response to criminal misuse of cryptocurrencies: The young, already outdated 5th Anti-Money Laundering Directive. *European Journal of Crime, Criminal Law and Criminal Justice, 28*(1), 217-251. ("*Covolo*") https://doi.org/10.1163/15718174-bja10003 Accessed May 1, 2024.
[17] *Covolo*, p. 243.
[18] *Covolo*, p. 243.
[19] *Egmont*, p. 9.
[20] *Egmont*, p. 9.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хамгийн идэвхтэй үйл ажиллагааг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (Цаашид "ФАТФ" гэх) явуулдаг. ФАТФ 1989 онд Парист Их 7-ийн уулзалтаар байгуулагдсан.[21] ФАТФ-ын стандартууд (Зөвлөмжүүд) анх 1990 онд гарч байсан бол 1996, 2003, 2012 болон хамгийн сүүлд 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон.[22] Эдгээр баримт бичиг нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамгийн суурь үндсэн баримт бичгүүд юм. Хэдийгээр эдгээр нь заавал дагаж мөрдөх олон улсын гэрээний хүчин чадалгүй боловч өдгөө улсууд түгээмэл байдлаар биелүүлж, дотоодын хууль тогтоомждоо тусгаж байна.

ФАТФ виртуал хөрөнгийн гүйлгээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Стандартуудыг хэрэглэх хүрээнд 2018 онд Зөвлөмж 15-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн талаарх гарын авлага 2019 онд гаргасан. 2020 онд Сэжигтэй гүйлгээ гэж сэжиглэх үндэслэлийн талаарх тайланг гаргасан. ФАТФ-ийн эдгээр баримт бичгээр виртуал хөрөнгөд тавигдах шаардлага, ВХҮҮ-ийн үйл ажиллагаа, сэжигтэй гүйлгээ мэдэгдэх тухай зохицуулсан. Эндээс өгч байгаа гол зөвлөмж нь ВХҮҮ-ийн үйл ажиллагааг бүртгэх эсхүл зөвшөөрөл олгох, энэ нь төрийн байгууллагын хяналтад байх, ВХҮҮ харилцагчаа таньж мэдэх (Цаашид "KYC"), шалгалт (Due Dilligince) хийх бодлогыг хэрэгжүүлэх, гүйлгээний бүртгэл хөтлөх, мэдээллийг тодорхой хугацаанд хадгалах болон сэжигтэй гүйлгээг зохих төрийн байгууллагад мэдэгдэх үйл ажиллагаа юм.

2.2. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улс 2023 онд ФАТФ-ын Зөвлөмжүүдийг бүрэн биелүүлсэн гэж дүгнэгдсэн ба энэ нь манай улсын хууль, эрх зүйн орчин сайжирч, мөнгө угаах гэмт хэргийн эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүнтэйг илэрхийлэх нэгэн хэмжүүр болж байна. Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд олон улсын гэрээнүүдэд нэгдэн орсон ба дотоодын эрх зүйн зохицуулалт нь мөн ФАТФ-ын зөвлөмжид заасантай нийцэж байна.

2.2.1. Олон улсын гэрээ

Монгол Улс 2003 онд "Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц"-д нэгдэн орж, 2004 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын салбар байгууллага болох Ази Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (APG)-д элсэн орсон.[23] Ийнхүү мөнгө угаах болон терроризмыг

[21] Covolo, V. (2022). The EU response to criminal misuse of cryptocurrencies: The young, already outdated 5th Anti-Money Laundering Directive. *Journal of Financial Crime, 29*(1), 73-89. https://doi.org/10.1108/JFC-01-2022-0013 Accessed May 1, 2024.

[22] *Ibid*, p. 2.

[23] Х.Батчулуун, "Монгол Улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал", "Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал" Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, 2018, 12 дахь тал.

санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартуудыг мөрдөн ажиллах үүрэг хүлээж, улмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ийм төрлийн хэрэгт ял шийтгэл оногдуулах холбогдох үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актуудыг дээр дурдсан олон улсын гэрээ, конвенц, стандартуудад нийцүүлэх ажил үе шаттайгаар хэрэгжиж эхэлжээ.[24]

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хэд хэдэн олон улсын гэрээ, баримт бичгүүд батлагдсан байдаг ба Монгол Улс дараах олон улсын гэрээнүүдэд нэгдэн орсон байна. Үүнд:

Хүснэгт 1. Монгол Улсын олон улсын гэрээ

Гэрээний нэр	Төрөл	Батлагдсан огноо	Нэгдэн орсон огноо
Авлигын эсрэг НҮБ-ын конвенц	Олон талт	2003-10-31	2005-10-27
Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протокол	Олон талт	2001-05-31	2008-05-16 с.б[25]
Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц	Олон талт	1961-03-25	1990-12-06 с.б
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц	Олон талт	1988-12-20	2001-01-25
Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц	Олон талт	1971-02-21	1999-04-22
Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц	Олон талт	2000-11-15	2008-05-16 с.б
Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол	Олон талт	2000-11-15	2008-05-16 с.б
Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол	Олон талт	2000-11-15	2008-05-16 с.б

Авлигын эсрэг НҮБ-ын 2003 оны конвенцын 23 дугаар зүйлд “Мөнгө угаах” гэмт хэргийг дараах байдлаар томьёолсон байдаг.

- Тухайн хөрөнгө нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүний эх үүсвэрийг нуун дарагдуулах буюу өөрчлөх эсвэл гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд хариуцлагаас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх; түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байршил, зарцуулалт, хөдөлгөөн буюу өмчлөл, эсхүл түүн дэх эрхийг нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргах,
- Тухайн эд хөрөнгийг хүлээн авч байх үед гэмт хэргээс олсон орлого гэдгийг нь мэдсээр байж түүнийг худалдан авах, эзэмших буюу ашиглах,

[24] Х.Эрдэм-Ундрах, Э.Мөнхболд, Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн тулгамдсан асуудал, Хууль дээдлэх ёс, 2020, №4, Дугаар 79, 141-157, 143 дахь тал. (“*Х.Эрдэм-Ундрах*”)

[25] С.Б - Соёрхон баталсан

- Энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэрэгт оролцох, холбогдох, түүнийг үйлдэхэд хуйвалдах, үйлдэхийг завдах, мөн иймгэмт хэрэг үйлдэхэд туслах, хатгах, дэмжих буюу зөвлөх гэж заажээ.[26]
- Дээрх "Гэмт хэргийн улмаас" гэдэг томьёолол нь авлига, албан тушаалын гэмт хэргийг тодорхойлж байгаа болохоос албан тушаалын шинжгүй ахуйн хүрээний гэмт хэргийг илэрхийлдэггүй гэдгийг ойлговол зохино гэсэн байна.[27]
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 6 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийн шинжийг дараах байдлаар тусгасан. Үүнд:
- Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх; эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах санаатай үйлдэл.[28]

"Эд хөрөнгө" гэдгийг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 2 дугаар зүйлд "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, биет эсвэл биет бус бүх төрлийн эд хөрөнгө хамаарах болон тэдгээр эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг нотлох хууль зүйн баримт бичиг, хэрэгсэл"[29] гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3-р зүйлийн 3.1 дэх хэсэгт "Мөнгө угаах" гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ гэж заасан байна.

Үүнээс үзэхэд Монгол Улс мөнгө угаах гэмт хэргийг олон улсын гэрээ, конвенцод тодорхойлсонтой ижил утгаар томьёолсон байна. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь зөвхөн нэг улсад үйлдэгдэх бус хил дамнаж үйлдэгдэх боломжтой гэмт хэрэг бөгөөд олон улсын байгууллагатай хамтран ажиллах, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орох нь тус гэмт хэрэгт хяналт тавих, арга хэмжээ авахад чухал ач холбогдолтой. Ийнхүү Монгол Улс нь мөнгө угаах

---

[26] Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 2003.

[27] *Х.Эрдэм-Ундрах,* 151 дэх тал.

[28] Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх гарын авлага, Санхүүгийн зохицуулах хороо, 2019. http://www.frc.mn/resource/frc/images/vote/Havtas_web_tawih.pdf Accessed May 1, 2024.

[29] *Ibid*.

болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой олон улсын гэрээ, конвенцод нэгдэж орсон ба энэ нь олон улсын байгууллагатай хамтарч ажиллах, ФАТФ-ын зөвлөмжийг даган хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг байна.

2.2.2. ФАТФ-ын зөвлөмж

ФАТФ-аас 2006 онд анх удаа Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд үнэлгээ хийсэн.[30] Тус үнэлгээний зөвлөмжид нийцүүлэн "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг 2013 онд баталсан боловч тус хуулийн зарим зүйл, заалт ФАТФ-ын зөвлөмжид нийцээгүй тул Монгол улсыг "өндөр эрсдэлтэй болон хамтран ажилладаггүй улс (хар саарал жагсаалт)" гэсэн ангилалд оруулсан байна. Ийнхүү 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох зохицуулалтыг ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлснээр манай улсыг дээрх дутагдлаа залруулсан гэж үнэлэн 2014 оны 6 дугаар сард "хар саарал жагсаалт"-аас гаргаж байжээ.[31]

Гэвч 2019 онд Монгол Улсын мөнгө угаах гэмт хэргийн илрүүлэлт, зүйлчлэл хангалтгүй гэх үндэслэлээр[32] дахин саарал жагсаалтад бүртгэгдэж 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр гарч Монгол Улс нийт 2 удаа ФАТФ-ын саарал жагсаалтад бүртгэгдэн, гарч байсан байна.

ФАТФ-ын 40 зөвлөмжийн "Зөвлөмж 15"-д шинэ технологитой холбоотой зохицуулалт хийхийг зөвлөсөн ба *"Улс орнууд виртуал хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг удирдах, бууруулах үүднээс виртуал хөрөнгөтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгч нарыг тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлд хамруулж ФАТФ-ын Зөвлөмжийн холбогдох заалтыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих арга хэмжээ авах шаардлагатай"*[33] гэж дурдсан байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ нь технологийн дэвшлийг ашиглаж, бага зардалтайгаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх давуу талтай ч сүүлийн үед койн, токенуудыг арилжаалах үйл явц нь богино хугацаанд, өндөр үнийн дүнтэйгээр явагдаж байгаагаас энэхүү үйл явцыг дагасан цахим гэмт хэрэгт иргэд, хөрөнгө оруулагчид өртөх, цаашлаад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдох өндөр эрсдэлтэй байсан[34] ба ФАТФ-ын 2019 оны шинэчлэгдсэн стандартад нийцүүлэн УИХ-аас "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль"-ийг батлан одоог хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсад одоогоор 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид бүртгэлтэй[35]

---

[30] ФАТФ, Монгол Улсад өгсөн зөвлөмж, үнэлгээний жилүүд, https://www.fatf-gafi.org/en/countries/detail/Mongolia.html Accessed May 1, 2024.

[31] *Ibid*.

[32] *Х.Эрдэм-Ундрах*, 146 дахь тал.

[33] Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, ФАТФ-ын зөвлөмж

[34] Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн танилцуулга https://www.parliament.mn/nn/16462/ Accessed May 1, 2024.

[35] Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид http://

байгаа ба Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх) хяналт тавьж ажилладаг. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь СЗХ-нд бүртгүүлж, тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах эрхтэй ба виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн харилцааг зохицуулсан 10 гаруй журам хүчин төгөлдөр үйлчилж байна.

Ийнхүү 2023 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс 14-ний өдрүүдэд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 25 дахь удаагийн уулзалтыг Канад Улсын Ванкувер хотноо зохион байгуулсан бөгөөд Монгол Улс ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийг бүрэн биелүүлсэн үнэлгээтэй Ази, Номхон далайн орнуудаас анхны орон (Зөвлөмж 15-ыг шинэчилсэн үнэлгээгээр), дэлхийн улсуудаас 5 дахь орон болсон байна.[36] Энэ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох ФАТФ-аас гаргасан 40 Зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай Монгол Улсын эрх зүйн орчныг бий болгон холбогдох шаардлагыг хууль тогтоомжид тусгаж, зохицуулалтыг боловсронгуй болгосныг олон улсаас баталгаажуулж буй явдал юм.[37]

2.2.3. Дотоодын эрх зүйн зохицуулалт

Монгол Улс нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг үйлдлийг дараах хууль, эрх зүйн баримт бичгээр зохицуулж байна. Үүнд:

- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль / шинэчилсэн найруулга/
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/ гэх хуулиудаар хяналт тавин зохицуулж байна.

www.frc.mn/#/sct;id=419/doc/list/424 Accessed May 1, 2024.

[36] Монгол банкны мэдээ https://fiu.mongolbank.mn/mn/r/700 Accessed May 1, 2024.

[37] *Ibid*.

Виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах. Улс орнуудад бүртгэгдсэн виртуал хөрөнгөтэй холбоотой гэмт хэргийн төрөлд мөнгө угаах, хориотой бодис болон бусад хориотой бараа (галт зэвсэг гэх мэт) худалдах, залилан мэхлэх, татвараас зайлсхийх, компьютерын гэмт хэрэг (жишээ нь, кибер халдлага үйлдэн хулгайлах), хүүхдийн мөлжлөг, хүний наймаа, хориг арга хэмжээнээс зайлсхийх, терроризмыг санхүүжүүлэх зэрэг багтсан байна.[38] Эдгээрээс хамгийн түгээмэл үйлдэгддэг нь хориотой бодисын хууль бус наймаа бөгөөд борлуулалтыг виртуал хөрөнгөөр хийж, виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах юм.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хяналт тавих, хяналт шалгалт хийхтэй холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан. Мөн түүнчлэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, зохистой засаглал, үйл ажиллагаа, тайлан мэдээнд тавигдах шаардлага, үйл ажиллагаанд зайны болон тухайн газар дээр нь хяналт шалгалт хийх, хязгаарлалт тогтоох, түр зогсоох зэрэг асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооны бүрэн эрхэд хамааруулахаар зохицуулсан[39] байна.

Сэжигтэй гүйлгээ. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д мэдээлэх үүрэгтэй этгээдийг заасан ба дараах этгээд сэжигтэй гүйлгээ болон сэжигтэй гүйлгээ хийх оролдлогыг СМА-нд мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

4.1.1. банк;

4.1.2. банк бус санхүүгийн байгууллага;

4.1.3. даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

4.1.4. хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;

4.1.5. үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

4.1.6. хадгаламж, зээлийн хоршоо;

4.1.7. үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

4.1.9. нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:

[38] Виртуал хөрөнгийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болох шинж тэмдгүүд, ФАТФ-ын тайлан https://fiu.mongolbank.mn/file/files/documents/cma/guide20220201.pdf Accessed May 1, 2024.

[39] Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн танилцуулга https://www.parliament.mn/nn/16462/ Accessed May 1, 2024.

4.1.9.а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;

4.1.9.б. харилцагчийн хөрөнгийг удирдах;

4.1.9.в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

4.1.9.г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;

4.1.9.д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах зэрэг этгээдүүд хамаарч байна.

Тус хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь сэжигтэй гүйлгээг СМА-нд мэдээлэх үүрэгтэй бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу дараах тохиолдолд сэжигтэй гүйлгээг СМА-нд мэдээлэх үүрэгтэй гэж заасан байна. Үүнд:

- *“Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол”.*

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7-р зүйлийн 7.1 болон 7.2-т зааснаас үзэхэд сэжигтэй гүйлгээг хуулиар нарийн тодорхойлоогүй ба мэдээлэх үүрэгтэй этгээд нь аливаа гүйлгээг сэжиглэсэн тохиолдолд сэжигтэй гүйлгээ хэмээн тооцож шууд мэдэгдэх үүрэгтэй байна. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан сэжигтэй гүйлгээг мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэг[40] ба сэжигтэй гүйлгээ хийх замаар гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах нь мөнгө угаах гэмт хэргийн хамгийн түгээмэл арга юм. Практик жишээ дурдвал, ихэнх тохиолдолд ББСБ-ын ажилтан нь харилцагч яг ямар гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаа хийж байгааг мэдэх боломжгүй байх ба гүйлгээнүүд болон тэдгээрийг хийж байгаа арга хэлбэрийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой танигдсан типологи, арга хэлбэр, сэжигтэй гүйлгээний түгээмэл шинж тэмдэгтэй тохирч байгаа эсэхийг ажиглаж шалгаснаар аль нэг төрлийн гэмт хэргийн шинжтэй байгааг таамаглаж, сэжиглэж болно.[41] Мэдээлэх үүрэгтэй этгээд сэжигтэй гүйлгээг таних, таамаглах гарын авлага, журамд заасны дагуу ойролцоо, түгээмэл шинжээр нь таних боломжтой ч сэжигтэй гүйлгээ нь зөвхөн эдгээр шинжээр хязгаарлагдахгүй өргөн агуулгатай байж болно. Сэжигтэй гүйлгээ нь виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх гол сэжүүр бөгөөд сэжигтэй гүйлгээг анзааралгүй, мэдэхгүй өнгөрөөх нь том үр дагаврыг бий болгох боломжтой.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан санкцийн хувьд

[40] Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4-р зүйл

[41] Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага, Монголбанк Санхүүгийн мэдээллийн алба, 2021 оны 3 дугаар сар, 11 дэх тал.

виртуал хөрөнгийн үйлчилгээг бүртгэлгүйгээр эрхэлсэн, үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэн компаниар дамжуулахгүйгээр нийтэд санал болгож худалдсан, хуульд заасан шаардлагыг хангаж ажиллаагүй, эсхүл үүргээ хэрэгжүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр (Зөрчлийн тухай хуулийн 11.33-р зүйл), түүнчлэн виртуал хөрөнгийн үйлчилгээний дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд арилжааг урвуулан ашигласан тохиолдлуудыг гэмт хэрэгт тооцож Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна (Эрүүгийн хуулийн 18.19-р зүйл болон 18.20-р зүйл).

2.3. Асуудал

ФАТФ-ийн Зөвлөмж 16-д ВХҮҮ-ийн үүргээ биелүүлж байгаа эсэхэд төрийн эрх бүхий байгууллага хяналт тавьж, үүргээ биелүүлэхгүй бол хариуцлага тооцох тухай, харин Зөвлөмж 20-д сэжигтэй гүйлгээг мэдэгдэх тухай тус тус тусгасан. ФАТФ-ын 2023 оны дагалдах тайланд Монгол Улс Зөвлөмж 16 болон 20-ийг “дийлэнх” хэсгийг биелүүлсэн гэж үнэлэгдсэн буюу “бүрэн биелүүлсэн” гэж дүгнээгүй байна.

Виртуал хөрөнгөөр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх гол ажиллагаа нь ВХҮҮ-ийн үйл ажиллагаанд тулгуурладаг. ВХҮҮ сэжигтэй гүйлгээг мэдэгдэх үүргээ биелүүлэхгүй бол мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа эсэхийг мэдэх боломжгүй байдалд хүрнэ. Монгол Улсад ВХҮҮ сэжигтэй гүйлгээг мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага хүлээх нь тодорхойгүй байна. Энэ тухай Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд зохицуулаагүй.

ФАТФ-аас Улс орнууд энэ талаар хууль тогтоомждоо тусгадаг. Тухайлбал:

Арабын Нэгдсэн Эмират улсад Сэжигтэй гүйлгээний тайланг хойшлуулалгүй мэдэгдэх үүргээ зориудаар эсхүл илтэд болгоомжгүйгээс биелүүлээгүй нь холбооны улсын гэмт хэрэг болно. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон хууль бус байгууллагатай тэмцэх тухай хуулийн 24 дүгээр зүйлд[42] мэдэгдэх үүргээ биелүүлээгүй этгээд дараах хариуцлага хүлээнэ гэж заасан. Хорих ял, 100,000 – 1,000,000 араб доллараас багагүйгээр торгуулах хамтад нь эсхүл аль нэгээр нь хуулийн 15 дугаар зүйлийг зөрчсөн этгээдийг шийтгэнэ.

Чех улсын Мөнгө угаахтай тэмцэх хуулийн 18 дугаар зүйлийн 1-д заасны дагуу ВХҮҮ нь сэжигтэй гүйлгээг мэдэгдэх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй нь хуулийн 46 дугаар зүйлийн 1-д заасан захиргааны шийтгэл болох CZK 30,000,000 хүртэл торгууль төлөх үндэслэл болно.[43]

Англи улсад сэжигтэй гүйлгээг мэдэгдээгүй нь Английн эрүүгийн хууль 330 дугаар зүйлд заасан зөрчил болдог. Англи Улс 2022 оны ФАТФ-ын тайланд Зөвлөмж 16

[42] UAE. Anti-Money Laundering and Combating the Financing of Terrorism and Illegal Organisations Laws Accessed May 1, 2024.

[43] Information for Obliged Entities, Information for VASPs (2024). *The Czech Republic*. https://fau.gov.cz/en/information-for-vasps Accessed May 1, 2024.

болон 20-ийн хэрэгжилт бүрэн хангалттай гэж дүгнэгдсэн.[44]

Монако улсын Мөнгө угаахтай тэмцэх тухай 3 хуулийн 71 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу дараах этгээдэд хариуцлага хүлээлгэнэ. Тус хуулийн 36, 39, 49 дүгээр зүйлүүдэд заасны дагуу сэжигтэй гүйлгээг зохих ёсоор мэдэгдээгүй бол хариуцлага хүлээнэ.[45] 2022 оны тайланд Монако улс ФАТФ-ийн Зөвлөмж 20 буюу Сэжигтэй гүйлгээ мэдэгдэх тухайд бүрэн хэрэгжилт хангасан[46] гэж үнэлэгджээ.

Монгол улсын санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тоо 2022 онд 2,626 байсан бол 2023 онд 1,799 болж буурчээ.[47] Харин АНУ-д санхүүгийн байгууллага 2022 оны байдлаар 3.6 сая сэжигтэй гүйлгээний тайланг ирүүлсэн байна.[48]

2021 оны 5-р сард АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (SEC) Сэжигтэй үйл ажиллагааны тайлан (SARs) гаргахыг зохицуулдаг холбооны үнэт цаасны хууль тогтоомжийг зөрчсөн хэмээн Колорадо мужид бүртгэлтэй брокер дилерийн үйл ажиллагаа эрхэлдэг Great-West Life & Annuity Insurance компанийн салбар компани GWFS Equities Inc. (GWFS)-д хариуцлага тооцсон. Энэ нь сэжигтэй үйл ажиллагааны тайлан (SAR) гаргахтай холбоотой зөрчил, тэр дундаа кибертэй холбоотой үйл явдалд ийнхүү хариуцлага тооцсон анхны тохиолдол болсон.[49]

ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Энэхүү хэсэгт Финланд болон БНСУ-ын виртуал хөрөнгийг ашиглан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг авч үзнэ.

3.1. Финланд улс

3.1.1. Эрх зүйн зохицуулалт

Финланд улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт нь олон улс болон ЕХ-ний зохицуулалт, үндэсний хууль тогтоомжоос тогтдог.

2023 оны судалгаагаар Финланд улс ФАТФ-ийн 40 зөвлөмжөөс 9-ийг биелүүлсэн,

---

[44] Financial Action Task Force. (2024). *United Kingdom*. https://www.fatf-gafi.org/en/countries/detail/united-kingdom.html Accessed May 1, 2024.

[45] Suspicious Transaction Report. (2023). *Monaco Financial Intelligence Unit*. https://amsf.mc/en/content/download/2623/file/AMSF_Guide%20DES_V7_VGB.pdf?inLanguage=fre-FR&version=1 Accessed May 1, 2024.

[46] Financial Action Task Force. (2022). *Mutual evaluation report: Monaco*. https://www.fatf-gafi.org/en/publications/Mutualevaluations/MER-Monaco-2022.html Accessed May 1, 2024.

[47] Монгол Улсын санхүүгийн мэдээллийн алба. (2023). *2023 оны 4-р улирлын статистик мэдээ*. https://fiu.mongolbank.mn/mn/r/1020 Accessed May 1, 2024.

[48] Special report: Suspicious activity reports surge; 2023 filings on pace for another record. (2023). *Thomsom Reuters*. https://www.thomsonreuters.com/en-us/posts/investigation-fraud-and-risk/special-report-suspicious-activity-reports/ Accessed May 1, 2024.

[49] The Securities and Exchange Commission. (2021). *SEC Charges Broker-Dealer for Failures Related to Filing Suspicious Activity Reports*. https://www.sec.gov/news/press-release/2021-82 Accessed May 1, 2024.

28-ийг нь нэлээд хэсгийг биелүүлсэн, 3-ийг нь хэсэгчлэн биелүүлсэн гэж дүгнэгдсэн (Хавсралт 1-ийг харна уу).

Мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхийг илрүүлэх, сэргийлэх хууль (Цаашид "Мөнгө угаахтай тэмцэх хууль")-иар мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхийг мөрдөн шалгах, илрүүлэхийг дэмжих, угаасан мөнгөний ул мөрийг дагаж мөрдөх ба сэргээхийг дэмжсэн заалтууд зэргээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн суурь харилцааг зохицуулдаг.[50]

Энэ хуулиар тодорхой салбарын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг хийх, харилцагчаа мэдэх бодлого хэрэгжүүлэх, шалгалт хийх зэрэг үүргийг хүлээлгэдэг. Мөн тус хуулийн дагуу ихэнх хуулийн этгээд эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх шаардлагатай. Сэжигтэй гүйлгээний мэдээллийг Үндэсний Тагнуулын Газрын (The National Bureau of Investigation) Санхүүгийн Мэдээллийн Нэгжид мэдэгдэх үүрэг хүлээдэг.[51]

Виртуал валютын үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиар бүртгүүлэх, маркетинг, харилцагчтай харилцах, хяналт тавих зэрэг асуудлыг зохицуулдаг.[52] Энэхүү хууль нь ЕХ-ны 5 дахь Мөнгө угаахын эсрэг удирдамжийн хэрэгжилтийг хангаж буй нэг хэсэг. Санхүүгийн хяналтын газарт бүртгүүлэх үүрэг хүлээдэг. Тус хуулиар ВХҮҮ-д Мөнгө угаахын эсрэг хуульд заасан үүргүүдийг мөн оногдуулдаг. Тус хуулийг ВХҮҮ дагаж мөрдөж байгаа эсэхэд санхүүгийн хяналтын газар хяналт тавьдаг. Хэрэв тус хуулийг биелүүлэхгүй бол үйл ажиллагаа эрхлэхийг зарим нөхцөлд торгууль оноох эрхтэй байдаг. Мөн Мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхийг сэргийлэхэд харилцагчийн шалгуурын арга хэмжээ болон эрсдэлийн хүчин зүйлс болон Улс төрийн нөлөө бүхий этгээд зэрэг холбогдох харилцааг зохицуулсан Засгийн газрын тогтоол үйлчилдэг.[53]

3.1.2. ВХҮҮ-ийн мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаа

Финланд улсад 11 ВХҮҮ үйл ажиллагаа явуулдаг буюу ВХҮҮ-ийн тоо харьцангуй цөөн байна. ВХҮҮ нь Финландын санхүүгийн хяналтын газрын (FIN-FSA) хүрээнд хамаарагддаг.[54] Тус санхүүгийн хяналтын газрын хяналтад байдаг байгууллагууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээнд зориулж, холбогдох баримт бичгийг ирүүлнэ. Баримт бичгийг нь жил бүрийн 12 сарын 31

[50] Prevention of money laundering and terrorist financing. (2024). https://rahanpesu.fi/en/legislation Accessed May 1, 2024.

[51] Финланд улсын Мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхийг илрүүлэх, сэргийлэх хууль. (2017) https://www.finlex.fi/fi/laki/ajantasa/2017/20170444 Accessed May 1, 2024.

[52] Финланд улсын Виртуал валютын үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль. (2019). https://www.finlex.fi/fi/laki/alkup/2019/20190572#Pidp447213872 Accessed May 1, 2024.

[53] Улс төрийн нөлөө бүхий этгээдэд холбогдох Финланд улсын Засгийн газрын тогтоол. (2019). https://www.finlex.fi/fi/laki/alkup/2019/20190610 Accessed May 1, 2024.

[54] Finnish Financial Supervisory Authority. *IMF Nordic-Baltic AML study 2013: Finland report*. https://www.finanssivalvonta.fi/globalassets/fi/tiedotteet-ja-julkaisut/verkkouutiset/2024/imf-nordic-baltic-aml-study-2013-finland-report-julkaistava.pdf Accessed May 1, 2024.

хүртэл цуглуулаад санхүүгийн хяналтын газарт эцсийн байдлаар 2 сарын 28-нд тайлагнадаг.

Финланд улсад бүртгэлтэй ВХҮҮ-ээс авсан судалгаагаар компани доторх мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо нь 4 хэсгээс тогтдог. Виртуал валютын үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн (572/2019) 14 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу харилцагч виртуал хөрөнгийн гүйлгээ хийхийн тулд KYC формыг бөглөх үүрэгтэй. Харилцагч бүрийн эрдлийн үнэлгээний түвшин нь харилцагчийн хувийн мэдээллийг баталгаажуулах болон бусад холбогдох мэдээллийг цуглуулснаар эхэлдэг. Энэ шатанд хуулийн 10-д заасны дагуу харилцагчийн мэдээллийг сүүлийн гүйлгээ хийгдсэнээс хойш 5 жилийн хугацаанд хадгалах үүрэг хүлээдэг.[55]

Нэгэнт харилцагч мэдээллийг дотоод сүлжээнд оруулсны дараа Технологийн хэлтсийн үйл ажиллагаа эхэлдэг. Энд харилцагчийн мэдээллийг гуравдагч талын оролцоотойгоор шалгадаг. Үүний дараа холбогдох тайланг Хяналтын хэлтэст шилжүүлдэг. Хяналтын хэлтэс мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг хийдэг. Энэ нь 3 үе шатаар дамжин хийгддэг.[56] Үүнд:

- 1-р шат. Эрсдэлийн хүчин зүйлийг тодорхойлох

Хүснэгт 2. Финланд улсын ВХҮҮ-ийн үйл ажиллагаа дахь мөнгө угаах эрсдэлийн хүчин зүйл

Харилцагч	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, суваг	Газар зүйн байрлал	Бусад эрсдэл
Дутуу болон үнэн биш KYC мэдээлэл	ВХ-ийн нууцлаг байдал	Өндөр эрсдэлтэй гуравдагч улсууд	Ер бусын гүйлгээний хэв маяг
Улс төрд нөлөө бүхий этгээд болон хориг	Бүрэн бүс блокчэйн шинжилгээ хийх	Мөнгө угаагчдын орогнуулдаг улс, бүс нутгууд	Мэдэгдэхгүй талууд гүйлгээнд орох
Бизнесийн чиглэл/ бизнесийн үйл ажиллагааны байдал	Хил дамнасан худалдаа	авлигал өндөртэй улс, бүс нутаг	Цаасан компани болон татварын диваажингаас болж түдгэлзсэн гүйлгээнүүд гэх мэт
Хөрөнгийн эх үүсвэрийг нуух	Хаягаар дамжин үйлчилгээ авах: биечлэн хийхгүй бизнесийн харилцаа	НҮБ-ын АЗ-өөс хориг тогтоосон улс, бүс нутаг	

Хяналтын хэлтэс тухайн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлдэг.[57]

- 0 - 20 : Бага эрсдэлийн түвшин
- 21 - 40: Бага-Дунд эрсдэлийн түвшин
- 41 - 60: Дунд эрсдэлийн түвшин

[55] Vo, T. T. (2020). *Applying the anti-money laundering regulations of virtual currency to build an effective internal control process: Case study: Finland*. Metropolia University of Applied Sciences. p. 36 ("*Case study: Finland"*) https://core.ac.uk/download/pdf/326044568.pdf Accessed May 1, 2024.

[56] *Case study: Finland*, p. 38.

[57] *Case study: Finland*, p. 38.

- 61 - 80: Дунд-Өндөр эрсдэлийн түвшин
- 81 - 100: Өндөр эрсдэлийн түвшин

- 2-р үе шат. Эрсдэлийн арга хэмжээг үнэлэх

Хяналтын хэлтэс эрсдэлийн үнэлгээг авч үзсэний дараа эрсдэлийг бууруулах хүрээнд авч хэрэгжүүлж буй KYC, харилцагчийн стандарт шалгалт болон дээд зэрэглэлийн шалгалт хийх процесс; Өгөгдлийг хадгалах ба бүртгэл хөтлөх; Ажилтан сургах; Мөнгө угаахтай тэмцэх бодлого ба компанийн засаглал; Сэжигтэй гүйлгээг мэдэгдэх гэх мэт дотоодын арга хэмжээний үр дүнтэй байдалд дүн шинжилгээ хийдэг. Эдгээр арга хэмжээ нь эрсдэл бууруулахад үр дүнтэй эсэхийг тогтооно.

- 3-р үе шат. Харилцагчид үлдэх эрсдэлийн үнэлгээг тооцоолох

Дээрх арга хэмжээг авснаар эрсдэл тодорхой хүрээнд буурах боломжтой. Ийнхүү үлдсэн эрсдэл 0-60 гэж үнэлэгдвэл стандарт шалгалт, 60-аас бол дээд зэрэглэлийн шалгалт хийдэг. Дээд зэрэглэлийн шалгалт хийх тохиолдолд харилцагчаас нэмэлтээр материал авдаг. Финландын харилцагчид шалгалт хийх журмын дагуу дээд зэрэглэлийн шалгалтыг дараах тохиолдолд хийгдэг:

- Европын комиссын тодорхойлсон өндөр эрсдэлтэй гуравдагч оронтой холбоотой байх;
- Улс төрийн нөлөө бүхий этгээд оролцсон байх;
- Царайг баталгаажуулах арга хэрэгсэл ашиглаагүй байх;
- Эрсдэлийн түвшин дундаас өндөр байх;
- Блокчэйн шинжилгээгээр хэвийн бус гүйлгээг илэрсэн болон харилцагчийн хаяг мөнгө угаах үйл ажиллагаатай холбогдсон.

Ийнхүү шалтгалтаар харилцагчийн гүйлгээ сэжигтэй болох нь тогтоогдвол Санхүүгийн мэдээллийн нэгжид зохих журмын дагуу мэдэгдэнэ.

3.2. БНСУ

3.2.1. Эрх зүйн зохицуулалт

Бүгд Найрамдах Солонгос улс (Цаашид “Солонгос” гэх) нь 2009 онд хойш ФАТФ-ын гишүүн орон болсон. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Солонгос улсын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр ашиг, мөн ФАТФ-ын зөвлөмжид нийцэж байгаа эсэхэд ФАТФ болон ФАТФ-ын холбогдох гишүүн болох APG 2020 онд хамтран үнэлгээ хийсэн. Уг тайланд дурдсанаар, Солонгос улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, холбогдох мөнгийг хураан авах хууль эрх зүйн хүчирхэг тогтолцоо бий гэж үзсэн. Уг үнэлгээний дагуу Өмнөд Солонгосыг ФАТФ-ын 40 зөвлөмжийн 12-ыг биелүүлж, 20-д нь ихээхэн нийцсэн гэж үзсэн байна.[58]

[58] Солонгос улсын мөнгө угаах гэмт хэргийн эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ https://sanctionscan-

Виртуал хөрөнгийн салбарт Солонгосын мөнгө угаахтай тэмцэх дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- **Зохицуулалтын хүрээ:** Солонгос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хууль эрх зүйн болон зохицуулалтын иж бүрэн тогтолцоог бий болгож, мөнгө угаахтай тэмцэх, хяналт тавих тогтолцоотой нэгтгэсэн. Энэхүү тогтолцоо нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг санхүүгийн байгууллагуудад ногдуулдагтай адил хатуу тайлагнаж, харилцагчийн хяналт шалгалтын шаардлагыг дагаж мөрдөхийг үүрэг болгодог.[59]
- **Санхүүгийн гүйлгээний тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хууль:** 2021 онд шинэчлэгдсэн энэхүү хууль нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч сэжигтэй гэж үзсэн гүйлгээг мэдээлэх, бүх гүйлгээний нарийвчилсан бүртгэлийг дор хаяж таван жилийн турш хадгалахыг шаарддаг ба уг үүргээ биелүүлээгүй тохиолдолд 30 сая воны торгууль төлөхөөр зохицуулсан байна.[60] Уг хууль нь мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч үйлчлүүлэгчдийг сайтар шалгаж нягтлахыг шаарддаг байна.
- **Виртуал хөрөнгийн тухай хууль:** Солонгос улс нь “Виртуал хөрөнгийн хэрэглэгчдийг хамгаалах тухай хууль” (Виртуал хөрөнгийн тухай хууль)-ийг 2023 оны 6-р сарын 30-ны өдөр баталсан ба тус хууль нь виртуал хөрөнгийн хэрэглэгчдийн хамгаалалтыг хөнгөвчлөх, бэхжүүлэх, виртуал хөрөнгийн зах зээл дэх шударга бус худалдааны үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалт тогтоох зорилготой бөгөөд 2024 оны 7-р сарын 19-нд хүчин төгөлдөр болно.[61]
- **Хяналт ба хэрэгжилт:** БНСУ-ын Санхүүгийн Мэдээллийн алба (KoFIU) нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаахтай тэмцэх дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянахад чухал үүрэг гүйцэтгэдэг. KoFIU нь хяналт шалгалт, аудит хийх эрхтэй бөгөөд мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээний үр дүнтэй байдлыг хангахын тулд бусад үндэсний болон олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.
- **Хориг арга хэмжээ, торгууль:** Эдгээр хууль, журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд торгууль ногдуулах, хорих, шийтгэл ногдуулах зэрэг санкцийг шууд хуульдаа тусгаж өгсөн ба энэхүү хатуу хэрэгжилт нь виртуал хөрөнгөөр дамжуулан мөнгө угаах боломжит үйл ажиллагааг таслан зогсооход тусалдаг байна.

ner.com/Aml-Guide/anti-money-laundering-aml-in-south-korea-302 Accessed May 1, 2024.

[59] Солонгос улс виртуал хөрөнгө хэрэглэгчдийг хамгаалах тухай хууль батлах тухай https://chambers.com/articles/korea-passage-of-the-act-on-the-protection-of-the-virtual-asset-users-2

[60] Солонгос улсын Санхүүгийн гүйлгээний тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хууль, 20-р зүйл https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query= Accessed May 1, 2024.

[61] Солонгос улсын Виртуал хөрөнгийн тухай хууль https://chambers.com/articles/korea-passage-of-the-act-on-the-protection-of-the-virtual-asset-users-2 Accessed May 1, 2024.

Солонгос улс нь 2001 онд «Санхүүгийн үйл ажиллагааны тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай» болон «Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулахыг зохицуулах, ял шийтгэл оногдуулах тухай» хуулиудыг батлан, мөрдөж эхэлснээр мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог бодитоор хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Санхүүгийн үйл ажиллагааны тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хуулийн дагуу мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэн, мэдээлэх үүрэг бүхий санхүүгийн байгууллагаас ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлан зэрэг санхүүгийн мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийн хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий санхүүгийн мэдээллийн алба /Financial Intelligence Unit, FIU/-г байгуулсан.[62] Тус байгууллага нь 2001 оны 11 сард бие даасан байгууллагаар байгуулагдан ажиллаж байгаад 2008 оноос мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тухайн улсын мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх тогтолцооны гол цөм нь гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг нуун дарагдуулахыг зохицуулах, ял шийтгэл оногдуулах тухай хуулийн дагуу мөнгө угаах гэмт хэрэг, Санхүүгийн үйл ажиллагааны тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хуулийн дагуу сэжигтэй гүйлгээг мэдээлэх, өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх, харилцагчийн баталгаажуулалтын систем юм.[63]

3.2.2. Мөнгө угаах гэмт хэргийг тодорхойлох

Солонгос улс мөнгө угаах гэмт хэргийг гэмт хэргийн төрлөөр жагсаалт гаргах замаар тодорхойлдог бөгөөд 2001 онд мөнгө угаах 38 төрлийн гэмт хэргийг тодорхойлж байснаас хойш энэ хүрээг улам өргөжүүлэн өнөөдрийн байдлаар 54 хуультай холбоотой нийт 116 төрлийн гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцож байна. Мөнгө угаах гэмт хэргийг Мансууруулах бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх онцгой хэргийн тухай хууль болон Гэмт хэргийн орлогыг нуун дарагдуулахыг зохицуулах, ял шийтгэл оногдуулах тухай хуулиудаар тус тус зохицуулсан бөгөөд мөнгө угаах гэмт хэрэгт,

- Мансууруулах бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх онцгой хэргийн тухай хуульд 7 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 30 сая хүртэл хэмжээний воноор торгох,
- Гэмт хэргийн орлогыг нуун дарагдуулахыг зохицуулах, ял шийтгэл оногдуулах тухай хуульд 5 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 30 сая хүртэл хэмжээний воноор торгох ял шийтгэл оногдуулахаар ялгамжтай хуульчилсан байна.[64]

Сэжигтэй гүйлгээг мэдээлэх систем: Санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг

[62] Б.Айбек, “Мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй тэмцэх арга барил, дэлхийн чиг хандлага”, Шүүх эрх мэдэл, 2021 он, № 4, 130 дахь тал. (“*Б.Айбек*”)

[63] *Б.Айбек*, 130 дахь тал.

[64] *Ibid*.

байгууллага /казино хамаарна/-ууд хууль бус хөрөнгө буюу харилцагч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулж байна гэж сэжиглэх үндэслэлтэй тохиолдолд санхүүгийн мэдээллийн албанд заавал сэжигтэй гүйлгээг мэдээлэх үүрэгтэй бөгөөд энэхүү мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд, холбогдох ажилтан болон хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэнэ. Тодруулбал,

- Хуулийн этгээд харилцагчтай хуйвалдан сэжигтэй гүйлгээг мэдээлээгүй эсвэл худал мэдээлсэн бол 6 сарын хугацаагаар үйл ажиллагааг нь зогсоох,
- Сэжигтэй гүйлгээний тайланг худал мэдээлсэн бол 1 жил хүртэл хугацаагаар хорих эсвэл 10 сая воны торгууль,
- Сэжигтэй гүйлгээг мэдээлээгүй бол 30 сая хүртэл хэмжээний воны торгууль ногдуулахаар хуульчилсан байна.[65]

Өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх систем: Бүгд Найрамдах Солонгос Улс өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх үүргийг 2006 оноос анх хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд мэдээлэх үндсэн хэмжээг 2006 онд 50 сая вон, 2008 онд 30 сая вон, 2010 онд 20 сая вон, 2019 оноос 10 сая вон болгон өөрчлөөд байна. Нэг удаагийн гүйлгээгээр 10 сая воноос дээш бэлэн мөнгөний орлого, зарлага хийсэн тохиолдолд харилцагчийн хэн болох, гүйлгээний огноо, гүйлгээний мөнгөн дүн зэрэг мэдээллийг компьютерын системээр дамжуулан автоматаар мэдээлэхээр зохицуулсан байна. Өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх системийг мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аргын нэг болгон нэвтрүүлсэн нь дараах 2 шалтгаантай гэж үзсэн байна:

- Хууль бус мөнгийг хувиргахыг эрмэлздэг ихэнх мөнгө угаах үйл ажиллагаа нь өндөр үнийн дүнтэй бэлэн мөнгөний үйл ажиллагаатай холбоотой байдаг,
- Зөвхөн санхүүгийн байгууллагын ажилтны субъектив дүгнэлтэд үндэслэсэн сэжигтэй гүйлгээний тайлангаар /сэжигтэй гүйлгээг мэдээлээгүй бол/ хууль бус хөрөнгө, мөнгийг илрүүлэхэд хязгаартай тул үүнийг нөхөх зорилготой.[66]

3.2.3. ВХҮҮ-ын мэдээлэх үүрэг

2020 оны 3-р сарын 5-ны өдөр Үндэсний ассемблей Санхүүгийн гүйлгээний тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хуульд хэсэгчлэн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (“Хэсэгчилсэн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”) тогтоолыг баталсан. Хэсэгчилсэн нэмэлт өөрчлөлтийн гол өөрчлөлт нь криптовалют бирж болон бусад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах мөнгө угаахтай тэмцэх шаардлагууд юм.

Солонгос улсад ВХҮҮ-ийг (i) виртуал хөрөнгийг худалдах, худалдан авах, (ii) виртуал хөрөнгийг өөр виртуал хөрөнгөтэй солилцох, (iii) (i) ба (ii) виртуал хөрөнгийг зуучлах, зохицуулалт хийх (iv) виртуал хөрөнгийг хадгалах эсвэл

[65] *Ibid*, 131 дахь тал.
[66] *Б.Айбек*, 131 дэх тал.

удирдах чиглэлээр мэргэшсэн бизнес эрхлэгчид гэж тодорхойлдог.[67]

Хэсэгчилсэн нэмэлт өөрчлөлтийн дагуу BXYY-ууд тайлангаа («BXYY тайлан») БНСУ-ын Санхүүгийн мэдээллийн алба («CMA»)-д урьдчилан гаргаж өгөх ёстой бөгөөд CMA-д тус тайлан нь хүлээн зөвшөөрөгдөх ёстой. Тус BXYY-ийн тайлан дараах мэдээллийг агуулсан байх ёстой. Үүнд:

- компанийн нэр,
- төлөөлөгчийн нэр,
- бизнесийн хаяг, байршил,
- холбоо барих мэдээлэл. BXYY тайлан гаргаж өгөөгүй буюу тайланг мэдээлээгүй тохиолдолд таван жил хүртэл хорих ял эсвэл 50 сая вон (ойролцоогоор 43,000 ам. доллар) хүртэл торгууль ногдуулахаар байна.[68]

Харилцагчийн зохих шалгалт буюу due diligence (CDD): Бусад санхүүгийн байгууллагуудын нэгэн адил BXYY-ууд нь сэжигтэй гүйлгээний тайлан ("STR"), валютын гүйлгээний тайлан ("CTR"), харилцагчийн зохих шалгалт ("CDD") зэрэг мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээ, шаардлагад хамрагдах ёстой. Санхүүгийн байгууллагуудын CDD шаардлагуудаас гадна BXYY нь CMA-д тайлангаа хүлээн зөвшөөрүүлэхийн тулд, харилцагчдын хадгаламж болон хөрөнгийг удирдах, тодорхой шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулах ёстой. Тухайлбал, санхүүгийн компани нь BXYY-ийн хүчин төгөлдөр тайлангүй, Мэдээллийн Аюулгүй байдлын Удирдлагын Системийн ("ISMS") гэрчилгээгүй, бодит нэрээр мөнгө байршуулж, мөнгө авах дансгүй эсвэл шаардлага хангаагүй бол BXYY-тэй хийх гүйлгээг цуцлах эсвэл хүчингүй болгох ёстой.

Иймхүү дээрх шаардлага нь CMA нь BXYY-ийн тайланг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл болох ба энэхүү үндэслэл байгаа тохиолдолд хүлээн авахаас татгалзаж болно. Үүнд (i) ISMS гэрчилгээ аваагүй; (ii) бодит нэрээр баталгаажсан хадгаламж, мөнгө авах данс ашиглан санхүүгийн гүйлгээ хийгээгүй; (iii) Санхүүгийн гүйлгээний тухай мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хууль, Терроризм, үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэх тухай болон Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон санхүүгийн бусад хууль тогтоомж (төлөөлөгчид, удирдах албан тушаалтнуудыг оролцуулан), Санхүүжилтийг хориглох тухай хуулийг зөрчсөний улмаас сүүлийн таван жилийн хугацаанд торгууль ногдуулахаас илүү хүнд эрүүгийн шийтгэл оногдуулсан, эсхүл ийм ялыг эдэлж дууссан тухай бүртгэл байгаа тохиолдолд; (iv) мөн дээр дурдсан (i), (ii), (iii)-д заасан шаардлагыг хангаагүйгээс татгалзсан сүүлийн таван жилийн дотор тайлангийн бүртгэл нь байгаа тохиолдолд CMA тайланг хүлээн авахгүй гэж заасан байна.[69] Түүнчлэн, CMA нь BXYY-ийн тайланг

[67] Криптовалютын бирж болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах мөнгө угаахтай тэмцэх шаардлага https://www.kimchang.com/en/insights/ Accessed May 1, 2024.

[68] Солонгос улсын Санхүүгийн үйлчилгээний тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хууль, 17-р зүйл https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do? Accessed May 1, 2024.

[69] Криптовалютын бирж болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах мөнгө угаахтай тэмцэх шаардлага https://www.kimchang.com/en/insights/detail.kc?s Accessed May 1, 2024.

аль хэдийн хүлээн зөвшөөрсний дараа хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл үүсвэл түүнийг цуцалж болохоор байна.

ДҮГНЭЛТ

Виртуал хөрөнгөөр арилжаа хийх явц өдгөө олон улсад түгээмэл, хурдацтай өсөж байгаа ба үүнийг даган виртуал хөрөнгө ашиглан гэмт хэрэг үйлдэх нь ихсэж байна. Виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэрэг нь зөвхөн нэг улсыг хамардаггүй ба хил дамнаж үйлдэгддэг тул улс бүр дотоодын хууль, эрх зүйн орчинг сайжруулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь тус гэмт хэргийн тоо багасах, урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй. Энэхүү судалгаагаар виртуал хөрөнгө ашиглан хэрхэн мөнгө угаах гэмт хэргийг үйлддэг, олон улсын чиг хандлага, Монгол Улсын эрх зүйн орчин, ФАТФ-ын зөвлөмжийн гүйцэтгэл, виртуал хөрөнгө ашиглан гэмт хэрэг үйлдэхийн эсрэг арга хэмжээг сайн хэрэгжүүлж буй хоёр улсын жишээг сонгон харьцуулан судаллаа. ФАТФ-ын зөвлөмжийг улс орнууд тогтмол дагаж мөрдөн, дотоодын хууль тогтоомжтой нийцүүлдэг ба Монгол Улс бүх зөвлөмжийг дагаж биелүүлсэн улсын тоонд нэгдсэн нь манай улсын хувьд чухал үзүүлэлт болсон байна. Гэвч виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэргийг түргэн, шуурхай илрүүлэх нь өнөөгийн практикт дутагдалтай хэвээр байгаа бөгөөд харьцуулан судалсан хоёр улсын жишээтэй харьцуулан авч үзэхэд хяналт, шалгалтын эрх зүйн орчин дутагдалтай байгаа нь харагдаж байна.

Улс орнууд өөрсдийн эрх зүйн орчин, эдийн засгийн нөхцөлөөс шалтгаалан тус гэмт хэрэгтэй тэмцэх хууль, дүрэм журмыг гаргадаг ба олон улсын жишиг, стандарттай нийцүүлэн баталж байна. Гэмт хэрэгтнүүд виртуал хөрөнгийн хурдацтай хөгжлийг ашиглан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх нэг арга хэрэгсэл болгож байна. Иймд виртуал хөрөнгөөр дамжуулан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орнуудын нэгдсэн эрх зүйн зохицуулалт чухал үүрэгтэй ба Монгол Улс тогтмол хууль, эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн, сайжруулах нь чухал ач холбогдолтой байна.

САНАЛ

Дээр дурдсан судалгааны дүгнэлт дээр үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна:

1. ВХҮҮ сэжигтэй гүйлгээг мэдээлэх ажиллагаанд төрийн байгууллагын хяналтын системийг сайжруулж, хуульд тусгах эсхүл шинээр эрх зүйн хэм хэмжээ батлах.
2. ВХҮҮ сэжигтэй гүйлгээг мэдэгдэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах санкцийг хуульд тусгах.

НОМ ЗҮЙ

Олон улсын гэрээ, конвенц

1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 2003.
2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, 2000.

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол Улс

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, 2021.
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013.
3. Эрүүгийн хууль, 2015.
4. Зөрчлийн тухай хууль, 2017.
5. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалын хавсралт, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, 2019.
6. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А-171 дүгээр тушаалын хавсралт, Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам, 2022.

Гадаад улс

1. БНСУ-ын Виртуал хөрөнгө хэрэглэгчдийг хамгаалах тухай хууль, 2021.
2. БНСУ-ын Санхүүгийн гүйлгээний тодорхой мэдээллийг тайлагнах, ашиглах тухай хууль, 2023.
3. Финланд улсын Мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэхийг илрүүлэх, сэргийлэх хууль, 2017.
4. Финланд улсын Виртуал валютын үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, 2019.
5. Улс төрийн нөлөө бүхий этгээдэд холбогдох Финланд улсын Засгийн газрын тогтоол, 2019.
6. УИНВУ-ын Эрүүгийн хууль, 2002.
7. БНАНЭУ-ын Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, 2018.
8. БНЧУ-ын мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, 2008.
9. Монако улсын Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, 2009.

Судалгааны бүтээл

Монгол хэлээр

1. Б.Айбек, Мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй тэмцэх арга барил, дэлхийн чиг хандлага, Шүүх эрх мэдэл, 2021 он, № 4.

2. М.Болор-Эрдэнэ, Блокчэйн болон криптовалютын хууль, эрх зүйн орчин, Хууль дээдлэх ёс, 2022 №1, 87, 137-149.
3. Х.Батчулуун, Монгол Улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал, "Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал" Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, 2018.
4. Х.Эрдэм-Ундрах, Э.Мөнхболд, Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн тулгамдсан асуудал, Хууль дээдлэх ёс, 2020, №4, Дугаар 79, 141-157.
5. Санхүүгийн зохицуулах хороо, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх гарын авлага, 2019.
6. Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага, 2021.

Гадаад хэлээр

1. Kolachala, K., Simsek, E., Ababneh, M., & Vishwanathan, R. (2021). SoK: Money laundering in cryptocurrencies. In *Proceedings of the 16th International Conference on Availability, Reliability and Security (ARES 2021)* August 17–20, 2021, Vienna, Austria: ACM. https://doi.org/10.1145/3465481.3465774
2. Gjoni, M., Gjoni, A. (Karameta), & Kora, H. (Bako). (2015). Money laundering effects. In *Proceedings of the UBT International Conference* https://knowledgecenter.ubt-uni.net/conference/2015/all-events/16 Accessed May 1, 2024.
3. Egmont Group. (2023). *Abuse of virtual assets for terrorism financing summary* https://egmontgroup.org/wp-content/uploads/2023/12/2023-July-HoFIU-06-IEWG-Project-Abuse-of-VA-for-TF-Summary-1.pdf Accessed May 1, 2024.
4. Velkes, G. C. (2020). International anti-money laundering regulation of virtual currencies and assets. *Journal of International Law and Politics*, 52(3), 875-897. https://egmontgroup.org/wp-content/uploads/2023/12/2023-July-HoFIU-06-IEWG-Project-Abuse-of-VA-for-TF-Summary-1.pdf Accessed May 1, 2024.
5. Marko, N. F. (2021). Anonymity technology in virtual assets: Scope, limitations, and emerging strategies. *PUBB 763, Fall 2021*, 15. https://traccc.gmu.edu/wp-content/uploads/2022/06/Marko_Anonymity-Technology-in-Virtual-Assets-Scope-Limitations-and-Emerging-Strategies.pdf Accessed May 1, 2024.
6. Finnish Financial Supervisory Authority. *IMF Nordic-Baltic AML study 2013: Finland report*. https://www.finanssivalvonta.fi/globalassets/fi/tiedotteet-ja-julkaisut/verkkouutiset/2024/imf-nordic-baltic-aml-study-2013-finland-report-julkaistava.pdf
7. Vo, T. T. (2020). *Applying the anti-money laundering regulations of virtual*

currency to build an effective internal control process: Case study: Finland. Metropolia University of Applied Sciences. https://core.ac.uk/download/pdf/326044568.pdf

Бусад

1. Information for Obliged Entities, Information for VASPs (2024). *The Czech Republic*. https://fau.gov.cz/en/information-for-vasps Accessed May 1, 2024.
2. Financial Action Task Force. (2024). *United Kingdom*. https://www.fatf-gafi.org/en/countries/detail/united-kingdom.html Accessed May 1, 2024.
3. Financial Action Task Force. (2022). *Mutual evaluation report: Monaco*. https://www.fatf-gafi.org/en/publications/Mutualevaluations/MER-Monaco-2022.html Accessed May 1, 2024.
4. Financial Action Task Force. (2023). *Mongolia*. https://www.fatf-gafi.org/en/publications/Mutualevaluations/Fur-mongolia-2022.html Accessed May 1, 2024.
5. Financial Action Task Force. (2023). *Finland*. https://www.fatf-gafi.org/en/countries/detail/Finland.html#:~:text=FATF%20concluded%20that%20Finland%20has,financial%20and%20non%2Dfinancial%20institutions. Accessed May 1, 2024.
6. Монгол Улсын санхүүгийн мэдээллийн алба. (2023). *2023 оны 4-р улирлын статистик мэдээ*. https://fiu.mongolbank.mn/mn/r/1020 Accessed May 1, 2024.
7. Special report: Suspicious activity reports surge; 2023 filings on pace for another record. (2023). *Thomsom Reuters*. https://www.thomsonreuters.com/en-us/posts/investigation-fraud-and-risk/special-report-suspicious-activity-reports/ Accessed May 1, 2024.
8. The Securities and Exchange Commission. (2021). *SEC Charges Broker-Dealer for Failures Related to Filing Suspicious Activity Reports*. https://www.sec.gov/news/press-release/2021-82 Accessed May 1, 2024.
9. United Nations Office on Drugs and Crime. (2024). *Overview of money-laundering & global efforts to combat it*. UNODC. https://www.unodc.org/unodc/en/money-laundering/overview.html Accessed April 30, 2024.
10. Chainalysis. (2024). *Analysis tool*. https://www.chainalysis.com/
11. Al Jazeera. (2021, February 11). *Crypto's dirty side: 270 addresses laundered $1.3bn in 2020*. https://www.aljazeera.com/economy/2021/2/11/cryptos-dirty-side-270-addresses-laundered-1-3bn-in-2020 Accessed May 1, 2024.

ХАВСРАЛТ

Хавсралт 1[70]

Хүснэгт 2. ФАТФ-ийн зөвлөмжүүдийн техникийн шаардлагуудыг хэрэгжүүлсэн тухай 2023 оны Монгол болон Финланд улсын дагалдах тайлан

	ФАТФ-ийн Зөвлөмж	Монгол	Финланд
R.1	Эрсдэлийг үнэлэх ба эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэглэх	ИН	ИН
R.2	Улсын хамтын ажиллагаа ба уялдаа холбоо	ИН	ИН
R.3	Мөнгө угаах гэмт хэрэг	ИН	ИН
R.4	Хураан авалт ба түр арга хэмжээ	ИН	ИН
R.5	Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг	ИН	ИН
R.6	Терроризм, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зорилтот санхүүгийн хориг	ИН	ИН
R.7	Тархалтын эсрэг зорилтот санхүүгийн хориг	ИН	ИН
R.8	Ашгийн бус байгууллагууд	Н	ХН
R.9	Санхүүгийн байгууллагын нууцлалын хууль	ИН	Н
R.10	Харилцагчийн хяналт /Due Diligence/	ИН	ИН
R.11	Бүртгэл хадгалах	Н	Н
R.12	Улс төрийн нөлөө бүхий этгээд	ИН	ИН
R.13	Корреспондент банкны үйл ажиллагаа	ИН	ИН
R.14	Мөнгө эсвэл үнэт зүйлийг шилжүүлэх үйлчилгээ	Н	Н
R.15	ВХҮҮ-ийг бүртгэх	ИН	ХН
R.16	Гүйлгээг бүртгэх /Wire transfers/	ИН	Н
R.17	Гуравдагч этгээдүүдэд тулгуурлах	ИН	ИН
R.18	Дотоод хяналт ба гадаад салбар, охин компаниуд	ИН	ИН
R.19	Өндөр эрсдэл бүхий улсууд	ИН	ИН
R.20	Сэжигтэй гүйлгээг мэдэгдэх	ИН	Н
R.21	Мэдээлэл өгөх ба нууцлал	Н	Н
R.22	Санхүүгийн бус бизнес ба мэргэжлүүд: Харилцагчийн хяналт /Due Diligence/	ИН	ИН
R.23	Санхүүгийн бус бизнес ба мэргэжлүүд: Бусад арга хэмжээ	ИН	ИН
R.24	Хуулийн этгээдийн ил тод байдал, эцсийн өмчлөгч	ИН	ИН
R.25	Эрх зүйн зохицуулалтуудын ил тод байдал ба эцсийн эзэмшигчийн тодорхойлолт	ИН	ИН
R.26	Санхүүгийн байгууллагын зохицуулалт ба хяналт	ИН	ИН
R.27	Зохицуулагчдын эрх мэдэл	ИН	ИН


[70] Financial Action Task Force. (2023). *Mongolia*. https://www.fatf-gafi.org/en/publications/Mutualevaluations/Fur-mongolia-2022.html Accessed May 1, 2024. Financial Action Task Force. (2023). *Finland*. https://www.fatf-gafi.org/en/countries/detail/Finland.html#:~:text=FATF%20concluded%20that%20Finland%20has,financial%20and%20non%2Dfinancial%20institutions. Accessed May 1, 2024.

R.28	Санхүүгийн бус бизнес ба мэргэжлүүдийг зохицуулах ба хянах	ИН	ХН
R.29	Санхүүгийн мэдээллийн нэгж	Н	Н
R.30	Хууль сахиулах ба мөрдөн шалгах байгууллагын үүрэг	Н	Н
R.31	Хууль сахиулах ба мөрдөн шалгах байгууллагын эрх мэдэл	Н	ИН
R.32	Мөнгө тээвэрлэх	ИН	ИН
R.33	Статистик	ИН	ИН
R.34	Зөвлөгөө ба хариу	ИН	Н
R.35	Хоригууд	ИН	ИН
R.36	Олон улсын хэрэгсэл	Н	ИН
R.37	Эрх зүйн харилцан туслалцаа	Н	ИН
R.38	Эрх зүйн харилцан туслалцаа: царцаах ба хураах	ИН	ИН
R.39	Гэмт хэрэгт холбогдогчийг шилжүүлэн өгөх /Extradition/	ИН	ИН
R.40	Бусад олон улсын хамтын ажиллагааны хэлбэрүүд	ИН	ИН

Н – нийцсэн ИН – ихэнх нь нийцсэн ХН – хэсэгчлэн нийцсэн

Хавсралт 2[71]

График 1. Финланд улсын ВХХҮ-ийн мөнгө угаахтай тэмцэх дотоод ажиллагаа



[71] *Case study: Finland*, p. 32.

“ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГ, ЛУЙВАР, ЗАЛИЛАНГ БУУРУУЛАХ ОНОВЧТОЙ АРГА АРГАЧЛАЛ”
/Өсвөр үеийнхний жишээн дээр/

У.Минжинсор, Д.Номин**, Г.Хоролмаа****

**Монгол улсын их сургууль, НББ- III түвшний оюутан*

*** Монгол улсын багшийн их сургууль, НУБ-III түвшний оюутан*

****Монгол улсын багшийн их сургууль НУБ-III түвшний оюутан, И-мэйл: horolmaag00@gmail.com, Утас:90405246, 94542205*

ТОВЧ ХУРААНГУЙ

Дэлхий ертөнц даяаршиж буй XXI зуунд Монгол улсад төдийгүй дэлхий улс орнуудад нэн түрүүнд тулгамдаж буй асуудлын нэг бол цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг юм. Нийт хүн төрөлхтний 55% хувь буюу 5,2 тэрбум хүн интернэт хэрэглэдэг бөгөөд манай орны хувьд интернтт хэрэглэгчдийн тоо 2,9 саяд хүрсэн гэсэн тоон мэдээлэл бүртгэгдсэн байна. Цахим хэрэгсэл нь бидний амьдралыг хөнгөвчлөх, дэлхийн хүн төрөлхтний хоорондын харилцаа холбоог бататгах мөн өөрт хэрэгтэй мэдээ мэдээллийг түргэн шуурхай авах маш олон давуу талтай хэдий ч түүнийг дагаад цахим орчин дахь хүмүүсийн зүй зохисгүй хэрэглээнээс үүдэн бусдыг залилах, хүүхдийг садар самуунд уруу татах, оюуны өмчийн хулгайлах, бусдын хувийн нууцад халдах зэрэг гэмт хэрэгтэй бид нүүр тулж байна. Монгол Улсад сүүлийн таван жилийн хугацаанд 14,085 залилах гэмт хэрэг бүртгэгдсэнээс 97 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн байна. Цахим орчинд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн тоо өнгөрсөн таван жилд 14.9 дахин, учирсан хохирлын хэмжээ 270.8 дахин өссөн. Зөвхөн сүүлийн нэг жилд цахим гэмт хэргийн хохирлын хэмжээ 7.5 дахин өсөж, 139.2 тэрбум төгрөгт хүржээ. Мөн нэг цаг тутамд нэг иргэн цахим гэмт хэрэгт өртөж буй учир үүнийг анхаарч үзэх нь зайлшгүй чухал асуудал юм. Түүнчлэн интернэт болон цахим технологийн эрин үед хүүхдийн сурах, хөгжих, тоглох, бие биетэйгээ харилцах хэлбэр үндсээрээ өөрчлөгдөж тэдэнд өөрийгөө илэрхийлэх, мэдлэг боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэх маш өргөн боломжууд нээгдэж байна. Гэвч нөгөө талаас интернэт болон цахим орчинд хүүхдүүд өөрсдийн насанд тохироогүй зохисгүй контент буюу мэдээлэл, зураг, бичлэг зэргийг олж үзэх, садар самуун, хүчирхийллийн шинж чанартай контентыг бусдаас хүлээж авах, хүчирхийлэл, бусад гэмт хэргийн хохирогч болох явдал нэмэгдэж байна. Энэ асуудлыг Хүүхдийн эрхийн хууль, Хүүхэд хамгаллын тухай хууль болон бусад хууль, түүнийг даган гарсан журам дүрэм боловсруулж эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч цахим орчинд хүүхдийн хамгаалагдах эрх зөрчигдсөөр байгааг статистикийн тоо баримтууд харуулсаар байна. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-д ирсэн цахим дарамтын дуудлага 2016 онд 85 байсан бол 2018 онд 229 болж бусад төрлийн хүүхэд хамгаллын дуудлагаас хамгийн их буюу 269%-иар өссөн[1] байна.

[1] https://108.mn/

Цахим хэрэглээ нь хүн төрөлхтний амьдралын хэвшил хийгээд харилцааны гол хэрэгсэл болсоор байх нь гарцаагүй болсон энэ цаг үед технологийн дэвшлийг ашиглан үйлдсэн гэмт хэргийн тоо хурдацтай өсөж буй нь өсвөр үеийнхнийг цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга замыг боловсруулахад оюутан бидний оролцоо чухал байгаа нь бидний энэхүү сэдвийг сонгох үндэслэл болсон билээ.

ЗОРИЛГО

Монгол улс дахь өсвөр үеийнхний цахим гэмт хэрэг, луйвар, залилан ямар түвшинд байгааг тодорхойлж, түүний үйлдэгдэж буй шалтгаан нөхцөл , үр дагавар мөн энэ төрлийн гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, бууруулах арга замыг боловсруулахад оршино. Бид энэхүү зорилгынхоо хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа.

ЗОРИЛТ

- Цахим орчин дахь гэмт хэрэг, залилан, луйврын талаар хуулийн заалт болон бусад эх сурвалжид хэрхэн тусгагдсан тухай уншиж судлан онол зүйн үндэслэлтэй тайлбар хийх
- Тус чиглэлээр бичигдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл зэргийг судалж баримт мэдээлэл цуглуулах
- Цуглуулсан баримт мэдээллээ боловсруулах, судалгааны тойм гаргах
- Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулах арга замын талаар түүврийн аргаар өсвөр үеийнхнээс судалгаа авах
- Өөрсдийн боловсруулсан судалгаанд дүн шинжилгээ хийх
- Судалгааны үр дүн дүгнэлтэд тулгуурлан цахим гэмт хэргийг бууруулах аргачлалыг боловсруулах

	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ОГНОО									
		1	2	3	4	5	6	7	8	9	10
НЭГ. БЭЛТГЭЛ ШАТ											
1	Онол зүйн үндсэн тайлбар хийх										
2	Судлагдсан байдлын тойм хийх										
ХОЁР. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ШАТ											
1	Судалгааны төсөл боловсруулах										
ГУРАВ. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ											
1	Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах										
2	Судалгаа авах										
ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧИХ ШАТ											
1	Судалгааны тайлан боловсруулах										

Тулгуур ойлголтууд:

Цахим:

- Цахилгаан тооцоолон бодох техник, ийм төрлийн техник ашиглан үйл ажиллагаа явуулах. цахим бараа, цахим тооцоолуур, цахим захиа, цахим шуудан, цахим багаж, цахим тоноглол, цахим карт, *цахим хуудас
- Маш хурдан. Цахилгаан цахих мэт хурдтай. *цахим хурд[2]

Гэмт хэрэг:

- Монгол улсын Эрүүгийн хуульд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй.[3]

Цахим гэмт хэрэг:

- Мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний кибер аюулгүй байдлыг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг. [4]

Өсвөр үеийнхэн:

- Өсвөр үе гэж 10-18 насны ид өсөн торниж буй хүүхдийг хэлнэ.[5]

Залилан:

- Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах[6]

Луйвар:

- Монгол хэлний тайлбар толь бичигт луйвар гэдэг үгийг булхай, заль мэх гэж тайлбарласан байдаг бол Эрх зүйн эх толь бичигт залилан мэхлэх нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг бөгөөд хүч хэрэглээгүй ашиглан шамшигдуулах хэлбэр хэмээн тодорхойлсон.[6]

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Нэг. Оршил хэсэг

XXI зуунд хүн төрөлхтний хамгийн том хөгжлийн нэг нь цахим хэрэглээ бөгөөд нийгмийн бүхий л харилцаа цахим хэлбэрт шилжиж байгаагийн хэрээр гэмт хэрэг үйлдэгдэх хэлбэр мөн адил цахим хэлбэрт шилжиж байна. Дэлхийн хүн амын 55 хувь буюу 5,2 тэрбум хүн интернэт хэрэглэдэг бөгөөд манай орны хувьд интернэт хэрэглэгчдийн тоо 2,9 саяд хүрсэн. Монгол Улсын хүн амын бүтэц нь харьцангуй

[2] https://tsevel.toli.query.mn/
[3] https://legalinfo.mn/mn/detail/11634
[4] https://legalinfo.mn/mn
[5] https://legalinfo.mn/mn/detail/11634
[6] https://mongoltoli.mn/

залуу ба цахим орчны хэрэглээгээр Ази тивд өндөртөө ордог. Тухайлбал, Монгол улсад фейсбүүк хэрэглэгчдийн тоо 2012 онд 654 мянга байсан бол өнгөрсөн жилийн байдлаар 2.7 сая болж нэмэгдсэн. Нийт хүн амын 80 гаруй хувь интернэт ашигладаг ба үүнээс 96 хувь нь фейсбүүк ашигладаг гэсэн судалгаа байна.

Цахим гэмт хэргийг илрүүлэх, шалгах, нотлох мөн урьдчилан сэргийлэх нь төр, хүн, хуулийн этгээдийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, цаашлаад үндэстэн дамнасан олон төрлийн гэмт хэрэг, тэр тусмаа мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй арга юм.

Хоёр. Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн ойлголт, *төрөл*

Цахим орчин гэдэг нь дэлхийн ихэнх улс орныг холбосон олон сая компьютерын сүлжээ ба асар их мэдээллийн санг тодорхойлсон нэршил юм. НҮБ-ын шинжээчдийн үзэж байгаагаар кибер гэмт хэрэг гэдэг нь виртуал орон зайд (хүмүүс, баримт, үйл явдлын талаарх мэдээллийг өөр хэлбэрээр агуулсан цахим орчин) явагддаг аливаа хууль бус үйлдэл бөгөөд харилцаа холбооны сүлжээ эсвэл компьютерын систем, түүнчлэн компьютерын систем, сүлжээний эсрэг үйлдэгдсэн бүх гэмт хэргийг хэлнэ.

Олон улсад кибер гэмт хэрэг гэдэгт кибер халдлага, пишинг, онлайн мөрдлөг болон залилан, заналхийлэл, скиминг буюу картын гэмт хэрэг, садар самуун дүрс бичлэг тараах болон интернэтэд суурилсан оюуны өмчийн эсрэг гэмт хэргийг багтаадаг бөгөөд дараах 4 төрөлд ангилдаг байна. Үүнд:

- Компьютерын мэдээлэл, сүлжээний бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг
- Компьютер ашиглаж үйлдэх гэмт хэрэг
- Интернэт дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг
- Интернэт дэх оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг эсхүл цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй гэмт хэрэг гэдэг нь цахим орчинд бусдын эд хөрөнгө, нэр хүндэд халдахад чиглэсэн үйлдлээс гадна бусдыг хууль бусаар мөрдөх, мэдээллийн аюулгүй байдалд халдах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүний наймаа, хүүхдийг садар самуунд уруу татах, бусдыг далайлган сүрдүүлэх, хар тамхи, мансууруулах төрлийн бодис худалдаалах зэрэг гэмт хэргийг үйлдэхдээ цахим хэрэгсэл ашиглаж байгаа бүхий л үйлдлийг ойлгоно.

Гурав. Монгол улсад бүртгэгдсэн цахим гэмт хэрэг, залилан, луйврын статистик мэдээлэл

Монгол улс нь НҮБ-аас гаргасан “Иргэдийн цахим оролцооны индекс”-ээр 74 дүгээрт, “Дижитал өрсөлдөх чадварын индекс”-ээр 62 дугаарт, Олон Улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) аас гаргадаг кибер аюулгүй байдлын

индексээр 120 дугаар байрт жагсжээ[7]. Энэхүү үзүүлэлтээс харахад сүүлийн жилүүдэд иргэдийн цахим хэрэглээ хурдацтай нэмэгдэж байгаа бөгөөд түүнийг даган цахим орчин дах гэмт хэргийн тоо эрс ихсэж зөвхөн сүүлийн нэг жилд цахим гэмт хэргийн хохирлын хэмжээ

7.5 дахин өсөж, 139.2 тэрбум төгрөгт хүрсэн нь харагдаж байна. Тиймээс энэхүү чиглэлийн эрх зүйн орчин, техник технологийн чадавх, дотоодын болон олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн тоог бууруулах нь монгол улсад тулгамдаж буй асуудлыг нэг юм.



Интернэт хэрэглэгчийн тоо нэмэгдэхийн хэрээр гэмт хэргийн тоо ч өссөөр. Манай улсын хэмжээнд өмнөх он буюу 2023 онд 9870 цахим гэмт хэргийн гаралт гарсан нь 2022 оныхтой харьцуулахад 4173 гэмт хэрэг нэмэгдэж гарсан ба 73.25%-иар өссөн байна. Энэхүү гэмт хэргээс үүдэн хохирч буй хүмүүсийн хохирлын хэмжээ 2023 онд 139,275,986,356 төгрөгт хүрч өмнөх оноос 120,767,286,356 төгрөгийн өөрчлөлт гарч өөрчлөлтийн хувь 652.5%-д хүрсэн байна. Өмнөх өмнөх жилүүдийг харахад Монгол улс дахь цахим гэмт хэрэг жилээс жилд эрс нэмэгдэж байгаа бөгөөд коронавирусын болон улс хоорондын дайны нөхцөл байдлаас шалтгаалан хүмүүс энэхүү төрлийн гэмт хэргийг үйлдэх нь улам бүр ихэсжээ.

он	2019	2020	2021	2022	2023	өөрчлөлт	хувь	өөрчлөлт	хувь	өөрчлөлт	хувь	өөрчлөлт	хувь
						2019-2020		2020-2021		2021-2022		2022-2023	
Цахим гэмт хэргийн тоо	659	737	1795	5697	9870	78	11.8	1058	143.6	3902	217.4	4173	73.2

он	2019	2020	2021	2022	2023	өөрчлөлт	хувь	өөрчлөлт	хувь	өөрчлөлт	хувь	өөрчлөлт	хувь
						2019-2020		2020-2021		2021-2022		2022-2023	
Цахим гэмт хэргийн хохирол ₮	514,200,000	587,800,000	985,200,000	18,508,700,000	139,275,986,356	73,600,000	14.3	397,400,000	67.6	17,523,500	1778.7	120,767,286,356	652.5

[7] https://www.isd.gov.mn/?id=241 Мэдээллийн аюулгүй байдлын газар. https://www.statista.com/

Монгол улсад цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн төрөл:

- Интернэт дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг буюу иргэд болон өсвөр насны хүүхдүүдийн фейсбүүк хаяг руу садар самуун агууламжтай зураг, бичлэг илгээж садар самуунд уруу татах, сурталчлах, биеэ үнэлэхийг зохион байгуулах
- Хуулиар хориглосон бараа бүтээгдэхүүний худалдаа зохион байгуулах буюу галт зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, согтууруулах ундааны зүйл худалдаалах;
- Бусдын нэр төрд халдах, айлган сүрдүүлэх, гүтгэн доромжлох, ялгаварлан гадуурхах
- Онлайн худалдаа гэх нэрээр залилах буюу зээлийн картын залилан, урьдчилгаа төлбөрийн залилан, интернэт маркетинг болон жижиглэн худалдааны луйвар. Фейсбүүк нь өдөр бүр 50 мянга гаруй гүйлгээ хийгддэг цахим худалдааны хамгийн эрэлт ихтэй орон нутгийн платформуудын нэг бөгөөд Монголын нийт фейсбүүкийн хэрэглэгчдийн 25 хувь нь онлайнаар худалдаа эрхэлдэг гэсэн[4] тооцоо гарчээ. Эдгээр борлуулалтаас олох нийт орлогыг хараахан тооцоолж чадаагүй байгаа боловч тэдний 70 хувь нь онлайн банкны программ ашигладаг бол үлдсэн хэсэг нь дебет, эсвэл зээлийн карт ашигладаг байна.
- Мөрийтэй тоглоом, азын сугалаа зохион байгуулах нэрийдлээр ашиг олох, иргэдийг хохироох,
- Интернэт дэх оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг буюу зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчсөн гэмт хэрэг. Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Берний конвенц, Оюуны өмчийн эрхтэй холбоотой худалдааны асуудлаарх хэлэлцээр (TRIPS), Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Зохиогчийн эрхийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу тухайн улсын дотоодын хууль тогтоомжоор хамгаалсан зохиогчийн эрхтэй холбоотой эрхийг санаатайгаар, ашиг олох зорилгоор компьютерын сүлжээ ашиглан зөрчсөн үйлдэл[8]
- Мөнгө угаах гэмт хэрэг буюу мэдээлэх үүрэг хүлээлгэн тогтоосон босго хэмжээнээс зайлсхийхийн тулд олон гүйлгээг (дансанд мөнгө тушаах, данснаас зарлагадах, шилжүүлгүүд) янз бүрийн хүмүүс их хэмжээний мөнгийг жижиг дүнтэйгээр зарим үед олон тооны дансанд шилжүүлэх арга юм. Электрон шилжүүлэг /Western Union, Cash money г.м/, цахим төлбөр тооцоо /PayPal, Second life Gold г.м/, урьдчилсан төлбөрт болон зээлийн картууд, мобайл болон интернэт шилжүүлгийг ашиглана.
- Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг. Үндэсний дата төв руу 2021 оны сүүлийн зургаан сарын хугацаанд өдөрт дунджаар 66 сая орчим

[8] https://rm.coe.int/16802fa427

хандалт хийгдэж байгаагаас 14,6 сая орчим нь халдлагын шинжтэй гэж бүртгэгджээ. Манай улсын хувьд 2018 онд НҮБ-н Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас жил бүр судлан гаргадаг Цахим Аюулгүй Байдлын Индексээр 193 орноос 85 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна.[9]

Дөрөв. Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тойм болон шалтгаан, нөхцөл

Дэлхийд учруулах заналхийллээр нэгд нь кибер гэмт хэрэг, хоёрт нь терроризм орж байна. Монгол улсад 2016 онд 976, 2018 онд 659, 2021 оны эхний хагаст 776 кибер гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2015 оныхоос даруй 79% -иар өссөн бөгөөд өнгөрсөн дөрвөн жилд цахим гэмт хэргийн хохирогчид нийтдээ 27.4 тэрбум төгрөгийг (ойролцоогоор 9.5 сая ам.доллар) гадаад руу шилжүүлж алджээ.

2021 онд Нийслэлийн прокурорын газраас олон нийтийн цахим мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн 388 зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан 377 хэрэгт хяналт тавин ажилласан байна. Нийт хэргийн 98.2 хувь буюу 372 нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлд заасан “Цахим мэдээлэлд хууль бусаар халдах” гэмт хэрэг, 1.6 хувь буюу 6 нь 26.2 дугаар зүйлд заасан “Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах” гэмт хэрэг, 1.1 хувь буюу 4 нь 26.3 дугаар зүйлд заасан “Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах” гэмт хэргүүд байна.

Цахим орчин дох хүүхдийн эрхийн зөрчлийн тухай судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн 70 гаруй хувь нь өдөрт 1-2 цагийг цахим орчинд өнгөрүүлдэг ба хоёр хүүхэд тутмын нэг нь садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, 82 хувь нь зүй бус утгатай зурвас и-мэйл, фейсбүүкийн хэрэглэгчдээс авч байсан, эцэг эхчүүдийн 95 хувьд нь энэ төрлийн сөрөг мэдээллийг шүүх программ хангамжийг ашиглах чадвар огт байхгүй бол 93 хувь нь хүүхдээ цахим дарамт, дээрэлхэлтэнд өртөж байсан гэж хариулсан байна.[12]

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлбол:

- Иргэд нийгмийн сүлжээ хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үгийг өөрийн нэр, төрсөн огноо, утасны дугаар гэх зэргийг бусад хүн тааварлаж болохуйц хялбар байдлаар /гар утасны дугаар, төрсөн огноо, автомашины дугаар г.м/ үүсгэдэг;
- Өгөөш бүхий мэдээллийг уншихаар сонирхон дарж нэвтрэх нэр, нууц үгээ алддаг, “зээл олгоно”, “илгээмж явуулна” “сугалаанд хожсон”, гэх байдлаар иргэдийг төөрөгдөлд оруулж, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн санаа, сэдлийг төрүүлж улмаар уг зүйлсийн татвар хураамж, тээврийн зардлыг

[9] https://vip76.mn/

шилжүүлнэ үү гэх зэргээр цахим мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй мэдээлэл үнэн зөв эсэх талаар нягтлан судалж үздэггүй;

- Цахим орчинд хүүхдэд тавих хараа хяналт сул, хүүхэд бүх төрлийн сөрөг мэдээллийг авах боломж нээлттэй
- Цахим мэдээллийн хэрэгслийг зохих түвшинд ашиглах мэдлэг дутмаг, хувь хүний амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сэтгэл зүйн онцлог, хайхрамжгүй байдал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэхээр байна.

Тав. Эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал

Кибер гэмт хэргийн гаралт ийнхүү нэмэгдэж байгаа нь Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйтэй холбоотой юм. Гэмт хэрэг үйлдэж буй хүмүүс ихэвчлэн гадаад сервертэй веб сайтуудыг хэрэглээндээ ашигладаг ба тухайлбал Фейсбүүк, твиттер нь АНУ-д бүртгэлтэй компани бөгөөд эдгээрт бүртгүүлсэн хэрэглэгчийн мэдээлэл Америкийн хуулиар хамгаалагддаг, манай улсын хуулиар зохицуулагдах боломжгүй тул иргэн гомдол гаргасан тохиолдолд тэр улсаас нь тухайн сайтыг шалгаж өгөх, мэдээлэл авах хүсэлтийг явуулдаг, цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн мэдээллийг автоматаар олж авах технологийн боломж дэлхийн аль ч улсад хязгаарлагдмал байдаг тухай мэдээллийн технологийн мэргэжилтнүүд тайлбарлаж байна. Мөн Фейсбүүк /Facebook/ компани нь терроризм, хүний амь нас хохирох нөхцөл байдал бий болсон, хүүхдийн садар самуун, секс сүрдүүлэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг /хар тамхи, хүн худалдаалах, мөнгө угаах/ зэрэг тодорхой төрлийн цөөн хэргээс бусад хэрэгт мэдээлэл гарган өгдөггүй нь олон төрлийн гэмт хэргийг таслан зогсооход хүндрэл учирч байна.

Цар тахлын нөхцөл байдал болон хэрэглэгчийн эрэлт, цаг хугацаа хэмнэлт гээд олон хүчин зүйлсээс шалтгаалж цахим худалдааны олон төрөл бий болсон бөгөөд цахим худалдааны эрх зүйн орчин хангалтгүй байгаа тул цахим хуурамч худалдааны хохирогч болсон иргэн өнөөдөр хохирлоо барагдуулж чадахгүй байна.

СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

“Монгол улс дахь цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулах” талаар судлагдсан байдлын тойм

Судалгааны нэр	ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ БАЙДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ
Судалгааг хийсэн он	Судалгааг 2019, 2020 он, 2021 оны гуравдугаар улирлын байдлаар улсын хэмжээнд явуулсан.
Байгууллага	Улсын Ерөнхий прокурорын газар
Судалгааны зорилго	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг болон цахим хэрэгсэл, цахим сүлжээ ашиглаж үйлдсэн гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан нөхцөлийг судлах

Судалгааны үр дүн	**Цахим гэмт хэргийн өсөлт** - Цахим төрлийн нийт 4593 хэрэг шалгагдсаны дийлэнх буюу 89.7 хувийг интернэт хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэрэг эзэлж байна.
Судалгааны үр дүн	Тодруулбал, 2019 онд 880 хэрэг шалгагдсан бол, 2020 онд 1099 хэрэг болж 24.9 хувиар өссөн. Харин 2021 оны гуравдугаар улирлын байдлаар 2140 хэрэг шалгагдсан байдлаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг жил бүр нэмэгдэж байгааг харуулж байна. **Цахим гэмт хэрэг гарах шалтгаан** - Техник, технологийн хурдацтай хөгжлийг дагаад нийгмийн бүхий л харилцаа цахим хэлбэрт шилжихийн хэрээр иргэдийн цахим сүлжээний хэрэгсэлд нэвтрэх хандалт нэмэгдсээр байна. Нөгөөтэйгүүр “Ковид-19” цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хэрэглэгчийн эрэлт, цаг хугацаа хэмнэлт гээд олон хүчин зүйлсээс шалтгаалан цахим худалдаа ихэссэн. Үүнийг дагасан маш олон төрөл бий болсон зэрэг нь цахим гэмт хэрэг нэмэгдэх гол үндсэн суурь шалтгаан болж байна. **Цахим гэмт хэргийг ямар хүмүүс ихэвчлэн үйлдэж байна вэ?** - Залилах гэмт хэргийг ихэвчлэн 18-45 насны, бүрэн дунд боловсролтой, тодорхой эрхэлсэн ажилгүй, хохирогчтой ямар нэгэн харилцаа хамааралгүй, таньж мэдэхгүй хүмүүс үйлдэж байна гэсэн дүн гарсан. **Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах зүй**л - Иргэд цахим сүлжээнд хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үгээ өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, өөрийн болон гэр бүлийн гишүүний утас, автомашины дугаар гэх мэт бусад хүн мэдэж тааварлаж болохуйц байдлаар үүсгэдэг учир нууцлалыг хангах код хийх. - Хууль ёсны эх сурвалжийн мэдээллийг нягталж , вебсайтаар зочлох

“АНУ дахь цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулах” талаар судлагдсан байдлын тойм

Судалгааны нэр	**2024 ОНЫ КИБЕР ГЭМТ ХЭРГИЙН ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ**
Судалгааг нийтэлсэн он	2024 он
Байгууллага	АНУ-ын “Accenture securtiy” байгууллага
Судалгааны зорилго	АНУ-ын хүн ам кибер гэм хэрэгт хэр зэрэг өртөж буйг тогтоож түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга замыг хэрэгжүүлдэг болох талаар судлах

Судалгааны үр дүн	**АНУ-ын нийт хүн амын хэдэн хувь нь кибер гэмт хэрэгт өртөж байна вэ?** • 2022 оны эхний хагаст АНУ-ын 53.35 сая иргэн кибер гэмт хэрэгт өртсөн гэсэн тоон мэдээлэл бүртгэгдсэн байна. 2020 оны 7-р сараас 2021 оны 6-р сарын хооронд АНУ кибер халдлагын хамгийн их халдлагад өртсөн улс бөгөөд дэлхийн хэмжээнд гарсан халдлагын 46 хувийг эзэлж байна. **АНУ кибер гэмт хэрэгт хэдэн насны хүмүүс илүү хохирогч болдог вэ?** • 2021 оны байдлаар АНУ кибер халдлагад өртсөн хохирогчдын нийт хүн амын 32 хувь буюу 60-аас дээш насныхан бүртгэгдсэн байна.
Судалгааны үр дүн	**АНУ кибер гэмт хэрэгт хэр их хохирол амсдаг вэ?** • 2021 онд АНУ-ын иргэд романтик луйвар (956 сая ам.доллар), хөрөнгө оруулалтын луйвар (1.4 тэрбум ам.доллар), бизнесийн цахим шуудан (2.39 тэрбум доллар) зэрэг цахим сүлжээтэй холбоотой гэмт хэргийн улмаас 6.9 тэрбум ам.доллар зэрэг асар их хохирол амссан. **АНУ-ын байгууллагууд кибер аюулаас хамгаалагдсан уу?** • АНУ-ын олон байгууллага кибер аюулаас зохих ёсоор хамгаалагдаагүй байна. Байгууллагуудын ердөө 50% нь кибер даатгалд бүрэн хамрагддаг. • АНУ-ын 10 байгууллагын 1 орчим нь (12%) нь кибер халдлагаас хамгаалах хамгаалалтгүй, халдлагад өртвөл санхүүгийн сүйрэлд орох эрсдэлтэй гэсэн үг юм. **АНУ кибер гэмт хэргийг бууруулахад авах арга зам** • АНУ цахим гэмт хэрэгтэй тэмцэж түүнийг анхаалдаа авж үзэх нь зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд тухайн улсын хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон шинжээчид цахим аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд 17.4 тэрбум ам.доллар шаардлагатай хэмээн үзсэн байна. • Цахим аюулгүй байдлын эсрэг мэдлэг олгох зорилгоор сургалт явуулах

“Өсвөр үеийхний цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулах” талаар судлагдсан байдлын тойм

Судалгааны нэр	**ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**
Судалгааг хийсэн он	2018 он
Байгууллага	Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар сургалт, судалгаа мэдээллийн төв
Судалгааны зорилго	Энэхүү судалгааны зорилго нь өсвөр үеийнхний цахим хэрэглээний түвшин, мэдлэг, хандлагыг тодорхойлон, хүүхдийг цахим хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн нотолгоонд тулгуурласан зөвлөмж боловсруулахад оршино.

Хамрах хүрээ	ЕБС-ийн 11-17 насны сурагчид, багш, нийгмийн ажилтнууд болон 11 наснаас дээш хүүхэдтэй эцэг эхчүүд судалгаанд хамрагдаж, судалгааны асуулгад хариулсан болно. Харин гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүд болон асрах газар, халамжийн төв зэрэг нийтийн байранд амьдарч буй хүүхдүүд хамрагдаагүй юм.
Судалгааны үр дүн	Өсвөр үеийнхний 92 хувь нь интернет хэрэглэдэг ба хэрэглэдэггүй гэсэн хариултын дийлэнх буюу 76 хувь нь орон нутгийн хүүхдүүд эзэлж байгаа бөгөөд үүнд 11-12 насныхан зонхилж байна. Хүүхдүүдийн 85 орчим хувь нь ухаалаг утас хэрэглэдэг, тэдний 92 хувь нь нүүр номын хаягтай байв. Эндээс үзэхэд ухаалаг утас авах нь тийм ч хүндрэлтэй асуудал биш гэдэг нь харагдаж байна.
Судалгааны үр дүн	Сурагчдын 70 гаруй хувь нь өдөрт 1-2 цаг, 30 хувь нь 2 ба түүнээс дээш цагийг цахим орчинд өнгөрүүлдэг ба тэдэнд аливаа асуудал тулгарахад ихэнхи тохиолдолд хамгийн дотны туслагч нь найз нөхөд, үе тэнгийнхэн нь байдаг байна. Олон улсын судалгаагаар өсвөр насны хүүхдүүд өдөрт 15-45 минут интернет ашиглах нь зохистойг гэж зөвлөсөн ба энэ жишгээр авч үзвэл бараг хоёр хүүхэд тутмын нэг нь интернетийг зохистой хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэж байна гэж үзэж болохоор байна. Түүнчлэн таван хүүхэд тутмын дөрөв нь зүй бус утгатай зурвас мэйл фейсбүүкийн хэрэглэгчээс авч байсан, хоёр хүүхэд тутмын нэг нь садар самууныг сурталчилсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралдаж байсан гэж хариулсан нь сөрөг мэдээллийг шүүгч программыг эцэг эхчүүд хүүхдийнхээ компьютер, гар утсыг интернэтэд холбуулахдаа заавал суулгуулах шаардлагатайг харуулж байна. Цаашид өсвөр насныхны хувьд цахим орчин нь нэгэнт хэрэглээ болсон тул шууд хязгаарлахаас илүүтэй ухаалаг хэрэглээг зүй зохистой хэрэглэх талаар сургалт, сурталчилгаа хийх, сургалтын хөтөлбөрт тусгах, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад цахим хэрэглээ, сэтгэл зүйн зөв дадал, ухаалаг хэрэгцээний талаар сургалт, үйл ажиллагааг хөтөлбөрөөр оруулах, сөрөг мэдээллийг шүүгч программ хангамжийн мэдлэгийг олон нийтэд, оновчтой сувгаар тогтмол олгох нь үр дүнтэй гэж үзэж байна.

СУДАЛГААНЫ АЖИЛ

Судалгааны сэдэв:

- Цахим гэмт хэрэг, луйвар, залилан бууруулах оновчтой арга аргачлал

Судалгааны онол:

- Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулах оновчтой арга аргачлалыг боловсруулах судалгаа нь социологийн онолууд тэр дундаа Позитивизм хандлагаар тайлбарлагдана.
- Позитивизм хандлагаар тайлбарлагдсан судалгааны эцсийн зорилго нь хүний зан үйлийн түгээмэл хуулийг нээж чадах шинжлэх ухааны тайлбар, баримтыг илрүүлэх явдал юм.

- Тус социологийн судалгааны хандлагаар өсвөр үеийнхний цахим хэрэглээ, цахим гэмт хэрэг/залилан, луйвар/ түүнийг бууруулах арга замыг илрүүлж, шийдвэрлэх оновчтой саналыг боловсруулах зорилгоор уг судалгааг хийнэ.

Судалгааны таамаглал:

- Цахим гэмт хэрэг, луйвар, залиланд өртөх гол шалтгаан нь өсвөр үеийнхний хүйсээс хамаарна.
- Цахим гэмт хэрэг, луйвар, залилан зэргээс урьдчилан сэргийлэх талаар өсвөр үеийнхний мэдлэг мэдээлэл дутмаг байгаагаас шалтгаалан тухайн гэмт хэрэгт өртөх эрсдэл их байдаг.


Судалгааны хамрах хүрээ:

- Ерөнхий боловсролын 14-18 насны суралцагчдыг түүврийн аргаар сонгон судалгаанд хамруулах

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Насны байдал



Насны байдлаар 18 насны 40 сурагч (62.5%), 17 насны 6 сурагч (9.4%), 16 насны 5 сурагч (7.8%), 15 насны 5 сурагч (7,8), 14 насны (12,5%) тус тус судалгаанд хамрагдсан байна.

1.2. Асуулга, судалгаанд хамрагсдын хүйсийн үзүүлэлт


Хүйс	Тоо	Хувь
Эрэгтэй	22	34.4
Эмэгтэй	42	65.6

Судалгаанд хамрагдсан сурагчдын 41.1 хувь нь эмэгтэй, 58.9 хувь нь эрэгтэй байна.

2. ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1. Цахим хэрэглээний үзүүлэлт, хувиар

Та интернет хэрэглэдэг үү?




Судалгаанд оролцсон сурагчдын 94.1 хувь нь интернэт хэрэглэдэг байв. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны статистик мэдээнд манай улсын 15-0 насны арван хүн тутмын найм нь ямар нэгэн байдлаар сошиал медиа ашигладаг гэсэн байна.[10] Эндээс үзэхэд өсвөр насныхны цахим хэрэглээ насанд хүрэгчдийнхээс илүү байгаа нь илэрхий байна.

2.2. Өсвөр үеийнхний интернет хэрэглэж буй шалтгаан, хувиар



Хүүхдүүд найз нөхдийн харилцаа (52,8%), мэдээллийг цаг алдалгүй хүлээж авах, мэдлэг чадвараа нэмэгдүүлэх (17.6%), хэрэгтэй бичлэг, кино, клип хайх (17.6%), хичээлийн холбогдолтойгоор (6%), тоглоом татах, хайх (6%) зорилгоор цахим хэрэглэгдэхүүн ашиглаж интернэт сүлжээг ихэвчлэн хэрэглэж байна.


2.3. Интернэтийн хэрэглээний эх үүсвэр



[10] https://crc.gov.mn/list/zah-zeel-rs-ld-n/mn?show=45

Хүүхдүүдийн дийлэнх нь буюу 76.4 хувь нь гар утасны дата болон гэрийн WIFI-гаар интернэтэд холбогддог гэж хариулснаас үзвэл тэдний цахим хэрэглээнд хяналт тавих, хэрэглээг зөв зохистой хязгаарлах боломж байгааг харуулж байна.

2.4. Ямар төхөөрөмжөөр интернэтэд холбогдож байна вэ?




Бүх сурагчид ухаалаг утас хэрэглэж байна. Тэдгээр хүүхдийн 95 хувь нь интернэт хэрэглэдэг, 92 хувь нь фейсбүүк хаягтай байв.

2.5. Өдөрт дунджаар хэдэн цаг интернэт хэрэглэдэг вэ?



Судалгаанд оролцсон хоёр сурагч тутмын нэг нь өдөрт 2-с дээш цагийг интернэт ашиглахад зарцуулдаг байна. Олон улсын судалгаагаар өсвөр насны хүүхдүүд өдөрт 15- 45 минут интернэт ашиглах нь зохистой гэдгийг баталсан байна.


2.6. Түгээмэл хэрэглэдэг аппликейшны төрлүүд (давхардсан хариулт)



Хамгийн түгээмэл ашигладаг нийгмийн сүлжээгээр сурагчдын дийлэнх нь буюу 76.4 хувь нь фейсбүүк, 41.2 хувь нь ютүүб, 70.5 хувь нь инстаграммыг тус тус нэрлэжээ. Түүнчлэн 17.6 хувь нь цахим тоглоом тоглох зорилгоор интернэт ашигладаг гэж хариулсан ба 2013-2017 оны хооронд Сэтгэцийн эрүүл мэндийн төвд 281 хүүхэд цахим тоглоомд донтож эмчлүүлсэн нь[11] сэтгэл эмзэглүүлж байна.

3. ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЛЭГ ХАНДЛАГА

3.1. Өсвөр үеийнхний интернет ашиглахыг сурсан байдал



Сурагчдын 41.2 хувь нь интернэт ашиглахыг өөрөө болон эцэг эхээсээ сурсан бол дөнгөж 17.6 хувь нь хичээлээр л энэ талын мэдлэгийг олж авсан гэж хариулжээ. Энэ нь ЕБС-ын мэдээллийн технологийн хичээлээр энэ талын зөв мэдлэг хангалттай хэмжээнд өгч чадахгүй байгааг харуулж байна.


3.2. Цахим орчинд хүүхдийн дотны туслагч хэн бэ?



Цахим орчинд хүүхдүүдийн хамгийн дотны туслагч нь үе тэнгийн найз нөхөд гэж дийлэнх буюу 70.5 хувь хариулсан байхад сургуулийн багш, нийгмийн ажилтан гэж дөнгөж 5.8 хувь нь үзсэн нь хүүхдийн эрхийг ханган хэрэгжүүлэхэд үүрэг хүлээгчид, ялангуяа тэдний хоёрдох гэр болсон ЕБС цахим хэрэглээний мэдлэг ойлголтыг өгөх талаарх үйлчилгээг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.


[11] https://moh.gov.mn/news/4762

3.3. Цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргооны мэдлэгийн түвшин, хувиар




Сурагчдын 52.9 хувь нь цахим орчинд хувийн нууц мэдээллээ хамгаалах тохиргооны ахисан түвшний мэдлэгтэй гэж хариулжээ. Харин 41.1 хувь нь дунд, 12 хувь нь анхан, 6 хувь нь огт мэдэхгүй гэж хариулсан байна.

3.4. Хүүхдүүд фейсбүүкийн хэдэн хаяг ашигладаг эсэх, хувиар




Сошиал орчинд Фейсбүүк хэрэглэдэг дөрвөн хүүхэд тутмын нэг нь хоёр ба түүнээс дээш хаягтай байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Элдэв санаагүй хүүхдүүд олон хаяг нээх нь хувийн мэдээллээ бусдад алдах, үүнээс болж бусдад ямар нэг хэлбэрээр хүчирхийлэл, тохуурхалд өртөх зэрэг эрсдэлд оруулж болзошгүй. Нөгөө талаар олон хаягтай байх нь санамсаргүй үйлдэл биш бөгөөд цахим орчинд хэн нэгнийг гутаан доромжилсон, садар самуунд уруу татсан, татагдсан, гэмт хэргийн шинжтэй аливаа үйлдлүүд нь ихэвчлэн өөрийн нэр хаяг, зураггүй профайлаас үйлдэгдэж байгаа тул фейсбүүкийн хуурамч хаягуудыг Монгол улс нэн даруй хориглох шаардлага амьдралаас урган гарч байгааг дурдах нь зүйтэй.

3.5. Хүүхдүүд цахим орчинд танихгүй хүнтэй чаталж байсан эсэх, хувиар




Хоёр хүүхэд тутмын нэг нь интернэтээр танихгүй хүнтэй танилцаж байсан гэж хариулсан нь сүүлийн жилүүдэд цахим хэрэглээ өргөжихийн хэрээ интернэт болзоо нь зөвхөн насанд хүрэгчдэд хамаатай асуудал биш болсныг харуулж байна. Энэхүү үзүүлэлт нь өсвөр үеийнхэн цахим гэмт хэргийн хохирогч болох нэг шалтгаан мөн.

3.6. Найзуудаа цахим орчинд шоолж тоглох дүрс бичлэг оруулж байсан эсэх, хувиар



Таван хүүхэд тутмын нэг нь үе тэнгийн найз нөхдөө цахим орчинд шоолж тоглосон дүрс бичлэг оруулж байсан гэж үзсэн нь цахим орчны зөв зохистой хэрэглээний мэдлэг, ойлголт тэдэнд дутагдаж байгааг харуулж байна.


3.6. Хүүхдүүд найзын хүсэлт авахдаа хэнийг нэмдэг вэ, хувиар



Фейсбүүк хэрэглэхдээ таван хүүхэд тутмын нэг нь таньдаггүй хүний найзын хүсэлтийг хүлээж авдаг байна. Энэ нь хувийн мэдээллээ бусдад алдах үүнээс болж өөрийгөө ямар нэг хэлбэрээр эрсдэлд оруулж болзошгүй байна.


4. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

4.1. Фейсбүүкээр зүй бус утгатай зурвас и-мейл авч байсан эсэх, хувиар




Сурагчдын 76.4 хувь нь цахим сүлжээгээр зүй бус утгатай зурвас, и-мэйл авч байсан бол 23.6 хувь нь үгүй гэж хариулжээ. Түүнчлэн зүй бус зурвас, и-мэйлийн агуулгад гутаан доромжилж нэр төрд халдаж, дарамталсан, хувийн мэдээллийг нууцыг задруулсан, гэмт хэрэгт уруу татах зэрэг үйлдлүүд зонхилж байна.

4.2. Ямар хэлбэрийн заналхийлсэн зурвас түгээмэл авч байсан бэ?



Зүй бус зурвас, и-мэйлийн агуулгад гутаан доромжилж нэр төрд халдаж, дарамталсан зурвас зонхилж байна.

4.3. Садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тааралдаж байсан эсэх, хувиар



Хүүхдүүдийн дийлэнх буюу 76 хувь нь садар самууныг сурталчилсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралдаж байсан гэж хариулжээ. Өсвөр насныхан нь аливаа зүйлийн үр дагавар нь ямар байхыг нягталж үзэлгүйгээр хийж үзэхийг эрмэлздэг ба сониуч байдлаар тэдгээр линкээр нэвтэрч хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүний наймааны золиос болох эрсдэл өндөр байна.

4.4. Эцэг эх интернет хэрэглээний цаг агуулгад хяналт тавьдаг эсэх, хувиар




Хүүхдийнхээ цахим хэрэглээнд эцэг эхчүүдийн 76.4 хувь нь их бага хэмжээнд хяналт тавьдаг нь гэсэн боловч цахим сүлжээ хэрэглэх мэдлэг, чадвар маш муу байлаа.

4.5. Цахим орчинд гутаан доромжлуулах, ялгаварлан гадуурхагдвал хэнд хандах вэ, хувиар



Цахим орчинд хэн нэгэнд гутаан доромжлуулах, ялгаварлан гадуурхагдвал ердөө 5.8 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандана, 11.7 хувь нь найз нөхөдтэйгөө зөвлөлдөн гэж үзсэн байхад сургуулийн багш, нийгмийн ажилтанд хандана гэж хэн ч хариулаагүй байна. Түүнчлэн энэ тохиолдол юу ч хийхгүй гэж 35.3 хувь нь үзэж байгаагаас харахад тус чиглэлээр мэдлэг олгох сургалт, зөвлөгөө зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.


4.6. Та цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар өмнө нь сонсож байсан уу?



Судалгаанд хамрагдсан нийт суралцагчдын 96.9% нь цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар өмнө сонсож байсан буюу тийм гэсэн хариулт өгсөн болох нь дээрх графикаас

харагдаж байна. Харин нийт суралцагчдын 0.4% буюу хамгийн бага хувийг цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар өмнө сонсож байгаагүй гэсэн хариултыг өгсөн байна. Энэхүү үзүүлэлтээс харахад суралцагчдын ихэнх хувь нь цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар сонсож байсан нь тухайн төрлийн гэмт хэрэг нь нийгэмд илүү их даамжирч тархсан байгааг илтгэж байна.

4.7. Хэрэв тийм бол цахим луйвар болон залилах дараах гэмт хэргүүдээс алинд нь өртөж байсан бэ? /олон сонголттой/



Цахим гэмт хэрэг, луйвар, залилан зэрэг өртөж байсан суралцагчид тухайн гэмт хэрэгт дараах байдлаар өртсөн байна. Тухайлбал суралцагчдын 45.3% бусад, 25% онлайн дэлгүүрээс бараа захиалсан боловч хугацаандаа ирээгүй, 23.4% онлайнаар хүнд мөнгө зээлдүүлээд буцаан авч чадаагүй, 12.5% хувийн мэдээллээ алдсаны улмаас санхүүгийн хохирол амссан, 3.1% хувийн мэдээллээ алдсаны улмаас сэтгэл зүйн дарамтад өртсөн

гэсэн үзүүлэлтүүд гарсан байна. Үүнээс үзэхэд тухайн гэмт хэрэгт өртсөн суралцагчдын дийлэнх нь бусад буюу 45.3%-ийг эзэлж байгаа нь өөр өөр төрлөөр мөн энэхүү хэрэг нь үйлдэгдэж буйг илтгэж байна.

4.8. Цахим луйвар болон залилах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?



Нийт судалгаанд оролцсон суралцагчдын 85% нь цахим луйвар болон залилах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар тодорхой хэмжээний өөрсдийн хариултыг өгсөн байсан. Тухайлбал, аюулгүй байдлыг сайтар чандлан сахих, хариуцлагатай болгоомжтой байх, өөрсдийн хувийн мэдээлэл зэрэгт нууцлалын зэрэглэлийг сайтар хангах мөн хэн нэгэнд хэт их итгэж болохгүй гэх мэт дараах түгээмэл хариултуудыг өгсөн. Харин судалгаанд оролцогчдын 15% нь цахим гэмт хэргээс хэрхэн

урьдчилан сэргийлэх, ямар арга хэмжээ авах зэрэг талаар мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байсан. Энэ нь суралцагчид цахим гэмт хэргийн талаар мэдлэг ойлголт хомс буйг илтэж байна. Үүнээс үүдэн тухайн гэмт хэрэг бий болох гол шалтгаан нь болж байна.

Судалгааны дүн шинжилгээ:

	Цахим гэмт хэрэг, залилан, луйварт өртсөж байсан эсэх				
	Тийм	%	Үгүй	%	P утга
Эр	13	0.54	9	0.23	0.12
Эм	11	0.46	31	0.78	0.48
Total	24	1	40	1	**0.26**

Conditional probability: Bayes' Theorem

$$P(A|B) = \frac{P(B|A)\,P(A)}{P(B)}$$

Байесийн теорем нь тухайн үйл явдалтай холбоотой байж болох нөхцөл байдлын талаарх өмнөх мэдлэг дээр үндэслэн үйл явдлын магадлалыг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл нэмэлт мэдээлэл өгөгдсөнөөр магадлалыг дахин томьёолох арга юм. Энэхүү теоремыг ашиглан судалгаанд оролцогчдыг цахим гэмт хэрэг, залилан, луйварт өртөж буй болон өртөөгүй эсэхийг хүйсийн байдлаар нь ангилан шинжилгээ хийлээ. Нийт 64 суралцагчийг тус судалгааны оролцогчоор санамсаргүй байдлаар сонгосон бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн 24 суралцагчдын 13 нь эрэгтэй, 11 нь эмэгтэй суралцагч байсан. Бидний судалгаагаар цахим гэмт хэрэг, залилан луйварт өсвөр насныхны хүйсээс хамаарах магадлалын P утга 0.26-тай гарч энэхүү гэмт хэрэгт өртөх магадлал хүйсээс ямар нэгэн хамааралгүй болохыг харуулж байна.

	Цахим гэмт хэрэг, залилан, луйварт өртсөж байсан				
	Тийм	%	Үгүй	%	P утга
Цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар өмнө нь сонсож байсан	24	1.00	38	0.95	0.95
Цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар өмнө нь сонсож байгаагүй		0.00	2	0.05	0.95
Нийт	24	1	40	1	**1.00**

Нийт 64 судалгаанд оролцогчдын 62.5% буюу 40 суралцагч цахим гэмт хэрэг, залилан, луйвар зэрэгт өртөж байгаагүй гэсэн үр дүн гарсан ба энэхүү өртөөгүй 40 суралцагчийн 95% буюу 38 суралцагч цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар өмнө нь сонсож байсан бол үлдсэн 0.05% буюу 2 суралцагч энэхүү гэмт хэргийн талаар ямар нэгэн мэдээ мэдээлэл сонсоогүй болохыг бидний судалгааны үр дүн харуулж байгаа юм. Үүнийг дүгнэн үзэхэд цахим гэмт хэрэг, залилан луйварт өртөх магадлал тухайн хүний мэдлэг, өмнө нь энэ талаар мэдээлэлтэй байсан эсэхээс шууд хамаарч байгаа болно. Үүнийг Байесийн теорем ашиглан шалган үзэхэд P утга 1 гарсан нь тухайн гэмт хэрэг мэдлэг боловсролтой шууд хамааралтай болохыг баталж байна.

H1 таамаглал	Байесийн теорем	Няцаагдсан
H2 таамаглал	Байесийн теорем	Дэмжигдсэн

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ:

1. Бидний судалгааны үр дүнд өсвөр насны хүүхдүүдийн интернэтийн хэрэглээ маш өндөр байгаа нь ажиглагдлаа. Судалгаанд оролцсон хоёр сурагч тутмын нэг нь өдөрт 2- с дээш цагийг интернэт ашиглахад зарцуулдаг ба тэдэнд цахим орчинтой холбоотой сөрөг зүйлс бий болох үед юуны түрүүнд найз нөхдөдөө ханддаг болох нь судалгаагаар илэрсэн. Үүнээс үзэхэд эцэг эхчүүд хүүхдийнхээ цахим орчны хэрэглээг тодорхой хэмжээнд хянаж хараа хяналтыг цаг тухай бүрд тавих нь зүйтэй.
2. Нийт судалгаанд оролцогчдын цахим гэмт хэрэгт өртсөн байдлыг хүйсийн байдлаар авч үзэхэд 56% эрэгтэй, үлдсэн 46% эмэгтэй байсан нь цахим гэмт хэрэг, луйвар, залилан зэрэгт өртөгдөж буй үйл явц хүний заяагдмал шинж чанар болох хүйсийн байдлаас үл шалтгаалж буйг харуулж байна. Тиймээс энэхүү гэмт хэрэгт өртөж буй хүмүүсийг эр, эм гэж ангилахаас илүүгээр тухайн хүн энэхүү цахим гэмт хэргийн талаар хэр мэдлэг мэдээлэлтэй байгаа талаас нь судалж үзвэл илүү үндэслэлтэй үр дүнд хүрнэ.
3. Бид судалгаагаараа өсвөр үеийнхний мэдлэг мэдээллийн түвшин, цахим гэмт хэрэгт өртөх магадлалд хэрхэн нөлөөлж буйг мэдэхийг зорьсон ба шинжилгээний үр дүнд нийт санамсаргүй байдлаар сонгосон 64 оролцогчдын 62.5% буюу 40 суралцагч цахим гэмт хэрэг, залилан, луйвар зэрэгт өртөж байгаагүй гэсэн үр дүн гарсан ба энэхүү өртөөгүй 40 суралцагчийн 95% буюу 38 суралцагч цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар өмнө нь сонсож байсан бол үлдсэн 0.05% буюу 2 суралцагч энэхүү гэмт хэргийн талаар ямар нэгэн мэдээ мэдээлэл сонсоогүй болохыг бидний судалгааны үр дүн харуулсан. Үүнийг дүгнэн үзэхэд цахим гэмт хэрэг, залилан луйварт өртөх магадлал тухайн хүний мэдлэг, өмнө нь энэ талаар мэдээлэлтэй байсан эсэхээс шууд хамаарч байгааг илтгэж байна.
4. Бидний судалгаагаар гурван хүүхэд тутмын хоёр нь интернэтээр танихгүй хүнтэй танилцаж байсан гэх үр дүн гарсан. Үүнээс үзэхэд нийт 64 оролцогчдын 42 оролцогч өмнө нь огт танихгүй хүнтэй интернэт ашиглан танилцаж байсан нь батлагдаж байгаа бөгөөд харьцангуй өндөр тоо юм. Тиймээс бид юуны түрүүнд аливаа зүйлд өөрсдөө илүү анхаарал болгоомж, хариуцлагатай байх нь чухал юм.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТЭД ҮНДЭСЛЭН ШИЙДВЭРЛЭЖ БОЛОХ АРГА ЗАМУУД

Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулахад төрийн зүгээс авах арга зам:

Нэг. Өсвөр үеийнхний цахим гэмт хэрэг, луйвар, залилан зэргээс урьдчилан сэргийлэх талаар боловсролын салбарт авах арга хэмжээ

- Өсвөр үеийнхний 94.1% нь цахим орчинг идэвхтэй ашигладаг хэдий ч

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгад цахим орчинд зохистой оролцох, цахим гэмт хэрэг, луйвар, залилангаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар агуулгад тусгаагүй байгаа нь дутагдалтай тал юм. Иймд ерөнхий боловсролын нийгмийн ухаан, иргэний ёс зүйн хичээлийн сургалтын хөтөлбөрт дээрх агуулгыг тусгаж өгснөөр өсвөр үеийнхний цахим гэмт хэрэг, луйвар, залилан зэргийг бууруулахад чухал нөлөө үзүүлнэ.

Хоёр. Цахим гэмт хэрэг, луйвар, залилан зэрийг бууруулахад эрх зүйн орчныг бүрдүүлэх

Цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй гэмт хэргийг таслан зогсоох, иргэдийг халдлагаас хамгаалахын тулд эрх зүйн орчинг бүрдүүлэх нь нэн түрүүний асуудал болж байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд:

- Эрх зүйн орчинг бүрдүүлэх гол нөхцөл нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, сүүлийн 3 жилийн байдлаар энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүн, халдлагад өртсөн хохирогчийн нийгэм хүн ам зүйн шинж, гэмт хэрэг үйлдсэн орчин нөхцөл зэргийг бүрэн хамруулсан суурь судалгааг мэргэжлийн байгууллагууд хамтран хийх
- Цахим хэрэгсэл ашиглан гэмт хэрэг / бусдыг заналхийлэх, цахим орчинд бусдыг доромжлох, цахим хэрэгсэл ашиглан хүүхдийн эсрэг хууль бус үйлдэл хийх, эрсдэлт нөхцөлд оруулах зэрэг/ үйлдэж байгааг Эрүүгийн хуульд заасан үндсэн гэмт хэргийн хүндрүүлэх шинж болгон тусгах
- Цахим худалдааны эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Энэ төрлийн хэргийг мөрдөн шалгах мөрдөгч, прокурор, шүүгчийг чадавхжуулах
- Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх /Эдгээр байгууллагын 84 гаруй хувь нь хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа насанд хүрсэн хүн мөн эсэхийг асуудаггүй бөгөөд бага насны хүүхэдтэй айлд сөрөг мэдээллийг шүүгч программыг заавал суулгуулах шаардлагатайг мэдээлэх үүргээ биелүүлээгүй талаар “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал” судалгааны тайлан”-д дурдсан байна.
- Цахим орчинд хүүхдийн эсрэг чиглэсэн аливаа төрлийн хүчирхийлэл, хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллийг зориуд түгээсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчлах шаардлагатай.

Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулахад бидний зүгээс хийж чадах арга зам:

Гурав. Цахим орчин дах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон видео шторк, постер, санамж, сурталчилгаа, контент зэргээр дамжуулан өсвөр үеийнхэнд мэдлэг мэдээллийг түгээх

- Өсвөр насны хүүхдүүдийн ихэнх хувь нь facebook, youtube, instagram зэрэг платформуудыг түлхүү ашигладаг бөгөөд энэхүү цахим сувгуудаар дамжуулан цахим гэмт хэрэг, залилан, луйвар зэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар тэдний нас сэтгэхүйн онцлогт тохирсон видео, шторк, постер, санамж, сурталчилгаа, контентоор дамжуулан мэдлэг мэдээллийг олгох.

Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулахад банк санхүүгийн зүгээс хийж чадах арга зам:

Дөрөв. Банк санхүүгийн байгууллагын зүгээс цахим гэмт гэрэг, луйвар, залилан зэргээс урьдчилан сэргийлэх талаар аппликейшнээр дамжуулан мэдлэг мэдээллийг өгөх

- Цахим гэмт хэрэг, луйвар, залилан зэрэг нь интернэт банкны оролцоотойгоор бий болдог үйл ажиллагаа тул банк санхүүгийн байгууллагаас зайлшгүй арга хэмжээ авах нь зөв. Энэхүү үүргийнхээ хүрээнд гүйлгээ хийхийн өмнө санамж зөвлөмж гарч ирдэг болгох хэрэгтэй.

Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулахад өсвөр насныхны зүгээс авах арга зам:

- Найдвартай, хууль ёсны эх сурвалжийн мэдээллийг ч ямагт нягталж, вебсайтаар нь зочлох, мэдээллийн ажилтнаас мэдээлэл авах
- Сошиал хаяг, банкны апп-ын нэвтрэх нууц үгийг “том, жижиг үсэг, тоо, тусгай тэмдэгт” оролцуулсан төвөгтэй байдлаар зохиох. “Two-factor authentication” буюу хоёр хүчин зүйлт баталгаажуулалтыг идэвхжүүлэх.
- Банкны гүйлгээний мэдээллийг апп болон мессежээр авч, мэдэгдэл бүрийг нягталж байх. Хэрэв сэжигтэй гүйлгээ гарсан тохиолдолд тэр даруй банктайгаа холбогдож дансаа хаалгах. Онлайнаар төлбөр тооцоо, гүйлгээ хийхдээ “URL” цонхны зүүн талд харагдах статус “Trusted”, “Secured” байгаа эсэхийг нягталж байх
- Нийтийн “Wi-Fi” сүлжээ ашиглахгүй байх. Ашигласан тохиолдолд сошиал медиа, банкны апп хэрэглэхгүй байх нь чухал юм. Онгоцны буудал, кофе шопын зэрэг нийтийн “Wi-Fi” хэрэглэхдээ заавал “VPN” ашиглах
- Сошиал орчинд өөрийн хувийн мэдээллээ хуваалцах нь хадлага үйлдэгч нарт бэлэн хоол өгч байгаагаас ялгаагүй юм. Иймээс “Messenger”, “Viber”, “Telegram”, “WhatsApp” зэрэг мессеж апп-аар ойр дотнынхоо хүнтэй харилцахдаа бичсэн нууц үг, хувийн болон санхүүгийн мэдээллээ хуваалцаж

байсан бол устгах

- Цахим луйвар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж тааралдвал цаг гарган уншиж, мэдлэг ойлголттой байх
- Хувийн болон байгууллагын ухаалаг төхөөрөмжүүдийн үйлдлийн системийг хамгийн сүүлийн хувилбараар тогтмол шинэчилж байх. Албан ёсны лицензтэй программ хангамж ашиглах. Компьютер болон гар утсандаа вирусийн эсрэг программ хангамж суулгах

Эх сурвалж

[1] https://www.isd.gov.mn/?id=241 Мэдээллийн аюулгүй байдлын газар

[2] https://gia.gov.mn/49/item/643. Тагнуулын Ерөнхий газар

[3] https://schollufsin.ru/mn/razvod/kiberprestupleniya-v-rf-chto-takoe-kiberprestupnost-pod- odin/

[4] Европын олон улсын гэрээний цуврал- Дугаар 185. Цахим гэмт хэргийн тухай конвенци

[5] https://vip76.mn/content/77439

[6] ЦЕГ-ын мэдээлэл 2021

[7] “ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЦАХИМ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН, 2018 он

[8] Харилцаа холбооны зохицуулах хороо. Статистик мэдээ. Улаанбаатар: 2018

Хавсралт 1

Судалгааны асуулт:

Сайн байна уу? Таны мэдээллийн нууцыг "Хувь хүний нууцын тухай" болон "Монгол Улсын Үндсэн хууль"-ийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу нууцлан хадгална. Та энэхүү судалгаанд үнэн зөв хариулт өгч оролцоноор хүүхдийг цахим хүчирхийллээс хамгаалахад шаардлагатай үндсэн мэдээллийг бүрдүүлэх болно.

№	Асуулт	Хариулт	
1	Нас	14 15 16	1 2 3
2	Хүйс	Эрэгтэй Эмэгтэй	1 2
3	Та интернет хэрэглэдэг үү ?	Тийм Үгүй	1 2
4	Та интернет ашиглахыг хэнээс суралцсан бэ ?	Өөрөө Найз нөхөд Эцэг эх Хичээлээр	1 2 3 4
5	Цахим орчинд зөвлөгөө, мэдээлэл хэрэгтэй үед хэн таны дотны туслагч вэ ?	Эцэг эх, гэр бүлийн гишүүд Багш, нийгмийн ажилтан Найз нөхөд, үе тэнгийнхэн Бусад	1 2 3 4
6	Өдөрт дунджаар хэдэн цаг интернет хэрэглэдэг вэ ?	1 хүртэлх цаг 1-2 цаг хүртэл 2-4 цаг хүртэл 4 болон түүнээс дээш цаг	1 2 3 4
7	Ямар төхөөрөмж ашиглан интернет хэрэглэдэг вэ ?	Ухаалаг утас Таблет Компьютер Смарт телевизор Бусад	1 2 3 4 5
8	Интернетэд холбогдох эх үүсвэр юу в	Гар утасны дата Гэрийн WIFI Гар утасны дата болон WIFI Интернет кафе	1 2 3 4

9	Хамгийн их ашигладаг аппликейшны нэрлэнэ үү (хамгийн чухал 2 хүртэлх хариултыг сонгоно уу)	Фейсбүүк Инстаграмм Youtube Твиттер Snapchat, wechat Цахим тоглоом И-мэйл Google account Бусад	1 2 3 4 5 6 7 8 9
10	Facebook-ийн хэдэн хаягтай вэ?	Нэг Хоёр Гурваас дээш	1 2 3
11	Та интернэтийг ихэвчлэн ямар агуулг хэрэглэдэг вэ?	Найз нөхдийн харилцаа Мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээж авах Хэрэгтэй бичлэг, клип, кино хайх Хичээлтэй холбогдолтойгоор ашиглах Тоглоом татах, хайх Бусад	1 2 3 4 5 6
12	Фейсбүүкт ирсэн найзын хүсэлтийг хүлээж авахдаа	Таньдаг хүн нэмдэг Таньдаггүй хүн нэмдэг Таньдаг болон таньдаггүй хүн нэмдэг	1 2 3
13	Та заналхийлсэн, үзэн ядсан, гутаан доромжилсон гүтгэлэг зурвас и-мэйл фэйсбүүкболон бусад олон нийтийн сүлжээний хэрэглэгчдээс авч байсан	Тийм Үгүй	1 2
14	Хэрэв тийм бол дараах сонголтуудаа дугуйлна уу?	Гутаан доромжилсон үгтэй сэтгэгдэл Дарамталсан үг зурвас Хувийн мэдээллийг нийтэд тараах Гэмт хэрэгт уруу татагдах	1 2 3 4
15	Интернетэд садар самууныг сурталчилсан, уруу татсан агуулга бүхий мэдээлэлт тааралдаж байсан уу ?	Тийм Үгүй	1 2
16	Та цахим орчинд танихгүй хүнтэй ча байсан уу ?	Тийм Үгүй	1 2
17	Үе тэнгийн найз нөхдөө цахим орчин шоолох, тоглох зэргээр сэтгэгдэл бич зураг, дүрс бичлэг оруулж байсан уу	Үргэлж Заримдаа Огт үгүй	1 2 3
18	Та цахим орчинд хувийн нууц, мэдээлэлээ хамгаалах тохиргоог хэрхэн хэрэглэ вэ?	Анхан Дунд Ахисан Мэдэхгүй	1 2 3 4

19	Таны эцэг эх интернэт хэрэглээний ц агуулга зэрэгт ямар нэг хяналт тавих оролдож байсан уу?	Үргэлж Заримдаа Огт үгүй	1 2 3
20	Таныг хэн нэгэн цахим орчинд гутаа доромжилж ялгаварлан гадуурхвал та үүний эсрэг ямар арга хэмжээ авах вэ	Найз нөхөдтэйгээ зөвлөлдөнө Эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хандах Сургуулийн багшид мэдэгдэнэ Хүүхдийн тусламжийн 108 утасны төвд хандах Юу ч хийхгүй	1 2 3 4 5
	Та цахим луйвар болон залилах гэмт хэргийн талаар өмнө нь сонсож байсан уу?	Тийм Үгүй	1 2
	Хэрэв тийм бол цахим луйвар болон залилах дараах гэмт хэргүүдээс алин өртөж байсан бэ?	Онлайн дэлгүүрээс бараа захиалсан хугацаандаа ирээгүй Онлайнаар хүнд мөнгө зээлдүүлээд буцаан авч чадаа Хувийн мэдээллээ алдсаны улмаас санхүүгийн хохирол амссан Хувийн мэдээллээ алдсаны улмаас сэтгэл зүйн дарам өртсөн/зураг, видео бичлэг гэх мэт/ Хонжворт тоглоом Бусад	1 2 3 4 5
	Цахим луйвар болон залилах гэмт хэ хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?		

ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭХ БАЙДЛААР ДАМЖУУЛАН МӨНГӨ УГААХ ЭРСДЭЛ, ХУУЛЬ ТОГТООМЖ БА ИНСТИТУТИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

Б.Одонтунгалаг[*], Л.Энхсайхан[**]

** Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн ухааны доктор. И-мэйл: odontungalag_b@num.edu.mn, Утас: 99119461,*

***Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн 5 дугаар түвшний оюутан. И-мэйл: enkhsaikhan518@gmail.com, Утас: 91220384*

ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улсад сүүлийн жилүүдэд цахим орчинд “Залилах” гэмт хэргийг үйлдэх нь тогтмол өсч үүнийгээ дагаад энэ гэмт хэрэг нь “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох тохиолдол эрсдэл бодитойгоор бий болж байна. Уг асуудлын мөн чанарыг тодорхойлж, аливаа гарц шийдэл олохын тулд судлаачийн хувьд Хууль, ОУГ-г дүгнэх, практик асуудлыг олж илрүүлэх, уг асуудлыг шийдвэрлэх оновчтой гарц, шийдлийг олсон улсуудтай харьцуулсан судалгааг хийсэн юм.

Манай Улсад “Мөнгө угаах” болон цахим залилангийн гэмт хэргийг Эрүүгийн хууль, эрүүгийн процессын хууль бусад хуулиуд, Монгол Улсын нэгдэн орсон ОУГ-нүүдээр хориглож, энэ нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Гэсэн хэдий боловч судалгаанд хөндөж буй асуудлыг нарийвчлан зохицуулах бус ерөнхий шинжтэй хуульчилсан нь судалгааны явцад харагдсан. Угтаа бол цахим хэлбэрээр үйлдэгдэж буй гэмт хэрэг нь уламжлалт гэмт хэргээс эрс ялгаатай, илрүүлэх этгээд нь мэргэшсэн, техник, технологийн давуу талыг ашиглах ёстой. Энэ төрлийн эрх зүйн харилцааг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай юм. Шүүхийн практикийг судлаад үзвэл цахим залилангийн гэмт хэрэг суурилсан “Мөнгө угаах” гэмт хэрэг үйлдэгдэж буй бөгөөд улам бүр нэмэгдэх эрсдэл байгаа нь ажиглагдсан. Эрүүгийн хуулийн зүйлчлэлийн хувьд практикт үүсээд асуудал бол цахим залилангийн хэрэг бүрт хохирлын хэмжээ, гэмт хэргийг үйлдсэн зорилго зэргийг үндэслэхгүйгээр бүх гэмт хэргийг хамааруулж байгаа юм.

Харьцуулсан судалгааны хүрээнд авч үзсэн ХБНГУ, Сингапур улсуудыг өөрийн улстай харьцуулан судалсан. Эдгээр улсууд цахим залилангийн гэмт хэрэг, мөнгө угаах гэмт хэргүүдэд маш сайн хяналт тавьдаг бөгөөд олон улсын байгууллагуудаас сайн үнэлгээг авдаг. Үүний учир нь гэвэл нарийвчилсан зохицуулсан хууль тогтоомж болон институтийн хувьд маш сайн гэдэг нь ажиглагдсан.

ТҮЛХҮҮР ҮГС

Залилах гэмт хэрэг, Мөнгө угаах гэмт хэрэг, Залилах гэмт хэргийг цахим орчинд үйлдэх, Институт

I. УДИРТГАЛ

2020 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд тусгайлан хуульчилсан “Залилах” гэмт хэргийг цахим орчинд үйлдэгдэх тохиолдол тогтмол ихэссээр байна. Тухайлбал манай улсад 2024 оны эхний 2 сарын байдлаар цахим орчинд үйлдсэн 7560 гэмт хэрэг бүртгэгдсэний 83 хувь нь кибер залилан байна.[1] Мөн түүнчлэн 2023 оны 11-р сард цахим залилан, цахим халдлага, цахим мөрийтэй тоглоом гэсэн 3 гэмт хэргийн өсөлтөөс шалтгаалан ЦЕГ-ын харьяа “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв”-ийг нээн ажиллуулж буй юм[2]. Гэвч практикт залилах гэмт хэргийн цахим хэлбэрээр үйлдэгдэх тоо буурах бус улам нэмэгдсээр байна.

Залилах гэмт хэргийн үр дүнд их хэмжээний хууль бусаар олсон орлого төвлөрөх, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах бөгөөд уг мөнгөний хууль бус эх үүсвэрийг нуун далдлах зорилгыг агуулдаг нь “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох эрсдэл тун өндөр байгааг харуулдаг. Мөнгө угаах гэмт хэргийн хувьд эдийн засаг, татварын системийн тогтвортой байдлыг алдагдуулах, олон улсын аюулгүй байдалд заналхийлэх зэрэг ноцтой хор, аюулыг бий болгодог билээ. Тиймээс судлаачийн хувьд өөрийн суралцаж буй хууль зүйн шинжлэх ухаанд үндэслэн гарц, гаргалгааг олохыг зорилоо.

Энэхүү эрдэм шинжилгээний судалгаа нь онолын, практик, харьцуулсан гэх судалгааны үндсэн гурван хэсэгтэй. Үүнд:

1. Хууль, ОУГ-нд хийсэн судалгааны хэсэг-Залилах, Мөнгө угаах гэмт хэргүүдийн бүрэлдэхүүн шинж, мөн чанарыг тодорхойлж хууль, тогтоомжид зохицуулагдсан байдалд дүгнэлт өгнө. Мөн түүнчлэн хуулийн хийдэл бий эсэхийг олж тогтооно.

2. Практик судалгааны хэсэг-Монгол Улсын хэмжээнд 2017 оноос хойш эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн цахим хэлбэрээр үйлдэгдсэн “Залилах” суурь гэмт хэрэгтэй “Мөнгө угаах” гэмт хэрэг үйлдсэн хэрэгт дүн шинжилгээ хийнэ.

3. Харьцуулсан судалгааны хэсэг-Харьцуулсан судалгааны хүрээнд Базелийн индексээр мөнгө угаах эрсдэл багатай, хууль тогтоомж боловсронгуй ХБНГУ, Сингапур Улсын сайн туршлагыг өөрийн улстай харьцуулан дүгнэлт хийх зорилго дэвшүүлсэн.

II. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1. Хууль, ОУГ-нд хийсэн судалгааны хэсэг

Манай улсын хувьд техник, технологийн хөгжлийг амьдралд нэвтрүүлэх, тэрхүү технологийн дэвшлийг иргэдэд хүртээмжтэй, түргэн шуурхай, аюулгүй хүргэх ажлын хүрээнд 2019 онд Монгол Улсын Засгийн газраас “Цахим хөгжлийн

[1] “**Цахим орчинд үйлдсэн гэмт хэргийн 80 гаруй хувь нь залилан байна**” цахим нийтлэл- https://montsame.mn/mn/read/339416

[2] “Б.Энхбаяр “**Сүүлийн таван жилд цахим залилангийн гэмт хэрэг 15 дахин нэмэгдсэн**” цахим нийтлэл-https://www.newswire.mn/n/30649

үндэсний хороо”-г байгуулсан. Түүнчлэн 2021-2024 онд “Digital nation” буюу “Цахим үндэстэн” болох зорилтыг тавин ажиллаж байна. Тиймдээ ч Монгол Улсад 2023 оны байдлаар интернэт хэрэглэгчдийн тоо 4.3 сая гаруй интернэт хэрэглэгч байна.[3] Тэгэхээр интернэт орчинг Монгол Улсын хүн амтай харьцуулбал мэдээлэл авах гол эх үүсвэр гэж хэлж болно. Тэгвэл энэхүү харилцааг зохицуулж, хамгаалж буй хууль, тогтоомжид цахим гэмт хэрэгтэй зохицуулалт хэрхэн хуульчлагдсаныг, онолын түвшинд авч үзье.

Хүснэгт №1 Хууль, тогтоомж, ОУГ-нд зохицуулагдсан байдал

№	Хуулийн нэр, хуулийн зохицуулалт	Онолын асуудал
1.	***Эрүүгийн хууль (2015)*** 17.3. Залилах гэмт хэрэг (Цахим хэрэгсэл ашиглах-Урьдач нөхцөл) 18.6. Мөнгө угаах гэмт хэрэг	Залилах гэмт хэргийн объект нь бусдын өмчлөх эрх байх бол Мөнгө угаах гэмт хэргийн объект нь банк санхүүгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, мөнгө угаах болон, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа байна.[4] Онолын хувьд үүсдэг асуудал нь ахуйн шинжтэй залилах гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэж үзэх эсэх талаарх юм. Судлаачийн хувьд дээрх 2 гэмт хэргийн объектуудын харилцан хамаарлыг тодорхойлох замаар мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт залилах гэмт хэргийг хамааруулах ёстой юм.
2.	***Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)***	Цахим хэлбэрээр үйлдэгдэж буй залилангийн гэмт хэрэг болон Мөнгө угаах гэмт хэргийн илрүүлэх, олж тогтоон ял оногдуулах зорилттой эрүүгийн процессын хууль юм. Уг хуульд зааснаар дээрх гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэхэд тусгай журам үйлчлэхгүй юм.
3.	***Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021)***	Уг хууль нь Монгол Улсын хэмжээнд кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой төр, хувь хүн хуулийн этгээдийн хоорондын харилцааг зохицуулна. Энэ хуулийг зөрчвөл Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээнэ.
4.	***Шүүх шинжилгээний тухай хууль (2022)***	Шүүх шинжилгээний тухай 2022 оны хууль нь тун онцлог шинжтэй бөгөөд “Цахим технологийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага”-ыг тусгасан байна. Мөн түүнчлэн цахим технологийн шинжилгээ хийх журмыг батлах субъектийг тодорхойлсноороо өмнөх хуулиас дэвшилттэй болсон.

[3] Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн вебсайт “**Нийт интернэт хэрэглэгчдийн тоо**”- https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1300_012V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table

[4] С.Гантулга, Б.Энхболд “**Эрүүгийн эрх зүй тусга**й анги” сурах бичиг УБ (2020) 194 дэх тал

5.	***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)***	Энэхүү хуулиар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ерөнхий зохицуулалтыг хуульчилсан. Хуулийг судлаад үзвэл Монгол банкны "Санхүүгийн мэдээллийн алба"-ны чиг үүрэг, эрх зүйн байдлыг тусгасан. Тухайлбал Мэлээллийн алба эцсийн өмчлөгчийг тогтоох, сэжигтэй гүйлгээг хянах зэрэг эрхтэй байна.
6.	***Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц (1988)***	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих энэхүү конвенцид Монгол Улс 2003 онд нэгдэн орсон. Энэхүү конвенцийн зорилго нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, олон улсын хамтын ажиллагааг дэмжих зорилготой.
7.	***Авилгын эсрэг НҮБ-ын конвенц (2003)***	Монгол Улс 2005 онд НҮБ-ын Авилгын эсрэг конвенцийг соёрхон баталсан. Уг конвенцийн үнэлгээг хамгийн сүүлд 2024 онд хийсэн байна. Энэ конвенцийн зорилго нь авилгаас урьдчилан сэргийлэх, шударга байдлыг бэхжүүлэх зорилготой.

2.1. Хэсгийн дүгнэлт

Монгол Улсад цахим залилангийн гэмт хэргээр суурилан мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг хууль, тогтоомжоор зохицуулах системчилсэн хууль, тогтоомж болон нэгдэн орсон олон тооны ОУГ хүчин төгөлдөр үйлчилж байна. Гэвч эдгээр хууль, тогтоомжууд нь нарийвчилсан зохицуулалт агуулаагүй нь ажиглагдсан. Мөн түүнчлэн цахим залилангийн гэмт хэргийг эрүүгийн процесст хэрхэн авч үзэх эсэх нь тодорхойгүй байгаа юм.

Товчхондоо цахим залилангийн гэмт хэрэг гэлтгүй бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эрх зүйн боловсронгуй зохицуулалт нь нэн чухал үүргийг гүйцэтгэдэг хэдий ч өнөөгийн Монгол Улсын түвшинд мэдээллийн аюулгүй байдлын болон мэдээллийн өгөгдлийг хамгаалах тухай хууль тогтоомж боловсронгуй биш байна.

2.2. Практик судалгааны хэсэг

Практик судалгааг хийхийн тулд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд үндэслэн шийдвэрлэгдсэн цахим хэлбэрээр үйлдэгдсэн залилангийн гэмт хэргийн суурьтай "Мөнгө угаах" гэмт хэргээр зүйлчилсэн 5 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийе.

2.2.1. Шинэ фейсбүүк хаяг нээж зохиомол байдлыг бий болгон хүнээс мөнгө шилжүүлж авсан хэрэг

- **Шүүхийн шийдвэр**-Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023.08.29-ний Дугаар 2023/ШЦТ/565 шийдвэр[5]

[5] "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/92302?daterange=2017-01-01%20-%202024-04-27&id=1&court_cat=2&bb=1

- **Хэргийн үйл баримт**-2022 оны 11, 12 дугаар саруудад М, С, Г нар ... гэх фейсбүүк хаягийг нээж контейнер зарна, дизель түлш зарна зэргээр зохиомол байдлыг зориуд бий болгож 9.4 сая төгрөгийг өөрсдийн ... банкны дансанд шилжүүлэн авчээ. Шүүгдэгч Г нь М-ийг зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдөлд оруулан, хууран мэхэлж, 2022 оны 12 дугаар сарын -ны өдөр "Фейсбүүк" цахим хэрэгсэл ашиглан … гэх хуурамч хаяг нээж "Цемент бааз, 42м3 сэгсрэх хүчтэй, яаралтай хямд зарна, үнэ тохиролцоно, бартер сонирхоно, утас 86892312" гэсэн хуурамч зарыг байршуулж тухайн зарын дагуу холбогдсон иргэн Д-ээс Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, 2 хороолол, 1008-3 тоот гэртээ байхад нь Д.гийн Хаан банкны 5302748265 дугаарын дансыг ашиглан 5,400,000 төгрөгийг шилжүүлэн авсныг мэдсээр байж 2,700,000 төгрөгийг авч хувьдаа зарцуулсан байна. Мөн М-ийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр фейсбүүк цахим хуудсанд "Дизель түлш зарна" гэсэн хуурамч зар оруулж, зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдөлд оруулан, хууран мэхэлж, иргэн М-аас 500,000 төгрөгийг шилжүүлэн авсныг мэдсээр байж хувьдаа зарцуулсан нь үйл баримтаар тогтоогдсон.
- **Шийдвэрийн агуулга, үндэслэл**-Хэргийг шүүхээс шийдвэрлэхдээ эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд "Залилах" гэмт хэргийг үйлдсэн гэж үзэн М, С, Г нарыг гэм буруутай гэж үзэн ялласан. Харин М-г гэмт хэрэг, бусдыг гэмт хэрэг үйлдэж олсон мөнгө гэдгийг мэдсээр байж авсан, ашигласан гэх үндэлэлээр 18.6 "Мөнгө угаах" гэмт хэргээр зүйлчилсэн.
- **Дүн шинжилгээ**-Шүүхийн шийдвэрийг ажиглаад байхад цахим хэлбэрээр залилах гэмт хэргийг М, С, Г нар үйлдсэн гэдэгт төдийлөн ямарваа нэг маргаан байхгүй юм. Харин гэмт хэргээс олсон орлогыг хувьдаа авсан, эзэмшсэн гэх нөхцөлд багтаан "Мөнгө угаах" гэмт хэргийн суурь гэмт хэрэг гэж үзсэн нь онолын хувьд маргаантай юм. Учир нь гэмт хэргийг үйлдсэн этгээдүүд нь гэмт хэргээс олсон мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах бус харин өөрийн ахуйн хэрэгцээнд ашигласан байгаа юм. Судлаачдын хувьд "Мөнгө угаах" гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлох, жижиг гэмт хэргүүдийг ялгах шаарлдлагатай гэх зэрэг саналыг дэвшүүлдэг.

2.2.2. Фейсбүүк хаягт хуурамч зарууд байршуулан мөнгө шилжүүлэн авсан залилангийн хэрэг

- **Шүүхийн шийдвэр**-Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.03.24-ний Дугаар 2022/ ШЦТ/279 шийдвэр[6]
- **Хэргийн үйл баримт**-Шүүгдэгч Б.Х, Х.Э, З.Ц, Э.О нар нь хамт түрээсийн байранд амьдарч байхдаа бүлэглэж 2020 оны 9 дүгээр сарын 24-ний

[6] "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/65308?daterange=2017-01-01%20-%202024-04-27&id=1&court_cat=2&bb=1

өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хооронд фейсбүүк цахим орчинд "хуучин хэрэглэж байсан буйдан, гал тогооны тавилга, цахилгаан бараа, зурагт, машин зарна, байр түрээслүүлнэ" гэх зэрэг хуурамч зарууд байршуулан, нийт 54 хохирогчийг хуурч, цахим хэрэгсэл ашиглан, зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдөлд оруулан залилсан гэмт үйлдлүүд хийсэн байна. Тэд бусдыг төөрөгдөлд оруулан 54 удаагийн үргэлжилсэн үйлдлээр нийт 9,690,000 төгрөгийг шилжүүлэн авч залилах гэмт хэргийн улмаас олсон мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж ашиглаж мөнгө угаасан гэмт үйлдэл хийсэн тус тус үйл баримтууд нь доорх хавтас хэрэгт авагдсан бичгийн баримтуудаар тогтоогдсон.

- **Шийдвэрийн агуулга, үндэслэл**-Шүүхээс Б.Х, Х.Э, З.Ц, Э.О нарын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар залилах гэмт хэргийг үйлдсэн гэж шийдвэрлэсэн. Харин Э.О-г гэмт хэргийн улмаас гэмт хэргийн улмаас олсон мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж ашиглаж мөнгө угаасан буюу Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 18.6 дугаар зүйлийн 1 "Мөнгө угаах" гэмт хэрэг үйлдсэн гэж шийдвэрлэсэн.
- **Дүн шинжилгээ**-Ерөнхийдөө энэ шүүхийн шийдвэр нь 2.2.1 дэх шүүхийн шийдвэртэй ижил агуулгатай байна. Цахим хэлбэрээр залилангийн гэмт хэргийг үйлдсэнээс бий болсон орлогыг гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд нуун далдлах зорилго агуулахгүйгээр өөрсдийн өдөр, тутмын хэрэгцээнд зарцуулсан байгаа юм.

2.2.3. Тайланд улсын банкны системд халдаж олсон их хэмжээний мөнгийг, Монгол Улсад эх үүсвэрийг нуун далдалсан хэрэг

- **Шүүхийн шийдвэр**-Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.11.23-ны Дугаар 2022/ШЦТ/1733 шийдвэр[7]
- **Хэргийн үйл баримт**- Шүүгдэгч Х Улсын иргэн Л нь Х, Е, Ж нартай бүлэглэн 2019 оны 09 дүгээр сарын 27-ны Тайландын Вант улсын "СПРП" /S/ компанийн Америкийн Нэгдсэн Улсын "Ш" /CH Inc/ гэх шатахуун үйлдвэрлэгч компанитай харилцаж байсан цахим хаяг буюу мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж, төлбөрийн нэхэмжлэлтэй холбоотой хуурамч мэйлийг Тайландын Вант Улсын "СПРП" /S/ компанийн цахим хаягт "Chevron.com" цахим хаягнаас ирэх байсан нэхэмжлэлийн 1 үсгийг сольж "Chveron.com" хаягаас 22,391,815.46 ам доллар нэхэмжилсэн хуурамч баримтыг хүргүүлэн, цахим сүлжээнд хууль бусаар халдаж, мэдээллийг өөрчлөн, "СПРП" /S/ компанийн хууль ёсны ашиг сонирхолд 22,391,815.46 ам долларын буюу 59,733,302,593.7 төгрөгийн хохирол учруулсан байдаг. Энэхүү мөнгийг "Голомт банк"-ны тоот дансанд "бизнесийн зориулалтаар", "хөрөнгө оруулалт" гэх нэрийдлээр хууль ёсны

[7] "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/86241?daterange=2017-01-01%20-%202024-04-27&id=1&court_cat=2&bb=1

мэтээр халхавчлан шилжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулж Монгол Улсад Тоёота Лексус-570, Тоёота Ланд крузер-200 загварын автомашин тус бүр 2 ширхэг, Тоёота Альфард загварын автомашин 3 ширхэг, Форт еверест загварын автомашин 1 ширхэг, Тоёота Акуа загварын автомашин 1 ширхэг буюу нийт 9 ширхэг автомашин худалдан авсан, өөрсдийн хууль бус үйл ажиллагаа явуулахаар байрлаж байсан орон сууц, оффис, зочид буудлуудын түрээсийн төлбөрийг төлөх замаар, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг ашиглаж байнга тогтвортой үйлдэж мөнгө угаасан гэмт хэргийг зохион байгуулалтай гэмт бүлэг үйлдсэн байна.

- **Шийдвэрийн агуулга, үндэслэл**-Хэргийг шийдвэрлэхдээ шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3.3.1, 17.3.3.3, 18.6.3, 20.3.1 дэх хэсгүүдэд зааснаар тус тус гэм буруутайд тооцож 12 жилийн хорих ял оноосон байна.
- **Дүн шинжилгээ**-Цахим хэлбэрээр залилах гэмт хэрэг нь дан ганц Монгол Улсад үйлдэгдэх бус хил дамнан үйлдэгддэгээрээ уламжлалт залилах гэмт хэргээс эрс ялгаатай гэдэг нь дээрх шийдвэрээс харагдаж буй юм. Шүүхийн шийдвэрийн хувьд Тайланд улсаас цахим хэлбэрээр залилан авсан мөнгийг Монгол Улсад хууль бус эх үүсвэрийг далдлах зорилго агуулсан гэх тайлбарыг хийсэн нь тун оновчтой үндэслэл болжээ. Учир нь "Мөнгө угаах" гэмт хэргийн объектив шинж болох нуун далдлах зорилгыг үйл баримтаар тогтоосон байгаа юм. Ерөнхийдөө цахим залилангаар дамжуулан Монгол Улсад гадаадын иргэн, хуулийн этгээд мөнгө угаах эрсдэл байгааг энэхүү шийдвэр харуулсан гэж хэлж болно.

2.2.4. Холбооны бүгд найрамдах Нигер улсын иргэн болон Монгол улсын иргэд нийлж гэмт бүлэглэл байгуулан цахим залилангийн гэмт хэргээр олж авсан хөрөнгийн эх үүсвэрийг нуун мөнгө угаасан хэрэг

- **Шүүхийн шийдвэр**-Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019.12.02-ны Дугаар 918 шийдвэр[8]
- **Хэргийн үйл баримт**- Нигер улсын иргэн шүүгдэгч Эжикэмэ Жон Чимэзиэ нь Монгол Улсын иргэн Б.Х, Д.Г, Т.А нартай бүлэглэн 2018 оны 6 дугаар сараас 12 сарын хооронд гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудтай ижил нэртэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг Монгол Улсад үүсгэн байгуулж, улмаар гадаадын аж ахуй нэгжийг цахим хэрэгсэл ашиглаж залилах замаар гэмт хэрэг байнга үйлдэж, ашиг олох зорилгоор урьдчилан нэгдэж, Монгол улсын нутаг дэвсгэрт 4 хүнтэй тогтвортой бүлэг байгуулсан. Нигер улсын иргэн шүүгдэгч Эжикэмэ Жон Чимэзиэ нь Монгол Улсын иргэн Б.Х, Д.Г, Т.А нартай бүлэглэн гадаад улсын аж ахуй нэгж байгууллагуудтай ижил нэртэй "Лонати СПА" ХХК-ийг 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр,

[8] "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/39520?daterange=2017-01-01%20-%202024-04-27&id=1&court_cat=2&bb=1

"Делүксе мулти сервисес СРЛ" ХХК-ийг 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр тус тус Монгол Улсад үүсгэн байгуулах замаар цахим хэрэгсэл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгон, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж Бүгд Найрамдах Турк улсын "Алпин чорап" /ALPIN CORAP SANAYI VE TIC/ компанийн Итали улсын "Лонати СПА" компани руу шилжүүлэх байсан 234.000 еврог Монгол Улсад үүсгэн байгуулсан "Делүксе мулти сервисес СРЛ" ХХК-ийн Голомт банк дахь 3455119540 дугаартай еврогийн харилцах дансаар 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр 234.000 евро буюу 702.861.120 төгрөгийг хүлээн авч, өмчлөгчийн хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авч залилсан байна. Улмаар дээрх "Лонати СПА" ХХК-ийн Голомт банк дахь 1415124052 дугаартай төгрөгийн харилцах дансанд 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр шилжиж орсон 464.832.24 евро буюу 1.366.262.809.74 төгрөгийг, 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр шилжиж орсон 21.300 ам.доллар буюу 56.215.173 төгрөгийг тус тус гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах зорилгоор Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Голомт банкны "Тэнгис" салбарт "Лонати СПА" ХХК-ний Голомт банк дахь 1415124052 дугаартай төгрөгийн харилцах данснаас 5 удаагийн үйлдлээр буюу 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 48.600.000 төгрөгийг, 29-ний өдөр 300.000.000 төгрөгийг, 30-ны өдөр 250.000.000 төгрөгийг, 12 дугаар сарын 4-ний өдөр 500.000.000 төгрөгийг, 6-ны өдөр 326.000.000 төгрөгийг тус тус бэлнээр зарлага гаргаж, улмаар "Сайн" банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 12 дугаар сарын 1-ний өдрийн хооронд 5 удаагийн үйлдлээр БНХАУ руу шилжүүлэн, мөнгө угаасан байна.

- **Шийдвэрийн агуулга, үндэслэл**-Шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3, 18.6 дугаар зүйлүүдийг тус тус баримталж Эжикэмэ Жон Чимэзиэд 10 жил, Б.Х-д 9 жил, Д.Г-д 8 жил, Т.А-д 6 жилийн хорих ялыг тус тус оногдуулсан.
- **Дүн шинжилгээ**-Шүүхийн шийдвэр тун үндэслэлтэй болжээ. Учир нь цахим залилангийн гэмт хэргээс олсон мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зорилгыг гэмт бүлэг агуулж байсан нь хэргийн үйл баримтаар бүрэн тогтоогдож байна. Мөн түүнчлэн энэ гэмт хэрэг нь 2.2.1, 2.2.2 дох хэсэгт заасан ахуйн шинж чанартай хохирол багатай хэргээс хохирлын хэмжээ маш өндөр байгаа юм.

2.2.5. Кибер орчинд хууль бусаар халдаж криптовалют өөртөө шилжүүлэн авсан хэрэг

- **Шүүхийн шийдвэр**-Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны

шүүхийн 2022.10.24-ний Дугаар 2022/ШЦТ/1590 шийдвэр[9]

- **Хэргийн үйл баримт**-Б.Э, Э.Б нар нь кибер орчинд хууль бусаар халдаж Майтволлет /Myethwallet/ криптовалют арилжааны бирж дээр байрлах Б.Эрдэнэбатын данснаас 32.7 итириум /ethereum/ буюу 182.476.307 төгрөгтэй тэнцэх хэмжээний криптовалютыг шилжүүлэн авч, Б.Эрдэнэбатын дижитал хөрөнгийн зах зээл дээр чөлөөтэй гүйлгээ хийх мэдээллийг хуулбарлаж авсан, ашиглах боломжгүй болгосон, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдэх зорилгоор мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай программ болох Спайрекс Кийлоггер /Spyrix Keylogger/ нэртэй хортой программыг зориудаар ашиглаж Кибер орчинд хууль бусаар халдах программ хангамжийг ашигласан гэмт хэргийг үйлдсэн буюу гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж өөрийн бусдаас зээлсэн мөнгийг төлөхийн тулд 2021 оны 08 дугаар сард Э.Бээс 25.000 ам.доллар үнэлгээ бүхий etherum-ыг binance арилжааны сайтаар дамжуулан өөртөө шилжүүлэн авч арилжаалан, төрсөн эгч Б.Эрдэнэтуяа, үеэл Б.Отгонцэцэг нарын дансаар дамжуулан ашигласан, бэлнээр 65.000.000 төгрөгийг өөртөө авсан байна.
- **Шийдвэрийн агуулга, үндэслэл**-Шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.2 “Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах” 18.6 “Мөнгө угаах” гэмт хэргийн үндсэн шинжийг хангаж байна гэх үндэслэлээр Э.Б, Б.Э нарыг аль алиныг хорих ялаар шийтгэсэн.
- **Дүн шинжилгээ**-Энэхүү шүүхийн шийдвэрийн хувьд цахим гэмт хэргийн өргөн хүрээтэйг харуулснаараа тун чухал шийдвэр болсон. Шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ хууль бусаар олсон мөнгийг эзэмшсэн, ашигласан, хууль бус эх үүсвэрийг нуун далдалсан гэх үндэслэлээр Э.Б, Б.Э нарыг гэм буруутайд тооцсон нь тун үндэслэлтэй болжээ. Учир нь үйл баримтыг үнэлээд үзвэл Э.Б нь төрсөн эгч, үеэлийнхээ дансаар дамжуулан тухайн мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зорилго агуулсан нь харагдаж байна. Мөн түүнчлэн Э.Б, Б.Э нар нь Эрүүгийн хуульд заасан их хэмжээнээс дээш хохирол 182 сая төгрөгийн хохирол учруулсныг үнэлсэн нь тун оновчтой байгаа юм.

2.2. Хэсгийн дүгнэлт

1. Практик судалгааны хэсгийг дүгнээд үзвэл Монгол Улсад цахим залилангийн гэмт хэргийг үйлдэх замаар “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох эрсдэл байгаа гэдэг нь ажиглагдлаа. Энэ нь 2.2.3, 2.2.4 дүгээр зүйлийн шийдвэрүүдээр ажиглагдсан.

[9] “**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**”- https://shuukh.mn/single_case/82456?daterange=2017-01-01%20-%202024-04-29&id=1&court_cat=2&bb=1

2. Цахим хэлбэрээр үйлдэгдэж буй залилангийн гэмт хэрэг бүрийг “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь гэмт хэрэгт хамааруулах нь зохимжгүй юм. Учир нь “Залилах” гэмт хэргийг үйлдэж олсон бага хэмжээний орлого, гэмт хэргээс олсон орлогыг өдөр тутмын хэрэгцээнд зарцуулсан зэрэг хэргүүд нь мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдэж буй нь ажиглагдлаа.
3. Гэмт хэргийг үйлдэхдээ цахим хэлбэрээр олж авсан эд хөрөнгө нь дан ганц залилах гэмт хэрэгт хамаарахгүй байгаа нь ажиглагдсан. Тухайлбал кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд нь криптовалют зэрэг виртуал хөрөнгөөр дамжин мөнгө угаах эрсдэлийг бий болгож буй нь ажиглагдлаа.

2.3. Харьцуулсан судалгаа

Харьцуулсан судалгааг хийхдээ судлаачийн хувьд Базелийн индексээр мөнгө угаах эрсдэл багатай, хууль тогтоомжийн хувьд харьцангуй боловсронгуй зохицуулалттай ХБНГУ, Сингапур улсуудыг сонгон судалллаа. Эдгээр сонгон авсан улсуулыг судлахдаа нэгдүгээрт тухайн улсын хууль, тогтоомжид цахим залилангийн гэмт хэргийг хэрхэн тодорхойлсон, хоёрдугаарт цахим залилангийн гэмт хэргийг институтийн түвшинд хэрхэн хянадаг эсэхийг харьцуулан судаллаа.

2.3.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

ХБНГУ-д дараах хууль, тогтоомжоор цахим залилангийн гэмт хэргийг тодорхойлж, хязгаарладаг байна. Үүнд:

- **Эрүүгийн хууль (Strafgesetzbuch, StGB)**: ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 263, 263а хэсэгт залилан мэхлэх, компьютерийн залилан хийх гэмт хэргийг тус тус тусгасан. Эдгээр хэсгүүдэд хувийн мэдээллийг хулгайлах, фишинг хийх болон цахим гэмт хэргийн бусад хэлбэрүүд зэрэг онлайнаар хийгдсэн залилан мэхлэх гэмт хэргийн шийтгэлийг тоймлон хуульчилсан байна.[10]
- **Шударга бус өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааны хууль (Gesetz gegen den unlauteren Wettbewerb, UWG)**: Энэхүү хууль нь шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаа, тэр дундаа хууран мэхлэх сурталчилгаа, шударга бус арилжааны үйл ажиллагааг хориглодог бөгөөд энэ нь цахим үйл ажиллагаанд ч хамаатай.[11]
- **Мэдээлэл хамгаалах тухай хуулиуд: Герман улс ЕХ-ны түвшинд Холбооны Мэдээллийн Хамгаалалтын Хууль (Bundesdatenschutzgesetz, BDSG) болон Мэдээллийн Хамгаалалтын Ерөнхий Зохицуулалт (GDPR)** зэрэг мэдээллийг хамгаалах хатуу хуулиудтай. Эдгээр хуулиуд нь хувийн мэдээллийг боловсруулах үйл явцыг зохицуулж, хувь хүмүүсийн мэдээллийн нууцлалыг хамгаалахын тулд бизнест шаардлага тавьдаг.[12]

[10] “**German Civil Code**”- https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html#p2467

[11] “**Act against Unfair Competition**”- https://www.gesetze-im-internet.de/englisch_uwg/englisch_uwg.html

[12] “**Cybersecurity Laws and Regulations in Germany**” article- https://www.upguard.com/blog/cybersecurity-laws-and-regulations-germany#:~:text=eligible%20to%20comply.-,Federal%20Data%20Protection%20Act%20(BDSG%20%2D%20Bundesdatenschutzgesetz),to%20oversee%20data%20protection%20regulations.

- **Төлбөрийн үйлчилгээний хяналтын хууль (Zahlungsdiensteaufsichtsges etz, ZAG)**: Энэхүү хууль нь төлбөрийн үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгч, тэр дундаа онлайн төлбөрийн процессоруудыг зохицуулдаг. Цахим төлбөрийн гүйлгээний аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хангах зорилготой.[13]

ХБНГУ-д кибер гэмт хэрэгтэй тэмцэх хариуцлага нь муж бүрийн Холбооны эрүүгийн цагдаагийн алба (BKA) эсвэл холбогдох Улсын Эрүүгийн цагдаагийн алба (LKA) хариуцдаг. Ер нь гэмт хэргийн золиос болсон бол байнга мэдээлж байх ёстой. Гэмт хэргийн талаар мэдээлснээр та эрх баригчдад буруутай этгээдүүдийг яллах боломжийг олгож, одоогийн гэмт хэргийн нөхцөл байдлын талаар үнэн зөв дүр төрхийг бий болгох боломжийг олгодог.[14]

Холбооны мэдээллийн аюулгүй байдлын алба (BSI) нь кибер гэмт хэрэгтэй холбоотой аюул заналхийллийн газрын талаар мэдээлэл өгөх, гэмтсэн тохиолдолд хурдан шуурхай, зохих ёсоор хариу арга хэмжээ авах боломжийг баталгаажуулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зөвлөмжийг хуваалцах үүрэгтэй[15] ажилладаг байна.

ХБНГУ-д мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүрэгтэй байгууллага нь «Zentralstelle für Finanztransaktionsuntersuchungen» (FIU) гэгддэг Германы Санхүүгийн Тагнуулын алба (FIU) юм. Энэ нь Холбооны Эрүүгийн Цагдаагийн Албаны (Bundeskriminalamt) дор үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд банк, санхүүгийн байгууллага болон мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомжийн дагуу янз бүрийн үүрэг хүлээсэн байгууллагуудаас сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авах, дүн шинжилгээ хийх, түгээх үүрэгтэй.

Ерөнхийдөө Германд цахим залилантай тэмцэх институтийн тогтолцоо нь төрийн байгууллагууд, хууль сахиулах байгууллага, зохицуулах байгууллага, хувийн хэвшлийн оролцогч талуудын хамтын ажиллагааны үндсэн дээр цахим гэмт хэрэгтэй институтийн түвшинд тэмцдэг гэж хэлж болно.

2.3.2. Сингапур Улс

Цахим гэмт хэргийн эсрэг хатуу байр суурьтай гэдгээрээ алдартай. Хууль, тогтоомжуудыг дурдвал:

- **Авлига, хар тамхины наймаа болон бусад онц хүнд гэмт хэргийн (Хураах) хууль (CDSA)**: Сингапур дахь мөнгө угаах гэмт хэргийг зохицуулдаг гол хууль тогтоомж нь Авлига, хар тамхины наймаа болон бусад онц хүнд гэмт хэрэг (Тэтгэмжийг хураах) хууль (CDSA) юм. CDSA-

[13] **Payment Services Oversight Act (Zahlungsdiensteaufsichtsgesetz – ZAG) ZAG full citation**-https://www.bundesbank.de/resource/blob/836488/4b807b6a0a7eb3188cd8f4329fc04473/mL/payment-services-oversight-act-data.pdf

[14] "**Cyber crime methods**"- https://www.bsi.bund.de/EN/Themen/Verbraucherinnen-und-Verbraucher/Cyber-Sicherheitslage/Methoden-der-Cyber-Kriminalitaet/methoden-der-cyber-kriminalitaet_node.html#:~:text=In%20Germany%2C%20responsibility%20for%20tackling,you%20should%20always%20report%20it.

[15] Мөн тэнд

ийн зорилго нь мөнгө угаах, хар тамхины наймаа болон бусад гэмт хэрэг зэрэг хууль бус үйлдлээс олсон орлого, үр ашгийг нь хураах явдал юм. CDSA нь хуулийн нэгдүгээр жагсаалтад заасан хар тамхины наймааны 14 төрлийн гэмт хэрэг, хоёрдугаар жагсаалтад заасан бусад олон төрлийн ноцтой гэмт хэргийг хамардаг.[16]

- **Терроризм (Санхүүжилтийг таслан зогсоох) тухай хууль (TSOFA)**: Энэхүү акт нь терроризмыг санхүүжүүлэх асуудлыг хөндсөн бөгөөд террорист үйл ажиллагаанаас олсон мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх заалтуудыг багтаасан болно. Террорист үйл ажиллагаа явуулахад террорист этгээдэд ашигтай санхүүгийн гүйлгээг хориглохоос гадна TSOFA-ийн IV хэсэг нь терроризмын эд хөрөнгийг хураах, царцаах, хураах эрхийг хууль сахиулах байгууллагуудад олгодог.[17]
- **Төлбөрийн үйлчилгээний тухай хууль (PSA)**: Төлбөрийн үйлчилгээний тухай хууль нь Сингапур дахь төлбөрийн систем болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалтад чиглэсэн хэтийн төлөв, уян хатан тогтолцоо юм. Энэ нь төлбөрийн үйлчилгээ болон Финтекийн инноваци, өсөлтийг дэмжихийн зэрэгцээ зохицуулалтын тодорхой байдал, хэрэглэгчийн хамгаалалтыг хангадаг.[18]
- **Зохицуулалтын хяналт**: Сингапурын Мөнгөний газар (MAS) зэрэг Сингапурын санхүүгийн зохицуулах байгууллагууд банк, мөнгөн гуйвуулгын агентлаг, дижитал төлбөр тооцоо, кибер аюулгүй байдал зэрэг санхүүгийн байгууллагуудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хатуу зохицуулалтыг мөрддөг.[19]

Сингапурт мөнгө угаахтай тэмцэх гол зохицуулалтын байгууллага нь Сингапурын Мөнгөний газар (MAS) юм. MAS нь Сингапурын төв банк, санхүүгийн зохицуулах байгууллага юм. Энэ нь банк, даатгалын компаниуд, үнэт цаас болон бусад санхүүгийн байгууллагуудыг оролцуулан мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомжийг дагаж мөрдөх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн салбарыг хянадаг. Сингапурын мөнгөний газар нь мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн байгууллагуудад дүрэм журам, заавар гаргадаг.[20]

[16] "**A Guide to Singapore's Anti-Money Laundering Laws**"- https://singaporelegaladvice.com/law-articles/anti-money-laundering-laws-and-you/#:~:text=What%20are%20the%20Laws%2FLegislation,Benefits)%20Act%20(CDSA).

[17] "**Countering the Financing of Terrorism**"- https://www.mha.gov.sg/what-we-do/managing-security-threats/countering-the-financing-of-terrorism#:~:text=The%20TSOFA%20is%20the%20domestic%20legislation%20to%20suppress%20the%20financing%20of%20terrorism.&text=Sections%203%20to%206%20of,or%20services%20for%20terrorist%20purposes

[18] "**Payment Services Act 2019**"- https://www.mas.gov.sg/regulation/acts/payment-services-act

[19] Сингапурын мөнгөний байгууллагын вебсайт-https://www.mas.gov.sg/regulation

[20] "**Anti-Money Laundering in Singapore: What you neeed to know**" article-https://www.dowjones.com/professional/risk/glossary/anti-money-laundering/singapore/#:~:text=AML%20regulators%20in%20Singapore,within%20the%20country's%20financial%20institutions.

2.3. Хэсгийн дүгнэлт

Монгол Улсад цахим залилан, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хууль, тогтоомж тогтолцоо байгаа боловч харьцуулан судалсан ХБНГУ, Сингапур Улсуудтай адил нарийвчилсан хууль тогтоомж, гүйцэтгэх институт маш сайн байгаа нь судалгааны явцад харагдлаа. Тэгэхээр манай улс эдгээр улсуудын сайн туршлагыг судлан цахим залилангийн гэмт хэрэгт суурилсан мөнгө угаах гэмт хэргийг бууруулах эрх зүйн орчныг сайжруулах бүрэн боломжтой юм.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

3.1. Нэгдсэн дүгнэлт

Монгол Улс 2023 оны байдлаар интернэт хэрэглэгчдийн тоо 4.3 саяд хүрсэн бөгөөд улс үндэстэн даяараа цахим үндэстэн болох уриалгыг гарган Засгийн газрын түвшинд ажиллаж байна. Цахим хөгжлийг дагаад олон давуу тал бий болж буй боловч цахим хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэргийн тоо, төрөл хэлбэр ч мөн адил үүссээр байна. Үүний нэг хэлбэр нь цахим орчинд залилах гэмт хэргийг үйлдэн, гэмт хэргийн улмаас олсон орлогыг мөнгө угаах эрсдэлтэй юм.

Судалгааны хүрээнд Монгол Улсад дээр дурдсан гэмт хэрэгтэй тэмцэх хууль, тогтоомж, тогтолцоо байгаа хэдий боловч ерөнхий зохицуулж, институтийн эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлоогүй байна. Үүнээс шалтгаалаад практикт цахим залилангийн гэмт хэргийг уламжлалт залилах гэмт хэргээс хэрхэн ялгаж үзэх, хохирлын хэмжээг хэрхэн харгалзан үзэх, ямар үед “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь болох эсэх нь тодорхойгүй байна. Харьцуулан судалсан Герман, Сингапур улсууд нь уг асуудлыг шийдвэрлэх хууль, тогтоомж болон институтийн хувьд боловсронгуй учраас энэ төрлийн гэмт хэргийн эрсдэл харьцангуй бага байгаа нь ажиглагдсан. Эдгээрээс үндэслээд судлаачийн хувьд дараах саналыг гаргаж байна.

3.2. Санал

- Цахим залилангийн гэмт хэргийн эрх зүйн байдлыг онолын түвшинд зөв тодорхойлж ямар үед “Мөнгө угаах” гэмт хэргийн суурь болох талаар судалж, хууль тогтоомжид нарийвчлан зөв томъёолох;
- Цахим залилангийн гэмт хэрэг, мөнгө угаах гэмт хэргийг хянах, шийдвэрлэх институтийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгож, чадавхжуулах ёстой.

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж

- Эрүүгийн хууль (2015)
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
- Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021)
- Шүүх шинжилгээний тухай хууль (2022)
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)
- Авилгын эсрэг НҮБ-ын конвенц (2003)

2. Цахим болон бусад эх сурвалж

- "**Цахим орчинд үйлдсэн гэмт хэргийн 80 гаруй хувь нь залилан байна**" цахим нийтлэл- https://montsame.mn/mn/read/339416
- "Б.Энхбаяр "**Сүүлийн таван жилд цахим залилангийн гэмт хэрэг 15 дахин нэмэгдсэн**" цахим нийтлэл-https://www.newswire.mn/n/30649
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн вебсайт "**Нийт интернэт хэрэглэгчдийн тоо**"- https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1300_012V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table
- С.Гантулга, Б.Энхболд "**Эрүүгийн эрх зүй тусгай анги**" сурах бичиг УБ (2020)
- "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/92302?daterange=2017-01-01%20-%202024-04-27&id=1&court_cat=2&bb=1
- "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/65308?daterange=2017-01-01%20-%202024-04-27&id=1&court_cat=2&bb=1
- "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/86241?daterange=2017-01-01%20-%202024-04-27&id=1&court_cat=2&bb=1
- "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/39520?daterange=2017-01-01%20-%202024-04-27&id=1&court_cat=2&bb=1
- "**Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан**"- https://shuukh.mn/single_case/82456?daterange=2017-01-01%20-%202024-04-29&id=1&court_cat=2&bb=1
- "**German Civil Code**"- https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/

englisch_stgb.html#p2467

- "**Act against Unfair Competition**"- https://www.gesetze-im-internet.de/englisch_uwg/englisch_uwg.html
- "**CybersecurityLawsandRegulationsinGermany**"article-https://www.upguard.com/blog/cybersecurity-laws-and-regulations-germany#:~:text=eligible%20to%20comply.-,Federal%20Data%20Protection%20Act%20(BDSG%20%2D%20Bundesdatenschutzgesetz),to%20oversee%20data%20protection%20regulations.
- **Payment Services Oversight Act (Zahlungsdiensteaufsichtsgesetz – ZAG) ZAG full citation**-https://www.bundesbank.de/resource/blob/836488/4b807b6a0a7eb3188cd8f4329fc04473/mL/payment-services-oversight-act-data.pdf
- "**Cyber crime methods**"- https://www.bsi.bund.de/EN/Themen/Verbraucherinnen-und-Verbraucher/Cyber-Sicherheitslage/Methoden-der-Cyber-Kriminalitaet/methoden-der-cyber-kriminalitaet_node.html#:~:text=In%20Germany%2C%20responsibility%20for%20tackling,you%20should%20always%20report%20it.
- "**A Guide to Singapore's Anti-Money Laundering Laws**"- https://singaporelegaladvice.com/law-articles/anti-money-laundering-laws-and-you/#:~:text=What%20are%20the%20Laws%2FLegislation,Benefits)%20Act%20(CDSA).
- "**Countering the Financing of Terrorism**"- https://www.mha.gov.sg/what-we-do/managing-security-threats/countering-the-financing-of-terrorism#:~:text=The%20TSOFA%20is%20the%20domestic%20legislation%20to%20suppress%20the%20financing%20of%20terrorism.&text=Sections%203%20to%206%20of,or%20services%20for%20terrorist%20purposes
- "**Payment Services Act 2019**"- https://www.mas.gov.sg/regulation/acts/payment-services-act
- Сингапурын мөнгөний байгууллагын вебсайт-https://www.mas.gov.sg/regulation
- "**Anti-Money Laundering in Singapore: What you neeed to know**" article-https://www.dowjones.com/professional/risk/glossary/anti-money-laundering/singapore/#:~:text=AML%20regulators%20in%20Singapore,within%20the%20country's%20financial%20institutions.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТ КРИПТОВАЛЮТЫГ АШИГЛАЖ БУЙ БАЙДАЛ БА ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗАМЫГ ЭРЭЛХИЙЛЭХ НЬ

*Б.Баяржаргал**

** Дотоод Хэргийн Их Сургуулийн Эрх Зүй, Нийгмийн Ухааны Сургуулийн 222-р дамжааны суралцагч, И-мэйл: bjargal344@gmail.com*

ТОВЧ ХУРААНГУЙ

Төвлөрсөн бус криптовалютын орчинд мөнгө угаах гэмт хэрэг нэмэгдэж байгаа нь олон улсын анхаарлыг татаж байна. Криптовалютын нууцлалт, төвлөрсөн бус байдал нь гэмт хэрэгтнүүд хууль бус үйл ажиллагааг далдалж, мөнгө угаах, хар тамхины наймаа, терроризм зэрэг хууль бус үйлдлийг санхүүжүүлэхэд ашиглагдаж, гэмт хэргийн гаралт өдрөөс өдөрт нэмэгдснээр энэхүү сэдвийг дэлгэрүүлэн судлах үндэслэл болох юм.

Засгийн газрууд, санхүүгийн зохицуулагчид үүнд хатуу арга хэмжээ авч, криптовалютын биржүүд болон үйлчилгээ үзүүлэгчдийг «Мөнгө угаахтай тэмцэх» (AML) болон «Үйлчлүүлэгчээ мэдэх» (KYC) журам мөрдүүлэхийг шаарддаг болсон. Технологийн дэвшил, тухайлбал блокчейн аналитик, нь хууль сахиулах байгууллагуудад гүйлгээг хянах, сэжигтэй үйлдлийг илрүүлэх боломжийг олгож, энэхүү асуудлыг шийдвэрлэхэд олон улсын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо болон олон улсын байгууллагуудын зөвлөмжүүд чухал үүрэгтэй. ФАТФ зэрэг байгууллагууд улс орнуудыг зохицуулалт, хууль эрх зүйн арга хэмжээг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгч, хамтын ажиллагааг дэмжиж байна.

I.УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Сэдэв: Мөнгө угаах гэмт хэрэгт криптовалютыг ашиглаж буй байдал ба түүнтэй тэмцэх арга замыг эрэлхийлэх нь

Үндэслэл: Мөнгө угаах гэмт хэрэгт криптовалютын үүрэг оролцоог нарийвчлан судлан тогтоох нь улс орон, бүс нутаг төдийгүй дэлхийн санхүүгийн тогтвортой байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад амин чухал байна. Технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж, криптовалютын тухай ойлголтыг судлан, олон улсын хамтын ажиллагааг дэмжиж, инновацийг нэвтрүүлснээр санхүүгийн харилцаанд оролцогч талууд хууль бус санхүүгийн үйл ажиллагаатай үр дүнтэй тэмцэх боломж нөхцөл бүрдэх тул энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго: Мөнгө угаах гэмт хэрэгт криптовалютыг ашиглаж буй байдал ба түүнтэй тэмцэх арга замыг тодруулан судлах.

Зорилт: Олон улсын болон монгол улсын туршлагаас тодорхойлж дедуктив судалгаа хийнэ.

1. Баримт бичигт анализ хийх, мэдээлэлд синтез хийх
2. Виртуал хөрөнгийн зах зээл хөгжсөн орнуудын туршлага болон манай улсын криптовалюттай холбогдох эрхзүйн кейс судалгаа
3. Дүгнэлт, санал боловсруулна

Судлагдахуун: Криптовалют, мөнгө угаах гэмт хэрэг

Таамаглал: Криптовалютаар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн зохицуулалт нь харьцангуй шинэ ойлголт бөгөөд манай улсад эрх зүйн зохицуулалт зайлшгүй хийх шаардлагатай байх магадлалтай.

Судлагдсан байдал: Өмнө нь энэхүү сэдвийн хүрээнд олон судалгаа шинжилгээ хийгдэж байсан ба эдгээр нь доорх хүрээг хамарч байна.

- Ж.Төгс-Очир “ФАТФ-ын тайлан: Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зөвлөмж (албан ёсны эрхтэй орчуулга)”, 2017 он.
- ХЗҮХ мөрдөх алба “Гадаадын зарим орны туршлага”, 2017 он
- Б.Досжан “Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг харьцуулан судлах нь” 2020 он
- М.Амина, Г.Мягмарцэрэн “Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн практик дахь хууль хэрэглээний тулгамдаж буй асуудал ба эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” 2023 он гэх мэт.

Эдгээр судалгааны ажлуудад мөнгө угаах гэмт хэрэгт үндэсний мөнгөн тэмдэгт, валютыг бэлэн болон бэлэн бус гүйлгээ хэлбэрээр шилжүүлэн ашиглаж буй байдал, тэдгээрийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны арга зүй, гэмт хэргийн зүйлчлэлийн талаар нарийвчлан судласан байна. Харин энэхүү илтгэл нь виртуал хөрөнгө буюу криптовалют, түүний ёуурь систем болох блокчейнийг ашиглах замаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хориг арга хэмжээг авахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг бий болгохтой холбогдсон харилцааг хөндсөн гэдгээрээ онцлогтой.

Судалгааны давуу ба онцлог тал: Судлагдаж байгаагүй, шийдэл, эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгаа шинэ сэдвээр судалгаа хийж, санал дэвшүүлнэ.

II.СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Мөнгө угаах гэмт хэрэг гэдэг нь хувь хүмүүс болон гэмт хэргийн бүлэглэлүүд хууль бусаар олсон хөрөнгийн эх үүсвэрийг хууль ёсны мэт харагдуулахын тулд нуун далдлах үйл явц ба ихэвчлэн мөнгөний жинхэнэ эх үүсвэрийг нуун дарагдуулах зорилготой хэд хэдэн нарийн төвөгтэй гүйлгээ, үйл ажиллагааг явуулж буй байдал юм[1]. Энэхүү үйл ажиллагаа нь гэмт хэрэгтнүүдэд хууль сахиулах болон зохицуулах

[1] “Мөнгө угаах гэж юу вэ?”, Financial Action Task Force (FATF). https://www.fatf-gafi.org/about/faqs/

байгууллагуудад мэдэгдэхгүйгээр хууль бус үйлдлээсээ олсон орлогыг эзэмшиж, захиран зарцуулах боломжийг олгодог.

“Мөнгө угаах” гэсэн ойлголт өнгөрсөн зууны 20-иод онд Чикагогийн гэмт бүлэглэлийн толгойлогч Аль Капонегийн үед анх бий болжээ. Тэр үед Америкт “хуурай” хууль буюу архины худалдааг хязгаарласан хууль үйлчилж байх үед Аль Капоне архи, хар тамхи, худалдаа, рэкетийн хууль бус үйлдлээсээ олсон мөнгөө өөрийн эзэмшлийн хувцас угаалгын газруудаас олсон ашиг мэтээр тайлан тооцоо гаргадаг байв. Үүнийг нь “L’expresse” сонины сэтгүүлчид анх олж мэдээд тэднийг “Хувцас биш мөнгө угааж байна” гэж бичсэнээр “мөнгө угаах” гэсэн нэр томьёо анх гарч ирсэн гэдэг. 1974 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсоныг огцруулж байсан “Watergate”-ийн дуулианы үеэр энэ нэр дахин гарч ирснээр дэлхий нийтэд танил болж, олон улсын гэмт хэргийн болон санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх болжээ. Тэр үед Ричард Никсоныг дэмжих “Ерөнхийлөгчийг дахин сонгох хороо”-гоор дамжуулан нууц данс ашиглан хууль бус мөнгийг Мексик рүү гуйвуулж байсан нь тогтоогджээ. Үүнээс хойш дэлхийн улс орнуудад мөнгө угаах нэр томьёог хэрэглэж эхэлсэн байна[2].

1.1. Мөнгө угаах гэмт хэргийг олон улсад ойлгож, тайлбарлаж буй байдал

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажилладаг засгийн газар хоорондын байгууллага болох ФАТФ (FATF[3])-ын мэдээлснээр мөнгө угаах гэмт хэрэг нь байршуулах, нуун далдлах, буцаан төвлөрүүлэн нэгтгэх[4] гэсэн гурван үе шаттай.

- Байршуулах үе шатанд хууль бус хөрөнгийг ихэвчлэн бэлэн мөнгө байршуулах, мөнгөн гуйвуулга хийх, гарал үүслийг нь нуун дарагдуулдаг бусад аргаар санхүүгийн системд нэвтрүүлдэг.
- Нуун далдлах үе шатанд олон улсын шилжүүлэг, криптовалютын гүйлгээ эсвэл санхүүгийн цогц хэрэглүүр зэрэг олон тооны гүйлгээ эсвэл дансаар дамжуулан хөрөнгө мөнгө шилжүүлдэг.
- Эцэст нь, интеграцийн гэж нэрлэгддэг буцаан төвлөрүүлэх үе шатанд угаасан хөрөнгийг үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт, тансаг хэрэглээний бараа худалдан авах, бизнес эрхлэх зэрэг “хууль ёсны” хөрөнгө болгон эдийн засгийн салбарт эргүүлэн оруулдаг.

---

faqs-mutual-evaluation.html#

[2] АНУ-н санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ. https://www.fincen.gov/what-money-laundering#:~:text=Money%20laundering%20involves%20disguising%20financial,with%20an%20apparently%20legal%20source.

[3] Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ/FATF) нь олон улсын санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс сэргийлэх бодлого боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус байгууллага юм. ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.

[4] “Мөнгө угаах гэж юу вэ?”, Financial Action Task Force (FATF). https://www.fatf-gafi.org/about/faqs/faqs-mutual-evaluation.html#

Мөнгө угаах нь зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, терроризмыг санхүүжүүлэх нэгэн үе шат болж, санхүүгийн тогтолцооны бүрэн бүтэн байдалд ихээхэн эрсдэл учруулдаг[5]. Иймд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль бус санхүүгийн урсгалыг илрүүлэхэд үр нөлөөтэй эрх зүйн орчин, үр дүнтэй хэрэгжүүлэх механизм, олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай байдаг аж.

Олон улсад мөнгө угаах гэмт хэргийг янз бүрийн конвенци, хууль эрх зүйн хүрээнд тодорхойлж, шийдвэрлэдэг. Иймээс тогтолцооны нэг нь мөнгө угаах гэмт хэргийн талаар иж бүрэн тодорхойлолт өгч, түүнтэй тэмцэх арга хэмжээг тогтоосон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц[6] (UNTOC) юм. Мөнгө угаах гэмт хэрэг нь хууль бус гарал үүслийг нуун далдлах, хууль ёсны болгох зорилгоор гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон орлогыг хөрвүүлэх, шилжүүлэхийг хэлнэ гэж UNTOC тодорхойлдог байна[7].

Мөнгө угаах гэмт хэргийн гол онцлог, бусад гэмт хэргээс ялгагдах шинж, хор уршиг

- Хууль бус хөрөнгийн оролцоо: Мөнгө угаах гэдэг нь хар тамхины наймаа, залилан мэхлэх, шамшигдуулах, авлига болон бусад гэмт хэргийн үйл ажиллагаа зэрэг хууль бус аргаар олж авсан мөнгөтэй харьцдаг.
- Нуун далдлах үе шат: Энэ үе шат нь ихэвчлэн хөрөнгийн гарал үүслийг нуун дарагдуулахын тулд олон давхар гүйлгээ хийж буй үеийг илэрхийлдэг. Гүйлгээ янз бүрийн данс, банк эсвэл улс орнуудаар дамжуулан мөнгө шилжүүлэх үйл явцаар илэрдэг.
- Интеграцчилал: Хууль бус эх үүсвэртэй хөрөнгийг зах зээлд оруулсны дараа мөнгө нь цэвэр мөнгө болж санхүүгийн системд дахин нэгдснээр хууль бус гарал үүслийг тодорхойлох боломжгүй болох ба “угаагдсан мөнгө” ихэвчлэн хууль ёсны бизнес, үл хөдлөх хөрөнгө эсвэл тансаг зэрэглэлийн бараа бүтээгдэхүүнд зарцуулагддаг ажээ.
- Хууль эрх зүйн санкц, үр дагавар: Мөнгө угаах нь ихэнх улс оронд гэмт хэрэг хэмээн тооцогддог бөгөөд торгох, хорих, эд хөрөнгийг хураах зэрэг эрх зүйн санкцтай байдаг.

Мөнгө угаах болон ижил төстэй гэмт хэрэг (залилан мэхлэх, шамшигдуулах) зэргийн гол ялгаа нь зорилго, арга хэлбэрт оршдог.

Зорилго: Залилах нь хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын

[5] “Мөнгө угаах гэж юу вэ?”, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC). https://www.unodc.org/e4j/en/money-laundering/module-1/key-issues/what-is-money-laundering.html

[6] 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2003 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол Улс 2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон ба зорилго нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс илүү үр дүнтэй урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

[7] https://www.unodc.org/unodc/en/money-laundering/index.html

харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах[8] замаар мөнгө, эд хөрөнгө олж авах зорилготой байдаг бол мөнгө угаах гэмт хэргийн хувьд аливаа төрлийн гэмт хэргийн улмаас олсон мөнгөний гарал үүслийг нуун дарагдуулах зорилготой байдаг.

Арга: Мөнгө угаах гэмт хэрэг нь ихэвчлэн янз бүрийн байгууллага, харьяаллын дагуу хөрөнгийн гарал үүслийг нуун дарагдуулах санхүүгийн нарийн төвөгтэй гүйлгээг хамардаг бол бусад санхүүгийн гэмт хэрэг нь мөнгийг шууд хулгайлах, буруугаар ашиглах гэх мэт илүү хялбар аргуудыг агуулж болдог аж[9].

Нийгмийн салбар институтуудад дараах хор уршгийг үзүүлдэг тул мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зайлшгүй шалтгааныг бий болгож буй юм:

Улс төрд үзүүлэх нөлөөлөл

Авлига: Мөнгө угаах гэмт хэрэг нь ихэвчлэн хээл хахууль, авлигатай холбоотой байдаг бөгөөд энэ нь ардчиллын зарчим, шударга засаглалын үйл явцыг алдагдуулж, улс төрийн манипуляцыг[10] ашиглахад хүргэдэг.

Төрд итгэх итгэл багасах: Авлигач гэж ойлгогдсон улс төрчид, намууд олон нийтийн итгэлийг алдснаар улс төрийн тогтворгүй байдалд хүргэж болзошгүй.

Эдийн засаг:

Гажуудсан зах зээл: Мөнгө угаах нь эдийн засгийн мэдээлэл, зах зээлийн нөхцөл байдлыг гажуудуулж, хууль ёсны бизнес эрхлэгчдэд шударгаар өрсөлдөхөд хүндрэл учруулдаг.

Нөөцийн буруу хуваарилалт: Хууль бус хөрөнгө нь эрүүл мэнд, боловсрол гэх мэт чухал салбараас нөөцийг өөр тийш нь чиглүүлж, үр ашиггүй эсвэл хууль бус бизнест хөрөнгө оруулалт хийхэд хүргэдэг.

Татварын орлого буурах: Мөнгө угаах нь татвараас зайлсхийхэд хүргэж, улмаар төрийн орлого буурч, төрийн үйлчилгээнд сөргөөр нөлөөлдөг.

Эрх зүй:

Хууль дээдлэх ёсыг алдагдуулах: Мөнгө угаах нь ихэвчлэн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоотой байдаг бөгөөд улмаар хууль эрх зүйн тогтолцоо, хууль сахиулах ажиллагааг удаашруулж, хууль дээдлэх ёсыг алдагдуулдаг.

Олон улсын харилцаа

Дэлхий дахины нэр хүндэд хохирол учруулах: Мөнгө угаах гэмт хэрэг дэлгэрсэн улс орнуудын бусад улс орон, олон улсын байгууллагатай харилцах харилцаанд нь сөргөөр нөлөөлж, нэр хүндэд нь хохирол учруулж болзошгүй.

---

[8] ЭХТА, 17.3-р зүйл

[9] https://corporatefinanceinstitute.com/resources/career-map/sell-side/risk-management/money-laundering/

[10] Манипуляци гэдэг нь тухайн хүний анхнаасаа хийх хүсэлгүй байсан зүйлийг хийх арга хэрэгсэл бөгөөд эрх мэдлийн нэг хэлбэр юм. Хүнийг ятгах, албадах, бие махбодийн хүч хэрэглэх гэх мэт бусад төрлийн албадлагаас ялгах нь чухал.

Хориг арга хэмжээ ба хар жагсаалт: Мөнгө угаахтай тэмцэж чадаагүй улс орнууд олон улсын санхүүгийн байгууллагуудаас хориг арга хэмжээ авах юм уу хар жагсаалтад орж, дэлхийн хэмжээнд эзлэх байр суурь, нөөцийн хүртээмжид нөлөөлж болзошгүй.

Нийгэм

Нийгмийн тэгш бус байдал: Мөнгө угаах нь хууль бус баялгийг цөөн хэдэн хувь хүн эсвэл байгууллагын гарт төвлөрүүлснээр баялгийн ялгааг улам хурцатгаж болно.

Гэмт хэргийн өсөлт: Зохион байгуулалттай гэмт хэргийг санхүүжүүлснээр мөнгө угаах нь хар тамхины наймаа, хүний наймаа, хүчирхийлэл зэрэг гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Санхүүгийн үйл ажиллагааны ажлын хэсэг (FATF) нь дэлхий даяар мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. ФАТФ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүй, зохицуулалтын болон үйл ажиллагааны арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд олон улсын жишиг тогтоодог засгийн газар хоорондын байгууллага юм[11]. ФАТФ-ын зөвлөмжүүд нь мөнгө угаахтай тэмцэх (AML) болон терроризмыг санхүүжүүлэхтэй (CFT) тэмцэх тогтолцоог бэхжүүлэх талаар гишүүн орнуудад зааварчилгаа өгдөг.

Олон улсад мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж буй байдал

Смурфинг (Бүтэцлэн хуваах): Эрх баригчдад илрүүлэхгүйн тулд их хэмжээний хууль бус мөнгийг жижиг, анзаарагдахгүй гүйлгээ болгон задлах арга бөгөөд бага хэмжээний мөнгийг янз бүрийн банкны дансанд хийж эсвэл олон улсад шилжүүлэн мөнгийг угааж болдог[12].

- Shell компаниуд: “Бүрхүүлэн” компаниуд нь үндсэндээ мөнгө шилжүүлэх, нуух зорилгоор үйл ажиллагаа явуулдаг хууль ёсны үйл ажиллагаа бага эсвэл огт байхгүй бизнесүүд ба олон улсын гүйлгээг хөнгөвчлөх, хөрөнгийн эх үүсвэр, очих газрыг нуухад болгоход ашиглаж болно[13].
- Оффшор дансууд[14]: Мөнгө угаагчид хууль бус хөрөнгийг хадгалах, шилжүүлэхийн тулд оффшор банкууд эсвэл санхүүгийн сул зохицуулалттай татварыг ашигладаг. Оффшор данс гүйлгээний нэрээ нууцлах, нууцлах боломжийг олгодог.
- Худалдаанд суурилан мөнгө угаах: Гэмт хэрэгтнүүд хуулийн дагуух бизнесийн хэлцэл гэж халхавчлан хууль бус хөрөнгийг хилээр нэвтрүүлэхийн тулд хэт их эсвэл дутуу нэхэмжлэх зэргээр мөнгө угаадаг.

---

[11] https://www.fatf-gafi.org/en/the-fatf/who-we-are.html

[12] https://www.investopedia.com/terms/s/smurf.asp

[13] https://www.idenfy.com/blog/shell-companies-money-laundering/#:~:text=A%20shell%20company%20is%20a,much%20income%20on%20their%20own.

[14] Энэ нэр томъёог ихэвчлэн банк, санхүүгийн салбарт хууль эрх зүйн зохицуулалт нь хилийн чанад дахь улс газрыг тодорхойлоход ашигладаг.

- Корреспондент банк: Олон улсын хэмжээнд мөнгө шилжүүлэхийн тулд өөр өөр орны банк хоорондын харилцааг ашиглах.
- Дижитал валютууд: Криптовалют болон бусад дижитал хөрөнгийг тодорхой хэмжээгээр нэрээ нууцлан олон улсын хэмжээнд шилжүүлэхэд ашигладаг. Гүйлгээ нь мөшгихөд хэцүү байдаг тул мөнгө угаах гэмт хэрэгт ашиглалт өндөртэй байдаг.
- Үл хөдлөх хөрөнгө ба өндөр үнэ цэнэтэй хөрөнгө: Хууль бус хөрөнгөөр нэг улсад үл хөдлөх хөрөнгө, тансаг хэрэглээний бараа, өндөр үнэ цэнэтэй хөрөнгийг худалдаж аваад өөр улсад зарж олсон орлогыг хууль ёсны болгох боломжтой байдаг.
- Буяны байгууллагууд: Гэмт этгээдүүд буяны болон ашгийн бус байгууллагын үйл ажиллагаануудаар дамжуулан хууль бус хөрөнгө оруулалт хийх замаар олон улсын мөнгө угаах гэмт хэргийн халхавч болгон ашиглаж байна.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын, манай орны арга хэмжээ

Дэлхий даяар хууль сахиулах болон санхүүгийн байгууллагууд мөнгө угаахтай тэмцэх (AML) зохицуулалтыг хэрэгжүүлэх, сэжигтэй гүйлгээг хянах, хил дамнуулан мэдээлэл, эх сурвалжаа хуваалцах замаар олон улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг.

Мөнгө угаахтай үр дүнтэй тэмцэхийн тулд улс орнууд хууль тогтоомжийг баталж, ФАТФ зэрэг байгууллагаас тогтоосон олон улсын стандартад нийцсэн зохицуулалтын тогтолцоог бий болгодог. Эдгээр арга хэмжээнүүдэд санхүүгийн байгууллагуудад үйлчлүүлэгчийг шалгах журам хэрэгжүүлэх, сэжигтэй гүйлгээний талаар эрх бүхий байгууллагад мэдээлэх, мөрдөн байцаалтын ажиллагааг хөнгөвчлөхийн тулд зохих бүртгэл хөтлөх зэрэг шаардлагууд багтана. Мөн хууль сахиулах байгууллагууд мөнгө угаах сүлжээг хянаж, таслан зогсоохын тулд хил дамнуулан хамтран ажилладаг бөгөөд гүйлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хууль бус үйл ажиллагааны хэв маягийг тодорхойлохын тулд санхүүгийн тагнуулын нэгжид тулгуурладаг.

Монгол улс дахь эрх зүйн зохицуулалт

Харин манай улс 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц”-д нэгдэн орж, 2004 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог Олон улсын санхүүгийн арга хэмжээ авах бүлэг (Financial Action Task Force буюу ФАТФ)-ийн салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага (APG)-д элсэн орсноор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээх болсон[15].

[15] Санхүүгийн зохицуулах хороо. http://www.frc.mn/resource/frc/Document/2020/05/29/459fwket7y-fjc5nv/sanhuu%20nom.pdf

Мөнгө угаах гэмт хэргийн эсрэг батлагдсан монгол улсын нэгдэн орсон олон улсын конвенцууд нь:

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц”
- “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын конвенц”
- “Авилгын эсрэг НҮБ-ын конвенц”
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ын нэмэлт болох “Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан
- сэргийлэх, таслан зогсоох, шийгтэх тухай протокол”
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ын нэмэлт болох “Галт зэвсэг, түүний бүрдэл хэсэг, эд анги болон галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протокол”
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ын нэмэлт болох “Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол” зэрэг байна[16].

Олон улсын конвенцид нэгдэн орсны улмаас “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийг батлан, шинэчлэн найруулсан бөгөөд уг хуулинаа “мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ” хэмээн тусгаж өгсөн[17].

Монгол улсын эрүүгийн хуулийн тусгай ангид мөнгө угаах гэмт хэргийг зүйлчлэн, гэмт хэргийн бүрэлдэхүүнээр задалж, нийгмийн хор аюулыг тодорхойлсон байгаагаас онцлог шинж, бусад ойролцоо төрлийн гэмт хэргээс юугаараа ялгаатайг нь тодотгон харж болно.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн сурах бичигт: “Мөнгө угаах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй эдийн засгийн хямралд хүргэдэг нийгэм аюултай, гэм буруутай үйлдэл юм. Энэ хэргийн улмаас олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаа татгалзах хүртэлх арга хэмжээ авдаг нь эдийн засагт сөрөг нөлөөтэй юм…

[16] https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=29&active=1&sort=title&page=1
[17] https://legalinfo.mn/mn/detail?lawId=9242

…Мөнгө угаах гэмт хэргийн үндсэн шинж ЭХ-н 18.6-р зүйлийн 1 дэхь хэсэг.

Мөнгө угаах гэмт хэргийн объектив шинж:

- Объект: Банк санхүүгийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа байна.
- Объектив тал: Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байх түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан үйлдэл, эс үйлдэхүй байна.

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан гэж гэмт хэргийн замаар олсон мөнгө гэдгийг лавтай сайн мэдсээр байж зориуд авч ашигласан, өөрийн эзэмшилд оруулсан байхыг хэлнэ.

Хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах гэж тухайн мөнгө, эд хөрөнгийг эх үүсвэрийг хууль бус гэдгийг мэдсээр хууль ёсны мэт болгож эргэлтэд оруулсан, эх үүсвэрийг нь өөрчилсөн байхыг хэлнэ.

Гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн гэж эх үүсвэрийг нь өөрчлөх, тухайн хүний нэрээс хасах, өөр хүнд шилжүүлэх хэлбэрээр илэрнэ.

Мөнгө угаах гэмт хэргийн субъектив шинж:

- Субъектив тал: Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан гэм буруугийн санаатай хэлбэртэй үйлдэгдэнэ. Гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилготой байна.
- Субьект: Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хэн ч байж болно.

Монгол улсын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протоколд нэгдэн орсон ч гэлээ эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг хийгээгүй, бүхэллэг байдлаар нь салбар хуулиудад дурдан тодорхойлж, зүйлчилсэн эрх зүйн зохицуулалттай манай улс Олон улсын Базелийн хорооноос жил бүр гаргадаг дэлхийн мөнгө угаах эрсдлийн 2022 оны үнэлгээгээр 128 орноос 36-т эрэмблэгдсэн бол, 2023 оны үнэлгээгээр 152 орноос 83-т жагсссан[18]. “Мөнгө угаахтай тэмцэх Базелийн индекс” нь олон улсын хэмжээнд улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх

[18] https://index.baselgovernance.org/ranking

эрсдэлийг харьцуулах хэлбэрээр хөндлөнгийн хараат бусаар үнэлгээгээ гаргадаг онцлогтой. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн хүчин зүйлийг тооцсон, энэ чиглэлээр дагнасан нэгдсэн индекс байдаггүй тул улс орнууд, төр, хувийн хэвшлийн байгууллагууд өөрсдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратеги гаргах, эрсдэлийг тооцохдоо энэ индексийг ашиглах нь элбэг байдаг аж. “Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сүүлийн жилүүдэд чамлахааргүй амжилт гаргаж байна. Тухайлбал, ФАТФ-ын 40 зөвлөмжийн техник хэрэгжилт бүхэлдээ сайн болон түүнээс дээш үнэлэгдээд байгаа. Энэ үзүүлэлтээрээ Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт Монгол Улс тэргүүлж байна. Энэ амжилт нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх бусад үнэлгээ, индекс, гадаадын банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах гадаад харилцаанд эерэгээр нөлөөлөхийг Монголбанк мэдээллээ. УИХ, Засгийн Газраас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүх шатны үйл ажиллагааг дэмжиж, хариуцан хэрэгжүүлж буй төр, хувийн хэвшлийн байгууллагууд дор бүрнээ арга хэмжээ авч, ахиц гаргаж байгаа нь Олон улсаас хийж байгаа үнэлгээнд сайнаар нөлөөлжээ. Цаашид бодит хэрэгжилтэд анхаарах, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн шийдвэрлэлтийг нэмэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанарт анхаарч, энэ чиглэлээр ажиллаж буй байгууллагуудын хүний нөөц, санхүүгийн чадавхад анхаарах шаардлагатайг мөн онцолжээ” хэмээн Монцаме агентлагаас мэдээлсэн байна[19].

Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Санхүүгийн арга хэмжээ авах ажлын хэсэг (ФАТФ)-аас хэд хэдэн үнэлгээ, дараагийн шатны үнэлгээ хийлгэсэн[20].

- 2007 оны 7-р сарын 24: Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бүлэг (APG)-аас харилцан үнэлгээ хийж эхэлсэн.
- 2011.06.24-2012.06.22 ФАТФ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсуудыг тодорхойлоход Монгол Улсыг дурдагдсан байв. Эдгээр дутагдлыг арилгах зорилгоор ФАТФ-тай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандартад нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалтаа үргэлжлүүлж, стратегийн дутагдалтай харъяалалуудыг тодорхойлж, тэдгээрийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулжээ.
- 2012-2014 онд Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг

[19] “Монцаме агентлаг” 2023.11.29-ний нийтлэл

[20] https://www.fatf-gafi.org/content/fatf-gafi/en/publications/Mutualevaluations/fur-mongolia-2023.html

санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд стратегийн дутагдалтай гэж ФАТФ тогтоосон. Гэвч 2014 оны зургадугаар сар гэхэд Монгол Улс эдгээр дутагдлыг арилгах тал дээр ихээхэн ахиц дэвшил гаргаж, ФАТФ-ын хяналтад хамрагдахаа больсон.

- 2017 оны тайланд 2016 оны арванннэгдүгээр сарын байдлаар Монгол Улсад хэрэгжиж буй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээг нэгтгэн харуулсан.
- Тэр цагаас хойш Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн чангатгасаар ирсэн нь 2019, 2020, 2021, 2022 онуудад хийсэн тайлангаас харагдаж байна. Эдгээр тайланд Монгол Улс өмнө нь илэрсэн техникийн шаардлага хангасан зөрчлүүдийг арилгах талаар хийсэн ахиц дэвшилд дүн шинжилгээ хийсэн.
- 2020 оны аравдугаар сард Монгол Улс ФАТФ-ын хяналт шалгалтад хамрагдах субъект байхаа больсон нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо улам сайжруулж байгааг харуулж байна.
- Хамгийн сүүлд 2023 оны арванннэгдүгээр сарын 9-ний өдрийн шинэчилсэн мэдээллээр Монгол Улсыг нэг зөвлөмжийн дагуу дахин үнэлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээгээ сайжруулахаар хүчин чармайлт гаргаж байгааг онцолсон.

Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх төрийн бодлого, дэглэмээ бэхжүүлж байгаа нь олон улсын стандартыг баримталж, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллаж байгааг харуулж байгаа бөгөөд 2023 оноос хойш 2024 оны эхний улирал хүртэлх хугацаанд нийт 70 хэргийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн байна.

МУ-н МУТСТ тогтолцоо

Монгол Улс ФАТФ-тай төстэй бүс нутгийн байгууллага болох Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-т гишүүнчлэлээрээ дамжуулж үйл ажиллагаагаа явуулдаг. Манай улс 2004 оны 7 дугаар сард APG-д гишүүнээр элссэн бөгөөд Монгол Улсыг төлөөлж тус бүлгийн үйл ажиллагаанд Монголбанк ажилладаг. Одоогоор тус бүлэгт Ази номхон далайн бүс нутгийг хамарсан 41 улс гишүүнээр элсч, БНАСАУ, Кирибати Улс зэрэг 8 улс ажиглагчаар оролцож байна. Түүнчлэн, НҮБ, Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын 28 байгууллага тус бүлэгт ажиглагчаар оролцож байна. Тус бүлэг нь гишүүн орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд ФАТФ-ын 40 5 зөвлөмжийн дагуу Харилцан үнэлгээ хийж олон нийтэд нээлттэй цахим хуудсанд тус үнэлгээний үр дүнг танилцуулдаг. Монгол улсад МУТС-тэй холбогдон байгуулагдсан, арга хэмжээ авдаг байгууллага нь үндсэн чиг үүрэг, эрх хэмжээг нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар олгон

зохицуулж өгсөн Монгол банкны харьяа Санхүүгийн мэдээлэх алба, Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 70 дугаартай захирамжаар ФАТФ-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх харилцан үнэлгээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл зэрэг юм.

Санхүүгийн мэдээллийн албаны үндсэн чиг үүрэг нь санхүүгийн байгууллага, бусад хувь хүн, хуулийн этгээд болон аж ахуйн нэгжүүдээс сэжигтэй гүйлгээний тухай тайланг хүлээн авч, тэдгээрт дүн шинжилгээ хийн үр дүнг мөнгө угаахтай тэмцэх зорилгоор дотоодын хууль сахиулах байгууллагууд болон гадаадын Санхүүгийн мэдээллийн албадад дамжуулах үйл ажиллагаа юм. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкинд байгуулагдсан СМА нь эдгээр олон улсын зарчим, стандартыг хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулсаар ирсний үр дүнд тэрбээр олон улсад, ялангуяа Эгмонтод хүлээн зөвшөөрөгдсөн Төв Азийн орнуудаас хоёр дахь (Киргизийн СМА-тай хамт), Азийн орнуудаас 15 дахь СМА юм.

Үндэсний зөвлөлийн чиг үүрэг нь

- Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог тодорхой давтамжтайгаар үнэлэх харилцан үнэлгээний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг удирдан зохион байгуулах;
- Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулж уялдуулах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулах.

Хамтын ажиллагааны зөвлөлийн чиг үүрэг нь

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох зөвлөмж, санал гаргах;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг Монгол улсын хэмжээнд судлах, эрсдэлийн үнэлгээ хийх, үр дүн тооцох ажиллагааг хоёр жилд нэг удаа зохион байгуулах; Санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллага /ФАТФ/ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт (ФАТФ-ын 40 зөвлөмж)-ыг гаргасан бөгөөд тус стандартын дагуу улс

орнууд Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх үүрэгтэй.

- Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар зөвлөмж гаргах,
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, үр дүнгийн талаар мэдээлэл солилцох;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхтэй танилцаж мөрдүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний болон ХАЗ-өөс гаргасан Зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцтай танилцах, шаардлагатай бол хэрэгжилтийг хангаж ажиллахыг шаардах, гүйцэтгэлийг ХАЗ-өөр хэлэлцүүлэх, хугацаатай үүрэг даалгавар өгөх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангуулах зэрэг холбогдох арга хэмжээг авах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг олон улсын стандарт, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх Байгууллага /ФАТФ/-ын 40 зөвлөмжид нийцүүлэх талаар санал гарган танилцуулах;
- Гишүүн байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон бүс нутаг, олон улсын байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилтай уялдуулахад дэмжлэг үзүүлэх;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, хувийн хэвшил болон олон нийтэд зориулсан сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх;
- Санхүүгийн мэдээллийн албаны бүтэц, зохион байгуулалт, төсөв, үйл ажиллагааны зардлын талаар санал гаргах, танилцуулах, шийдвэрлүүлэх;
- ХАЗ-ийн дэргэдэх Ажлын хэсгийн хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй танилцах, хэрэгжүүлэх санал зөвлөмж, хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулах,
- ХАЗ-ын гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих.

Үндэсний эрсдэлийн үнэлгээний зорилго бол Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг ойлгох, хууль сахиулах, зохицуулах, урьдчилан сэргийлэх байгууллагуудын хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй хуваарилах, оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар тус эрсдэлийг бууруулахад орших ба анх 2016 онд хийсэн эрсдлийн үнэлгээг 2020 онд дахин хийсэн.

ФАТФ-ын зөвлөмж нь аливаа улс орны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгийн суурь болж байгаа олон улсын стандарт төдийгүй уг стандарт зөвлөмжийг хэрэгжүүлдэг улс орны хувьд санхүүгийн салбарт бусад улс оронтой хамтран таатай орчин бүрдэх үндэс болдог.

Иймд ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх, улмаар өөрийн улсын мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх тогтолцоог сайжруулж, чадавхыг бэхжүүлэх зорилгоор Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх шаардлага бий болдог ба Монгол улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2017-2020 оны үндэсний хөтөлбөр нь Засгийн газраар батлуулсан 10 зорилтоос бүрдсэн. 2019 оны 6 дугаар сард хөтөлбөрийн биелэлтийг үнэлүүлэхэд 90% байсан ба нэмэлт ажлын төлөвлөгөө нь Үндэсний хөтөлбөрийн биелэгдээгүй ажлуудын хэрэгжилтийг 73%-р хангажээ.

Зураг 1 Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн хамтын ажиллагааны бүтэц



2019 оны байдлаар үйл ажиллагаа нь жигдэрч, амжилттай хэрэгжиж байсан үндэсний хөтөлбөр тасалдахад хүрсэн гол шалтгаан нь цар тахал байсан ба дэлхий нийтийн цахимжилттай холбоотойгоор криптовалют, хөрөнгө зэргээр мөнгө угааж эхэлсэн байна.

Хувьсгалт тоон хөрөнгийн ангилал болох криптовалют нь санхүү, технологийн ландшафтыгцартахлынүеэсэрчимтэйгээрөөрчилжэхэлсэн.Төвлөрсөнбусблокчейн технологид суурилан ажилладаг Bitcoin, Ethereum болон бусад криптовалютууд нь банк, санхүүгийн байгууллага зэрэг зуучлагчийн шаардлагагүйгээр найдвартай, ил тод гүйлгээгээр ханган, бүрэн бүтэн байдал, хувиршгүй байдал, нууцлалыг хангахын тулд криптографийн зарчмуудыг ашигладаг. Блокчэйн буюу үндсэн технологи нь гүйлгээний өгөгдлийг агуулсан блокуудын гинжин хэлхээнээс бүрдэх бөгөөд криптографаар холбогдож, компьютерийн сүлжээнд түгээгдэж, ил тод байдлыг хангаснаар санхүүгийн салбар дахь өнгөлөн далдлалт, залилангаас сэргийлэх боломжуудыг олгож байлаа. Төвлөрсөн бус байдал (Decentralized) нь засгийн газрын хяналт эсвэл инфляцийн бодлогын эрсдэлийг бууруулж, эдийн засгийн эрх чөлөө, чөлөөт зах зээлийн зарчмыг дэмждэг ч криптовалютын зах зээлийн тогтворгүй шинж чанар нь хөрөнгө оруулагчдад эрсдэл учруулдаг ба үнэ нь дамын таамаглал, зах зээлийн мэдрэмжээс шалтгаалж хурдан хэлбэлздэг.

Дэлхийн зах зээлд шинээр нэвтэрсэн энэ ойлголт зохицуулалтын тодорхой бус байдал, хакердах, залилан мэхлэх зэрэг аюулгүй байдлын асуудалд мөн эмзэг цэг болоход хүргэж, улмаар болгоомжтой оролцох шаардлагатайг улам тодотгох нөхцөл байдал бүрдсээр байна.

Орчин үед нууц вэбсайтуудын тархалт нь мөнгө угаах гэмт хэрэгт нэрээ нууцлах, төвлөрлийг сааруулах, технологийн боловсронгуй байдлаар тодорхойлогддог шинэ хэмжигдэхүүнийг бий болгож байна. Энэхүү далд хүрээнд гэмт хэргийн байгууллагууд хууль бус хөрөнгө, хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг угаахын тулд криптовалют, виртуаль хөрөнгө, төвлөрсөн бус санхүүгийн (DeFi) платформ зэрэг шинээр гарч ирж буй технологиудыг ашиглаж эхэлжээ[21].

Криптовалютууд, ялангуяа биткойн нь уламжлалт санхүүгийн системд байдаггүй нэрээ нууцлах, төвлөрлийг сааруулах боломжийг бий болгож, мөнгө угаах хэрэгсэл гол хэрэгслүүдийн нэг болжээ. Гэмт этгээдүүд дижитал түрийвч, биржийн цогц сүлжээгээр дамжуулан гүйлгээний мөрийг нуун дарагдуулах, мөнгө угаах зорилгоор mixer, tumbler[22] гэх мэт арга техникийг ашигладаг. Мөнгө угаах үйлчилгээний зах зээл болох хууль бус хөрөнгийн гарал үүслийг нуун дарагдуулах компани, оффшор данс болон бусад механизмыг бий болгох чиглэлийн талбар нь нууц вэб болох хандлага гарчээ.

Криптовалютаас гадна онлайн тоглоомын платформ дахь виртуал хөрөнгө нь мөнгө угаах өөр арга замыг бий болгож байна. Гэмт хэрэгтнүүд эдгээр платформуудын хөрвөх чадвар, нэрээ нууцлах чадварыг ашиглан хөрөнгө мөнгөө нууцаар шилжүүлж, виртуал хөрөнгийг fiat валют[23] эсвэл хууль ёсны байдлаар угааж болох

[21] https://www.sec.gov/news/statement/crenshaw-defi-20211109

[22] Cryptocurrency холигч, өөрөөр “tumblers” гэдэг нь олон тооны криптовалютын гүйлгээг хооронд нь хольж, анхны эх үүсвэр рүүгээ буцаах замыг далдлах үйлчилгээ юм.

[23] Fiat валют нь алт, мөнгө зэрэг үнэт металлаар баталгааждаггүй мөнгөн тэмдэгт ба төв банкуудад хэдий хэмжээний мөнгө хэвлэгдэж байгааг хянадаг тул эдийн засагт илүү их хяналт тогтоох

бусад хөрөнгийн хэлбэрт хөрвүүлдэг аж.

Төвлөрсөн бус санхүүгийн (DeFi) платформууд гарч ирснээр мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл байдал улам бүр төвөгтэй болж байна. Эдгээр платформууд нь илүү их хувийн нууцлал, бие даасан байдлаар хангаж өгдөг ч хууль бус санхүүгийн үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд зохицуулагчид болон хууль сахиулах байгууллагуудад ихээхэн бэрхшээл учруулдаг[24].

Түгээмэл ашиглагдаж буй аргуудын нэг нь Initial Coin Offering[25] буюу хөрөнгө босголт байна. Мөнгө угаагч гэмт этгээдүүд хуурамч төслүүдэд зориулж хөрөнгө босгохын (ICO) тулд криптовалютыг ашиглан их хэмжээний мөнгийг хуулийн дагуух зах зээлд оруулдаг. Шинэ криптовалют эсвэл токен[26] бий болгосноор тэд хөрөнгө оруулагчдыг татаж, олсон орлогыг хууль бус зорилгоор ашиглах эрсдэл үүсдэг байна[27].

Үүний улмаас дэлхийн улсууд криптовальттай холбогдох зохицуулалтыг хийхээр оролдож буй бөгөөд арга хэмжээний ФАТФ (FATF) мөнгө угаах (AML) болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (CTF) журмыг дагаж мөрдөх виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд (VASPs) зориулсан удирдамжийг[28] шинэчлэн гаргасан. Энэхүү удирдамжид виртуал хөрөнгийн шилжүүлгийг илгээгч болон хүлээн авагчийн талаарх мэдээллийг уламжлалт санхүүгийн байгууллагуудтай адил цуглуулан хуваалцах, төвлөрсөн бус санхүү (DeFi), тогтвортой коинуудыг зохицуулах, эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, ойлгох, тэдгээрийг бууруулах зохих арга хэмжээг хэрэгжүүлэх, харилцагчийн хяналт шалгалт, гүйлгээний хяналт, сэжигтэй үйлдлийг мэдээлэх, улс орнууд, зохицуулах байгууллагууд болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих талаар зөвлөн, удирдамжид тусгасан байна.

Мөн ФАТФ-н удирдамжтай зэрэгцэн олны анхаарлыг татсан баривчилгаа хийсэн нь 2022 оны 2-р сард 2016 онд Bitfinex-ийг хакердаж хулгайлагдсан биткойноор ойролцоогоор 4.5 тэрбум доллар угаасан хэрэгт холбогдуулан хоёр хүнийг

боломж олгодог. Засгийн газраас бодлогын хүрээнд зохицуулалтаар зөвшөөрөгдөн гаргадаг тул хууль ёсны төлбөрийн хэрэгсэл байдаг.

Fiat мөнгө болон криптовалютын аль аль нь биет бус боловч Fiat валют АНУ-ын доллар гэх мэт засгийн газраас гаргасан валюттай холбоотой хууль ёсны төлбөрийн хэрэгсэл бөгөөд криптовалют нь өөрийн үнэ цэнийг өөрийн блокчейнээс олж авдаг дижитал хөрөнгө юм.

[24] "Statement on DeFi Risks, Regulations, and Opportunities", Commissioner Caroline A. Crenshaw, Nov. 9, 2021

[25] ICO гэдэг нь Initial Coin Offering гэсэн үгийн товчлол бөгөөд шинэ криптовалютын саналд зориулж хөрөнгө босгох үйл ажиллагааг нэрлэдэг. Бидний заншсаар шинэ компани хөрөнгийн зах зээлд гарах үед хөрөнгө босгодог IPO (Initial Public Offering)-тэй төстэй юм.

[26] Token нь ямар нэгэн блокчэйн дээрх актив хөрөнгийн илэрхийлэл бөгөөд ямар ч төрлийн харилцан солилцож болох үнэ цэнэ бүхий хөрөнгийг төлөөлүүлж болно. Токеныг тодорхой төслийг санхүүжүүлэх эх үүсвэрийг босгохын тулд ICO (Initial Coin Offering) эсвэл IEO (Initial Exchange Offering) хийх замаар нийтэд санал болгож зардаг бөгөөд үүнийг худалдаж авснаар тухайн этгээд уг төсөлд хөрөнгө оруулагч болно гэсэн үг юм. ICO гэдэг нь шинээр криптовалют, цахим мөнгө гаргах, хөгжүүлэх зорилгоор олон нийтээс хөрөнгө оруулалт татах ажиллагааг хэлнэ.

[27] https://www.investopedia.com/terms/i/initial-coin-offering-ico.asp

[28] https://www.fatf-gafi.org/en/publications/Fatfrecommendations/Guidance-rba-virtual-assets-2021.html

баривчилжээ[29]. Технологийн салбарын мэргэжилтнүүд ч блокчейн шинжилгээний хэрэгслүүдийг бүтээж, Chainalysis болон CipherTrace зэрэг компаниуд криптовалютын гүйлгээг хянах, хянахад туслах блокчейн шинжилгээний хэрэгслийг зах зээлд нийлүүлж эхэлсэн байна. Эдгээр хэрэгслийг хууль сахиулах байгууллагууд гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, мөнгө угаах үйл ажиллагааг таслан зогсооход ашиглаж байна[30].

Монгол банкны ерөнхийлөгчийн 2023 оны 1 сарын 25-ны өдрийн тушаалаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбогдох заалтуудыг нэмсэн бөгөөд энэ нь монгол улсын хувьд эрх зүйн бүрэн зохицуулалт болж чадахгүй байгаа юм.

Криптовалютад суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь криптовалютуудын өвөрмөц шинж чанар, салбарын хувьсан өөрчлөгдөж буй шинж чанараас шалтгаалан дараах асуудалтай тулгарч байна.

1. Нэр нууцлах систем ба нууцлал: Криптовалютууд олон түвшинд нэрээ нууцлах боломжийг олгодог тул шилжүүлэгдэж буй хөрөнгийн гарал үүслийг судлах, хууль бус үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийг илрүүлэхэд хүндрэл учруулдаг. Monero, Zcash зэрэг нууцлалт койн[31] нь нууцлалын нэмэлт давхаргыг бий болгож, хэрэг хянан шийдвэрлэх үйл явцийг удаашруулдаг[32].

2. Хил дамнасан гүйлгээ: Криптовалют валютын арилжигч, зуучлагчийн шаардлагагүйгээр хурдан, хялбар хил дамнасан гүйлгээг хийх боломжийг олгодог тул хууль тогтоогч, эрх баригчид мөнгө угаах үйл ажиллагааг үр дүнтэйгээр хянах, эрсдлийн үнэлгээ хийх, зохицуулахад хүндрэл учруулдаг.

3. Нэгдмэл зохицуулалт дутмаг байдал: Дэлхийн улс орнуудад криптовалюттай холбоотой эрх зүйн болон санхүүгийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн түвшин өөр өөр байгаагаас олон улсын түвшинд мөнгө угааж буй гэмт хэрэгтнүүдэд зохицуулалтын тогтолцооны алдаа, эрх зүйн хийдлийг ашиглах боломжийг бий болгож буй нь мөнгө угаах гэмт хэрэгт криптовалютыг ашиглаж буй байдлыг улам даамжруулж байна.

4. Технологийн нарийн төвөгтэй байдал, мэргэжлийн хомсдол: Криптовалют болон блокчэйн технологи нь нарийн төвөгтэй бөгөөд технологийн салбарын шаардлагаас шалтгаалан байнга хөгжиж, өөрчлөгдөж байдаг. Сүүлийн үеийн хөгжил дэвшил, шинэлэг шийдэл, арга зүйтэй байнга холбоотой байх нь хууль

---

[29] АНУ-н Хууль зүйн яам https://www.justice.gov/opa/pr/bitfinex-hacker-and-wife-plead-guilty-money-laundering-conspiracy-involving-billions

[30] https://www.chainalysis.com/blog/how-to-evaluate-blockchain-analysis-tools/

[31] Нууцлалт зоос нь нууцлалыг хадгалах, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах зарчим дээр суурилсан криптовалютуудын нэг төрөл бөгөөд гүйлгээ болон худалдаачдын мэдээллийг нуун дарагдуулах зорилготой юм.

[32] https://www.ledger.com/academy/glossary/privacycoin#:~:text=%E2%80%9CPrivacy%20coin%E2%80%9D%20is%20a%20type,conceal%20transactions%20and%20trader%20identities.

сахиулах байгууллага, зохицуулах байгууллагуудад бэрхшээлтэй байгаа гэмт хэргийн илрүүлэлтийн түвшинд сөргөөр нөлөөлж байгаа юм. Криптовалютын техникийн болон нарийн төвөгтэй шинж чанар нь тусгай мэдлэг, туршлага шаарддаг бөгөөд энэ нь зарим хууль сахиулах байгууллага, зохицуулах байгууллагуудад дутагдалтай байж болох юм. Энэхүү мэдлэгийн зөрүү нь үр дүнтэй мөрдөн байцаалт, хэрэгжилтэд саад учруулж болзошгүй.

5. DeFi, Peer-to-Peer шилжүүлэг болон DApps: Төвлөрсөн бус санхүүгийн (DeFi) платформууд болон төвлөрсөн бус програмууд (DApps) нь уламжлалт зарчмаар зуучлагчгүйгээр санхүүгийн үйлчилгээг санал болгож байгаа нь энэ платформуудыг мөнгө угаахад ашиглах боломжийн хувийг ихэсгэж байна.Эдгээр платформуудын төвлөрсөн бус шинж чанар нь зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэхэд улам хүндрэл учруулдаг. Peer-to-peer (P2P) гүйлгээ нь хувь хүмүүст гуравдагч этгээдийн оролцоогүйгээр шууд криптовалют солилцох боломжийг олгодог. Нууцлалын зэрэглэлтэй, хувийн мэдээлэл бүрэн шаарддаггүй эдгээр платформуудад гүйлгээг хянах, энэ харилцаатай холбогдсон хэргийг хянан шалгах үйл явцыг хүндрүүлэх бөгөөд мөнгө угаах эрсдэлийг нэмэгдүүлдэг.

6. Mixing and Tumbling Services: Гэмт этгээдүүд криптовалютын гүйлгээний гарал үүслийг нуун дарагдуулахын тулд mixing and tumbling үйлчилгээг ашиглаж байгаа эдгээр үйлчилгээ нь хөрөнгийн урсгалыг хянах, хяналт тогтооход хүндрэл учруулж, хууль сахиулах байгууллагад ихээхэн бэрхшээл учруулж байна.

7. Хөгжиж буй криптовалютууд: Шинэ криптовалютууд болон токенууд тасралтгүй гарч байгаа нь мөнгө угаах нэмэлт боломжуудыг бий болгож чадна. Гэмт этгээдүүд өөрсдийн мөнгө угаалт нь илрэхээс зайлсхийхийн тулд төдийлөн танигдаагүй эсвэл шинээр худалдаанд гарсан криптовалютын давуу талыг ашиглаж болно.

8. Хязгаарлагдмал хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо: Улс орнууд, зохицуулах байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах талаар хүчин чармайлт гаргаж байгаа ч дэлхийн хамтын ажиллагаанд хязгаарлалт байсаар байна. Энэ нь криптовалют дээр суурилсан мөнгө угаах гэмт хэргийг үр дүнтэй хянах, тэмцэхэд саад учруулж болзошгүй юм.

Эдгээр сорилтыг шийдвэрлэхийн тулд олон улсын зохицуулах байгууллага, хууль сахиулах байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хамарсан олон талт арга барил шаардлагатай. Дэвшилтэт аналитик болон блокчейн хянах хэрэгслүүдийг үргэлжлүүлэн хөгжүүлэх, түүнчлэн тодорхой, тууштай зохицуулалтуудыг хэрэгжүүлэх нь криптовалют дээр суурилсан мөнгө угаахтай тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Мөнгө угаах гэмт хэрэгт криптовалютыг ашиглаж буй байдад дэлхий дахины улс орнууд өөрсдийн эрх зүйн тогтолцоонд тулгуурлан олон төрлийн зохицуулалт хийж байна.

1. Америкийн засгийн газар криптовалют дээр суурилсан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлж буй хэмээн зарлагдсан. Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (FinCEN) болон Үнэт цаас, биржийн хороо (SEC) зэрэг зохицуулах байгууллагууд криптовалютын гүйлгээнд тавих хяналтыг нэмэгдүүлж, биржүүд болон бусад үйлчилгээ үзүүлэгчдээс мөнгө угаахтай тэмцэх (AML) болон KYC журмыг чанд мөрдөхийг шаардаж байна. Нэмж дурдахад, АНУ-н татварын алба (IRS) криптовалютын гүйлгээтэй холбоотой татварын үүргээ биелүүлэх ажлыг эрчимжүүлж байна[33].

Хууль зүйн яам (DOJ) болон Холбооны мөрдөх товчоо (ХМТ) зэрэг хууль сахиулах байгууллагууд мөнгө угаах, залилан мэхлэх, darknet зах зээл дээрх хууль бус үйл ажиллагаа зэрэг криптовалюттай холбоотой гэмт хэргүүдийг мөрдөн шалгаж, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцож байна[34].

Цаашилбал, криптовалютын эргэн тойронд зохицуулалтыг бэхжүүлэх хууль тогтоомжийн хүчин чармайлт гарсаар байна. Тухайлбал, 2020 оны Криптовалютын тухай хуулийг нэвтрүүлэх нь дижитал хөрөнгийн зохицуулалтын тогтолцоог тодорхой болгох, хууль бус зорилгоор буруугаар ашиглахтай тэмцэх зорилготой юм.

Ерөнхийдөө Америкийн засгийн газрын арга барил нь криптовалютад суурилсан мөнгө угаах болон хууль бус санхүүжилтээс үүдэлтэй сорилтуудыг шийдвэрлэхийн тулд зохицуулалтын хэрэгжилт, хууль сахиулах үйл ажиллагаа, хууль тогтоох санаачлагыг хослуулсан олон талт стратегийг хамарч байна.

2.Нэгдсэн Вант Улс: Их Британи нь Мөнгө угаахтай тэмцэх (AML) журмын дагуу криптовалютын солилцоо болон үйлчилгээ үзүүлэгчдийг зохицуулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Санхүүгийн үйл ажиллагааны газар (FCA) нь эдгээр журмын хэрэгжилтэд хяналт тавьж, крипто бизнес эрхлэгчдэд дагаж мөрдөх удирдамж гаргасан[35].

Тус улс Европын Холбооны Мөнгө угаахтай тэмцэх 5 болон 6-р заавар (5AMLD, 6AMLD)-д тусгагдсан мөнгө угаахтай тэмцэх, журмын шаардлагуудыг өмнө нь баталсан тул крипто хэлцлийн Их Британийн зохицуулалтын хүрээ нь ЕХ-той нийцдэг аж. Гэсэн хэдий ч засгийн газар тус улсыг крипто технологи, хөрөнгө оруулалтын дэлхийн төв болгох дэд бүтцийг байгуулахаар төлөвлөж байгаагаа саяхан л зарласан тул Их Британийн үндэсний хууль тогтоомжийн боловсруулалт эхний шатандаа байна.

Их Британид крипто хөрөнгийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй бүх компаниуд 4А зөвшөөрлийг (Их Британид крипто лиценз гэж нэрлэдэг) авахдаа Санхүүгийн зохицуулах газарт (FCA) бүртгүүлэх ёстой болдог бөгөөд Санхүүгийн зохицуулах газар нь одоо байгаа Мөнгө угаахтай тэмцэх журмыг

[33] https://www.investopedia.com/cryptocurrency-regulations-around-the-world-5202122
[34] Ministry of Justice, Federal information
[35] https://rue.ee/crypto-regulations/uk/

мөрддөг, зохицуулагчид болон зах зээлд оролцогчдын хоорондын яриа хэлэлцээг удирдан чиглүүлдэг хяналтын байгууллага. Байгуулгынхаа чиг үүргийн хүрээнд Санхүүгийн зохицуулах газар саяхан хоёр өдрийн CryptoSprint хамтарсан арга хэмжээ зохион байгуулж, эрх баригчид, зохицуулагчид инновацлаг санаа дэвшүүлэгчидтэй уулзаж, крипто бодлогыг боловсруулах талаар ярилцаж, хамтран ажиллахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж буй юм[36].

Криптохөрөнгө нь тодорхой төрлийн тархсан нягтлан бодох бүртгэлийн технологи (DLT) ашигладаг, цахим хэлбэрээр шилжүүлэх, хадгалах, зарах боломжтой үнэт хөрөнгө, гэрээний эрхийн дижитал дүрслэл хэмээн Их Британийн хууль тогтоомжид тодорхойлогдсон байдаг бөгөөд одоогоор крипто хөрөнгийн зохицуулалттай токен ба зохицуулалтгүй токен хэмээн 2 ангилж үзэж байгаа ажээ.

3. Япон: Япон улс криптовалютын солилцооны лицензийн системийг бий болгож, AML болон KYC журмыг чанд мөрддөг. Тус улсын Санхүүгийн Үйлчилгээний Агентлаг (FSA) эдгээр солилцоог дагаж мөрдөх, мөнгө угаах эрсдэлийг бууруулахын тулд нарийн хяналт тавьдаг. Япон улс крипто хөрөнгийг хууль эрх зүйн үүднээс тодорхойлсон дэлхийн анхны улс ба криптовалютыг зохицуулах санхүүгийн, эрх зүйн зохицуулалтыг анхлан боловсруулсан. 2015 онд Японы засгийн газар крипто биржүүдийг бүртгүүлж, лицензтэй байхыг зөвлөөд 2016 онд Гэмт үйл ажиллагаагаар олсон ашиг, мөнгийг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү акт нь дижитал хөрөнгийн арилжаа, шилжүүлгийг мөн хамарсан ба 2020 онд засгийн газар виртуал валют дээр тавих хяналтаа чангатгаснаар криптовалютыг удирдах хүрээгээ бэхжүүлсэн[37].

4. Австрали: Австрали улс криптовалютын солилцоог зохицуулах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (CTF) тухай хуулийг дагаж мөрдөх зохицуулалтыг нэвтрүүлжээ. Австралийн гүйлгээний тайлан, шинжилгээний төв (AUSTRAC) энэ төрлийн солилцоог хянаж, сэжигтэй гүйлгээг хянадаг. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (AML/CTF Act) нь Австралид үйл ажиллагаа явуулж буй криптовалютуудын биржүүдийн үйл ажиллагаандаа баримталж мөрдлөг болгодог хууль бөгөөд тус улсын санхүүгийн тагнуулын агентлаг болох Австралийн Гүйлгээний тайлан, шинжилгээний төвд (AUSTRAC) бүртгүүлэхийг шаарддаг ажээ. Бүртгүүлсний дараа үйл ажиллагааг тайлагнах, харилцагчийн баталгаажуулалт, бүртгэл хөтлөх үүрэг зэрэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (CTF) тухай хуулийг дагаж мөрдөх ёстой болдог. Эдгээр үйл ажиллагааг тогтмол тайлагнах шаардлагатайгаас гадна Харилцагчаа-мэдэх-шаардлага(KYC) буюу биржүүд мөнгө угаах болон бусад хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд харилцагчдынхаа хувийн

[36] FCA official website, https://www.fca.org.uk/news/news-stories/guidance-crypto-firms-help-them-comply-marketing-rules#:~:text=Since%208%20October%202023%2C%20firms,approved%20by%20an%20authorised%20firm.

[37] https://www.globallegalinsights.com/practice-areas/blockchain-laws-and-regulations/japan/#:~:text=In%20Japan%2C%20there%20is%20no,(the%20%E2%80%9CPSA%E2%80%9D

мэдээллийг баталгаажуулж, гүйлгээний бүртгэл хөтлөхийг шаарддаг. Австралийн биржүүд олон улсад хил дамнуулан мөнгө шилжүүлэх заавар болон босго гүйлгээг (10,000 AUD-аас дээш гүйлгээ) AUSTRAC-д мэдээлэх ёстой байдаг бөлгөө.

III. ДҮГНЭЛТ

Дижитал хөрөнгийн зохиомол нэр, төвлөрсөн бус шинж чанараас шалтгаалан криптовалютаар дамжуулан мөнгө угаах нь дэлхий даяар үйлдэгдэж байна. Гэмт хэрэгтнүүд хууль бус хөрөнгийн гарал үүслийг нуун дарагдуулахын тулд нууцлалт байдал, төвлөрсөн бус байдал гэх мэт шинж чанарыг ашигладаг тул хууль сахиулах болон зохицуулагчид гүйлгээг хянах, хянахад бэрхшээлтэй болгодог ажээ. Хар тамхины наймаа, терроризмыг санхүүжүүлэх, кибер гэмт хэрэг зэрэг хууль бус үйл ажиллагаанд криптовалютыг өргөнөөр ашиглаж байгаа нь энэ цахим орон зайд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хатуу арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулж байна.

Дэлхийн улс орнуудын засгийн газрууд энэ асуудлыг цогц зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авч байгаа ба криптовалютын биржүүд болон үйлчилгээ үзүүлэгчдээс мөнгө угаахтай тэмцэх (AML) болон үйлчлүүлэгчээ-мэдэх (KYC) стандартыг чанд мөрдөхийг шаардах нь энэ арга хэмжээний гол алхам болох юм. Эдгээр журмууд нь үйлчлүүлэгчийг баталгаажуулах, гүйлгээний хяналт тавих, сэжигтэй үйл ажиллагааг санхүүгийн тагнуулын нэгжүүдэд мэдээлэх үүргийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд хүлээлгэдэг.

Хил дамнасан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд тухайн улсын зохицуулалтын арга хэмжээнээс гадна олон улсын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох, олон улсын байгууллагуудаас зөвлөмж авах зэрэг нь чухал юм. ФАТФ (FATF), APG зэрэг мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэгч байгууллагууд эрх зүйн болон санхүүгийн зохицуулалтын тогтолцоондоо дагаж мөрдөх удирдамж, зөвлөгөөгөөр улс орнуудыг хангадаг.

Хууль сахиулах байгууллагууд криптовалюттай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд блокчейн аналитик гэх мэт технологийн дэвшлийг тоон гүйлгээний мөрдөх чадварыг сайжруулах, сэжигтэй хэв маягийг тодорхойлоход ашиглаж байна.

Зохицуулалтын хяналт, хэрэгжилт, технологийн шинэчлэл, олон улсын хамтын ажиллагааг хослуулснаар дэлхийн хамтын нийгэмлэг криптовалютаар дамжуулан мөнгө угаахтай тэмцэх, дэлхийн хэмжээнд санхүүгийн системийн нэгдмэл байдлыг хамгаалахад ихээхэн ахиц дэвшил гаргах боломжтой байна.

IV. САНАЛ

Монгол Улс криптовалютаар дамжуулан мөнгө угаах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд АНУ, Их Британи, Япон, Австралийн зохицуулалтын арга хэмжээ, туршлагыг хослуулан авч хэрэгжүүлэх боломжтой.

1. Зохицуулалтын тогтолцоог бий болгох: Бирж, үйлчилгээ үзүүлэгч зэрэг криптовалютын бизнест зориулсан эрх зүйн зохицуулалтын цогц тогтолцоог боловсруулах.
2. Үйлчлүүлэгчээ-мэдэх (KYC) процедурыг хэрэгжүүлэх: Мөнгө угаахтай тэмцэх дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд бүх криптовалютын гүйлгээнд харилцагчийн баталгаажуулалтыг хянах, нэрээ нууцлах, залилан хийх гүйлгээ хийхээс урьдчилан сэргийлэх.
3. Гүйлгээний хяналт ба тайлан: Криптовалютын бизнест сэжигтэй үйлдлүүдийн гүйлгээг хянаж, санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэхийг шаардах. Их хэмжээний мөнгөн дүнтэй, ер бусын, эсвэл хууль бус гүйлгээг мэдэгдэх зэрэг үйл ажиллагаа хамаарна.
4. Олон улсын хамтын ажиллагаа: Криптовалютын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх мэдээлэл, туршлагыг бусад улс орон, ФАТФ (FATF) зэрэг олон улсын байгууллагуудаас судлан, хамтран ажиллах.
5. Blockchain Analytics ашиглах: Дижитал гүйлгээний сэжигтэй үйлдлийг мөрдөх, тодорхойлохын тулд блокчейн аналитик хэрэгслийг ашиглах. Энэхүү технологи нь ил тод байдлыг сайжруулж, мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэхэд хууль сахиулах байгууллагад туслана.
6. Олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх: Олон нийт болон нийгмийн институтуудын гишүүдийн дунд криптовалют дээр суурилсан мөнгө угаах эрсдэлийн талаарх мэдлэг, боловсролыг сурталчилснаар хууль бус үйл ажиллагаанд санамсаргүй, болгоомжгүйгээр оролцохоос сэргийлнэ.
7. Тогтмол аудит, шалгалт: Криптовалютын бизнест тогтмол аудит, шалгалт хийж, Мөнгө угаахтай тэмцэх дүрмийн зохицуулалтыг дагаж мөрдөх. Энэ нь мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд тусална.

V. НОМЗҮЙ

1. “Мөнгө угаах гэж юу вэ?”, Financial Action Task Force (FATF). https://www.fatf-gafi.org/about/faqs/faqs-mutual-evaluation.html#
2. АНУ-н санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ. https://www.fincen.gov/what-money-laundering#:~:text=Money%20laundering%20involves%20disguising%20financial,with%20an%20apparently%20legal%20source.
3. “Мөнгө угаах гэж юу вэ?”, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC). https://www.unodc.org/e4j/en/money-laundering/module-1/key-issues/what-is-money-laundering.html
4. https://www.unodc.org/unodc/en/money-laundering/index.html
5. ЭХТА, 17.3-р зүйл
6. https://corporatefinanceinstitute.com/resources/career-map/sell-side/risk-management/money-laundering/
7. https://www.fatf-gafi.org/en/the-fatf/who-we-are.html
8. https://www.investopedia.com/terms/s/smurf.asp
9. https://www.idenfy.com/blog/shell-companies-money-laundering/#:~:text=A%20shell%20company%20is%20a,much%20income%20on%20their%20own.
10. Санхүүгийн зохицуулах хороо. http://www.frc.mn/resource/frc/Document/2020/05/29/459fwket7yfjc5nv/sanhuu%20nom.pd
11. https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=29&active=1&sort=title&page=1
12. https://legalinfo.mn/mn/detail?lawId=9242
13. https://legalinfo.mn/mn/detail/11634
14. https://index.baselgovernance.org/ranking
15. “Монцаме агентлаг” 2023.11.29-ний нийтлэл
16. https://www.fatf-gafi.org/content/fatf-gafi/en/publications/Mutualevaluations/fur-mongolia-2023.html
17. https://www.sec.gov/news/statement/crenshaw-defi-20211109
18. “Statement on DeFi Risks, Regulations, and Opportunities”, Commissioner Caroline A. Crenshaw, Nov. 9, 2021
19. https://www.investopedia.com/terms/i/initial-coin-offering-ico.asp
20. https://www.fatf-gafi.org/en/publications/Fatfrecommendations/Guidance-rba-virtual-assets-2021.html
21. АНУ-н Хууль зүйн яам https://www.justice.gov/opa/pr/bitfinex-hacker-and-wife-plead-guilty-money-laundering-conspiracy-involving-billions
22. https://www.chainalysis.com/blog/how-to-evaluate-blockchain-analysis-tools/

23. https://www.ledger.com/academy/glossary/privacy-coin#:~:text=%E2%80%9CPrivacy%20coin%E2%80%9D%20is%20a%20type,conceal%20transactions%20and%20trader%20identities.
24. https://www.investopedia.com/cryptocurrency-regulations-around-the-world-5202122
25. Ministry of Justice, Federal information
26. https://rue.ee/crypto-regulations/uk/
27. FCA official website, https://www.fca.org.uk/news/news-stories/guidance-crypto-firms-help-them-comply-marketing-rules#:~:text=Since%208%20October%202023%2C%20firms,approved%20by%20an%20authorised%20firm.
28. https://www.globallegalinsights.com/practice-areas/blockchain-laws-and-regulations/japan/#:~:text=In%20Japan%2C%20there%20is%20no,(the%20%E2%80%9CPSA%E2%80%9D).

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН САЛБАРААР ДАМЖУУЛАН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЧИГ ХАНДЛАГА ТҮҮНИЙГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАР ЗОХИЦУУЛАХ АСУУДАЛ

Г.Хишигдалай, Б.Хүслэн***

* *Монгол Улсын Их сургууль, Хууль зүйн сургууль, Японы эрх зүйн боловсрол судалгааны төв, V курсын оюутан. И-мэйл: khishgee3599@gmail.com*

** *Монгол Улсын Их сургууль, Хууль зүйн сургууль, Японы эрх зүйн боловсрол судалгааны төв, V курсын оюутан. И-мэйл: Xvslen4912@gmail.com*

ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улс 2015 он болон 2017 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр мөнгө угаах гэмт хэргийн талаар шинэчлэн найруулсан. Түүнчлэн 2019 онд Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас Монгол улсыг "Саарал жагсаалт"-д оруулснаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ шаардлага үүсэж улмаар 2021 онд ВХҮҮтХ-ийг баталсан. Тус хууль батлагдсантай холбоотойгоор ЭХ-ийн тусгай ангид виртуал хөрөнгөөр үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хоёр төрлийн гэмт хэргийг нэмэлтээр оруулсан. Өөрөөр хэлбэл, зөвхөн тус хоёр төрлийн суурь гэмт хэргийг үйлдэж байж виртуал хөрөнгөөр дамжуулж мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх боломжтой байна. Гэвч олон улсад виртуал хөрөнгө болон түүний үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй байж болох зуу гаруй төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Монгол Улсад ч мөн адил эдгээр тохиолдлууд гарах магадлал тун өндөр хэвээр байгаа тул энэхүү судалгаанд эдгээр асуудлаас урьдчилан сэргийлэх талаар санал дэвшүүлэв.

ТҮЛХҮҮР ҮГ

Виртуал хөрөнгө, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Мөнгө угаах гэмт хэрэг, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага

УДИРТГАЛ

Судалгааны хэрэгцээ, шаардлага

Монгол Улс 2019 оны 10 дугаар сард Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага болох ФАТФ[1]-ын Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх болон

[1] Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) [(FATF) Financial action task force] нь 1989 онд Их долоогийн санаачилгаар байгуулагдсан, олон улсын санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг

үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт (ФАТФ-ын 40 зөвлөмж)-ын 15 дугаар зөвлөмжийг хангаагүй гэх үндэслэлээр "Саарал жагсаалт"-д орсон. Гэсэн хэдий ч харьцангуй хурдан хугацаанд буюу ердөө нэг жилийн дараа 2020 оны 10 дугаар сард мөн жагсаалтаас гарсан гэдгээрээ олон улсад сайшаагдахуйц байж чадсан билээ.

Тус зөвлөмжийн 15-д "Улс орнууд виртуал хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг удирдах, бууруулах үүднээс виртуал хөрөнгөтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгч нарыг тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлд хамруулж ФАТФ-ын Зөвлөмжийн холбогдох заалтыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих арга хэмжээ авах шаардлагатай."[2] гэж зааснаар УИХ зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор виртуал хөрөнгийн үйлчилгээнд холбогдох үндэсний зохицуулалтын орчин бүрдүүлэх төлөвлөгөөний[3] дагуу ВХҮҮтХ-ийг баталж 2021 оны 12 сарын 27-ны өдөр баталж,[4] уг хууль нь 2022 оны 2 сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.[5]

Тус хууль батлагдсанаар СЗХ нь бүртгэх, үйл ажиллагааг нь хянахтай холбоотой 6 төрлийн журам батлах бүрэн эрхтэй болсон[6] бөгөөд нэмэлтээр 2 журам баталж, ВХҮҮ-ийн үйл ажиллагаа, түүний бүртгэл, аудит хийх байгууллагатай холбогдох нийт 8 журам хүчин төгөлдөр мөрдөгдөж байх[7] бөгөөд одоогийн байдлаар СЗХ-д хуульд заасны дагуу албан ёсоор бүртгэгдсэн нэр бүхий 12 ВХҮҮ байна.[8]

Мөн ВХҮҮтХ хуулийг даган ЭХ, МУТСтХ, СЗХЭЗБтХнийт 10 хуульд нэмэлт орсон бөгөөд МУТСтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т ВХҮҮ-ийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамруулсан.[9]

Учир нь блокчейн технологи түүнд үндэслэсэн виртуал хөрөнгө, түүнийг даган хөгжиж буй техник, технологийн шинэчлэлийг ашиглан гэмт хэрэгтнүүдийн мөнгө угаах арга замууд илүү нарийсаж, нэмэгдэх хандлагатай байна.

Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргүүдийн онцлогийг авч үзвэл, ихэвчлэн дижитал өгөгдөл, мэдээллийг аливаа техник, технологийг

дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс сэргийлэх бодлого боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус байгууллага юм. ФАТФ-ын зөвлөмжийг олон улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрдөг.

2 FATF, "INTERNATIONAL STANDARDS ON COMBATING MONEY LAUNDERING AND THE FINANCING OF TERRORISM & PROLIFERATION, The FATF Recommendations", 2023.11., (https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/recommendations/FATF%20Recommendations%202012.pdf.coredownload.inline.pdf Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.)

3 https://legalinfo.mn/mn/detail?lawId=210690&showType=1 Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

4 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390242606091 Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

5 https://www.parliament.mn/nn/16020/ Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

6 ВХҮҮтХ-ийн 10.9.1.

7 Санхүүгийн зохицуулах хороо, http://www.frc.mn/#/sct;id=419/doc/list/424 Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

8 Санхүүгийн зохицуулах хороо, "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан 2023", http://www.frc.mn/resources/Images/Document/202404/cRk75/%D0%9D%D1%8D%D0%B3%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB-final-2023.04.pdf Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

9 https://legalinfo.mn/mn/detail?lawId=9242 Сүүлд нэвтэрсэн: 2024.04.30.

ашиглан хакердах буюу “Rug-pulls”[10], “Address poisoning”(zero transfer)[11], “Seed phrase”[12]-ийг хакердах гэх мэт аргуудаар үйлдэгдэж байгаагаараа онцлогтой.

Тэгвэл Монгол Улсын ЭХ-ийн тусгай ангийн 18.19, 18.20 дугаар зүйлд заасан “Виртуал хөрөнгө”-той холбогдох гэмт хэргүүдийн заалт нь Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргүүдийн онцлогоос шалтгаалах гэмт хэргийн хүрээг хангалттай хэмжээнд хамарч чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Судлагдсан байдал

Мөнгө угаах гэмт хэргийн мөн чанар, ойлголт, өнөөгийн байдлын талаар эрдэж шинжилгээний өгүүлэл цөөнгүй нийтлэгджээ. Тухайлбал, М.Амина, Г.Мягмарцэрэн “Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн практик дахь хууль хэрэглээний тулгамдаж буй асуудал ба эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь”, Л.Галбаатар “Монгол улсад мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик”, Б.Досжан “Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг харьцуулан судлах нь”, Б.Ганболд “Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлд анхаарах асуудал”, Б.Ариунзаяа “Мөнгө угаах гэмт хэргийн субьектив талын тулгамдаж буй асуудал (харьцуулсан судалгаа)”, Ц.Цэлмэг “Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэж буй практикт хийсэн дүн шинжилгээ”, П.Анарзаяа Х.Мичидмаа “Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн ойлголт, олон улсын туршлага: монгол улс дах мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг боловсронгуй болгох асуудал \гадаад орнуудын туршлага\” зэрэг нэг сэдэвт бүтээлүүд гарсан байна.

Мөн Э.Мөнхболд “Мөнгө угаах гэмт хэргийн зохицуулалт, зүйлчлэлийн тулгамдсан асуудал” гэх эрх зүйн бакалаврын зэрэг горилсон бүтээл, М.Тамир “Мөнгө угаах гэмт хэргээс бизнесийн хэлцэл, гүйлгээг ялгах асуудал” хэмээх бизнесийн удирдлагын магистрын зэрэг горилсон бүтээл байна.

Дээрх судлаачдын судалгаа, шинжилгээний ажлын агуулгыг ерөнхийлөн нэгтгэж харвал, МУГХ практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, эрх зүйн хийдлийг тодорхойлж, тус гэмт хэргийн зохицуулалтыг боловсронгуй болгон хэрэглээний нэгдмэл байдлыг хангах арга замыг эрэлхийлж, хууль тогтоомжийг боловсронгуй

[10] “Rug-pulls” нь ихэвчлэн криптовалют болон төвлөрсөн бус санхүүгийн (DeFi) төслүүдтэй холбоотой хуурах тактик юм. Аливаа төслийн санаачлагчид эсвэл хөгжүүлэгчид төсөлд оруулсан бүх хөрвөх чадвар, хөрөнгөө гэнэт татан авч, хөрөнгө оруулагчдад ямар ч үнэ цэнэгүй виртуал хөрөнгө эсвэл токен үлдээхийг хэлнэ. Энэ нь гэнэтийн байдлаар тохиолдож, хөрөнгө оруулагчдыг ямар ч арга хэмжээ авах аргагүй болгож, санхүүгийн томоохон алдагдал хүлээлгэдэг. Виртуал хөрөнгийн салбарт “pump and dump” ч гэж нэрлэдэг.

[11] “Address poisoning” нь виртуал хөрөнгийн шилжүүлэг ашиглагддаг тоо, үсэгнээс бүрдсэн “address”-ийг хакердаж шилжүүлгийн замыг нь өөрчилж анх шилжүүлэх гэж байсан хаягаас өөр хаяг руу шилжүүлэхэд хүргэдэг арга.

[12] “Seed phrase” нь виртуал хөрөнгийг хадгалахад зориулсан “wallet” буюу хэтэвчийг удирдаж, хянаж, аюулгүй байдлыг нь хангахад ашигладаг санамсаргүй байдлаар сонгосон 12, 18, 24 үгээс бүрддэг хамгаалалтын систем гэж хэлж болно. Эдгээр үгс нь хэтэвчний аюулгүй байдал алдагдсан, гэмтсэн эсвэл нэвтрэх боломжгүй тохиолдолд хэтэвчийг буцаан сэргээхэд ашигладаг нөөц болдог.

болгох тэр дундаа мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг хуульчлах эсэх дээр дүгнэлт хийсэн бүтээлүүд байна.

Энэ ч утгаараа энэхүү судалгаа нь виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн чиг хандлага түүний эрх зүйн зохицуулалтыг уялдуулан авч үзсэнээрээ шинэлэг юм.

Судалгааны арга зүй

Тус судалгааны хүрээнд формал буюу хууль зүйн үнэлэлт дүгнэлт өгөх болон эрх зүйн харьцуулсан судалгааны аргыг суурь үндэслэл болгосон.

1. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ.

1.1. Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт.

Мөнгө угаах (англ. “Money laundering”) гэдэг нэршил нь АНУ-д 1930-аад оны үед үүссэн ба 1990-ээд оноос “non drug property” буюу хар тамхи, мансууруулах бодисын хууль бус орлого, түүний эргэлтийг хянах, илрүүлэх олон улсын хамтын ажиллагааны үр дүнд энэ төрлийн гэмт хэргийн хууль бус орлого нь ямар нэгэн байдлаар дүрсээ хувиргаж, өөр гэмт хэрэг болж байгааг олж тогтоосон үеэс эхлэн Олон улсын эрүүгийн эрх зүйн шинэ ойлголт болсон байна[13].

Мөнгө угаах гэдгийг хэл, утга зүйн талаас нь тодорхойлвол хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулалгүйгээр холбогдох хууль шүүхийн байгууллагын анхаарлын төвөөс холуур ашиглан хууль ёсны хөрөнгө болгох үйл явц[14] гэж судлаач нар тайлбарладаг бол Монгол хэлний их тайлбар толинд хууль зөрчиж олсон бохир мөнгийг гүйлгээнд оруулж өөрийн болгон арвижуулах явдал хэмээн тусгажээ. Дээрх хоёр тодорхойлолтоос үзэхэд мөнгө угаах гэмт хэрэг нь хууль бус үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгийг өөрийн өмчлөл эсхүл эзэмшилдээ авч, түүний эх үүсвэрийг нуун дарагдуулах зорилготой үйлдлийг ойлгож болохоор байна.

Нөгөө талаас гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж эдийн засгийн эргэлтэд оруулж, улмаар “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлого нь мөнгө угаах гэмт хэрэг юм. Мөнгө угаах гэмт хэрэг нь гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан хууль бус хөрөнгийг цэвэр мэт болгон анхны эзэн нь олж авах, ашиг хонжоо олох сэдэлтэйгээр үйлдэгддэг. Өөрөөр хэлбэл мөнгө угаах гэдэг нь хууль бус орлогоо хууль ёсны салбараар дамжуулж гарал үүслийг нь нуун дарагдуулах эцэст нь ашиг хонжоо олох үйлдлийг хэлдэг[15].

---

[13] Амарбаясгалан Б. “Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик. УДШ/хамтын бүтээл/”. УБ., 2022 он. 164 дэх тал.

[14] Financial Supervisory Agency, http://www.fin-fsa.fi/en/Supervision/Moneylaundering/Pages/Definitions.aspx. Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

[15] Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас, http://amlcft.mn/news/t-geemel-asuult-hariult-1?f-

Мөнгө угаах ажиллагааны зорилго нь богино хугацаанд их хэмжээний ашиг олох гэхээс илүүтэй, гол нь гэмт хэрэг үйлдэж олсон гэх ул мөр үлдээхгүй байх нь чухал байдаг тул хуулийн байгууллагын ажилтнуудыг төөрөгдүүлэхэд чиглэгдсэн, ойлгоход төвөгтэй олон хэлбэр, хувилбараар үргэлжлэн явагддаг нь илрүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулж байна.[16] Иймч утгаар орчин цагт мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд виртуал хөрөнгөөр дамжуулж техник технологи, программчлалыг ашиглах нь гэмт хэргээ нуун дарагдуулахад хамгийн тохиромжтой аргуудын нэг болоод байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь улс орны санхүүгийн системийн тогтвортой байдалд аюул заналхийлэл учруулах бөгөөд гэмт этгээд, гэмт бүлэг, зохион байгуулалттай бүлэглэлүүд гэмт хэргээс олсон орлого, хөрөнгөөр дамжуулан санхүүгийн системд өөрийн нөлөөг тогтоох, гэмт үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засагт хор уршигтай үйл ажиллагаа юм[17].

Мөнгө угаах гэмт хэрэг нь үндсэн 3 үе шаттай явагддаг.

1. Байршуулах үе /Placement/: Хууль бусаар олсон мөнгө, эд зүйлийг хаа нэгтээ байршуулдаг. Тухайлбал: Өөр хүний нэр дээрх хадгаламж болон харилцах данс нээлгэх, үнэт цаас, чек худалдан авах, алт үнэт зүйлийг хадгалуулах гэх мэт.
2. Нуун далдлах үе /Layering/: Тухайн мөнгө, эд зүйлсийн гарал үүслийг нь нуун далдлах зорилгоор байршуулсан зүйлээрээ хөрөнгө оруулалт, хандив тусламж, хүүтэй зээл, бусдын нэр объект, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах, асрамжийн болон буяны байгууллага, сан, компани, банк байгуулах зэрэг үйлдэл.
3. Эргэлтэд оруулах үе /Integration/: Гарал үүслийг нь нуусан мөнгийг хууль ёсны эдийн засгийн эргэлтэд оруулдаг.[18]

Дээрх байдлаар гэмт хэрэгтнүүд нь мөнгө угаах гэмт хэргийн улмаас олсон орлогоо чөлөөтэй захиран зарцуулах үүднээс тус орлогоо хууль ёсны мэт болгож мөнгө цэвэрлэж угаах, буцаагаад гүйлгээнд оруулах зорилготой байдаг.

1.2. Монгол Улс дахь мөнгө угаах гэмт хэргийн эсрэг эрх зүйн зохицуулалт.

Монгол Улс 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын

bclid=IwZXh0bgNhZW0CMTAAAR2QYZNlRPyZi0Zo-phvuai4nQIA-MF7-3BtbrGByhGS-ij8JVs-F09k0Dv4_aem_ASQAO63kS4lC0_quAmJ17sm3uARPcObWIwL888Z2MiCXt_s1tFv6Zy0zR8uG-jXp5oFn3dxcg5zpb9dQO1ERFnXzr Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

[16] Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын “Эдийн засгийн гэмт хэрэг II”. УБ., 2018 он. 195 дахь тал.

[17] Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”, 2016 он.

[18] Ц.Цэлмэг “Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэж буй практикт хийсэн дүн шинжилгээ” (2023), 3 дахь тал.

конвенц”-д нэгдэн орж[19], 2004 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлж, Фатф-ын салбар байгууллага болох Ази, Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага /APG/-д элсэн орсноор[20] мөнгө угаахтай тэмцэх олон улсын стандартуудыг мөрдөн ажиллах үүрэг хүлээж, улмаар мөнгө угаах үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ийм төрлийн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулах холбогдох үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актуудыг дээр дурдсан олон улсын гэрээ, конвенц, стандартуудад нийцүүлэх ажил үе шаттайгаар хэрэгжиж эхэлсэн.

Манай улс 2002 онд батлагдсан Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийн талаар хуульчилж байсан. Улмаар 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр мөнгө угаах гэмт хэргийн суурь өөрчлөлтийг анх тусгаж өгсөн хэдий ч авлига, татвар төлөхөөс зайлсхийх, хууль бус зэвсгийн наймаа зэрэг зарим гэмт хэргүүдийг суурь гэмт хэрэгт тооцоогүй нь учир дутагдалтай байсан. 2007 оноос хойш ФАТФ-ын идэвхтэй хяналтад байсан бөгөөд тус байгууллагаас 2013 онд хяналт шалгалт явуулахад ФАТФ-ын зөвлөмжийг бүрэн биелүүлж чадаагүй гэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож чадаагүй гэх үндэслэлээр “Саарал жагсаалт”-д Монгол Улсыг оруулсан[21]. Тус жагсаалтаас гарахын тулд манай улс хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүднээс 2013 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтоох зорилгын хүрээнд хуулийг шинэчлэн найруулсан.

МУТСтХ-д “Мөнгө угаах” гэх ойлголтыг “энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг”[22] ойлгоно хэмээн тодорхойлсон байна.

Түүнчлэн 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний

[19] Монгол Улсын Гадаад харилцааны яам, Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний жагсаалт. 2015.12.

[20] “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэнцэх асуудал” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018. 12 дахь тал. “Монгол Банкны санхүүгийн мэдээллийн албаны дарга Х. Батчулууны итгэл.” (Монгол улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал).

[21] Мөнхболд Э. “Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн тулгамдсан асуудал” (2020), 19-20 дахь тал.

[22] МУТСтХ 3.1.1.

бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” хэмээн хуульчилсан байна.

МУГХ-ийн бусад гэмт хэргүүдээс ялгагдах шинж нь суурь гэмт хэрэг өмнө нь үйлдэгдсэн байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, суурь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө гэдгийг мэдсээр байж байршуулж, нуун далдалж, эргэлтэд оруулсан үйлдэл юм. “ФАТФ”-аас мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт 21 төрлийн гэмт хэргийг оруулан тооцсон байдаг[23].

Монгол Улсын хувьд 2015 оны Эрүүгийн хуульд “Гэмт хэргийн улмаас…” гэж зааснаас үзэхэд суурь гэмт хэргүүдийг тусгайлан заалгүйгээр Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүхий л гэмт хэрэг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болохоор зохицуулсан агуулгатай буй мэт харагдаж байна.

1.3. Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах чиг хандлагууд.

Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн чиг хандлагыг харвал, тус гэмт хэрэг нь 2020 оноос эхлэн жил бүр гарах тохиолдол нь өсөн нэмэгдэх хандлагатай байна.[24]

Мөнгө угаах гэмт хэргийн гол зорилго нь мөнгөн хөрөнгийн гэмт хэргийн гарал үүслийг нуун дарагдуулж, түүнийг хууль ёсны болгон зарцуулахад чиглэгддэг талаар дээр дурдсан. Тэгвэл, виртуал хөрөнгөд суурилсан мөнгө угаах гэмт хэргийн хүрээнд аливаа хөрөнгийг бэлэн мөнгө болгон хөрвүүлэх боломжтой үйлчилгээ рүү шилжүүлэхийн зэрэгцээ мөнгө хаанаас ирсэнийг нуун дарагдуулах нэмэлт арга хэмжээнүүдийг авдаг.

2019-2023 оны виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн чиг хандлагыг харвал дээрх байдлаар харагдаж байна.


Виртуал хөрөнгөд суурилсан мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхдээ дээр дурдсанчлан Rug-pulls, Address poisoning/ zero transfer, Seed phrase hack гэх мэт техник, технологи, программ ашигласан хакерын аргуудыг ашиглаж “illicit wallet” буюу хууль бус данс, хэтэвч рүү виртуал хөрөнгийг шилжүүлж аван, түүнийхээ дараа тус виртуал хөрөнгийг угаах буюу хууль ёсны болгож, бэлэн мөнгө болгон хөрвүүлэх боломжтой үйлчилгээ рүү шилжүүлэхдээ зураг 1-т харуулсан сувгуудыг ашиглах байдлаар виртуал хөрөнгийн салбараар дамжуулсан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх хандлагатай байна.

---

[23] Financial Action Task Force website. https://www.fatf-gafi.org/glossary/d-i/ Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

[24] Chainalysis, “The 2024 Crypto Crime Report”, https://go.chainalysis.com/rs/503-FAP-074/images/The%202024%20Crypto%20Crime%20Report.pdf?version=0, Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

Зураг 1[25]



1.3.1. Виртуал хөрөнгийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болох шинж тэмдгүүд.

ФАТФ-ын глобал сүлжээгээр 2017 оноос хойш цуглуулсан зуу гаруй тохиолдлын судалгаа, ном зохиолын тойм, нээлттэй эх сурвалжийн судалгаагаар тогтоогдсон сэжигтэй шинж тэмдгүүдийг олж тогтоосон байна. Гэвч нэг шинж тэмдэг байгаа нь заавал гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илэрхийлэх албагүй. Ихэнхдээ гүйлгээнд бизнесийн логик тайлбаргүй олон шинж тэмдгүүд илрэх нь гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааны сэжиглэлийг төрүүлдэг. Шинж тэмдэг илэрч байгаа нь цаашид нягтлах, дэлгэрүүлж шалгах шаардлагатай бол гүйлгээг мэдээлэхийг дэмжиж байгаа гэсэн үг юм.[26]

Уг судалгаанд гэмт хэрэгтэй холбогдох шинж тэмдгүүдийг тодорхой төрлийн багцуудад ангилсан байна. Үүнд:

Гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд

Гүйлгээний давтамж болон хэмжээтэй холбоотой шинж тэмдгүүд:

- Виртуал хөрөнгийн гүйлгээг (жишээ нь арилжаа болон шилжүүлэг) бэлэн мөнгөтэй ижил баримт материал хадгалах болон мэдээлэх ёстой босго дүнгээс доогуур, жижиг дүнгээр хуваан хийх;
- Өндөр дүнтэй олон гүйлгээ хийх

[25] Мөн тэнд.

[26] ФАТФ-ын тайлан “Виртуал хөрөнгийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болох шинж тэмдгүүд” 2020 оны 9 сар. /https://fiu.mongolbank.mn/file/files/documents/cma/guide20220201.pdf Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

- Ойрхон давтамжтай, тухайлбал 24 цагийн дотор;
- Огцом өөрчлөгдсөний дараа хэвийн гүйлгээ хийгдэх, түүний дараа урт хугацаанд ямар нэг гүйлгээ хийгдэхгүй байх ялангуяа рэнсомвэйртэй (ransomware) холбоотой кейсийн үед их тохиолддог;
- Шинээр нээсэн болон өмнө нь идэвхгүй байсан данс ашиглах.

- ВХ-ийг биржид хадгалж байснаа гэнэт –
  - Өөр виртуал хөрөнгөөр солих ажиллагаа хийхгүйгээр виртуал хөрөнгийг шаардлагагүй гүйлгээний шимтгэл төлж эргүүлэн татах;
  - Ямар нэгэн бизнесийн үндэслэл тайлбаргүйгээр (портфолио үүсгэх г.м.), нэмэлт гүйлгээний төлбөр төлж виртуал хөрөнгийг олон төрлийн виртуал хөрөнгөд хувиргах;
  - ВХҮҮ-ээс виртуал хөрөнгийг эргүүлэн татаж хувийн хэтэвчиндээ шууд авах. Энэ нь бирж болон ВХҮҮ-ийг мөнгө угаахад ашиглаж буй хэлбэр юм.

Гүйлгээ хийж буй хэлбэртэй холбоотой шинж тэмдгүүд

Шинэ хэрэглэгчтэй холбоотой гүйлгээ:

- ВХҮҮ-тэй шинээр харилцаа үүсгэхдээ өндөр дүнтэй хөрөнгийг байршуулах бөгөөд хөрөнгийн дүн нь харилцагчийн мэдээлэлтэй уялдахгүй байх.
- ВХҮҮ-тэй шинээр харилцаа үүсгэхдээ өндөр дүнтэй хөрөнгийг байршуулж, эхний өдрөө хуримтлалаа тэр чигт нь ашиглах, харилцагч нь нийт дүнгээр юм уу өндөр дүнгээр арилжаа хийж эхлэх болон харилцагч дараа өдөр нь бүх мөнгөө эргүүлэн татах гэх мэт. Ихэнх виртуал хөрөнгө нь орлогын гүйлгээний хязгаартай байдаг тул биржийн бус арилжаагаар дамжуулан өндөр дүнгээр хөрөнгө угааж болдог.

Нийт хэрэглэгчдэд хамааралтай гүйлгээ:

- Тодорхой бизнесийн болон логик үндэслэлгүй олон виртуал хөрөнгө, олон данс ашиглан хийсэн гүйлгээнүүд.
- Виртуал хөрөнгийн нэг данс руу олон удаа (тухайлбал өдөр бүр, долоо хоног бүр, сар бүр гэх мэт) шилжүүлэг хийх –
  - Шилжүүлгийг нэгээс олон хүмүүс хийх;
  - Шилжүүлгийг нэг болон түүнээс дээш тооны хүмүүс ижил IP хаягаас хийх;
  - Шилжүүлгийг өндөр дүнгээр хийх.

Нэрийн нууцлалтай холбоотой шинж тэмдгүүд

- Нэмэлт гүйлгээний шимтгэлийг үл харгалзан харилцагч нь нэгээс олон төрлийн ВХ-ийг хамруулсан гүйлгээ хийх, тэр дундаа өндөр түвшинд нэрээ нууцлах боломжтой “нэрээ нууцалсан криптовалют (ННК, anonymity-

enhanced cryptocurrency) эсвэл хувийн койн (Privacy coin)" зэрэг ВХ-ийг ашиглах.

- Харилцагч нь P2P (хэрэглэгч хоорондын дундын зуучлалгүй харилцаа – peer to peer) биржийн цахим хуудаст бүртгэлгүй/тусгай зөвшөөрөлгүй ВХҮҮ хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх, ялангуяа харилцагчийн нэрийн өмнөөс их хэмжээний ВХ-ийг арилждаг бөгөөд бусад биржтэй харьцуулахад өндөр дүнтэй шимтгэл авдаг байх. Эдгээр P2P гүйлгээг хөнгөвчлөх зорилгоор банкны данс ашиглах.
- Тодорхой үндэслэл бүхий тайлбаргүйгээр P2P платформтой холбоотой хэтэвчнээс ВХ-ийн хэвийн бус (хэмжээ болон тооны хувьд) гүйлгээг хийж, биржээс бэлэн мөнгө гаргах гэх мэт.

Шилжүүлэгч, хүлээн авагчтай холбоотой шинж тэмдгүүд

Данс нээхэд ажиглагдсан хэвийн бус зүйлс:

- ВХҮҮ-ийн арилжааны хязгаар болон татах боломжтой дүнгийн хязгаарлалтаас зайлсхийх зорилгоор өөр нэрээр тусдаа данс үүсгэх.
- Сэжигтэй гэж өмнө нь илэрсэн, хориг арга хэмжээнд орсон бүс нутгийн болон итгэж болохгүй IP хаягаас шилжүүлсэн гүйлгээ байх гэх мэт.

Харилцагчийн таньж мэдэх явцын хэвийн бус зүйлс:

- Бүрэн бус ХТМ27 мэдээлэл өгөх, харилцагч нь ХТМ баримт бичиг болон хөрөнгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл гаргаж өгөхөөс татгалзах.
- Шилжүүлэгч/хүлээн авагчийн талаарх мэдээлэлгүй байх, гүйлгээ, хөрөнгийн эх үүсвэр нөгөө талын харилцааны талаар буруу мэдээлэл өгөх гэх мэт.

Бусад ердийн бус зан төлөвтэй холбоотой шинж тэмдгүүд

- Харилцагч нь мэйл хаяг, IP хаяг, санхүүгийн мэдээлэл зэрэг мэдээллээ байнга өөрчилдөг энэ нь мөн харилцагчийн дансыг өөр хүмүүс ашиглаж байгааг харуулдаг.
- Харилцагч их хэмжээний ашиг эсвэл алдагдалтай гүйлгээг тодорхой хүмүүстэй дахин дахин хийдэг. Энэ нь дансыг өөр хүмүүс булаан авсан, арилжааны замаар хохирогчийн хөрөнгийг шилжүүлж авах оролдлого болон ВХҮҮ-ийн дэд бүтцээр хөрөнгийн урсгалыг бүдгэрүүлэх мөнгө угаах схемийг илэрхийлж болно.

Хөрөнгийн эх үүсвэртэй холбоотой шинж тэмдгүүд

- Залилан, сүрдүүлгээр мөнгө авах, эсвэл "ransomware" схем, хориг арга хэмжээнд багтсан хаяг, "darknet" зах зээл болон бусад хууль бус цахим хуудастай холбогдсон виртуал хөрөнгийн данс, банкны карт ашиглан гүйлгээ хийх.

[27] ENG: KYC

- Виртуал хөрөнгийн гүйлгээний эх үүсвэр эсвэл хүлээн авагч нь цахим мөрийтэй тоглоомын үйлчилгээ байх гэх мэт.

Газар зүйн байршилтай холбоотой шинж тэмдгүүд

- Харилцагч хөрөнгийг шилжүүлсэн/хүлээн авсан бирж нь тухайн харилцагчийн болон биржийн бүртгэлтэй улс орон биш байх.
- Харилцагч нь зохих ХТМ арга хэмжээ авдаггүй, ВХҮҮ-дэд МҮТСТ хангалтгүй хяналттай нь тогтоогдсон өндөр эрсдэлтэй улс оронд байршсан ВХ-ийн бирж болон гадаад улсын мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ ашиглах.
- Харилцагч нь хөрөнгийг виртуал хөрөнгийн тодорхой зохицуулалтгүй болон МҮТСТ хяналтгүй улсад үйл ажиллагаа эрхлэгч ВХҮҮ-д шилжүүлэх[28] гэх мэт нийтдээ зуу гаруй шинж тэмдгийг тусгажээ.

2. МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль

ВХҮҮтХ нь ФАТФ-аас гаргасан зөвлөмж 15-н хэрэгжилтийг ханган Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх харилцан үнэлгээнд эрсдэлтэй орны тоонд оруулах эрсдэлээс хамгаалах зорилготой тухай тус хуулийн танилцуулгад[29] дурдсан байдаг. Тиймээс тус хуульд ВХҮҮ-д мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой дараах үүргийг хүлээлгэсэн.

Үүнд:

- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагч нь МҮТСТтХ, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системтэй байх;30
- Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологитой холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийсэн байх;31
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх;32
- Мөнгө угаах, мөнгө угаах гэмт хэрэгт холбогдуулан шалгагдсан бусад гэмт хэрэг, терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг

[28] Мөн тэнд. 7-19 дэх тал.

[29] Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлалаас, https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/01/VASP-%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1% 86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0.pdf .

[30] ВХҮҮтХ 7.1.6.

[31] ВХҮҮтХ 7.1.8.

[32] ВХҮҮтХ 7.1.9.

санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдоогүй байх;[33]

2.2. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

Монгол Улсад МУТСТ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг 2013 оны Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар зохицуулж байна. 2021 оны ВХУУтХ батлагдсантай холбогдуулан тус хуульд дараах агуулга бүхий нэмэлт өөрчлөлт орсон.

Үүнд:

- Мэдээлэх үүрэгтэй этгээдээр "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч"-ийг нэмсэн. Улмаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь тус хуульд заасан үүргийг хүлээсэн;34
- Мөн хуулийн мэдээлэх үүрэгтэй этгээдүүд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй виртуал хөрөнгийн гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэг хүлээсэн;35
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тус хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ.[36]

Дээрх хуулийн зохицуулалтуудаас үзвэл Монгол Улсад виртуал хөрөнгийн үйл ажиллагаа явуулах виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь МУТСТтХ-д заасан мэдээлэх үүрэгтэй бусад этгээд болох банк, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын адилаар мэдээлэх үүрэг хүлээсэн этгээд болж хуульд заасан гүйлгээний талаар мэдээлэх, харилцагчийг таньж мэдэх, тусгай хяналт тавих, нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглахгүй байх зэрэг үүргийг хүлээж байна.

2.3. Эрүүгийн хууль

ВХУУтХ батлагдсанаар ЭХ-д түүнтэй уялдаж нэмэлт өөрчлөлт орсон. Тус хуулийн 18.19 дүгээр зүйлд "Виртуал хөрөнгийн үйлчилгээний дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах", 18.20 дугаар зүйлд "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд арилжааг урвуулан ашиглах" гэх виртуал хөрөнгөтэй холбогдох 2 төрлийн гэмт хэргийг хуульчилсан байна.

Эдгээрээс үзэхэд, ЭХ-иар ВХ-тэй холбоотой хоёр төрлийн гэмт хэрэг мөнгө угаах /ЭХ 18.6/ гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох боломжтой байгаа нь ЭХ-д тусгагдаагүй дээр дурдсан виртуал хөрөнгөтэй холбоотой гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд гарсан тохиолдолд МУГХ-ийн шинжийг хангах, түүнийг

[33] ВХУУтХ 7.1.6.
[34] МУБТСТтХ 4.1.10.
[35] МУБТСТтХ 7.1.
[36] МУБТСТтХ 19.1.

хэрхэн шийдвэрлэх талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай бус байна гэж үзэж болохоор байна.

Тодруулбал, ЭХ-ийн 18.19-р зүйл заалт нь ерөнхийдөө “market manipulation” буюу дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцож хууль бусаар өөрт давуу болон ашигт талыг олж авах гэмт хэрэг. Үүнийг ашиглан “Rug-pulls”-ийг үйлдэх боломжтой гэж харч байна.

Харин мөн хуулийн 18.20-р зүйл заалтыг харвал ВХҮҮ-ийн харилцагч, түүний хэрэглэгчийг төөрөгдүүлж, хууран мэхлэх байдлаар арилжаанд оролцуулах эсхүл эс оролцуулж хууль бусаар илүү ашиг олох зорилготой үйлдлийг хуульчилсан байна.

3. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

3.1. Япон улс

Япон улс 2014 онд томоохон ВХҮҮ дампуурсантай холбогдуулан 2016 онд Төлбөрийн үйлчилгээний тухай хууль[37] болон Гэмт хэргийн орлого шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай хууль[38] нэмэлт өөрчлөлт оруулсан.[39]

“Гэмт хэрэгтэй холбоотой орлого шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай хууль” нь гэмт хэрэгтнүүд мөнгө угаахаас сэргийлэхийн тулд мөнгөний урсгалд оролцдог санхүүгийн байгууллагууд болон үүнтэй холбогдох бусад байгууллагууд мөрдөх ёстой дүрмийг тогтоосон хууль юм. 2016 онд нэмэлт өөрчлөлт оруулсанаар крипто хөрөнгийн[40] үйлчилгээ үзүүлэгч ч мөн энэ хуулийг дагаж мөрдөхөөр зохицуулагдсан. Өөрөөр хэлбэл, мөнгө угаах, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь санхүүгийн байгууллагуудын нэгэн адилаар дараах үүргүүдийг хүлээхээр болсон.

1. Харилцагчийн таних (KYC) ба бүртгэлийг хадгалах.
2. Гүйлгээний бүртгэл үүсгэх, хадгалах.
3. Сэжигтэй гүйлгээний талаар эрх бүхий байгууллага (Санхүүгийн

[37] 資金決済法、https://elaws.e-gov.go.jp/document?lawid=421AC0000000059_20240401_505AC0000000079&keyword=%E8%B3%87%E9%87%91%E6%B1%BA%E6%B8%88.

[38] 犯罪による収益の移転防止に関する法律、https://elaws.e-gov.go.jp/document?lawid=419AC0000000022_20240401_504AC0000000097&keyword=%E7%8A%AF%E7%BD%AA%E5%8F%8E%E7%9B%8A.

[39] Фатф, “Эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага, ВИРТУАЛ ХӨРӨНГӨ БОЛОН ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД”, http://www.frc.mn/resource/frc/Document/2022/01/19/ezhz2sw5t6qc52eg/%D0%92%D0%A5%20%D0%92%D0%A5%D2%AE%D2%AE%20%D1%81%D0%B0%D0%BB%D0%B1%D0%B0%D1%80%D1%8B%D0%BD%20%D1%8D%D1%80%D1%81%D0%B4%D1%8D%D0%BB%D0%B4%20%D1%81%D1%83%D1%83%D1%80%D0%B8%D0%BB%D1%81%D0%B0%D0%BD%20%D0%B0%D1%80%D0%B3%D0%B0%D1%87%D0%BB%D0%B0%D0%BB.pdf Сүүлд нэвтэрсэн: 2024.04.28.

[40] Япон Улсын Төлбөрийн үйлчилгээний тухай хуулиар виртуал хөрөнгийг “暗号資産” буюу крипто хөрөнгө гэх нэр томьёогоор хуульдаа тусгасан байдаг.

үйлчилгээний агентлаг)-д мэдэгдэх.

4. Системийн байнгын засвар үйлчилгээ.

Эдгээр нь ФАТФ-ын зөвлөмжтэй нийцэж байгаа бөгөөд Япон улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад чухал зааварчилгаа болдог.[41]

2020 оны 4-р сард хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлтөөр санхүүгийн байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг оролцуулан бүх тусгай үйл ажиллагаа эрхлэгчид явуулах ёстой хэрэглэгчийг таних арга чангарч, харилцагчийн биеийн байцаалтыг баталгаажуулахдаа иргэний үнэмлэхийг 2 хувь гаргаж өгөх шаардлагатай болосон. Олон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид харилцагчийг таних үүргээ дагаж мөрддөг байсан ч ийнхүү чангатгасан нь биржийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг хүлээх шинэ хэрэглэгчдэд зориулсан магадлан шинжилгээ (due diligence)-ний түвшин дээшилсэн.[42]

Тус хуулийн 2 дугаар зүйлд "Энэ хууль дахь "гэмт хэргийн орлого" гэдэг нь Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн[43] 2 дугаар зүйлийн 4-т заасан гэмт хэргийн орлого, эсхүл хар тамхины онцгой тохиолдлын тухай хуулийн[44] 2 дугаар зүйлийн 5-д заасан хар тамхины гэмт хэргийн орлогогыг хэлнэ." гэж заасан.[45]

Мөн хуулийн 25 дугаар зүйлд 18 дугаар зүйлд заасан тушаалыг зөрчсөн этгээд хоёр жил хүртэл хорих ял, эсхүл гурван сая хүртэлх иений торгох, эсхүл аль алинаар нь ял шийтгэнэ гэж заасан.[46]

Үүнээс харахад Япон улс нь Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргээс сэргийлэх, түүнийг зохицуулахдаа ЭХ-иасаа гадна давхар тусгай хууль баталж түүгээр давхар зохицуулж өгснөөр өөрийн гэсэн онцлогтой Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийн хүрээг илүү өргөн хүрээнд авч үзэх боломжтой болсон байна.

---

41 「Chainalysis」、日本における暗号資産(仮想通貨)の規制法についての要点（https://blog.chainalysis.com/reports/japan-cryptocurrency-regulation-updates-2020-japanese-version/ 2024年4月28日最終閲覧）

42 同上。

43 組織的犯罪処罰法

44 麻薬特例法

45 第二条　この法律において「犯罪による収益」とは、組織的犯罪処罰法第二条第四項に規定する犯罪収益等又は麻薬特例法第二条第五項に規定する薬物犯罪収益等をいう。(2 дугаар зүйл Япон хэлээрээ)

46 第二十五条　　第十八条の規定による命令に違反したときは、当該違反行為をした者は、二年以下の懲役若しくは三百万円以下の罰金に処し、又はこれを併科する。(25 дугаар зүйл Япон хэлээрээ)

4. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт:

Криптовалют болон бусад виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэргийг нарийн төвөгтэй аргаар үйлдэгдэж, дэлхийн дахинд их хэмжээний хохирол учруулж байгаа нь улс орны санаа зовоосон асуудал болоод байна.

Хэдийгээр Монгол Улсад хараахан виртуал хөрөнгөөр дамжуулж мөнгө угаах гэмт хэрэг бүртгэгдээгүй байгаа хэдий ч цаашлаад тус гэмт хэрэг гарах магадлал харьцангуй өндөр хэвээр байсаар байна. Техник, технологи, сүүлийн үеийн программ хангамжийг ашиглан виртуал хөрөнгийн хэтэвч, данс, ВХҮҮ-ийг хакердах байдлаар үйлдэгдэх хандлагатай байгаа виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэрэг Монгол улсад бүртгэгдэхэд Эрүүгийн хууль тогтоомжид заасан виртуал хөрөнгөтэй холбогдох гэмт хэргүүдийн талаар тусгасан зүйл заалтууд хангалтгүй хэмжээнд буюу ЭХ-ийн тусгай ангид заасан виртуал хөрөнгөтэй холбогдох гэмт хэргийн хүрээ хумигдмал байна.

Иймд дээр дурдсан олон улсад гараад буй виртуал хөрөнгийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болох шинж тэмдэг, туршлагыг ашиглаж уг гэмт хэргээс сэргийлэх нь нэн чухал юм. Хэдийгээр шинж тэмдэг илэрсэн гэдэг нь мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг байж болзошгүй гэж үзэж, сэжиглэх үндэслэл болохгүй хэдий ч цаашид нягтлах, дэлгэрүүлж шалгах шаардлагатайг илэрхийлж байгаа юм. Гол нь харилцагч өөрөө тухайн гүйлгээний зорилго, сэжигтэй шинж тэмдэг зэргийг зөвтгөх тайлбар гаргах боломжтой гэдгийг санах хэрэгтэй.

Санал:

- ЭХ-иар виртуал хөрөнгөтэй холбоотойгоор гарч болох гэмт хэргийн хүрээг бусад орны туршлага дээр үндэслэн нэмэгдүүлэх.
- “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлтийг оруулах. Ялангуяа дээрх сэжигтэй тохиолдолд гэмт хэрэг гарахаас сэргийлэхийн тулд ямар арга хэмжээг авч ажиллах талаар тусгайлан зохицуулах.
- Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагч, ВХҮҮ-д чиглэсэн виртуал хөрөнгөтэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болох шинж тэмдгүүдийн талаар тогтмол сургалт зохион байгуулах, виртуал хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн талаар хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөхийг дэмжих.
- Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд зохицуулалтын байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд болон салбарын оролцогч талууд хүчтэй зохицуулалтыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, криптовалютын гүйлгээг хянах, хянах технологийн шийдлүүдийг боловсруулахад хамтран ажиллах ёстой.

НОМ ЗҮЙ

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Төрийн мэдээлэл, УБ., 2021 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл, УБ., 2016 он
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл, УБ., 2013 он

Хоёр. Нэг сэдэвт бүтээл, тайлан

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал, https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/01/VASP-%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1% 86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0.pdf
2. Санхүүгийн зохицуулах хороо, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарийн үйл ажиллагааны нэгдсэн тайлан” 2023он
3. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар. “Эдийн засгийн гэмт хэрэг II”, УБ., 2018 он
4. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ, 2016 он
5. ФАТФ-ын тайлан “Виртуал хөрөнгийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болох шинж тэмдгүүд” 2020 он

Гурав. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, нийтлэл

1. Б.Амарбаясгалан “Авлигын болон эдийн засгийн зарим гэмт хэргийн эрх зүйн шинж, шүүхийн практик. УДШ/хамтын бүтээл/”. УБ., 2022 он.
2. Монгол Банкны санхүүгийн мэдээллийн албаны дарга Х. Батчулуун “Монгол улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал” илтгэл. УБ., 2018 он.
3. “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэнцэх асуудал” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018 он.
4. Ц.Цэлмэг “Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэж буй практикт хийсэн дүн шинжилгээ”. 2023 он
5. Э.Мөнхболд “Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн тулгамдсан асуудал” 2020 он.

Дөрөв. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. FATF, “INTERNATIONAL STANDARDS ON COMBATING MONEY LAUNDERING AND THE FINANCING OF TERRORISM & PROLIFERATION, The FATF Recommendations”, 2023.11., (https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/recommendations/FATF%20Recommendations%202012.pdf.coredownload.inline.pdf
2. Chainalysis, “The 2024 Crypto Crime Report”, https://go.chainalysis.com/rs/503-FAP-074/images/The%202024%20Crypto%20Crime%20Report.pdf?version=0
3. 資金決済法、https://elaws.e-gov.go.jp/document?lawid=421AC0000000059_20240401_505AC0000000079&keyword=%E8%B3%87%E9%87%91%E6%B1%BA%E6%B8%88
4. 犯罪による収益の移転防止に関する法律、https://elaws.e-gov.go.jp/document?lawid=419AC0000000022_20240401_504AC0000000097&keyword=%E7%8A%AF%E7%BD%AA%E5%8F%8E%E7%9B%8A
5. 「Chainalysis」、日本における暗号資産(仮想通貨)の規制法についての要点（https://blog.chainalysis.com/reports/japan-cryptocurrency-regulation-updates-2020-japanese-version/

Тав. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын төв банк. www.mongolbank.mn
2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. www.legalinfo.mn
3. Санхүүгийн зохицуулах хороо. www.frc.mn
4. Төрийн мэдээлэл эмхтгэл. www.parliament.mn
5. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар. www.prokuror.mn
6. Монгол Улсын гадаад харилцааны яам. www.mfa.gov.mn
7. Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага. www.fatf-gafi.org
8. Монгол хэлний их тайлбар толь. www.mongoltoli.mn

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Ж.Гантулга, Б.Маралмаа***

**Мандах Их Сургууль, Эдийн засаг бизнесийн тэнхим, Удирдагч багш, Магистр. И-мэйл: j_gantulga@mandakh.edu.mn*

***Мандах Их Сургууль, Эдийн засаг бизнесийн тэнхим, Санхүү менежмент III-р курсын оюутан. И-мэйл: bfm21d072@mandakh.edu.mn*

ТОВЧ ХУРААНГУЙ

Даяаршсан өнөөгийн нийгэмд мөнгө угаах асуудал тулгамдсан асуудал болоод байна. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орон бүрийн хамтын ажиллагаа, үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай томоохон аюулуудын нэг юм.Мөнгө угаах нь эдийн засгийн асар их сөрөг үр дагавартай. Нэгдүгээрт, хөрөнгийн үнийг зохиомлоор өсгөх замаар эдийн засгийг гажуудуулж, зах зээлийн тогтворгүй байдалд хүргэдэг. Хоёрт санхүүгийн байгууллагуудын шударга байдлыг алдагдуулж, иргэдийн итгэл, харилцагчидийн итгэлийг алдагдуулдаг. Эдгээр эдийн засгийн үр дагавар нь эдийн засгийн өсөлтийг саатуулаад зогсохгүй санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулдаг.

Дэлхийн 45 улс орныг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч Basel AML_index буюу мөнгө угаахтай тэмцэх индексид тухайн улсын санхүүгийн индексийн үзүүлэлт болон авилгын төсөөллийн индексийг сонгон 5 бүлэг нийт 2580 дата өгөгдлийг цуглуулан хувьсангч хоорондын хамаарлыг Least Squarnes загвараар шугаман регресс хийж нэг нэгжэд дэх өөрчлөлтийг гаргаж ирхийг зорисон. Судалгааны үр дүнд мөнгө угаахтай тэмцэх индексэд авилгын төсөөллийн индекс сөрөг хүчтэй хамааралтай гаасан ба энэ нь авилгыг нээж илрүүлэх, хяналт шалгалт хийх нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргэйлэх боломжтой хэмээн үзэж байна.

ТҮЛХҮҮР ҮГ

Мөнгө угаахтай тэмцэх индекс, Авилгын төсөөллийн индекс, Санхүүгийн хөгжлийн индекс, Санхүүгийн зах зээлийн индекс, Санхүүгийн технологийн индекс

УДИРТГАЛ

Мөнгө угаах гэж юу вэ?

“Мөнгө угаах” гэсэн ойлголт Чикагогийн мафийн толгойлогч Аль Капонегийн үед буюу өнгөрсөн зууны 20-иод онд анх бий болжээ. Тэр үед Америкт “хуурай” хууль буюу архины худалдааг хязгаарласан хууль үйлчилж байх үед Аль Капоне архи, хар тамхи, худалдаа, рэкетийн хууль бус үйлдлээсээ олсон мөнгөө өөрийн эзэмшлийн хувцас угаалгын газруудаас олсон ашиг мэтээр тайлан тооцоо гаргадаг байв. Үүнийг нь “L’expresse” сонины сэтгүүлчид анх олж мэдээд тэднийг “Хувцас

биш мөнгө угааж байна” нэж бичсэнээр “мөнгө угаах” гэсэн нэр томъёо анх гарч ирсэн гэдэг. Анх мөнгө угаах арга нь энгийн байсан бөгөөд гэмт хэрэгтэн Аль Капонегийн хууль бусаар олсон мөнгөө хууль ёсны болгох үүднээс Чикаго хотын хими цэвэрлэгээ, угаалгын газруудыг ашигладаг байсан учир ийм төрлийн хууль бус ажиллагааг “Мөнгө угаах” буюу “Money Laundering” гэж нэрлэх болжээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь эдийн засаг, нийгмийн сөрөг үр дагвартай:

- Их хэмжээний мөнгө гэнэт орж ирээд гэнэт гарах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг алдагдуулах, цаашлаад хямралд хүргэж болзошгүй.
- Олон улсын хэмжээнд банк, санхүүгийн байгууллагын нэр хүнд алдагдах, тэдгээртэй харилцахаас татгалзах.
- Хууль бус мөнгө дотоодынх бол тус мөнгө нь хээл хахууль, авилгыг гааруулах, шудрага өрсөлдөөнийг үгүй хийх, шударгаар бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахан гаргаж, монополь байдал бий болгох.

Терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ?

Террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсаныг “терроризмыг санхүүжүүлэх” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар тогтоосон. (Монголбанк, Санхүүгийн боловсрол, 2016)

Зураг 1 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн ялгаа

Мөнгө угаах гэмт хэрэг	Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг
Хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харагдуулахыг зорьдог.	Хууль ёсны болон хууль бус орлогыг террорист үйл ажиллагаанд зарцуулахыг хэлдэг.
Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр гэмт хэргийг нягт холбодог. Гэвч агуулгын хувьд энэ хоёр нь тусдаа явагддаг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор ч бас санхүүжиж болдог.	

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Мөнгө угаах үйлдлийн талаар дараах чиглэлд судалгаа хийгдсэн байна. Үүнд: (а) Мөнгө угаахтай тэмцэх бүтэц ба түүний үр нөлөө: судлаачид Мөнгө угаахтай тэмцэх бүтэц, ФАТФ-н гаргасан зөвлөмжийг шүүмжилсэн ба түүний үр нөлөөнд анхаарлаа хандуулсан; (б) Мөнгө угаах гэмт хэргийн бусад салбар болон эдийн

засагт үзүүлэх нөлөөлөл: мөнгө угаах гэмт хэрэг нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг гэж дүгнэсэн; (в) мөнгө угаах үйлдлийн хүрээ: жил бүр дотоодын нийт бүтээгдэхийн 2-5 хувьтай тэмцэх хэмжээний хөрөнгө угаагддаг гэж дүгнэсэн; (г) мөнгө угаах шинэ боломжууд: технологийн болон хяналтын өөрчлөлтөөс шалтгаалан мөнгө угаах шинэ технологиудыг хөгжихөд түлхэц өгсөн байна; (д) мөнгө угаалтыг илрүүлэх: мөнгө угаалтыг автоматаар илрүүлэх чиглэлээр хэд хэдэн загварууд боловсруулсан байна. (Б.Бадрах,Л.Наранчимэг,Д.Баттуяа, 2022)

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (цаашид МУТС гэх)2 гэмт хэрэг болон дижитал шилжилтийн тухай ойлголтыг судалж, Монгол улсын МУТС тогтолцоо хэрхэн ямар шат дарааллаар явагддаг, олон улсын байгууллагууд, зохицуулагч байгууллагууд, болон банк санхүүгийн байгууллагууд энэ гэмт хэргийн эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагааг судалжээ. 2016 онд хийгдсэн МУТСТ үндэсний эрсдэлийн үнэлгээнд дурдсанаар 2010- 2015 орд СМА-нд нийт 863 сэжигтэй гүйлгээний тайлан ирснээс 850-ыг арилжааны банкууд үлдсэн 13-ыг нь бусад санхүүгийн байгууллагуудаас ирүүлсэн байдаг. Тиймээс банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн МУТСТ үйл ажиллагааг сайжруулах хэрэгтэй гэж дүгнэсэн ба МУТС урьдчилан сэргийлэх, илрүүлэх үйл ажиллагаанд тавигдах хяналт нь өндөр зардалтай, эргээд ямар нэгэн зөрчил гарвал өндөр торгуультай, хариуцлагатай үйл ажиллагаа юм. Мөн техник технологи хөгжихийн хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ дижитал хэлбэрт шилжээд байгаа энэ үед мөнгө угаах гэмт хэрэг ч энэ байдлаар их үйлдэгдэх болсон ба бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжиж байгаа цагт хяналтын систем нь хүртэл дагаж хувьсан өөрчлөгдөж байж энэхүү гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэнэ хэмээн бодож байна. (МАНДАЛМАА, 2022) Үүнээс үзэхэд санхүүгийн дижитал шилжилт нь буюу fintech нь МУТС -д эерэг нөлөө үзүүлдэг хэмээх зүйл гарч ирж байна.

Мөнгө угаах гэмт хэргийг олон улсын эрүүгийн эрх зүйд эдийн засаг, нийгэм, улс төрийн гэсэн үндсэн 3 харилцаанд хамгийн их хор хохирол учруулдаг гэмт хэрэг гэж үздэг бөгөөд энэ гэмт хэрэг нь “биет хохирогчгүй”, хохиролын хэмжээг нь бодитоор тодорхойлох боломжгүй, хор хохирол нь негатив болон позитив байдлаар банк санхүү, хөрөнгө оруулалт, худалдаа үйлчилгээ, үнэт цаас гэх мэт эдийн засаг , нийгмийн салбарт хор уршигтай үр дагаваруудыг бий болгож байна. (ЦОЛМОНТУЯА, 2018) 1т Мөнгө угаах гэмт хэрэг яаж үйлдэгддэг, шинж байдлын талаар наад захын мэдлэгийг ард иргэдэд ойлгуулж таниулах. Хууль сахиулах байгууллагуудад мэдээлэл өгч туслалцаа үзүүлсэн этгээдэд мэдээллийг тодорхой хэмжээгээр үнэлдэг байх, 2т 20 сая төгрөгөөс дээш гүйлгээг биш түүнээс доош давтамжтай хийгддэг, эсхүл гүйлгээний утгыг кодон хэлбэр ашиглаж явуулж байгаа, тонгоргож, далд утга агуулсан үгсийг ашиглаж байгаа эсэхийг тогтоох зэрэг санал зөвлөмжүүдийг гаргасан.

Ирээдүйд чиглэсэн сэдвүүдэд ердийн судалгааны арга, дүн шинжилгээ хийхэд шаардлагатай тодорхой өгөгдөл, нотлох баримт дутмаг байдаг. 1950-иад онд


RAND корпорацийн бүтээсэн Delphi арга нь ийм ойлголтыг хэмжсэн. Дельфийн энэхүү судалгааг хийснээс хойших үйл явдлууд, тухайлбал, үл хэрэглэгдэх токенуудын (NFTs, «өнгөт зоос»-ын жишээ) алдаршсан зэрэг нь үнэлэгдсэн эрсдэлүүдийн үнэмшилтэй байдал болон технологийн дэвшилтэт санхүүгийн байдлыг урьдчилан сэргийлэхийн чухлыг онцсон. (Eray Arda Akartuna, Shane D. Johnson, Amy Thornton , 2022,07)

LASSO болон санамсаргүй ойг ашигласан. Санамсаргүй ойн таван хүчин зүйлийн (RF-FF) загвар нь өндөр нарийвчлалтай (86.31%), MER-AML индексийг түүврээс гадуур урьдчилан таамаглах чадвартай. FATF/FRSB-ийн 172 орны харилцан хувьслын хоёр үе шатны тайланд үндэслэн эрсдэлд суурилсан аргын дагуу AML нөөцийн хуваарилалтыг оновчтой болгох нэн шаардлагатай. RF-FF загвар нь одоогоор хамгийн сайн таамаглах гүйцэтгэлтэй MER-AML индексийг таамаглах загвар юм. (Guike Zhang, Zengan Gao, June Dong, Dexiang Mei, 2023,03)

I. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ИНДЕКСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

МУТС 2 гэмт хэрэг нь аливаа улсын нийгэм, эдийн засагт ихээхэн хор уршигтай байдаг. Тухайлбал, хууль бус их хэмжээний мөнгө тухайн улсад угаагдвал нэн түрүүнд санхүүгийн системийн тогтвортой байдалд аюул учруулдаг байна.

График 1. Монгол улс болон Олон улсын дундаж Basel AML index 2012-2023 он



Олон улсын Базел институт нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/, Трансперенси интернэшнл, Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг байгууллагын олон нийтэд нээлттэй 18 төрлийн өгөгдөлд үндэслэн энэхүү индексийг гаргадаг. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үзүүлэлтийг гаргахдаа эрсдэлийн үнэлгээг дараах 5 бүлэгт авч үздэг:

1. МУТСТ тогтолцооны чанар (65%)
2. Авлига, хээл хахууль (10%)
3. Санхүүгийн ил тод байдал ба стандарт (10%)


4. Нийтийн ил тод байдал ба хариуцлага (5%)
5. Хууль зүйн болон улс төрийн эрсдэл зэрэг юм. (10%)

Эрсдэлийг тодорхой аргачлалаар тооцдог бөгөөд дэлхийн дундаж 5.31 гэж үнэлэгджээ.

“Базелийн индекс-2023”-ыг 2023 оны 11 дүгээр сарын 13-нд зарлагдсан байна. Энэ жагсаалтын 1 дүгээрт буюу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хамгийн өндөр эрсдэлтэй улсаар Гайти Улс гарсан бол хамгийн эрсдэл багатай улсаар буюу 152 дугаарт Исланд улс шалгарчээ.

Монгол Улсын хувьд 2019 онд ФАТФ-ын саарал жагсаалтад орох үед Базел индексийн 20 дугаарт жагсаж байсан бол 2023 оны байдлаар эрсдэлийн үзүүлэлт буурч, нийт 152 улсаас 83 дугаарт жагссан. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл буурсан үзүүлэлт гарчээ. (Монголбанк, 2023 оны Базелийн мөнгө угаахтай тэмцэх индекс зарлагдлаа, 2023)

Зураг 2 Basel AML index 2023 оны Зүүн Ази,Номхон далай орнуудын maps,ranking



II. СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ БОЛОН АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны ажилд санамсаргүй түүврээр 45 улсын 2012-2023 оны хоорондох Basel-аас гаргасан мөнгө угаахтай тэмцэх индекс (AML_index), авилгын төсөөллийн индекс (CP_index), санхүүгийн хөгжлийн индекс (FD_index),

санхүүгийн зах зээлийн индекс (FM_index), санхүүгийн технологийн индекс(FIN_index) зэрэг МУТС-д нөлөөлөх боломжтой макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг хамруулсан бөгөөд тоон өгөгдлийг Basel-ийн жил бүрийн олон нийтэд гаргадаг нийтлэл, World bank-ний Open Data мэдээллийн сангаас авч ашиглав. Basel-аас гаргасан мөнгө угаахтай тэмцэх индексэд нөлөөлнө гэж үзсэн авилгын төсөөллийн индекс, санхүүгийн хөгжлийн индекс, санхүүгийн зах зээлийн индекс, санхүүгийн технологийн индексын хоорондын хамаарлыг судлахдаа Шугаман регрессийн загварыг ашиглан тодоорхойлох явдал юм.

$$LS - Least\ Squares\ (NLS\ and\ ARMA)$$

$$yi = \beta_1 x_1 i + \beta_2 x_2 i + \cdots + \beta_k x_k i + e_i \; i = 1, \dots, n \qquad (1)$$

Регрессийн шинжилгээнд тайлбарлагч хувьсагчийн тоо хоёроос их байх тохиолдолд олон хувьсагчийн регрессийн шинжилгээ гэж нэрлэдэг. Энд:

- $x2i$, $x3i$ … , xki нь хамаарагч хувьсагч болох yi-д нөлөөлдөг тайлбарлагч хувьсагчид
- $\beta 1, \beta 2, \beta 3, \dots, \beta k$ нь тэдгээрийн параметр, ei нь загварын алдааны илэрхийлэл байна.

$$(AML_{index})_i = \beta_1 (CP_{index}) + \beta_2 (FD_{index}) + \beta_3 (FM_{index}) + \beta_4 (Fin_{index}) + e_i \qquad (2)$$

H0: β_1= AML_index-д CP_index эерэг хүчтэй хамааралтай

H1: β_2= AML_index -д FD_index сөрөг хамааралтай

H2: β_3=AML_index -д FM_index сөрөг хамааралтай

H3: β_1=AML_index-д Fin_index сараг хамааралтай

III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Мөнгө угаахтай тэмцэх индекст авилгын төсөөллийн индекс, санхүүгийн хөгжлийн индекс, санхүүгийн зах зээлийн индекс, санхүүгийн технологийн индекс зэрэг хүчийн зүйлсүүд нөлөөлж байгааг эсэхийг харгаж ирэх.

45 улсын нийт 2580 өгөгдлийг цуглуулж, AML_index-ийг хамаарагч хувьсагч болгон CP_index, FIN_index, FD_index, FM_index-ыг нөлөөлөгч хувьсагчаар сонгон авсан.

Хүснэгт 1 Өгөгдлүүдийн ерөнхий үзүүлэлтүүд

	AML_index	CP_index	FIN_index	FD_index	FM_index
Mean	5.526337	45.98256	61.19845	0.391376	0.290850
Median	5.530000	38.00000	55.35000	0.340000	0.240000

Maximum	8.280000	92.00000	100.00000	0.990000	0.920000
Minimum	1.230000	20.00000	13.04000	0.090000	0.00000
Std.Dev	0.977044	18.91949	25.49574	0.231032	0.270667
Skewness	-0.039597	0.930387	0.130719	0.968621	0.820186
Kurtosis	3.386439	2.611115	1.776291	2.961140	2.522972
Jarque-Bera	3.345544	77.69483	33.66500	80.72004	62.74514
Probability	0.18773	0.00000	0.00000	0.00000	0.00000
Sum	2851.5900	23727.0000	31578.4000	201.9500	152.7800
Sum Sq.Dev	491.6270	184342.8000	334766.8000	27.4885	37.7293
Observations	516	516	516	516	516

Эх сурвалж: Судлаачдын тооцоо (Eviews 12.0 программын үр дүн)

Нийт 2580 өгөгдлийг 5 бүлэг болгон үзэж, бүлэг тус бүрт 516 ширхэг дата өгөгдөл байна. Ерөнхий статистик үзүүлэлтийг (Хүснэгт1)т харуулав.

Хүснэгт 1. ADF тестийн үр дүн

Series	Prob.	Lag	Max Lag	Obs	Integration
AML_index	0	0	18	515	I (0)
CP_index	0.1632	12	18	503	
FD_index	0.0224**	0	18	515	
FIN_index	0.0004*	0	18	515	
FM_index	0.003*	0	18	515	
AML_index	0.0000*	0	18	515	I (1)
CP_index	0.0000*	11	18	503	
FD_index	0.0000*	3	18	511	
FIN_index	0.0000*	11	18	515	
FM_index	0.0000*	11	18	515	
*Тайлбар: *, **, *** тэмдэглэгээ нь цуваа нэгж язгууртай буюу тогтвортой бус гэсэн тэг таамаглалыг 1, 5 болон 10 хувийн ач холбогдлын түвшинд няцааж байгааг харуулна. Харин I(0), I(1) гэсэн тэмдэглэгээ тэгшитгэлийн хэлбэрийг илэрхийлэх бөгөөд I(0) нь цуваа өгөгдсөн түвшинд тогтвортой болохыг, I(1) нь 1-р эрэмбийн ялгавар авч тогтворжуулсныг харуулна.*					

Эх сурвалж: Судлаачдын тооцоо (Eviews 12.0 программын үр дүн)

ADT тест-ээр хувьсагчүүдын ач холбогдлын түвшинг шалгахад авилгын төсөөллийн индекс 0.1632 гарч ач холбогдлолгүй гарсан. Тиймээс авилгын төсөөллийн индексээс log авч дахин ач холбогдлын түвшинг шалгахад сонгон авсан хувьсагчид бүгд ач холбогдолтой гарсан. Энэ нь авилгын төсөөллийн индексийг хувийн дүнгээр гаргадаг бол мөнгө угаахтай тэмцэх индекс нь 1-ээс 10-ын хооронд үнэлж гардаг ба үүнээс болж ач холбогдолын түвшин ялгаатай гарах боломжтой.

Хүснэгт 2 Correlation

	AML_index	CP_index	FIN_index	FD_index	FM_index
AML_index	1.000000	-0.592473	-0.448660	-0.515346	-0.414643
CP_index	-0.592473	1.000000	0.718100	0.768356	0.694693
FIN_index	-0.448660	0.718100	1.000000	0.733796	0.642785
FD_index	-0.515346	0.768356	0.733796	1.000000	0.948625
FM_index	-0.414643	0.694693	0.642785	0.948625	1.000000

Эх сурвалж: Судлаачдын тооцоо (Eviews 12.0 программын үр дүн)

Correlation ашиглан хувьсагч хоорондын хамаарлыг харахыг оролдсон. Мөнгө угаахтай тэмцэх индекс нь авилганы төсөөллийн индекстэй урвуу хамааралтай гарсан нь авилгыг илүүлж, авилга авсан хүмүүсийг барих тусам мөнгө угаахтай тэмцэх индекс нь буурдэг гэсэн үзүүлэлт гарсан.

Санхүүгийн технологи мөнгө угаахтай тэмцэх индекстэй -0.448 буюу -44.8%-ын урвуу хамааралтай гарчээ. Энэ нь цахим хэлбэрээр төлбөр тооцоо хийх нь шилэн дансны бүртгэлээр мөнгө угаалтыг бууруулдаг гэсэн үзүүлэлт гарч байна. Мөн санхүүгийн технологи нь санхүүгийн хөгжлийн индексэд эерэг хамааралтай буюу 73.37%-ын хамааралтай гарчээ.

Санхүүгийн зах зээл (FM_index) гэх үзүүлэлт шугаман регрессээр үзэхэд хамаарал хувь 0-тэй тэнцүү гарсан тул санхүүгийн зах зээлийн индексийг хасч санхүүгийн хөгжлийн индекс(FD_index)-ийг оруулж шугаман регрессийн дахин хийхсэн.

Хүснэгт 3 Least Squares

Variable	Coefficient	Std.Error	t-Statistic	Prob
C	1.561926	0.187477	8.331284	0.000000
D(CP_index)	-0.015101	0.004612	-3.274198	0.001100
FD_index	-0.311939	0.155147	-2.010595	0.044900
FIN_index	-0.002690	0.001337	-2.012654	0.447000
AML_index(-1)	0.769294	0.027414	28.062230	0.000000
R-squared	0.715703	Mean dependent var		5.528291
Adjusted R-squared	0.713473	S.D dependent var		0.976984
S.E. of regression	0.52296	Akaike into criterion		1.55105
Sum squared resid	139.47980	Schwarz criterion		1.59225
Log Likehood	-394.3946	Hannan-Quinn criter		1.5672
F-statistic	320.9742	Durbin-Watson stat		2.0625
Prob(F-statistic)	0.00000			

Эх сурвалж: Судлаачдын тооцоо (Eviews 12.0 программын үр дүн)


$$(AML_{index})_i = -0.01501(CP_{index}) - 0.311939(FD_{index}) - 0.002690(Fin_{index}) + 1.561926$$

Шугаман решрессийн тэгшитгэлийг авч үзвэл C Variable буюу мөнгө угаахтай тэмцэх индекс нь сонгож авсан авилгын төсөөллийн индекс, санхүүгийн хөгжлийн индекс, санхүүгийн технологийн индексүүд тэг буюу 0 утгатай байх буюу тогтмол байх үед тогтмол 1.56 нэгжээр дээшилдэг ба авилгын төсөөлийн индекс, санхүүгийн хөгжлийн индекс, санхүүгийн технологийн индекс зэрэг үзүүлэлтүүд нь мөнгө угаахтай тэмцэх индексийг бууралдаг буюу урвуу хамааралтай гарсан.

Детерминацийн коэффициент нь мөнгө угаахтай тэмцэх индексийг авилгын төсөөлийн индекс, санхүүгийн хөгжлийн индекс, санхүүгийн технологийн индекс нь 0.7134 буюу 71.34%-ийн тайлбарлаж чадаж байна.

Регрессийн тэгшитгэлийн стандарт алдаа0.52 буюу 52%-ын алдааны утгатай байгаа нь 48% нь регрессийн тэгшитгэлийн бодит байдлыг тусгасан загвар болсон.

График 2 Хувьсагчдийн тархалт



Эх сурвалж: Судлаачдын тооцоо (Eviews 12.0 программын үр дүн)

H0: β_1= AML_index-д CP_index эерэг хүчтэй хамааралтай гэсэн таамаглал маань няцаагдаж авилгын төсөөллийн индекс мөнгө угаахтай тэмцэх индекстэй сөрөг

хүчтэй хамааралтай гарсан.

H1: β_2= AML_index -д FD_index сөрөг хамааралтай таамаглал биелэгдэж мөнгө угаахтай тэмцэх индекстэй санхүүгийн хөгжлийн индекс урвуу хүчтэй хамааралтай

H2:β_3=AML_index -д FM_index сөрөг хамааралтай гэсэн таамаглал биелэгдэж мөнгө угаах индекстэй санхүүгийн зах зээлийн индекс урвуу сул хүчтэй хамааралтай

H3: β_4=AML_index-д Fin_index сөрөг хамааралтай гэсэн таамаг биелэгдэж, санхүүгийн технологийн индекс нь мөнгө угаахтай тэмцэх индекстэй сул хамааралтай гарсан байна.

VI. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар 45 улс орны 5 индекс үзүүлүүлэлт буюу 2580 дата өгөгдөлыг цушлуулж мөнгө угаахтай тэмцэх индексэд нөлөөлж байгаа зах зээлийн бусад индексүүдийн хамаарал байгаа эсэхийг хамгийн ойр байдлаар тэгшитгэл хэлбэрт оруулан судлахыг зорилоо. Ингэхдээ Least Squarnes-ийг ашиглан шугаман регрессийн үнэлгээ хийсэн.

Судалгааны үр дүнд мөнгө угаахтай тэмцэх индексэд санхүүгийн хөгжлийн индекс, санхүүгийн технологийн индекс, авилгын төсөөллийн индекс бүгд уруу хамааралтай гарсан. үүнээс харахад санхүүийн хөгжлийн индекс өсөх нь мөнгө угаахтай тэмцэх индексийн бууруулдаг гэсэн үг ба улс орны санхүүгийн байдал дээшилж хөгжихийн хэрээр мөнгө угаах гэдэг зүйл багасна. Мөн санхүүгийн технологийн индекс өсөх нь мөнгө угаахтай тэмцэх индексийг бууруулдаг гэж гарсан нь санхүүгийн дижитал шилжилт, цахим мөнгө, шилэн данс гэх санхүүгийн технологи дээр суурилсан үйлчилгээнүүд мөнгө орох болон гарах үйлдүүд нь технологийн тусмалжтай дэлгэрэнгүй бүтгэж, мэдээллийг төвлөрсөн бус санхүүгийн программыг ашиглан нь ихэсх тусам мөнгө угаахтыг багасгаж байна.

Авилгын төсөөллийн индекс мөнгө угаахтай тэмцэх индекстэй урвуу хүчтэй хамааралтай гарсан ба энэ нь улс төрийн зүгээс хяналт шалгалт хийх,авилга, хээл хахуулыг илрүүлэх, нийтэл ил тод болгох, шүгэл үлээх зэрэг арга хэмжээ нь мөнгө угаах үйлдлыг бууруулдаг гэсэн хандлага ажиглагдаж байгаа юм.

Судалгаанд мөнгө угаахтай тэмцэх индексэд сонгон авсан 4 хувьсагч сөрөг хамааралтай бууруулдаг бол 4 хувьсагч тогтмол байх үед мөнгө угаахтай тэмцэх индекс маань 1.56 нэгжэр өсдөг гэж гарсан. Тэгвэл мөнгө угаахтай тэмцэх индекс буюу AML_index-ын 5 бүлэгт хуваан авч үздэг үзүүлэлтийн ямар үзүүлэлт илүү нөлөөлснөөр мөнгө угаах индекс өсөөд байгааг дахин цааш нь судлах хэрэгтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монголбанк. (2023 оны 11 29). *2023 оны Базелийн мөнгө угаахтай тэмцэх индекс зарлагдлаа.* mongolbank.mn: https://www.mongolbank.mn/mn/r/5644-ээс Гаргасан

Б.Бадрах, Л.Наранчимэг, Д.Баттуяа. (2022). https://journal.num.edu.mn/BusinessAndInnovation/issue/view/163. journal of business & innovation, 51-67.

МАНДАЛМАА, Д. (2022). *МӨНГӨ УГААЛТ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАРЧ БУЙ ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ.* Улаанбаатар.

ЦОЛМОНТУЯА, М. (2018). *МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ.* Улаанбаатар.

Guike Zhang, Zengan Gao, June Dong, Dexiang Mei. (2023.03). https://www.sciencedirect.com/science/article/abs/pii/S1544612322007449. *Machine learning approaches for constructing the national anti-money laundering index.*

Eray Arda Akartuna, Shane D. Johnson, Amy Thornton . (2022,07). https://www.sciencedirect.com/science/article/abs/pii/S0040162522001640. *Preventing the money laundering and terrorist financing risks of emerging technologies: An international policy Delphi study.*

Монголбанк. (2016). Санхүүгийн боловсрол. https://www.sankhuugiinbolovsrol.mn/cdn/pdf/terrorism.pdf.

https://www.fatf-gafi.org/en/countries/detail/Mongolia.html

https://www.sciencedirect.com/science/article/abs/pii/S1544612322007449#preview-section-references

https://www.sciencedirect.com/science/article/abs/pii/S0040162522001640

https://journal.num.edu.mn/BusinessAndInnovation/article/view/1718

https://www.mongolbank.mn/mn/r/5644